

# **ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ**

Улаанбаатар хот 2006 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр  
**ТУСГАЙ ДУГААРЫН V БОТЬ**

## **ГАРЧИГ**

### **Ес. ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН КОНВЕНЦУУД**

88. Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн (I) конвенц.....1066
89. Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн (II) конвенц.....1091
90. Дайнд олзлогчидтой харьцах тухай Женевийн (III) конвенц .....1113
91. Дайны үед энгийн хүмүүсийг хамгаалах тухай (IV) конвенц .....1183

**Арав. ОЛОН УЛСЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН КОНВЕНЦУУД**

**88. ДАЙНЫ ТАЛБАРТ БАЙГАА ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШАРХТАН БОЛОН  
ӨВЧТӨНИЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ ЖЕНЕВИЙН (I)  
КОНВЕНЦ**

*1949 оны 8 дугаар сарын 12-ны өдөр баталж,  
1950 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон\**

Удиртгал

Дайны талбарт байгаа цэргийн шархтан, өвчтөнд тусламж үзүүлэх тухай 1929 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн Женевийн конвенцийг хянан өөрчлөх зорилгоор 1949 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс 8 дугаар сарын 12-ны өдөр хүртэл Женев хотноо болсон Дипломат бага хуралд засгийн газраа төлөөлж дор гарын үсэг зурсан бүрэн эрхт төлөөлөгчид дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

**I бүлэг**

**НИЙТЛЭГ ЗААЛТ**

*1 дүгээр зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийг ямар ч нөхцөл байдалд хүндэтгэн сахих буюу хүндэтгэн сахих явдлыг хангах үүрэг хүлээнэ.

*2 дугаар зүйл*

Тайван цагт хэрэгжүүлэх заалтуудын сацуу хоёр буюу хэд хэдэн хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын хооронд үүсч болох зарласан аливаа дайн буюу бусад зэвсэгт мөргөлдөөний бүх тохиолдолд тэдгээр талын аль нэг нь дайны байдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан ч энэхүү конвенцийг хэрэглэнэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн буюу бүхэлд нь эзэлсэн тохиолдолд тухайн эзлэлт нь зэвсэгт эсэргүүцэлтэй тулгараагүй байсан ч энэхүү конвенцийг мөн хэрэглэнэ.

Хэдийгээр мөргөлдөөнд оролцогч гүрнүүдийн аль нэг нь энэхүү конвенцид оролцогч тал биш байсан ч түүнд оролцогч тал болох гүрнүүд өөр хоорондын харилцаандаа энэхүү конвенцийг заавал биелүүлэх үүрэгтэй хэвээр байна. Үүнээс гадна хэрэв дээр дурдсан гүрэн энэхүү конвенцийн заалтыг хүлээн авч хэрэглэвэл түүний хувьд тэд энэхүү конвенцийг заавал биелүүлэх үүрэгтэй байна.

\* Монгол Улс 1958.11.05-нд нэгдэн орсон

*3 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нэгний нь нутаг дэвсгэрт үүсэх олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний тохиолдолд тухайн мөргөлдөөнд оролцогч тал бүр наад зах нь дараахь заалтыг хэрэглэх үүрэг хүлээнэ:

(1) Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй этгээд, түүний дотор байлдахаа зогсоосон болон өвчлөх, шархдах, саатуулагдах буюу аливаа бусад шалтгааны улмаас байлдаанд биеэр оролцоогүй зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний этгээдтэй арьс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, гарал үүсэл, эд хөрөнгийн байдал болон бусад төсөөтэй шалгуурт үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр бүх нөхцөл байдалд хүнлэг харьцана.

Энэ үүднээс дараахь үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хэзээ ч, хаана ч хийхийг хориглоно:

(a) амь нас, бие махбодид халдах, тухайлбал, бүхий л хэлбэрээр амийг нь хөнөөх, хүнд гэмтэл учруулах, харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;

(b) барьцаанд авах;

(c) хүний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах;

(d) соёл иргэншилт ард түмнүүдийн зайлшгүй гэж хүлээн зөвшөөрсөн шүүхийн бүх баталгаагаар хангаж байнгын ажиллагаатай шүүхээс урьдчилан гаргасан шийдвэргүйгээр ял оноох болон ял эдлүүлэх.

(2) Өвчтөн, шархтанг олж авч тусламж үзүүлнэ.

Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хараат бус хүмүүнлэгийн байгууллага мөргөлдөөнд оролцогч талуудад өөрийн үйлчилгээг санал болгож болно.

Мөргөлдөөнд оролцогч талууд тусгай хэлэлцээрийн замаар энэхүү конвенцийн бусад заалтыг бүгдийг буюу хэсэгчлэн хүчин төгөлдөр болгохыг цаашид чармайна.

Өмнөх заалтуудыг хэрэглэх нь мөргөлдөөнд оролцогч талуудын эрх зүйн байдлыг хөндөхгүй.

*4 дүгээр зүйл*

Төвийг сахисан гүрнүүд өөрийн нутаг дэвсгэрт хүлээн авсан буюу хорьсон мөргөлдөөнд оролцогч талуудын зэвсэгт хүчний өвчтөн, шархтан, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгч, мөн олдсон нас барсан этгээдийн хувьд энэхүү конвенцийг төсөөтэй хэрэглэнэ.

*5 дугаар зүйл*

Дайсны гарт орсон хамгаалагдсан хүмүүсийн хувьд энэхүү конвенцийг тэднийг эх оронд нь бүрмөсөн буцаах хүртэл хэрэглэнэ.

*6 дугаар зүйл*

Энэхүү конвенцийн 10, 15, 23, 28, 31, 36, 37 болон 52 дугаар зүйлд шууд заасан хэлэлцээрийн сацуу хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тусгай заалтаар зохицуулах нь тохиромжтой гэж үзэж болох бүх асуудлаар өөр тусгай хэлэлцээр байгуулж болно. Ямар ч тусгай хэлэлцээр өвчтөн, шархтан, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчийн энэхүү конвенцоор тодорхойлсон байдалд сөргөөр нөлөөлөхгүй бөгөөд энэхүү конвенцоор тэдэнд олгосон эрхийг хязгаарлахгүй.

Дээр дурдсан хэлэлцээр, эсхүл дараа дараагийн хэлэлцээрт эсрэгээр шууд зааснаас бусад тохиолдолд, эсхүл мөргөлдөөнд оролцогч талуудын аль нэг нь өвчтөн, шархтан, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчдийн хувьд илүү тааламжтай арга хэмжээ авснаас бусад тохиолдолд тэд тэдгээр хэлэлцээрээр олгогдсон давуу байдлыг энэхүү конвенцийг тэдний хувьд хэрэглэх хугацаанд үргэлжлүүлэн эдэлнэ.

*7 дугаар зүйл*

Өвчтөн, шархтан, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчид нь энэхүү конвенц болон хэрэв өмнөх зүйлд дурдсан тусгай хэлэлцээр байгаа бол түүгээр хангагдсан эрхээсээ ямар ч нөхцөл байдалд хэсэгчлэн буюу бүрэн татгалзаж болохгүй.

*8 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий хамгаалагч гүрний дэмжлэг, хяналтын дор энэхүү конвенцийг хэрэглэнэ. Эл зорилгоор хамгаалагч гүрнүүд өөрийн дипломат болон консулын ажилтнуудаас тусдаа өөрийн орны, эсхүл төвийг сахисан бусад гүрний харьяатаас бүрдсэн төлөөлөгчдийг томилж болно. Дурдсан төлөөлөгчдийг томилохдоо тэдний очиж ажиллах гүрний зөвшөөрлийг авна.

Мөргөлдөөнд оролцогч талууд хамгаалагч гүрний төлөөлөгчдийн ажлыг боломжтой дээд хэмжээнд хөнгөвчлөн дэмжинэ.

Хамгаалагч гүрний төлөөлөгчид ажлаа явуулахдаа ямар ч тохиолдолд энэхүү конвенцийн дагуу хүлээсэн зорилгот үүргээсээ хэтэрч болохгүй. Ялангуяа тэд нутаг дэвсгэрт нь үүргээ биелүүлж байгаа улсын аюулгүй байдлын зайлшгүй шаардлагыг харгалзан үзнэ. Тэдний үйл ажиллагааг зөвхөн цэргийн зайлшгүй шаардлагын улмаас шаардлагатай болсон онцгой болон түр зуурын арга хэмжээний хувьд хязгаарлана.

*9 дүгээр зүйл*

Энэхүү конвенцийн заалт нь Олон улсын улаан загалмайн хороо буюу аливаа хүмүүнлэгийн хараат бус бусад байгууллагаас өвчтөн, шархтан, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчдийг хамгаалж, тэдэнд тусламж үзүүлэх талаар тухайн мөргөлдөөнд оролцогч талуудын зөвшөөрөлтэйгөөр явуулах хүмүүнлэгийн үйл ажиллагаанд саад болохгүй.

*10 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн дагуу хамгаалагч гүрнүүдэд хүлээлгэсэн үүргийг хараат бус бөгөөд үр ашигтай байх бүх баталгааг гаргаж буй байгууллагад олгохоор хэдийд ч тохиролцож болно.

Өвчтөн, шархтан, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчид аль нэг хамгаалагч гүрэн буюу дээрх эхний хэсэгт заасан байгууллагын үйл ажиллагаанаас ямар нэгэн шалтгааны улмаас ашиг тус хүртэхгүй, эсхүл хүртэхээ болих тохиолдолд олзлогч гүрэн мөргөлдөөнд оролцогч талуудын томилсон хамгаалагч улсын энэхүү конвенцийн дагуу биелүүлж буй чиг үүргийг хүлээхийг төвийг сахисан улс, эсхүл тийм байгууллагаас хүснэ.

Хэрэв хамгаалалтыг ийнхүү хэрэгжүүлж чадахгүй бол олзлогч гүрэн нь хамгаалагч гүрнүүдийн энэхүү конвенцийн дагуу биелүүлж буй хүмүүнлэгийн чиг үүргийг өөртөө хүлээх талаар Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хүмүүнлэгийн байгууллагаас санал болгохыг хүсэх буюу ийм саналыг энэ зүйлийн заалтыг мөрдөхийн хамт хүлээн авна.

Төвийг сахисан аливаа гүрэн, эсхүл холбогдох гүрний урьсан буюу эл зорилгоор өөрийгөө санал болгож буй байгууллага энэхүү конвенцоор хамгаалдаг этгээдийн харьяалагдаж буй мөргөлдөөнд оролцогч талтай хариуцлагаа ухамсарлан үйл ажиллагаа явуулах шаардлагатай бөгөөд зохих чиг үүрэг хүлээж, уг чиг үүргээ хараат бусаар биелүүлэх чадвартай гэсэн хангалттай баталгаа гаргах шаардлагатай.

Аль нэг гүрэн дайны үйл явдлаас шалтгаалан, ялангуяа түүний нутаг дэвсгэр бүхэлдээ, эсхүл түүний үлэмж хэсэг нь эзлэгдсэн тохиолдолд нөгөө гүрэн буюу түүний холбоотонтой хэлэлцээ хийх эрх чөлөө нь түр хугацаагаар ч гэсэн хязгаарлагдсан бол тэдгээрийн хооронд байгуулсан тусгай хэлэлцээрээр өмнөх заалтуудыг зөрчихгүй.

Энэхүү конвенцид хамгаалагч гүрэн гэж дурдах бүрд энэ нэр томъёог энэ зүйлийн дагуу түүнийг орлох байгууллагад ч мөн хэрэглэнэ.

*11 дүгээр зүйл*

Хамгаалагч гүрнүүд хамгаалагдсан хүмүүсийн ашиг сонирхолд хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд, ялангуяа энэхүү конвенцийн заалтыг хэрэглэх буюу тайлбарлах талаар мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд санал зөрөлдсөн тохиолдолд саналын зөрөлдөөнийг зохицуулах үүднээс асуудалд оролцоно.

Эл зорилгоор хамгаалагч гүрэн бүр аль нэг талын урилгаар буюу өөрийн санаачилгаар өөрсдийн төлөөлөгчдийн, ялангуяа өвчтөн, шархтан, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчдийг хариуцаж буй эрх бүхий байгууллагын нь уулзалтыг зохион явуулах саналыг мөргөлдөөнд оролцогч талуудад тавьж болох бөгөөд чингэхдээ тохиромжтой гэж сонгож авсан төвийг сахигч нутагт дэвсгэрт боломжтой бол зохион байгуулна. Мөргөлдөөнд оролцогч талууд эл зорилгоор тэдэнд тавьсан саналыг хүчин төгөлдөр хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Шаардлагатай бол хамгаалагч гүрнүүд ийм уулзалтад оролцохыг урих төвийг сахисан гүрэнд харьяалагдах, эсхүл Олон улсын улаан загалмайн хорооноос томилсон этгээдийг мөргөлдөөнд оролцогч талуудаар дэмжүүлэн батлуулахаар санал болгож болно.

## II бүлэг

### ӨВЧТӨН, ШАРХТАН

#### 12 дугаар зүйл

Өвчтөн, шархтан буюу зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн болон дараагийн зүйлд заах бусад этгээдийг ямар ч нөхцөл байдалд хүндэтгэж, хамгаална.

Тэд мэдэлд нь байж болох мөргөлдөөнд оролцогч тал хүйс, арьс үндэс, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол болон бусад төсөөтэй шалгуурт үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр тэдэнтэй хүнлэг харьцан асран хамгаална. Тэдний амь насанд халдахыг завдах, эсхүл бие махбодид халдахыг хатуу хориглоно; ялангуяа тэдний амийг хөнөөх буюу устгах, эрүүдэн шүүх буюу биологийн туршилт хийх; тэдэнд эмнэлгийн тусламж, асрамж үзүүлэхгүй санаатайгаар орхих, тэдэнд халдварт өвчин халдах буюу тархах нөхцлийг буй болгохыг хориглоно.

Зөвхөн эмнэлгийн нэн яаралтай шалтгаанаар эмчилгээний дарааллыг харгалзахгүй тусламж үзүүлж болно.

Эмэгтэйчүүдэд хүйсний нь онцлогийг бүх талаар харгалзан анхаарал тавина. Өвчтөн буюу шархтанг аргагүйн эрхэнд дайсанд үлдээх болсон мөргөлдөөнд оролцогч тал тэдэнд асрамж үзүүлэх эмнэлгийн хэсэг ажилтан, материалыг цэргийн шаардлагын хүрээнд үлдээнэ.

#### 13 дугаар зүйл

Энэхүү конвенцийг дараахь ангилалд хамаарах өвчтөн, шархтны хувьд хэрэглэнэ:

(1) Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, мөн зэвсэгт хүчний хэсэг болж буй журамт цэрэг буюу сайн дурын ангийн бие бүрэлдэхүүн.

(2) Мөргөлдөөнд оролцогч талд харьяалагдах бөгөөд энэ нутаг дэвсгэр нь эзлэгдсэн байсан ч түүний нутаг дэвсгэрт буюу нутаг дэвсгэрээс гадна үйл ажиллагаа явуулж буй бусад журамт цэргийн болон сайн дурын бусад ангийн бие бүрэлдэхүүн, түүний дотор зохион байгуулалттай эсэргүүцлийн хөдөлгөөний бие бүрэлдэхүүн, чингэхдээ эдгээр журамт цэрэг буюу сайн дурын анги, түүний дотор зохион байгуулалттай эсэргүүцлийн хөдөлгөөн нь дараахь нөхцлийг хангасан байвал зохино:

- (a) захирагдагсдынхаа төлөө хариуцлага хүлээсэн этгээдээр удирдуулж байх;
- (b) алсаас танигдах тогтсон ялгах тэмдэгтэй байх;
- (c) зэвсгээ ил авч явах;
- (d) үйл ажиллагаагаа дайны хууль, заншилд нийцүүлэн явуулж байх.

(3) Олзлогч гүрэн хүлээн зөвшөөрөөгүй засгийн газар буюу эрх бүхий байгууллагыг дэмжиж буй байнгын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн.

(4) Цэргийн агаарын хөлгийн багийн гишүүн болох энгийн иргэд, цэргийн сурвалжлагчид, хангамж түгээгчид, ажлын баг буюу зэвсэгт хүчний ахуйн үйлчилгээний гишүүд зэрэг зэвсэгт хүчний жинхэнэ бие бүрэлдэхүүн биш боловч тэднийг дагалдан яваа этгээд, чингэхдээ тэд дагалдаж яваа зэвсэгт хүчнээс зөвшөөрөл авсан байвал зохино.

(5) Олон улсын эрх зүйн аливаа бусад заалтын дагуу илүү тааламжтай нөхцөл эдэлдэггүй мөргөлдөөнд оролцогч талуудын худалдааны усан цэргийн багийн гишүүд, түүний дотор ахмад, замчин болон дагалдан сурагч, түүнчлэн иргэний агаарын хөлгийн баг.

(6) Дайсан ойртож ирэхэд, байнгын зэвсэгт нэгж болж бүрэлдэж амжилгүй, орж ирж буй хүчнийг эсэргүүцэхээр гэнэт зэвсэг барьж буй эзлэгдээгүй нутаг дэвсгэрийн оршин суугчид, чингэхдээ тэд зэвсгээ ил авч явж, дайны хууль, заншлыг хүндэтгэн сахивал зохино.

#### *14 дүгээр зүйл*

12 дугаар зүйлийн заалтыг мөрдөхийн хамт, дайсны гарт орсон дайтаж буй талын шархтан, өвчтөнг дайнд олзлогдогчид гэж үзэх бөгөөд тэдний хувьд дайнд олзлогдогчдын талаархи олон улсын эрх зүйн заалтыг хэрэглэнэ.

#### *15 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талууд өвчтөн, шархтанг эрж хайх, олж авах, тэднийг тонон дээрэмдэх, зүй бусаар харьцахаас хамгаалах, зохих асрамжаар хангах, нас барагсдыг эрж хайх болон тэднийг дээрэмдүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар боломжтой бүх арга хэмжээг цаг ямагт, ялангуяа тулалдаан бүрийн дараа цаг алдалгүй авна.

Тухайн нөхцөл байдалд боломжтой бол тулалдааны талбарт үлдсэн шархтанг зөөж гаргах, солилцох болон тээвэрлэх бололцоо бий болгох зорилгоор найрамдах, гал түр зогсоохоор тохиролцох буюу орон нутгийн тохиролцоонд хүрнэ.

Үүний нэгэн адил өвчтөн, шархтанг бүслэгдсэн буюу тойруулагдсан газраас зөөж гаргах буюу солилцох, тухайн газар луу явж буй эмнэлгийн болон шашны ажилтан, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх талаар мөргөлдөөнд оролцогч талууд орон нутгийн тохиролцоонд хүрч болно.

#### *16 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн гарт орсон дайсны талын шархтан, өвчтөн буюу нас барсан этгээд бүрийн хэн болохыг тогтооход хэрэгтэй аливаа мэдээллийг аль болох түргэн бүртгэнэ. Ийм бүртгэлд боломжтой бол дараахь зүйлийг тусгана:

(a) уг этгээдийг харьяалах гүрэн;

(b) армийн, цэргийн ангийн, хувийн буюу серийн дугаар;

- (c) овог;
- (d) нэр буюу нэрс;
- (e) төрсөн он, сар, өдөр;
- (f) түүний үнэмлэх буюу таних пайзад байгаа аливаа бусад мэдээлэл;
- (g) олзлогдсон буюу нас барсан он, сар, өдөр болон газар;
- (h) шарх буюу өвчин, нас барсан шалтгааны талаархи мэдээлэл.

Дээр дурдсан мэдээллийг Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 122 дугаар зүйлд заасан мэдээллийн товчоонд аль болох түргэн хүргүүлнэ. Уг товчоо нь хамгаалагч гүрэн болон Дайнд олзлогдогчдын хэрэг эрхлэх төв байгууллагаар дамжуулан энэ мэдээллийг эдгээр этгээдийг харьяалах гүрэнд дамжуулна.

Мөргөлдөөнд оролцогч талууд нас барсны гэрчилгээ буюу нас барагсдын нэрсийн зохих ёсоор гэрчилсэн жагсаалтыг бэлтгэж дээрх товчоогоор дамжуулан бие биедээ илгээнэ. Тэд нас барагсдаас олдсон хоёрлосон таних пайзын хагас, гэрээслэл, нас барагчийн ойрын төрөл саданд чухал бусад баримт бичиг, мөнгө болон ерөнхийдөө эдийн болон сэтгэл санааны хувьд үнэт бүх зүйлийг цуглуулж мөн товчоогоор дамжуулан хүргүүлнэ. Эдгээр зүйлийг хэнийх болох нь танигдаагүй зүйлсийн хамт лацадсан боодолд хийж нас барсан эзнийг нь тогтооход шаардлагатай бүх мэдээлэл, түүнчлэн боодолд байгаа зүйлийн бүрэн жагсаалтыг дагалдуулан илгээнэ.

#### *17 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талууд тухайн нөхцөл байдалд боломжтой бол нас барагсдыг ганцаарчлан оршуулж буюу чандарлаж тэдний нас барсныг батлах, хэн болохыг тогтоох болон тайлан гаргах боломж бүрдүүлэх үүднээс цогцост урьдчилан нарийвчилсан үзлэг, боломжтой бол эмнэлгийн үзлэг хийх явдлыг хангана. Хоёрлосон пайзын хагасыг, эсхүл ганц таних пайз бол уг пайзыг цогцос дээр үлдээнэ.

Цогцсыг эрүүл ахуйн зайлшгүй шалтгаан, эсхүл нас барагсдын шашин шүтлэгийн шалтгаанаас бусад тохиолдолд чандарлаж болно. Чандарлах тохиолдолд чандарлах нөхцөл байдал болон шалтгааныг нас барсны гэрчилгээ буюу нас барагсдын баталгаат жагсаалтад нарийвчлан заана.

Тэд нас барагсдыг ёс төртэй, боломжтой бол шашны нь зан үйлийн дагуу оршуулах, булшийг хүндэтгэх, боломжтой бол нас барагсдын үндэс угсааг харгалзан бүлэглэн байрлуулах, зохих ёсоор хадгалах болон тэднийг хэзээд олж болохуйцаар тэмдэглэх явдлыг цаашид хангана. Эл зорилгоор, тэд хойшид цогцсыг хөндөхийг зөвшөөрөх, булшны байрлалаас үл хамааран цогцсыг таних тэмдгээр хангах, шарилыг эх оронд нь буцаах боломж олгох тээврийн хэрэгслээр хангах Булшны албан ёсны бүртгэлийн албыг дайтах ажиллагаа эхлэх үед байгуулна. Эдгээр заалт нь нас барагчийн эх орноос тавьсан хүсэлтийн дагуу зохих ёсоор шийдвэрлэх хүртэл Булшны бүртгэлийн албанд хадгалагдаж байгаа чандарт мөн адил хамаарна.



Нөхцөл байдал боломжтой болмогц, чингэхдээ цаад зах нь дайтах ажиллагааны эцэст эдгээр алба нь 16 дугаар зүйлийн 2 дахь догол мөрд дурдсан Мэдээллийн товчоогоор дамжуулан булш байгаа газар, тэмдэглэгээний жагсаалтыг түүнд оршуулсан нас барагчийн талаарх мэдээллийн хамт солилцоно.

### *18 дугаар зүйл*

Цэргийн эрх бүхий байгууллагууд тэдний өгсөн чиглэлийн дагуу шархтан, өвчтөнг сайн дураар олж авч, асрахыг орон нутгийн оршин суугчдад уриалж болох бөгөөд уриалгыг хүлээн авсан этгээдүүдэд шаардлагатай хамгаалалт, нөхцөл боломж олгоно. Хэрэв дайсагнагч тал тухайн газарт хяналт тогтоох буюу дахин хяналт тогтоовол эдгээр этгээдэд мөн адил хамгаалалт, нөхцөл боломж олгоно.

Цэргийн эрх бүхий байгууллагууд дайсан нэвтрэн орсон буюу эзлэгдсэн газарт байсан ч орон нутгийн оршин суугчид болон тусламжийн нийгэмлэгүүдэд аль ч үндэс угсааны шархтан буюу өвчтөнг сайн дураараа олж авч, асрахыг зөвшөөрнө. Энгийн иргэд эдгээр шархтан, өвчтөнг хүндэтгэх бөгөөд ялангуяа тэдэнд хүч хэрэглэхгүй.

Шархтан, өвчтөнг асран сувилсны төлөө хэнийг ч хэзээ ч дайран буруутгаж болохгүй.

Энэ зүйлийн заалтууд нь шархтан, өвчтөнд бие болон сэтгэл санааны тусламж дэмжлэг үзүүлэх үүргээс нь эзлэгч гүрнийг чөлөөлөхгүй.

## **III бүлэг**

### **ЭМНЭЛГИЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА**

### *19 дүгээр зүйл*

Эмнэлгийн албаны суурин байгууллага болон эмнэлгийн явуулын нэгжүүд рүү ямар ч нөхцөл байдалд довтолж болохгүй бөгөөд харин мөргөлдөөнд оролцогч талууд тэдгээрийг ямагт хүндэтгэж, хамгаална. Хэрэв тэдгээр нь дайсагнагч талын гарт орвол тэдгээр байгууллага, нэгжид олдсон шархтан, өвчтөнг тэднийг олзолсон гүрэн шаардлагатай асрамжаар хангах хүртэл уг байгууллага, нэгжийн ажилтнууд үүргээ гүйцэтгэсээр байх эрхтэй.

Дээрх эмнэлгийн байгууллага, нэгжийн аюулгүй байдал нь аль болох цэргийн объектын эсрэг халдлагад өртөхөөргүй байрласан байх явдлыг холбогдох эрх бүхий байгууллагууд хангана.

### *20 дугаар зүйл*

Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн үйлчлэлд багтах эмнэлгийн хөлөг онгоц уруу хуурай газраас довтолох ёсгүй.

### 21 дүгээр зүйл

Эмнэлгийн албаны суурин байгууллага, эмнэлгийн явуулын нэгжүүдийг хүмүүнлэгийн үүргээс гадуур дайсанд хортой үйлдэл хийхээр ашиглаагүй бол тэдгээрийн эдлэх хамгаалалтыг зогсоохгүй. Гэвч хамгаалалтыг зөвхөн тэдгээрт зохих бүх тохиолдолд боломжит хугацааны хязгаар зааж зохих ёсны сануулга өгсний дараа уг сануулгыг үл тоомсорлосон тохиолдолд зогсоож болно.

### 22 дугаар зүйл

Дараахь нөхцлийг 19 дүгээр зүйлээр эмнэлгийн нэгж буюу байгууллагад баталгаажуулан олгосон хамгаалалтыг үгүйсгэж байна гэж үзэхгүй:

(1) Нэгж, байгууллагын ажилтнууд өөрийгөө хамгаалах буюу өөрийн мэдэлд байгаа шархтан, өвчтөнг хамгаалах зорилгоор зэвсэгтэй байх.

(2) Зэвсэгтэй асрагч байхгүй үед нэгж буюу байгууллага нь харуул буюу манаагаар хамгаалагдсан байх.

(3) Шархтан, өвчтөнөөс авсан бөгөөд зохих зориулалтаар хараахан хураалгаагүй байсан жижиг зэвсэг болон байлдааны сум хэрэгслийг нэгж буюу байгууллагаас олох.

(4) Нэгж буюу байгууллагын салшгүй хэсэг болоогүй мал эмнэлгийн ажилтан, материалыг тухайн нэгж буюу байгууллагаас олох.

(5) Эмнэлгийн нэгж болон байгууллага, эсхүл тэдний ажилтнуудын явуулж буй хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь шархадсан буюу өвчтэй энгийн иргэдэд хамаарч байгаа.

### 23 дугаар зүйл

Тайван цагт хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд, дайтах ажиллагаа эхэлсний дараа түүнд оролцогч талууд өөрийн нутаг дэвсгэрт болон шаардлага бий болбол эзлэгдсэн газарт шархтан, өвчтөнг дайны аюулаас хамгаалахаар зохион байгуулагдах эмнэлгийн бүс болон орон нутгийн бүсийг байгуулахын сацуу эдгээр бүсийг зохион байгуулан удирдаж, тэнд цугларсан этгээдүүдийг асрах үүрэг бүхий ажилтнуудыг бий болгоно.

Дайтах ажиллагаа эхэлмэгц, эсхүл түүний явц дунд холбогдох талууд өөрийн байгуулсан эмнэлгийн бүс болон орон нутгийн бүсийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр байгуулж болно. Эл зорилгоор тэд энэхүү конвенцийн хавсралт болох хэлэлцээрийн төслийн заалтыг шаардлагатай гэж үзэж болох нэмэлт, өөрчлөлтийн хамт хэрэгжүүлж болно.

Эдгээр эмнэлгийн бүс, орон нутгийн бүсийг байгуулах, хүлээн зөвшөөрөх явдлыг хөнгөвчлөн дэмжих зорилгоор хамгаалагч гүрнүүд болон Олон улсын улаан загалмайн хороог оролцуулахаар урина.

IV бүлэг

**АЖИЛТНУУД**

*24 дүгээр зүйл*

Шархтан, өвчтөнг эрж хайх, олж авах, тээвэрлэх, эмчлэх буюу өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа гагцхүү эрхэлж буй эмнэлгийн ажилтнууд, түүнчлэн эмнэлгийн нэгж, байгууллагын үйл ажиллагаа гагцхүү эрхэлж буй ажилтнууд болон зэвсэгт хүчний дэргэд байгаа шашны төлөөлөгчдийг бүх нөхцөл байдалд хүндэтгэж, хамгаална.

*25 дугаар зүйл*

Хэрэгцээ гарсан тохиолдолд шархтан, өвчтөнг эрж хайх, олж авах, тээвэрлэх буюу эмчлэхэд асрагч, сувилагч, эсхүл зөөгчөөр ажиллахаар тусгайлан бэлтгэгдсэн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн дайсантай тулгарах буюу түүний гарт орох үед эдгээр үүргээ биелүүлж байгаа бол тэднийг мөн адил хүндэтгэж, хамгаална.

*26 дугаар зүйл*

24 дүгээр зүйлд заасан ажилтнуудын адил үүрэг биелүүлэхээр ажиллах, засгийн газар нь зохих ёсоор хүлээн зөвшөөрсөн бөгөөд эрх олгосон Үндэсний Улаан загалмайн нийгэмлэгийн ажилтнууд болон сайн дурын тусламжийн бусад нийгэмлэгийн ажилтнуудыг дээрх зүйлд заасан ажилтнуудтай адилтгаж үзэх бөгөөд чингэхдээ тэд цэргийн хууль, журмыг мөрдвөл зохино.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр өөрийн зэвсэгт хүчний эмнэлгийн албанд тусламж үзүүлэх эрхийг өөрийн хариуцлаган дор олгосон нийгэмлэгүүдийнхээ нэрийг тайван цагт эсхүл дайтах ажиллагаа эхлэх үед буюу түүний явц дунд, гэхдээ ямар ч тохиолдолд тэднийг ажиллуулахаасаа өмнө өөр хоорондоо мэдэгдэнэ.

*27 дугаар зүйл*

Төвийг сахисан орны хүлээн зөвшөөрөгдсөн нийгэмлэг нь зөвхөн өөрийн засгийн газраас урьдчилан авсан зөвшөөрөл болон мөргөлдөөнд оролцогч талын зөвшөөрөлтэйгөөр мөргөлдөөнд оролцогч талд өөрийн эмнэлгийн ажилтан, нэгжийн туслалцаа үзүүлж болно. Эмнэлгийн ийм ажилтан, нэгж нь мөргөлдөөнд оролцогч тухайн талын хяналтад байна.

Төвийг сахигч засгийн газар энэ зөвшөөрлийн талаар туслалцаа хүлээн авч буй улсын дайсагнагч талд мэдэгдэнэ. Ийм туслалцаа хүлээн авч буй мөргөлдөөнд оролцогч тал уг туслалцааг хүлээж авахаасаа өмнө энэ талаар дайсагнагч талдаа заавал мэдэгдэх үүрэгтэй.

Энэхүү туслалцааг ямар ч нөхцөл байдалд мөргөлдөөнд хөндлөнгөөс оролцож байна гэж үзэхгүй.

Эхний догол мөрд заасан ажилтнуудад өөрийн харьяалагдах төвийг сахисан орноос гарч явахын өмнө 40 дүгээр зүйлд заасан үнэмлэхийг зохих ёсоор олгосон байна.

### 28 дугаар зүйл

Дайсагнагч талын гарт орсон 24, 26 дугаар зүйлд заасан ажилтнуудыг дайнд олзлогдогчдын эрүүл мэндийн байдал, оюун санааны хэрэгцээ, тооноос шалтгаалан зөвхөн саатуулж байлгана.

Ийнхүү саатуулагдан байгаа ажилтнуудыг дайнд олзлогдогч гэж үзэхгүй. Гэсэн хэдий ч тэд наад зах нь Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн бүх заалтын давуу байдлыг эдлэнэ. Тэд олзлогч гүрний цэргийн хууль, журмын хүрээнд болон түүний эрх бүхий албаны удирдлаган дор мэргэжлийн ёс зүйдээ нийцүүлэн дайнд олзлогдогчдод, чингэхдээ аль болох өөрийн хамаарах зэвсэгт хүчний дайнд олзлогдогчдын тусын тулд эмнэлгийн болон оюун санааны үүргээ үргэлжлүүлэн биелүүлнэ. Тэд эмнэлгийн болон оюун санааны үүргээ биелүүлэхийн тулд дараахь нөхцөл боломжийг мөн эдлэнэ:

(а) Тэдэнд лагерийн гадна орших хөдөлмөр эрхлэх нэгж болон эмнэлэгт байгаа дайнд олзлогдогчдыг үе үе эргэхийг зөвшөөрнө. Олзлогч гүрэн тэднийг шаардлагатай тээврийн хэрэгслээр хангана.

(б) Лагерь бүрт хамгийн ахмад цолтой эмнэлгийн ахлах ажилтан саатуулагдан байгаа эмнэлгийн ажилтнуудын мэргэжлийн үйл ажиллагааны талаар лагерийн цэргийн эрх баригчдын өмнө хариуцлага хүлээнэ. Эл зорилгоор мөргөлдөөнд оролцогч талууд дайтах ажиллагаа эхэлсэн үеэс 26 дугаар зүйлд заасан нийгэмлэгийн ажилтнуудыг оролцуулан өөрийн эмнэлгийн ажилтнуудын цолны харьцааны талаар тохиролцоно. Тэдний үүргээс үүсэх бүхий л асуудлаар эмнэлгийн тухайн ажилтан болон шашны төлөөлөгчид лагерийн цэргийн болон эмнэлгийн эрх баригчидтай шууд харилцах боломжтой байх бөгөөд тэдгээр эрх баригчид нь эдгээр асуудлаар шаардагдаж болох нөхцөл боломжоор хангана.

(с) Хэдийгээр лагерьт саатуулагдан байгаа ажилтнууд лагерийн дотоод дэгд захирагдах боловч тэднийг эмнэлгийн болон шашны үүргээс гадуур аливаа ажил гүйцэтгэхийг шаардахгүй.

Дайтах ажиллагааны үед мөргөлдөөнд оролцогч талууд саатуулагдан байгаа ажилтнуудыг боломжтой үед солих талаар тохиролцож, ийнхүү солих талаар журам тогтооно.

Өмнөх заалтуудын аль нь ч олзлогч гүрнийг дайнд олзлогдогчидын эмнэлгийн болон шашны хэрэгцээг хангах талаар хүлээх үүргээс чөлөөлөхгүй.

### 29 дүгээр зүйл

Дайсны гарт орсон 25 дугаар зүйлд заасан ажилтнууд нь дайнд олзлогдогчид гэж тооцогдох боловч хэрэгцээ гарахын хэрээр тэднээр эмнэлгийн үүрэг гүйцэтгүүлнэ.

### *30 дугаар зүйл*

28 дугаар зүйлийн заалтын дагуу зайлшгүй саатуулах шаардлагагүй ажилтнуудыг тэднийг буцаах боломж гарч, цэргийн шаардлага тийм бололцоо олгомогц түүнийг харьяалах мөргөлдөөнд оролцогч талд нь буцаана.

Буцах нь хүлээгдэж буй ажилтнуудыг дайнд олзлогдогч гэж үзэхгүй. Гэсэн хэдий ч тэд наад зах нь Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн бүх заалтын давуу байдлыг эдлэнэ. Тэд дайсагнагч талын удирдлаган дор үүргээ үргэлжлүүлэн биелүүлэх бөгөөд өөрийг нь харьяалах мөргөлдөөнд оролцогч талын шархтан, өвчтөнг асрах ажилд аль болох оролцвол зохино.

Буцахдаа тэд эд хогшил, хувийн эд хөрөнгө, үнэт зүйлс, өөрийн багаж хэрэгслийг авч явна.

### *31 дүгээр зүйл*

30 дугаар зүйлийн дагуу буцаах эмнэлгийн ажилтнуудыг сонгохдоо арьс үндэс, шашин шүтлэг буюу улс төрийн үзэл бодлыг үл харгалзан харин тэднийг саатуулсан цаг хугацааны дараалал, эрүүл мэндийн байдлыг аль болох харгалзана.

Дайтах ажиллагаа эхэлсэн үеэс мөргөлдөөнд оролцогч талууд саатуулах ажилтнуудын хувь хэмжээг олзлогдогчдын тоо болон дээрх ажилтнуудыг лагерьт хуваарилах тоотой харьцуулан тусгай хэлэлцээрээр тодорхойлж болно.

### *32 дугаар зүйл*

Дайсагнагч талын гарт орсон 27 дугаар зүйлд заасан этгээдүүдийг саатуулж болохгүй.

Өөрөөр тохиролцоогүй бол тэднийг буцаах боломж гарч, цэргийн шаардлага тийм бололцоо олгомогц тэдэнд эх орондоо буцах, эсхүл энэ нь бололцоогүй бол алба хааж байсан мөргөлдөөнд оролцогч талынх нь нутаг дэвсгэрт буцахыг зөвшөөрнө.

Буцах нь хүлээгдэж буй хүмүүс дайсагнагч талын удирдлаган дор ажлаа үргэлжлүүлэх бөгөөд алба хааж байсан мөргөлдөөнд оролцогч талынхаа шархтан, өвчтөнг асрах ажилд аль болох оролцвол зохино. Буцахдаа тэд хувийн эд зүйлс, үнэт зүйлс, түүнчлэн өөрийн багаж хэрэгсэл, зэвсэг, боломжтой бол тээврийн хэрэгслээ авч явна.

Мөргөлдөөнд оролцогч талууд эдгээр ажилтан өөрийн нь мэдэлд байх хугацаанд тэднийг өөрийн зэвсэгт хүчний адилтгах ажилтнуудад олгодгийн адил хоол хүнс, байр, тэтгэмж, цалин хөлсөөр хангана. Хоол хүнс нь ямар ч тохиолдолд хэмжээ, чанар, төрөл зүйлийн хувьд дээрх ажилтны эрүүл мэндийн хэвийн байдлыг хадгалахад хүрэлцэхүйц хангалттай байна.

## **V бүлэг**

### **БАРИЛГА, МАТЕРИАЛ**

#### *33 дугаар зүйл*

Дайсны гарт орсон зэвсэгт хүчний эмнэлгийн явуулын нэгжийн материалыг шархтан, өвчтөнг асрахад зориулан хадгална.

Зэвсэгт хүчний эмнэлгийн суурин байгууллагын барилга, материал болон агуулах зэрэг нь дайны хуульд захирагдан үлдэх боловч тэдгээрийг шархтан, өвчтөнг асрахад шаардлагатай цагт өөр зорилгоор ашиглаж болохгүй. Гэсэн хэдий ч дайны талбарт байгаа хүчний командлагч нар цэргийн яаралтай шаардлага гарсан тохиолдолд тэдгээрийг ашиглаж болох бөгөөд чингэхдээ тэд тэнд сувилуулж байгаа шархтан, өвчтөнийг зохих асрамжаар урьдчилан хангасан байвал зохино.

Энэ зүйлд тодорхойлсон материал, агуулахыг санаатайгаар устгахгүй.

#### *34 дүгээр зүйл*

Уг конвенцоор олгох давуу байдалд хамрагдах тусламжийн нийгэмлэгүүдийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг хувийн өмч гэж үзнэ.

Дайны хууль, заншлаар хүлээн зөвшөөрөгдсөн дайтаж буй талуудын дайчлах эрхийг яаралтай шаардлагаас бусад тохиолдолд хэрэгжүүлэхгүй бөгөөд зөвхөн шархтан, өвчтөнийг зохих асрамжаар хангасны дараа хэрэгжүүлж болно.

## **VI бүлэг**

### **ЭМНЭЛГИЙН ТЭЭВЭР**

#### *35 дугаар зүйл*

Шархтан, өвчтөн болон эмнэлгийн тоног төхөөрөмжийн тээврийг эмнэлгийн явуулын нэгжийн нэгэн адил хүндэлж, хамгаална.

Ийм тээвэр, зөөврийн хэрэгсэл дайсагнагч талын гарт орвол тэдгээрийг саатуулсан мөргөлдөөнд оролцогч тал ямар ч тохиолдолд тэдгээрт байгаа шархтан, өвчтөнг зохих асрамжаар хангасан нөхцөлд л тэдгээр нь дайны хуулийн үйлчлэлд хамрагдана.

Энгийн иргэн ажилтнууд болон дайчлах замаар олж авсан тээврийн бүх хэрэгсэлд олон улсын эрх зүйн нийтлэг хэм хэмжээ үйлчилнэ.

*36 дугаар зүйл*

Эмнэлгийн агаарын хөлөг, өөрөөр хэлбэл гагцхүү шархтан, өвчтөнг шилжүүлэх, эмнэлгийн ажилтнууд болон тоног төхөөрөмжийг тээвэрлэх зорилгоор ашиглаж буй агаарын хөлөг руу халдаж болохгүй, харин дайтаж буй холбогдох талуудын хооронд тусгайлан тохиролцсон өндөр, хугацаа, замаар нисч байх үед дайтаж буй талууд түүнд хүндэтгэлтэй хандана.

Агаарын хөлгийг 38 дугаар зүйлд заасан ялгах бэлгэ тэмдгээр тэдгээрийн доод, дээд, хажуу талд үндэсний далбааны өнгөний хамт тод тэмдэглэсэн байна. Тэдгээрт дайтах ажиллагаа эхлэх буюу явагдах үед дайтаж буй талуудын хооронд тохиролцсон аливаа бусад тэмдэг буюу таних хэрэгсэл хэрэглэж болно.

Өөрөөр тохиролцоогүй бол дайсны нутаг дэвсгэр буюу түүний эзэлсэн нутаг дэвсгэр дээгүүр нисэхийг хориглоно.

Эмнэлгийн агаарын хөлөг газардах аливаа шаардлагад захирагдана. Ийнхүү газардах болсон тохиолдолд хэрэв үзлэг хийсэн бол үзлэг хийсний дараа агаарын хөлөг нь зорчигчдынхоо хамт нислэгээ үргэлжлүүлж болно.

Дайсны нутаг дэвсгэр буюу түүний эзэлсэн нутаг дэвсгэрт газардахад хүрсэн тохиолдолд өвчтөн, шархтан болон агаарын хөлгийн багийнхан дайнд олзлогдогчид болно. Эмнэлгийн ажилтнуудтай 24 дүгээр зүйл болон түүний дараахь зүйлийн дагуу харьцана.

*37 дугаар зүйл*

Дараагийн догол мөрний заалтын дагуу мөргөлдөөнд оролцогч талуудын эмнэлгийн агаарын хөлөг төвийг сахисан гүрнүүдийн нутаг дэвсгэр дээгүүр нисэж өнгөрөх, шаардлагатай тохиолдолд газардах, эсхүл түр бууж болно. Тэд тухайн нутаг дэвсгэр дээгүүр нь өнгөрөх талаар төвийг сахисан гүрэнд урьдчилан мэдэгдэх бөгөөд газардах буюу усан дээр буух аливаа шаардлагад захирагдана. Тэд зөвхөн мөргөлдөөнд оролцогч талууд болон төвийг сахисан холбогдох гүрэнтэй тохиролцсон зам, өндөр, хугацааг баримтлан нислэг хийх тохиолдолд халдлагаас хамгаалагдана.

Гэвч төвийг сахисан гүрнүүд эмнэлгийн агаарын хөлөг нутаг дэвсгэр дээгүүр нь нисэж өнгөрөх буюу нутаг дэвсгэрт нь газардахад болзол, хязгаар тогтоож болно. Ийнхүү тогтоож болох болзол, хязгаарыг мөргөлдөөнд оролцогч бүх талд адил тэгш хэрэглэнэ.

Төвийг сахисан гүрнүүд, мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд өөрөөр тохиролцоогүй бол орон нутгийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр төвийг сахигч нутаг дэвсгэрт эмнэлгийн агаарын хөлгөөр буусан шархтан, өвчтөнг дайны ажиллагаанд дахин оролцуулахгүйгээр олон улсын эрх зүйн дагуу шаардлагатай тохиолдолд төвийг сахисан гүрэн саатуулна. Шархтан, өвчтөнг эмнэлэгт хэвтүүлэх, тусгаарлан хорихтой холбогдсон зардлыг тэднийг харьяалж буй гүрэн хариуцна.

## **VII бүлэг**

### **ЯЛГАХ БЭЛГЭ ТЭМДЭГ**

#### *38 дугаар зүйл*

Швейцари Улсад хүндэтгэл үзүүлж, Холбооны далбааны өнгийг сольж байрлуулах замаар бүрдсэн цагаан дэвсгэр дээрх улаан загалмай бүхий сүлд тэмдгийг зэвсэгт хүчний эмнэлгийн албаны бэлгэ тэмдэг болон ялгах тэмдэг хэвээр үлдээнэ.

Гэсэн хэдий ч улаан загалмайн оронд цагаан дэвсгэр дээр улаан хавирган сар, улаан арслан болон нарыг бэлгэ тэмдэг болгон хэрэглэдэг орнуудын хувьд энэхүү конвенцийн нөхцөлөөр тэдгээр бэлгэ тэмдгийг мөн хүлээн зөвшөөрнө.

#### *39 дүгээр зүйл*

Цэргийн эрх бүхий байгууллагын далбаа, гарын таних тэмдэг болон эмнэлгийн албанд хэрэглэх бүх тоног төхөөрөмжид тавина.

#### *40 дүгээр зүйл*

24, 26, 27 дугаар зүйлд заасан ажилтнууд цэргийн эрх бүхий байгууллагаас тамга дарж олгосон ялгах бэлгэ тэмдэг бүхий усанд гэмтэхгүй гарын таних тэмдгийг зүүн гартаа зүүнэ.

Эдгээр ажилтан нь 16 дугаар зүйлд заасан таних пайз зүүхээс гадна ялгах бэлгэ тэмдэг бүхий тусгай үнэмлэх авч явах ёстой. Энэ үнэмлэх нь усанд гэмтэхгүй бөгөөд халаасанд авч явж болохуйц хэмжээтэй байна. Түүнд наад зах нь эзэмшигчийн овог, нэр, төрсөн он, сар, өдөр, цол зэрэг болон цэргийн ангийн дугаарыг зааж үндэсний хэлээр бичих бөгөөд энэхүү конвенцоор ямар хэмжээгээр хамгаалагдах эрхтэй болохыг тодорхойлно. Уг үнэмлэхэд эзэмшигчийн гэрэл зураг, түүнчлэн гарын үсэг буюу хурууны хээ, эсхүл аль аль нь байна. Тэр нь цэргийн эрх бүхий байгууллагын товгор тамгатай байна.

Нэг зэвсэгт хүчний үнэмлэх нь ижил байх бөгөөд хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын зэвсэгт хүчний үнэмлэх нь боломжийн хэрээр төсөөтэй хэлбэртэй байна. Мөргөлдөөнд оролцогч талууд энэхүү конвенцид жишээ болгон хавсаргасан загварыг удирдлага болгож болно. Тэд хэрэглэж буй загвараа дайтах ажиллагаа эхлэхэд өөр хоорондоо мэдээлнэ. Үнэмлэхийг боломжтой тохиолдолд наад зах нь хоёр хувь үйлдэж нэг хувийг тухайн этгээдийн эх оронд нь хадгална.

Дурдсан ажилтнуудыг таних тэмдэг буюу үнэмлэхээс нь, түүнчлэн гарын таних тэмдэг зүүх эрхээс нь ямар ч нөхцөл байдалд салгаж болохгүй. Тэдгээрийг алдаж үрэгдүүлсэн тохиолдолд тэд үнэмлэхийн хувийг авч, таних тэмдгийг солих эрх эдлэнэ.



*41 дүгээр зүйл*

25 дугаар зүйлд заасан ажилтнууд дундаа жижиг хэмжээний ялгах тэмдэг бүхий цагаан өнгөтэй гарын таних тэмдэг зүүх, гэхдээ зөвхөн эмнэлгийн үүргээ гүйцэтгэж байхдаа зүүх бөгөөд гарын таних тэмдгийг цэргийн эрх бүхий байгууллагаас тамга дарж олгоно.

Ийм төрлийн ажилтнуудын авч явах цэргийн үнэмлэхэд тэдний хамрагдсан тусгай бэлтгэл, тэдний гүйцэтгэж буй үүргийн түр шинж чанар болон гарын таних тэмдэг зүүх эрхийг заана.

*42 дугаар зүйл*

Конвенцийн ялгах далбааг зөвхөн Конвенцийн дагуу хүндэтгэл эдлэх эрхтэй эмнэлгийн нэгж, байгууллагад зөвхөн цэргийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр мандуулна. Явуулын нэгжүүд суурин байгууллагын адил тухайн нэгж буюу байгууллагын хамаарагдах мөргөлдөөнд оролцогч талын үндэсний далбааг давхар мандуулж болно.

Гэсэн хэдий ч дайсны гарт орсон эмнэлгийн нэгжүүд Конвенцийн далбаагаас өөр далбаа мандуулахгүй. Мөргөлдөөнд оролцогч талууд дайны аливаа үйлдлээс зайлсхийхийн тулд эмнэлгийн нэгж, байгууллагын ялгах бэлгэ тэмдгийг дайсны хуурай зам, агаар болон тэнгэсийн хүчнийхэнд тод харагдуулахад шаардлагатай арга хэмжээг цэргийн шаардлагын хүрээнд авна.

*43 дугаар зүйл*

Дайтаж байгаа аль нэг талд 27 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу туслалцаа үзүүлэхээр зөвшөөрөгдсөн байж болох төвийг сахисан оронд харьяалагдах эмнэлгийн нэгжүүд нь дайтаж байгаа тухайн тал 42 дугаар зүйлээр олгогдсон эрхээ эдлэж байгаа үед Конвенцийн далбааны сацуу дайтаж байгаа тухайн талын үндэсний далбааг мандуулна.

Цэргийн эрх бүхий холбогдох байгууллагаас гаргасан эсрэг утгатай тушаалыг мөрдөхийн хамт тэд бүх тохиолдолд, дайсагнагч талын гарт орсон байсан ч үндэсний далбаагаа мандуулж болно.

*44 дүгээр зүйл*

Энэ зүйлийн дараагийн догол мөрүүдэд дурдсанаас бусад тохиолдолд цагаан дэвсгэр дээрх улаан загалмайн бэлгэ тэмдэг бөгөөд “Улаан загалмай” буюу “Женевийн загалмай” гэсэн үгийг энэхүү конвенцоор болон төсөөтэй асуудал зохицуулсан бусад конвенцоор хамгаалагдсан эмнэлгийн нэгж, байгууллага, ажилтнууд болон материалыг заах буюу хамгаалахаас бусад тохиолдолд тайван цаг буюу дайны үед хэрэглэж болохгүй. 38 дугаар зүйлийн 2 дахь догол мөрд заасан бэлгэ тэмдгийг хэрэглэж буй орнуудын хувьд мөн адил зарчмыг баримтална. Үндэсний Улаан загалмайн нийгэмлэг болон 26 дугаар зүйлд заасан бусад нийгэмлэг зөвхөн энэ догол мөрийн хүрээнд Конвенцийн хамгаалалтыг олгох ялгах бэлгэ тэмдгийг хэрэглэх эрхтэй байна.

Цаашилбал, Үндэсний Улаан загалмайн (Улаан хавирган сар, Улаан арслан болон нарны) нийгэмлэг нь Олон улсын улаан загалмайн бага хурлуудаас гаргасан зарчимд нийцсэн бусад үйл ажиллагаандаа Улаан загалмайн нэр, бэлгэ тэмдгийг үндэснийхээ хууль тогтоомжид нийцүүлэн тайван цагт хэрэглэж болно. Ийм үйл ажиллагааг дайны үед хэрэгжүүлж байгаа тохиолдолд бэлгэ тэмдгийг хэрэглэх нөхцөл нь Конвенцийн хамгаалалтыг олгож байна гэж үзэхгүй байхаар байна; ийм ялгах тэмдэг нь харьцангуй жижиг хэмжээтэй бөгөөд түүнийг гарын таних тэмдэг буюу барилгын дээвэр дээр байрлуулж болохгүй.

Олон улсын улаан загалмайн байгууллагууд болон тэдний зохих ёсоор эрх олгогдсон ажилтнуудад цагаан дэвсгэр дээрх улаан загалмайн ялгах тэмдгийг ямагт хэрэглэхийг зөвшөөрнө.

Үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн, түүнчлэн Үндэсний улаан загалмайн (Улаан хавирган сар, Улаан арслан болон нарны) нийгэмлэгүүдийн аль нэгний шууд зөвшөөрөлтэйгөөр Конвенцийн бэлгэ тэмдгийг тайван цагт эмнэлгийн түргэн тусламжид хэрэглэх тээврийн хэрэгслийг таних бөгөөд гагцхүү шархтан, өвчтөнд үнэ төлбөргүй эмчилгээ хийхэд зориулагдсан тусламжийн газрын байрлалыг тэмдэглэхэд онцгой арга хэмжээний хувьд ашиглаж болно.

## **VIII бүлэг**

### **КОНВЕНЦИЙГ БИЕЛҮҮЛЭХ**

#### *45 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч тал бүр энэхүү конвенцийн нийтлэг зарчимд нийцүүлэн ерөнхий командлагчаараа дамжуулан өмнөх зүйлүүдийн нарийвчилсан биелэлтийг хангаж, урьдчилан харах боломжгүй тохиолдолд ч биелэлтийг хангана.

#### *46 дугаар зүйл*

Конвенцоор хамгаалсан өвчтөн, шархтан, ажилтнууд болон барилга, багаж тоног төхөөрөмжийн эсрэг өширхөн халдахыг хориглоно.

#### *47 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн зарчмыг нийт хүн ам, ялангуяа дайтаж байгаа зэвсэгт хүчин, эмнэлгийн ажилтан болон шашны төлөөлөгчдөд таниулах үүднээс энэхүү конвенцийн эх бичвэрийг өөрийн оронд аль болох өргөнөөр түгээн сурталчлах, тухайлбал түүний талаар цэргийн, боломжтой бол иргэний сургалтын хөтөлбөрт оруулах үүргийг дайны цагийн адил тайван цагт хүлээнэ.

#### *48 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн албан ёсны орчуулга болон түүнийг хэрэглэх явдлыг хангахын тулд баталж болох хууль, журмыг тайван цагт

Швейцарийн холбооны зөвлөлөөр, дайтах ажиллагааны үед хамгаалагч гүрнээр дамжуулан өөр хоорондоо өгнө.

## IX бүлэг

### УРВУУЛАН АШИГЛАХ, ЗӨРЧИХ ЯВДЛЫГ ТАСЛАН ЗОГСООХ

#### 49 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд дараагийн зүйлд тодорхойлсон энэхүү конвенцийн ноцтой зөрчлийг үйлдэж байгаа буюу үйлдэхийг тушаасан этгээдэд үр дүнтэй эрүүгийн ял хүлээлгэхэд шаардлагатай аливаа хууль тогтоомжийг батлах үүрэг хүлээнэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр ийм ноцтой зөрчлийг үйлдсэн буюу үйлдэхийг тушаасан гэж буруутгагдаж байгаа этгээдийг эрж олох, түүний харьяаллыг үл харгалзан өөрийн шүүхэд шилжүүлэх үүрэг хүлээнэ. Тухайн тал хүсвэл өөрийн хууль тогтоомжийн заалтад нийцүүлэн тийм этгээдийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд өөр холбогдох талын шүүхэд шилжүүлж болох бөгөөд чингэхдээ хэлэлцэн тохирогч эрхэм дээд тухайн тал нь *prima facie* хэрэг үүсгэсэн байвал зохино.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр дараагийн зүйлд тодорхойлсон ноцтой зөрчлөөс бусад энэхүү конвенцийн заалтад харш бүх үйлдлийг таслан зогсооход шаардлагатай арга хэмжээг авна.

Яллагдаж байгаа этгээд ямар ч нөхцөл байдалд Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 105 дугаар зүйл болон түүний дараагийн зүйлүүдэд зааснаас дордуулахааргүй шүүх болон өмгөөллийн зохих ажиллагааны баталгаа эдэлнэ.

#### 50 дугаар зүйл

Өмнөх зүйлд дурдсан ноцтой зөрчил нь энэхүү конвенцоор хамгаалагдаж байгаа этгээд буюу эд хөрөнгийн эсрэг үйлдсэн дараахь аливаа үйлдлийг оролцуулсан зөрчил байна: санаатайгаар амийг нь хөнөөх, эрүүдэн шүүх буюу хүнлэг бусаар харьцах, түүний дотор биологийн туршилт хийх, бие махбодь буюу эрүүл мэндэд үлэмж шаналал буюу ноцтой гэмтэл санаатайгаар учруулах, түүнчлэн дайны шаардлагаар зөвтгөх боломжгүйгээр бөгөөд хууль бусаар болон дур зоргоор эд хөрөнгө их хэмжээгээр эвдэж сүйтгэх буюу ашиглан завших.

#### 51 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аль ч талд өмнөх зүйлд дурдсан зөрчлийн талаар өөрөө хүлээсэн буюу хэлэлцэн тохирогч эрхэм дээд өөр талаас хүлээлгэх хариуцлагаас өөрийгөө буюу хэлэлцэн тохирогч эрхэм дээд өөр талыг чөлөөлөхийг зөвшөөрөхгүй.

*52 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талын хүсэлтээр мөрдөн байцаалтыг сонирхогч талуудын хооронд тохиролцсон журмаар энэхүү конвенцийн аливаа зөрчилтэй холбогдуулан эхлүүлнэ.

Хэрэв мөрдөн байцаалтын журмын талаар тохиролцоонд хүрч чадаагүй бол талууд дагаж мөрдөх журмыг шийдвэрлэх зуучлагчийг тохиролцон сонгоно.

Нэгэнт зөрчил гарсныг тогтоосон тохиолдолд мөргөлдөөнд оролцогч талууд түүнийг дуусгавар болгож, аль болох хойшлуулахгүй таслан зогсооно.

*53 дугаар зүйл*

Энэхүү конвенцийн дагуу эрх олгогдсоноос бусад хувь хүн, нийгэмлэг, улсын буюу хувийн пүүс, компани бэлгэ тэмдэг буюу “Улаан загалмай” буюу “Женевийн загалмай”, эсхүл тэдгээрийг дуурайлгасан аливаа тэмдэг буюу нэрийг хэрэглэсэн зорилго, өдрөөс үл хамааран хэдийд ч хэрэглэхийг хориглоно.

Холбооны далбааны өнгийг сольж байрлуулан хэрэглэж Швейцари Улсыг хүндэтгэх шалтгаанаар, түүнчлэн Швейцарийн сүлд болон Конвенцийн ялгах бэлгэ тэмдэгтэй андуурч болох шалтгаанаар Швейцарийн Холбооны Улсын сүлд, эсхүл түүнийг дуурайлгасан тэмдгийг хувь хүн, нийгэмлэг буюу пүүс барааны буюу худалдааны тэмдэг буюу ийм тэмдгийн хэсэг болгон, эсхүл худалдааны шударга ёсонд харшлах зорилгоор, эсхүл Швейцарийн үндэсний үзлийг хөндөх нөхцөл байдалд хэрэглэхийг хэдийд ч хориглоно.

Гэсэн хэдий ч 1929 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн Женевийн конвенцид оролцогч бус байсан хэлэлцэн тохирогч эрхэм дээд ийм талууд эхний догол мөрд заасан бэлгэ тэмдэг, нэр, таних тэмдэг буюу тэмдгийг өмнө нь хэрэглэж байсан этгээдүүдэд тэдгээр тэмдгийг тийнхүү хэрэглэхийг зогсооход зориулан энэхүү конвенц хүчин төгөлдөр болсноос хойш гурван жилээс хэтрэхгүй хугацааг олгож болох бөгөөд чингэхдээ тийнхүү хэрэглэх нь дайны цагт конвенцийн хамгаалалт олгох зорилготой байсан гэж үзэхээргүй байвал зохино.

Энэ зүйлийн эхний догол мөрд заасан хоригийг өмнө нь тэдгээр тэмдгийг хэрэглэж байснаас олж авсан аливаа эрхийг үл хөндөн 38 дугаар зүйлийн хоёр дахь догол мөрд дурдсан бэлгэ тэмдэг, тэмдгүүдэд мөн хэрэглэнэ.

*54 дүгээр зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд хэрэв хууль тогтоомж нь хараахан тохирохгүй байгаа бол 53 дугаар зүйлд дурдсанаар тэмдэг урвуулан хэрэглэхээс ямагт урьдчилан сэргийлж, таслан зогсоох талаар шаардлагатай арга хэмжээг авна.

## ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ

### *55 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг англи, франц хэлээр үйлдэв. Хоёр эх бичвэр нь адил хүчинтэй байна.

Швейцарийн холбооны зөвлөл Конвенцийн орос, испани хэлний албан ёсны орчуулгыг зохион байгуулна.

### *56 дугаар зүйл*

Энэ өдрийн он, сар, өдрөөр тэмдэглэгдэх энэхүү конвенц 1949 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Женев хотноо нээгдсэн бага хуралд оролцсон гүрнүүд, түүнчлэн уг бага хуралд оролцоогүй боловч Дайны талбарт цэргийн шархадсан ба өвчтэй этгээдэд тусламж үзүүлэх тухай 1864, 1906 буюу 1929 оны Женевийн конвенцуудад оролцогч болох гүрнүүдийн нэрийн өмнөөс 1950 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

### *57 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг аль болох түргэн соёрхон батлах бөгөөд батламж жуух бичгийг Берн хотноо хадгалуулна.

Швейцарийн холбооны зөвлөл хадгалуулахаар өгсөн батламж жуух бичиг бүрийн бүртгэл хөтөлж, энэ бүртгэлийн баталгаатай хуулбарыг нэрийн нь өмнөөс конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсноо мэдэгдсэн бүх гүрэнд дамжуулна.

### *58 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь хоёроос доошгүй батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Түүнээс хойш энэ нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрийн хувьд батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

### *59 дүгээр зүйл*

Энэхүү конвенц нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын хоорондын харилцаанд 1864 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн, 1906 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн болон 1929 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн конвенцийг орлоно.

### *60 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш түүнд нэрийн нь өмнөөс гарын үсэг зураагүй аливаа гүрний хувьд нэгдэн ороход нээлттэй байна.

*61 дүгээр зүйл*

Нэгдэж орсноо Швейцарийн холбооны зөвлөлд бичгээр мэдэгдэх бөгөөд ийнхүү нэгдэж орсон нь тухайн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Швейцарийн холбооны зөвлөл нэгдэн орсон талаар нэрийн нь өмнөөс Конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсноо мэдэгдсэн бүх гүрэнд мэдэгдэнэ.

*62 дугаар зүйл*

Дайтах ажиллагаа буюу эзлэлт эхлэхээс өмнө буюу эхэлсний дараа мөргөлдөөнд оролцогч талуудын хадгалуулсан батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай мэдэгдэл 2, 3 дугаар зүйлд заасан тохиолдолд нэн даруй хүчин төгөлдөр болно. Швейцарийн холбооны зөвлөл мөргөлдөөнд оролцогч талуудаас хүлээн авсан соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай аливаа мэдэгдлийг хамгийн түргэн аргаар хүргүүлнэ.

*63 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр энэхүү конвенцийг цуцлах эрхтэй.

Цуцлах тухайгаа Швейцарийн холбооны зөвлөлд бичгээр мэдэгдэх бөгөөд түүнийг Швейцарийн холбооны зөвлөл хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талын засгийн газарт дамжуулна.

Цуцлалт нь цуцлах тухай Швейцарийн холбооны зөвлөлд мэдэгдсэнээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно. Гэвч цуцалж буй гүрэн мөргөлдөөнд оролцож байгаа үед цуцлах тухай мэдэгдсэн тохиолдолд цуцлалт нь энх тайван зарлах болон энэхүү конвенцоор хамгаалагдах этгээдүүдийг суллаж, эх оронд нь буцаах ажиллагаа дуусах хүртэл хүчин төгөлдөр болохгүй.

Цуцлалт нь зөвхөн цуцалж буй гүрний хувьд хүчинтэй байна. Энэ нь дэлхийн соёл иргэншилт ард түмнүүдийн хооронд тогтсон заншил, хүнлэг ёсны хууль болон олон нийтийн ухамсарт ёс суртахуунаас үндэстэй олон улсын эрх зүйн зарчмын дагуу мөргөлдөөнд оролцогч талуудын заавал биелүүлэх ёстой хэвээр байх үүрэгт хэрхэвч нөлөөлөхгүй.

*64 дүгээр зүйл*

Швейцарийн холбооны зөвлөл энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ. Мөн Швейцарийн холбооны зөвлөл нь энэхүү конвенцийг соёрхон батласан, түүнд нэгдэж орсон болон түүнийг цуцалсан тухай мэдэгдлийг хүлээн авсан талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлнэ.

Дээр дурдсаныг нотолж дор гарын үсэг зурагчид бүрэн эрхээ хадгалуулж энэхүү конвенцид гарын үсэг зурцгаав.

1949 оны 8 дугаар сарын арван хоёрны өдөр Женев хотноо англи, франц хэлээр үйлдэв. Жинхэнэ эхийг Швейцарийн Холбооны Улсын архивт хадгална. Швейцарийн холбооны зөвлөл түүний баталгаатай хуулбарыг гарын үсэг зурсан болон нэгдэж орсон улс бүрт дамжуулна.

## **I ХАВСРАЛТ**

### **ЭМНЭЛГИЙН БҮС БОЛОН ОРОН НУТГИЙН БҮСЭД ХАМААРАХ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСӨЛ**

#### *1 дүгээр зүйл*

Эмнэлгийн бүсийг зөвхөн Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 23 дугаар зүйлд заасан этгээдүүд, мөн эдгээр бүсийг зохион байгуулан удирдаж, тэнд цугларсан этгээдүүдийг асрах үүрэг бүхий ажилтнуудад зориулна.

Гэсэн хэдий ч ийм бүсийн дотор байнга оршин суугчид тэндээ үлдэх эрхтэй байна.

#### *2 дугаар зүйл*

Эмнэлгийн бүсэд аливаа эрхтэйгээр оршин суугаа ямар ч этгээд уг бүсийн дотор буюу гадна цэргийн үйл ажиллагаатай буюу дайны материал үйлдвэрлэхтэй шууд холбоотой ажил гүйцэтгэхгүй.

#### *3 дугаар зүйл*

Эмнэлгийн бүс байгуулж байгаа гүрэн тухайн бүсэд оршин суух буюу түүнд нэвтрэх эрхгүй бүх этгээдийг оруулахыг хориглох талаар шаардлагатай бүх арга хэмжээг авна.

#### *4 дүгээр зүйл*

Эмнэлгийн бүс нь дараахь нөхцлийг хангасан байна:

(a) Тухайн бүсийг байгуулсан гүрний захирч буй нутаг дэвсгэрийн зөвхөн бага хэсгийг бүрдүүлж байх;

(b) Байрны боломжтой харьцуулахад цөөн хүн амтай байх;

(c) Цэргийн бүх объект, эсхүл аж үйлдвэр буюу захиргааны томоохон байгууллагаас алслагдсан газар орших бөгөөд тийм объект, байгууллагагүй байх;

(d) Аливаа магадлалаас хамааран дайны ажиллагаа явуулахад чухал болж болох газарт байрлаагүй байх.

*5 дугаар зүйл*

Эмнэлгийн бүс нь дараахь үүргийг хүлээнэ:

(а) Эдгээр бүсийн эзэмшиж буй зам харилцаа болон тээврийн хэрэгслийг цэргийн ажилтан буюу материал тээвэрлэхэд дамжин өнгөрүүлэхээр ч байсан ашиглаж болохгүй;

(б) Тэдгээрийг ямар ч тохиолдолд цэргийн аргаар хамгаалахгүй.

*6 дугаар зүйл*

Эмнэлгийн бүсийг бүсийн зах болон барилга дээр байрлуулсан цагаан дэвсгэр дээрх улаан загалмай (улаан хавирган сар, улаан арслан болон нар)-гаар тэмдэглэнэ. Тэдгээрийг мөн адилаар шөнийн цагт зохих гэрэлтүүлгийн аргаар тэмдэглэж болно.

*7 дугаар зүйл*

Гүрнүүд захирч байгаа нутаг дэвсгэрт нь байгаа эмнэлгийн бүсийн жагсаалтыг тайван цагт буюу дайны ажиллагаа эхлэхэд хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талд хүргүүлнэ. Түүнчлэн тэд дайтах ажиллагааны үед байгуулсан аливаа шинэ бүсийн тухай мэдэгдэнэ.

Дайсагнагч тал дээр дурдсан мэдэгдлийг хүлээн авмагц бүсийг зохих ёсоор байгуулна.

Гэвч хэрэв дайсагнагч тал энэхүү хэлэлцээрийн нөхцөл хангагдаагүй гэж үзвэл тухайн бүсийг хариуцаж буй талд нэн даруй мэдэгдэх замаар бүсийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж эсхүл бүсийг хүлээн зөвшөөрөх асуудлыг 8 дугаар зүйлд заасан хяналтыг бий болгохоос хамааруулж болно.

*8 дугаар зүйл*

Дайсагнагч талын байгуулсан эмнэлгийн нэг буюу хэд хэдэн бүсийг хүлээн зөвшөөрсөн аливаа гүрэн эдгээр бүс нь энэхүү хэлэлцээрт заасан нөхцөл, үүргийг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор нэг буюу хэд хэдэн тусгай комиссараар хяналт тавихыг шаардах эрх эдлэнэ.

Эл зорилгоор тусгай комиссын гишүүд нь хэдийд ч янз бүрийн бүсэд чөлөөтэй нэвтрэх бөгөөд тэнд байнга оршин сууж ч болно. Тэдэнд шалгалт хийх үүргээ биелүүлэх бүх нөхцөл боломжийг олгоно.

*9 дүгээр зүйл*

Тусгай комиссын гишүүд энэхүү хэлэлцээрийн нөхцөлд харшилж байна гэж үзэж буй аливаа үйл баримт анзаарвал тухайн бүсийг захирч буй гүрний анхаарлыг уг үйл баримтад даруй хандуулах бөгөөд байдлыг засаж залруулахад тав хоногийн хугацаа олгоно. Тэд бүсийг хүлээн зөвшөөрсөн гүрэнд энэ тухай зохих ёсоор мэдэгдэнэ.



Хэрэв хугацаа дуусахад бүсийг захирч буй гүрэн сануулгыг биелүүлээгүй бол дайсагнагч тал тухайн бүсийн хувьд энэхүү хэлэлцээрийг цаашид заавал биелүүлэх үүрэггүйгээ мэдэгдэж болно.

*10 дугаар зүйл*

Нэг буюу хэд хэдэн эмнэлгийн бүс болон орон нутгийн бүс байгуулж аливаа гүрэн, түүнчлэн эдгээр бүс байгаа тухай мэдэгдсэн дайсагнагч талууд 8, 9 дүгээр зүйлд дурдсан тусгай комиссын гишүүд болох этгээдүүдийг нэр дэвшүүлнэ эсхүл төвийг сахигч гүрнээр нэр дэвшүүлүүлнэ.

*11 дүгээр зүйл*

Эмнэлгийн бүс рүү ямар ч нөхцөл байдалд халдаж болохгүй. Мөргөлдөөнд оролцогч талууд эдгээр бүсийг ямагт хамгаалж, хүндэтгэнэ.

*12 дугаар зүйл*

Нутаг дэвсгэрийг эзлэсэн тохиолдолд түүний дотор байгаа эмнэлгийн бүсийг хүндэтгэж, зориулалтаар ашигласан хэвээр байна.

Гэвч эзлэгч гүрэн тухайн бүсэд байрлуулсан этгээдүүдийн аюулгүй байдлыг хангах бүх арга хэмжээг авсан нөхцөлд бүсийн зориулалтыг өөрчилж болно.

*13 дугаар зүйл*


Гүрнүүд эмнэлгийн бүсийн зориулалтын адил зориулалтаар ашиглаж байгаа орон нутгийн бүсэд энэхүү хэлэлцээрийг мөн хэрэглэж болно.

## II ХАВСРАЛТ

Зэвсэгт хүчний дэргэдэх  
эмнэлгийн болон шашны ажилтнуудад олгох үнэмлэх

### Нүүрэн тал

(Энэ үнэмлэхийг олгож буй орон, цэргийн  
эрх бүхий байгууллагын нэр бичихэд зориулсан зай)



Зэвсэгт хүчний дэргэдэх  
эмнэлгийн болон шашны ажилтнуудад олгох  
**ҮНЭМЛЭХ**

Овог .....

Нэр .....

Төрсөн он, сар, өдөр .....

Цол, зэрэг .....

Цэргийн ангийн дугаар .....

Энэхүү үнэмлэхийг эзэмшигч нь Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний  
өвчтөн, шархтны нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын  
12-ны өдрийн Женевийн конвенцоор ..... хувьд хамгаалагдах  
болно.

.....  
Олгосон он, сар, өдөр

.....  
Үнэмлэхийн дугаар

**Ар тал**

Үнэмлэх  
эзэмшигчийн  
гэрэл зураг

Үнэмлэх эзэмшигчийн гарын үсэг буюу  
хурууны хээ, эсхүл аль аль нь

Үнэмлэх олгож  
буй цэргийн эрх  
бүхий  
байгууллагын  
товгор тамга

Өндөр

Нүд

Үс

Бусад содон тэмдэг

**89. ТЭНГИСИЙН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШАРХТАН, ӨВЧТӨН БОЛОН ХӨЛӨГ  
ОНГОЦНЫ СҮЙРЭЛД ӨРТӨГДӨГСДИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ  
ТУХАЙ ЖЕНЕВИЙН (II) КОНВЕНЦ**

*1949 оны 8 дугаар сарын 12-ны өдөр баталж,  
1950 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон\**

Удиртгал

1906 оны Женевийн конвенцийн зарчмыг далайд дайтахад зохицуулан хэрэглэх 1907 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Гаагийн X конвенцийг хянан өөрчлөх зорилгоор 1949 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс 8 дугаар сарын 12-ны өдөр хүртэл Женев хотноо болсон Дипломат бага хуралд засгийн газраа төлөөлж дор гарын үсэг зурсан бүрэн эрхт төлөөлөгчид дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

**I бүлэг**

**НИЙТЛЭГ ЗААЛТ**

*1 дүгээр зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийг бүх нөхцөл байдалд хүндэтгэн сахих буюу хүндэтгэн сахих явдлыг хангах үүрэг хүлээнэ.

*2 дугаар зүйл*

Тайван цагт хэрэгжүүлэх заалтуудын сацуу хоёр буюу хэлэлцэн тохирогч эрхэм дээд хэд хэдэн талын хооронд үүсч болох зарласан дайн буюу аливаа бусад зэвсэгт мөргөлдөөний бүх тохиолдолд тэдгээр талын аль нэг нь дайны байдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан ч энэхүү конвенцийг хэрэглэнэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн буюу бүхэлд нь эзэлсэн бүх тохиолдолд тухайн эзлэлт нь зэвсэгт эсэргүүцэлтэй тулгараагүй байсан ч энэхүү конвенцийг мөн хэрэглэнэ.

Хэдийгээр мөргөлдөөнд оролцогч гүрнүүдийн аль нэг нь энэхүү конвенцид оролцогч тал биш байсан ч түүнд оролцогч тал болох гүрнүүд өөр хоорондын харилцаандаа энэхүү конвенцийг заавал биелүүлэх үүрэгтэй хэвээр байна. Үүнээс гадна хэрэв дээр дурдсан гүрэн энэхүү конвенцийн заалтыг хүлээн авч хэрэглэвэл түүний хувьд тэд энэхүү конвенцийг заавал биелүүлэх үүрэгтэй байна.

\* Монгол Улс 1958.11.05-нд нэгдэн орсон

### 3 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нэгний нь нутаг дэвсгэрт үүсэх олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний тохиолдолд тухайн мөргөлдөөнд оролцогч тал бүр наад зах нь дараахь заалтыг хэрэглэх үүрэг хүлээнэ:

1) Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй этгээд, түүний дотор байлдахаа зогсоосон болон өвчлөх, шархдах, саатуулагдах буюу аливаа бусад шалтгааны улмаас байлдаанд оролцоогүй зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний этгээдтэй арьс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, гарал үүсэл, эд хөрөнгийн байдал буюу бусад төсөөтэй шалгуурт үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр бүх нөхцөл байдалд хүнлэг харьцана.

Энэ үүднээс дараахь үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хийхийг хэзээ ч, хаана ч хориглоно:

a) амь нас, бие махбодид халдах, тухайлбал, бүхий л хэлбэрээр амийг нь хөнөөх, хүнд гэмтэл учруулах, харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;

b) барьцаанд авах;

c) хүний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах;

d) соёл иргэншилт ард түмнүүдийн зайлшгүй гэж хүлээн зөвшөөрсөн шүүхийн бүх баталгаагаар хангаж байнгын ажиллагаатай шүүхээс урьдчилан гаргасан шийдвэргүйгээр ял шийтгэх болон ял эдлүүлэх.

2) Шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг олж авч тусламж үзүүлнэ. Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хүмүүнлэгийн хараат бус байгууллага мөргөлдөөнд оролцогч талуудад өөрийн үйлчилгээг санал болгож болно.

Мөргөлдөөнд оролцогч талууд тусгай хэлэлцээрийн замаар энэхүү конвенцийн бусад заалтыг бүгдийг буюу хэсэгчлэн хүчин төгөлдөр болгохыг цаашид чармайна.

Өмнөх заалтуудыг хэрэглэх явдал мөргөлдөөнд оролцогч талуудын эрх зүйн байдлыг хөндөхгүй.

### 4 дүгээр зүйл

Мөргөлдөөнд оролцогч талуудын хуурай замын болон тэнгисийн хүчний хооронд дайтах ажиллагаа үүссэн тохиолдолд энэхүү конвенцийн заалтыг зөвхөн хөлөг онгоцон дээрх хүчинд хэрэглэнэ.

Эдгээр хүчин эрэг дээр гармагц Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн заалтуудын үйлчлэлд хамрагдана.

### 5 дугаар зүйл

Төвийг сахисан гүрнүүд өөрийн нутагт дэвсгэрт хүлээн авсан буюу хорьсон мөргөлдөөнд оролцогч талуудын зэвсэгт хүчний шархтан, өвчтөн болон хөлөг

онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгч, мөн олдсон нас барсан этгээдийн хувьд энэхүү конвенцийг төсөөтэй хэрэглэнэ.

*6 дугаар зүйл*

Энэхүү конвенцийн 10, 18, 31, 38, 39, 40, 43 болон 53 дугаар зүйлд шууд заасан хэлэлцээрийн сацуу хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тусгай заалтаар зохицуулах нь тохиромжтой гэж үзэж болох бүх асуудлаар өөр тусгай хэлэлцээр байгуулж болно. Ямар ч тусгай хэлэлцээр шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчийн энэхүү конвенцоор тодорхойлсон байдалд сөргөөр нөлөөлөхгүй бөгөөд энэхүү конвенцоор тэдэнд олгосон эрхийг хязгаарлахгүй.

Дээр дурдсан хэлэлцээр, эсхүл дараа дараагийн хэлэлцээрт эсрэгээр шууд зааснаас бусад тохиолдолд эсхүл мөргөлдөөнд оролцогч талуудын аль нэг нь шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчдийн хувьд илүү тааламжтай арга хэмжээ авснаас бусад тохиолдолд тэд тэдгээр хэлэлцээрээр олгогдсон давуу байдлыг энэхүү конвенцийг тэдний хувьд хэрэглэх хугацаанд үргэлжлүүлэн эдэлнэ.

*7 дугаар зүйл*

Шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчид нь энэхүү конвенц болон хэрэв өмнөх зүйлд дурдсан тусгай хэлэлцээр байгаа бол тэдгээрээр хангагдсан эрхээсээ ямар ч нөхцөл байдалд хэсэгчлэн буюу бүрэн татгалзаж болохгүй.

*8 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий хамгаалагч гүрний дэмжлэг, хяналтын дор энэхүү конвенцийг хэрэглэнэ. Эл зорилгоор хамгаалагч гүрнүүд өөрийн дипломат болон консулын ажилтнуудаас тусдаа өөрийн орны, эсхүл төвийг сахисан бусад гүрний харьяатаас бүрдсэн төлөөлөгчдийг томилж болно. Дурдсан төлөөлөгчдийг томилохдоо тэдний очиж ажиллах гүрний зөвшөөрлийг авна.

Мөргөлдөөнд оролцогч талууд хамгаалагч гүрний төлөөлөгчдийн ажлыг аль болох боломжийн хэмжээнд хөнгөвчлөн дэмжинэ.

Хамгаалагч гүрний төлөөлөгчид ажлаа явуулахдаа ямар ч тохиолдолд энэхүү конвенцийн дагуу хүлээсэн зорилгот үүргээсээ хэтэрч болохгүй. Ялангуяа тэд нутаг дэвсгэрт нь үүргээ биелүүлж байгаа улсын аюулгүй байдлын зайлшгүй шаардлагыг харгалзан үзнэ. Тэдний үйл ажиллагааг зөвхөн цэргийн зайлшгүй шаардлагын улмаас шаардлагатай болсон онцгой болон түр зуурын арга хэмжээний хувьд хязгаарлана.

*9 дүгээр зүйл*

Энэхүү конвенцийн заалт нь Олон улсын улаан загалмайн хороо буюу аливаа бусад хүмүүнлэгийн хараат бус байгууллагаас шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны

сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчдийг хамгаалж, тэдэнд тусламж үзүүлэх талаар тухайн мөргөлдөөнд оролцогч талуудын зөвшөөрөлтэйгөөр явуулах хүмүүнлэгийн үйл ажиллагаанд саад болохгүй.

### *10 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн дагуу хамгаалагч гүрнүүдэд хүлээлгэсэн үүргийг хараат бус бөгөөд үр ашигтай байх бүх баталгааг гаргаж буй байгууллагад олгохоор хэдийд ч тохиролцож болно.

Шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчид аль нэг хамгаалагч гүрэн буюу дээрх эхний хэсэгт заасан байгууллагын үйл ажиллагаанаас ямар нэгэн шалтгааны улмаас ашиг тус хүртэхгүй эсхүл хүртэхээ болих тохиолдолд олзлогч гүрэн мөргөлдөөнд оролцогч талуудын томилсон хамгаалагч улсын энэхүү конвенцийн дагуу биелүүлж буй чиг үүргийг хүлээхийг төвийг сахисан улс эсхүл тийм байгууллагаас хүснэ.

Хэрэв хамгаалалтыг ийнхүү хэрэгжүүлж чадахгүй бол олзлогч гүрэн нь хамгаалагч гүрнүүдийн энэхүү конвенцийн дагуу биелүүлж буй хүмүүнлэгийн чиг үүргийг өөртөө хүлээх талаар Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хүмүүнлэгийн байгууллагаас санал болгохыг хүсэх буюу ийм саналыг энэ зүйлийн заалтыг мөрдөхийн хамт хүлээн авна.

Төвийг сахисан аливаа гүрэн, эсхүл холбогдох гүрний урьсан буюу эл зорилгоор өөрийгөө санал болгож буй байгууллага энэхүү конвенцоор хамгаалдаг этгээдийн харьяалагдаж буй мөргөлдөөнд оролцогч талтай хариуцлагаа ухамсарлан үйл ажиллагаа явуулах шаардлагатай, түүнчлэн зохих чиг үүрэг хүлээж, уг чиг үүргээ хараат бусаар биелүүлэх чадвартай гэсэн хангалттай баталгаа гаргах шаардлагатай.

Аль нэг гүрэн дайны үйл явдлаас шалтгаалан, ялангуяа түүний нутаг дэвсгэр бүхэлдээ, эсхүл түүний үлэмж хэсэг нь эзлэгдсэн тохиолдолд нөгөө гүрэн буюу түүний холбоотонтой хэлэлцээ хийх эрх чөлөө нь түр хугацаагаар ч гэсэн хязгаарлагдсан бол тэдгээрийн хооронд байгуулсан тусгай хэлэлцээрээр өмнөх заалтуудыг зөрчихгүй.

Энэхүү конвенцид хамгаалагч гүрэн гэж дурдах бүрд энэ нэр томъёог энэ зүйлийн дагуу түүнийг орлох байгууллагад ч мөн хэрэглэнэ.

### *11 дүгээр зүйл*

Хамгаалагч гүрнүүд хамгаалагдсан хүмүүсийн ашиг сонирхолд хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд, ялангуяа энэхүү конвенцийн заалтыг хэрэглэх буюу тайлбарлах талаар мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд санал зөрөлдсөн тохиолдолд саналын зөрөлдөөнийг зохицуулах үүднээс асуудалд оролцоно.

Эл зорилгоор хамгаалагч гүрэн бүр аль нэг талын урилгаар буюу өөрийн санаачилгаар өөрсдийн төлөөлөгчдийн, ялангуяа шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн эмнэлгийн ажилтан, шашны төлөөлөгчдийг хариуцаж буй эрх бүхий байгууллагын нь уулзалтыг зохион явуулах саналыг мөргөлдөөнд оролцогч талуудад тавьж болох бөгөөд чингэхдээ тохиромжтой гэж сонгож авсан төвийг сахигч нутагт дэвсгэрт боломжтой бол зохион байгуулна. Мөргөлдөөнд оролцогч талууд эл зорилгоор тэдэнд тавьсан саналыг хүчин төгөлдөр

хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Шаардлагатай бол хамгаалагч гүрнүүд ийм уулзалтад оролцохыг урих төвийг сахисан гүрэнд харьяалагдах, эсхүл Олон улсын улаан загалмайн хорооноос томилсон этгээдийг мөргөлдөөнд оролцогч талуудаар дэмжүүлэн батлуулахаар санал болгож болно.

## **II бүлэг**

### **ШАРХТАН, ӨВЧТӨН БОЛОН ХӨЛӨГ ОНГОЦНЫ СҮЙРЭЛД ӨРТӨГДӨГСӨД**

#### *12 дугаар зүйл*

Далайд байгаа шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртсөн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн болон дараахь зүйлд заасан бусад этгээдийг ямар ч нөхцөл байдалд хүндэтгэж, хамгаална, чингэхдээ “хөлөг онгоцны сүйрэл” гэсэн нэр томъёо нь аливаа шалтгааны улмаас үүссэн хөлөг онгоцны сүйрлийг хэлэх бөгөөд үүнд агаарын хөлгөөр буюу агаарын хөлгөөс далайд газардахад хүрснийг хамааруулна.

Эдгээр этгээд мэдэлд нь байж болох мөргөлдөөнд оролцогч тал хүйс, арьс үндэс, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол болон бусад төсөөтэй шалгуурт үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр тэдэнтэй хүнлэг харьцан асран хамгаална. Тэдний амь насанд халдахыг завдах, эсхүл бие махбодид халдахыг хатуу хориглоно; ялангуяа тэдний амийг хөнөөх буюу хороох, эрүүдэн шүүх буюу биологийн туршилт хийх; тэдэнд эмнэлгийн тусламж, асрамж үзүүлэхгүй санаатайгаар орхих, тэдэнд халдварт өвчин халдах буюу тархах нөхцлийг буй болгохыг хориглоно.

Зөвхөн эмнэлгийн нэн яаралтай шалтгаанаар эмчилгээний дарааллыг харгалзахгүй тусламж үзүүлж болно.

Эмэгтэйчүүдэд хүйсний нь онцлогийг бүх талаар харгалзан анхаарал тавина.

#### *13 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг дараахь ангилалд хамаарах шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн хувьд хэрэглэнэ:

(1) Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, мөн зэвсэгт хүчний хэсэг болж буй журамт цэрэг буюу сайн дурын ангийн бие бүрэлдэхүүн.

(2) Мөргөлдөөнд оролцогч талд харьяалагдах бөгөөд энэ нутаг дэвсгэр нь эзлэгдсэн байсан ч түүний нутаг дэвсгэрт буюу нутаг дэвсгэрээс гадна үйл ажиллагаа явуулж буй бусад журамт цэргийн болон сайн дурын бусад ангийн бие бүрэлдэхүүн, түүний дотор зохион байгуулалттай эсэргүүцлийн хөдөлгөөний бие бүрэлдэхүүн, чингэхдээ эдгээр журамт цэрэг буюу сайн дурын анги, түүний дотор зохион байгуулалттай эсэргүүцлийн хөдөлгөөн нь дараахь нөхцлийг хангасан байвал зохино:

(a) захирагдагсдынхаа төлөө хариуцлага хүлээсэн этгээдээр удирдуулж байх;

(b) алсаас танигдах тогтсон ялгах тэмдэгтэй байх;



(с) зэвсгээ ил авч явах;

(d) үйл ажиллагаагаа дайны хууль, заншилд нийцүүлэн явуулж байх.

(3) Олзлогч гүрэн хүлээн зөвшөөрөөгүй засгийн газар буюу эрх бүхий байгууллагыг дэмжиж буй байнгын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн.

(4) Цэргийн агаарын хөлгийн багийн гишүүн болох энгийн иргэд, цэргийн сурвалжлагчид, хангамж түгээгчид, ажлын баг буюу зэвсэгт хүчний ахуйн үйлчилгээний гишүүд зэрэг зэвсэгт хүчний жинхэнэ бие бүрэлдэхүүн биш боловч тэднийг дагалдан яваа этгээд, чингэхдээ тэд дагалдаж яваа зэвсэгт хүчнээс зөвшөөрөл авсан байвал зохино.

(5) Олон улсын эрх зүйн аливаа бусад заалтын дагуу илүү тааламжтай нөхцөл эдэлдэггүй мөргөлдөөнд оролцогч талуудын худалдааны усан цэргийн багийн гишүүд, түүний дотор ахмад, замчин болон дагалдан сурагч, түүнчлэн иргэний агаарын хөлгийн баг.

(6) Дайсан ойртож ирэхэд, байнгын зэвсэгт нэгж болж бүрэлдэж амжилгүй, орж ирж буй хүчнийг эсэргүүцэхээр гэнэт зэвсэг барьж буй эзлэгдээгүй нутаг дэвсгэрийн оршин суугчид, чингэхдээ тэд зэвсгээ ил авч явж, дайны хууль, заншлыг хүндэтгэн сахивал зохино.

#### *14 дүгээр зүйл*

Цэргийн эмнэлгийн хөлөг онгоц, тусламжийн нийгэмлэг буюу хувь хүмүүсийн эмнэлгийн хөлөг онгоц, түүнчлэн худалдааны усан онгоц, дарвуулт онгоц болон бусад хөлөг онгоцонд байгаа шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг тэдгээр хөлөг онгоцны харьяаллаас үл хамааран шилжүүлэхийг дайтаж буй талын байлдааны бүх хөлөг онгоц шаардах эрхтэй бөгөөд чингэхдээ шархтан, өвчтөн нь тэднийг зөөвөрлөх боломжтой эрүүл мэндийн байдалд байгаа бөгөөд тухайн байлдааны хөлөг онгоц нь тэдэнд шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлэх зохих нөхцөлөөр хангагдсан байвал зохино.

#### *15 дугаар зүйл*

Хэрэв шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг төвийг сахигч байлдааны хөлөг онгоц буюу төвийг сахигч цэргийн агаарын хөлөгт олж авбал тэднийг дайны ажиллагаанд цаашид оролцуулахгүй байх явдлыг олон улсын эрх зүйн дагуу шаардлагатай тохиолдолд хангана.

#### *16 дугаар зүйл*

12 дугаар зүйлийн заалтыг мөрдөхийн хамт, дайсны гарт орсон дайтаж буй талын шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг дайнд олзлогдогчид гэж үзэх бөгөөд тэдний хувьд дайнд олзлогдогчдын талаархи олон улсын эрх зүйн заалтыг хэрэглэнэ. Олзлогч нь олзлогдогчдыг авч үлдэх эсхүл өөрийн орны

боомт, төвийг сахигч боомт, эсхүл бүр дайсны нутаг дэвсгэрийн боомтод шилжүүлэх эсэхийг нөхцөл байдалд нийцүүлэн шийдвэрлэж болно. Сүүлчийн тохиолдолд ийнхүү эх орондоо эргэж ирсэн дайнд олзлогдогчид нь уг дайны туршид цэргийн алба хааж болохгүй.

*17 дугаар зүйл*

Орон нутгийн эрх баригчдын зөвшөөрөлтэйгөөр төвийг сахигч боомтод буусан шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг төвийг сахигч болон дайтаж буй гүрнүүдийн хооронд өөрөөр заасан тохиролцоо байхгүй бол төвийг сахисан гүрэн тэднийг дайны ажиллагаанд дахин оролцуулахгүйгээр олон улсын эрх зүйн дагуу шаардлагатай тохиолдолд хамгаалалтандаа авна.

Шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг эмнэлэгт хэвтүүлэх, тусгаарлан хорихтой холбогдсон зардлыг тэднийг харьяалж буй гүрэн хариуцна.

*18 дугаар зүйл*

Тулалдаан бүрийн дараа мөргөлдөөнд оролцогч талууд хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, шархтан болон өвчтөнг эрж хайх, олж авах, тэднийг тонон дээрэмдэх, зүй бусаар харьцахаас хамгаалах, зохих асрамжаар хангах, нас барагсдыг эрж хайх болон тэднийг дээрэмдүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар боломжтой бүх арга хэмжээг цаг алдалгүй авна.

Тухайн нөхцөл байдалд боломжтой л бол мөргөлдөөнд оролцогч талууд шархтан, өвчтөнг бүслэгдсэн буюу тойруулагдсан газраас далайгаар зөөж гаргах, тухайн газар уруу явж буй эмнэлгийн болон шашны ажилтан, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх талаар орон нутгийн тохиролцоонд хүрнэ.

*19 дүгээр зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн гарт орсон дайсны талын хөлөг онгоцны сүйрэлд өртсөн, шархадсан, өвчтэй буюу нас барсан этгээд бүрийн хэн болохыг тогтооход хэрэгтэй аливаа мэдээллийг аль болох түргэн бүртгэнэ. Ийм бүртгэлд боломжтой бол дараахь зүйлийг тусгана:

- (a) уг этгээдийг харьяалах гүрэн;
- (b) армийн, цэргийн ангийн, хувийн буюу серийн дугаар;
- (c) овог;
- (d) нэр буюу нэрс;
- (e) төрсөн он, сар, өдөр;
- (f) түүний үнэмлэх буюу таних пайзад байгаа аливаа бусад мэдээлэл;

(g) олзлогдсон буюу нас барсан он, сар, өдөр болон газар;

(h) шарх буюу өвчин, нас барсан шалтгааны талаархи мэдээлэл.

Дээр дурдсан мэдээллийг Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 122 дугаар зүйлд заасан мэдээллийн товчоонд аль болох түргэн хүргүүлнэ. Уг товчоо нь хамгаалагч гүрэн болон Дайнд олзлогдогчдын хэрэг эрхлэх төв байгууллагаар дамжуулан энэ мэдээллийг эдгээр этгээдийн харьяалагдаж буй гүрэнд дамжуулна.

Мөргөлдөөнд оролцогч талууд нас барсны гэрчилгээ буюу нас барагсдын нэрсийн зохих ёсоор гэрчилсэн жагсаалтыг бэлтгэж дээрх товчоогоор дамжуулан бие биедээ илгээнэ. Тэд нас барагсдаас олдсон хоёрлосон таних пайзын хагасыг, эсхүл ганц таних пайз бол уг пайзыг, гэрээслэл, нас барагчийн ойрын төрөл саданд чухал бусад баримт бичиг, мөнгө болон ерөнхийдөө эдийн болон сэтгэл санааны хувьд үнэт бүх зүйлийг цуглуулж мөн товчоогоор дамжуулан хүргүүлнэ. Эдгээр зүйлийг хэнийх болох нь танигдаагүй зүйлсийн хамт лацадсан боодолд хийж нас барсан эзнийг нь тогтооход шаардлагатай бүх мэдээлэл, түүнчлэн боодолд байгаа зүйлийн бүрэн жагсаалтыг дагалдуулан илгээнэ.

#### *20 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талууд тухайн нөхцөл байдалд боломжтой бол нас барагсдыг далайд ганцаарчлан оршуулж тэдний нас барсныг батлах, хэн болохыг тогтоох болон тайлан гаргах боломж бүрдүүлэх үүднээс цогцост урьдчилан нарийвчилсан үзлэг, боломжтой бол эмнэлгийн үзлэг хийх явдлыг хангана. Хоёрлосон таних пайз хэрэглэж байгаа тохиолдолд пайзны хагасыг цогцос дээр үлдээнэ.

Хэрэв нас барсан этгээдийг эх газарт авч ирсэн бол Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн заалтыг хэрэглэнэ.

#### *21 дүгээр зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талууд шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг хөлөг онгоцондоо авч, асрах, түүнчлэн нас барагсдыг олж авахыг төвийг сахигч худалдааны усан онгоц, дарвуулт онгоц буюу бусад хөлөг онгоцны ахмадуудад уриалж болно.

Энэхүү уриалгыг хүлээн авсан усан онгоц, мөн тэрчлэн өөрсдийн санаачлагаар шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг олж авсан хөлөг онгоцуудыг ийнхүү тусламжийн үйл ажиллагаагаа явуулахад нь тусгай хамгаалалт, нөхцөл боломжоор хангана.

Тэднийг ийм тээвэрлэлт хийсний нь төлөө ямар ч тохиолдолд эзлэн авч болохгүй боловч өөрөөр амлалт өгөөгүй бол төвийг сахисан байдлыг зөрчсөний нь төлөө эзлэн авч болно.

### **III бүлэг**

## **ЭМНЭЛГИЙН ХӨЛӨГ ОНГОЦ**

#### *22 дугаар зүйл*

Цэргийн эмнэлгийн хөлөг онгоц, өөрөөр хэлбэл гагцхүү шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдөд тусламж үзүүлэх, тэднийг эмчлэх, зөөж тээвэрлэхийн тулд тусгайлан баригдаж, тоноглогдсон хөлөг онгоцонд ямар ч нөхцөл байдалд халдаж буюу эзэлж болохгүй боловч тэдгээр хөлөг онгоцны нэр, тодорхойлолтын тухай мөргөлдөөнд оролцогч талуудад тухайн хөлөг онгоцыг хэрэглэж эхлэхээс арав хоногийн өмнө мэдэгдсэн нөхцөлд ямагт хүндэтгэж, хамгаална.

Мэдэгдэлд тусгах ёстой өгөгдөхүүнд хөлөг онгоцны бүртгэгдсэн бохир даац, хошуунаас хитэг хүртэлх урт, сураг болон яндангийн тоог тусгана.

#### *23 дугаар зүйл*

Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн үйлчлэлд багтах эрх бүхий эргийн байгууллагуудыг далайн зүгээс бөмбөгдөх буюу довтлох ёсгүй.

#### *24 дүгээр зүйл*

Хэрэв Үндэсний улаан загалмайн нийгэмлэгүүд, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн тусламжийн нийгэмлэгүүд, эсхүл хувь хүмүүсийн ашиглаж буй эмнэлгийн хөлөг онгоцонд тэдгээрийг харьяалж байгаа мөргөлдөөнд оролцогч тал албан ёсны үүрэг өгсөн бөгөөд мэдэгдлийн талаархи 22 дугаар зүйлийн заалтыг мөрдсөн тохиолдолд тэдгээр хөлөг онгоцыг цэргийн эмнэлгийн хөлөг онгоцны нэгэн адил хамгаалж, эзлэн авч болохгүй.

Эдгээр усан онгоцонд ачаа ачих болон хөдлөх үед тэдгээр нь хариуцах байгууллагын хяналтан дор байсныг нотлох гэрчилгээг эдгээр хөлөг онгоцонд олгох ёстой.

#### *25 дугаар зүйл*

Үндэсний Улаан загалмайн нийгэмлэгүүд, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн тусламжийн нийгэмлэгүүд, эсхүл хувь хүмүүсийн ашиглаж буй эмнэлгийн хөлөг онгоц нь өөрийн засгийн газрын урьдчилсан зөвшөөрөл болон тухайн мөргөлдөөнд оролцогч талын зөвшөөрөлтэйгөөр мөргөлдөөнд оролцогч талын хяналтан дор орсон бөгөөд мэдэгдлийн талаархи 22 дугаар зүйлийн заалтыг мөрдсөн нөхцөлд уг хөлөг онгоцыг цэргийн эмнэлгийн хөлөг онгоцны нэгэн адил хамгаалж, эзлэн авч болохгүй.

*26 дугаар зүйл*

22, 24 болон 25 дугаар зүйлд дурдсан хамгаалалтыг аливаа даацын эмнэлгийн хөлөг онгоц болон тэдний аврах жижиг завинд хаана үйл ажиллагаа явуулж байгаагаас нь үл хамааран олгоно. Гэсэн хэдий ч тав тух, аюулгүй байдлыг хангахын тулд мөргөлдөөнд оролцогч талууд нь шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг холын замд, чөлөөт далайд тээвэрлэхдээ зөвхөн 2.000 тоннын бохир даац бүхий эмнэлгийн хөлөг онгоц ашиглахыг чармайна.

*27 дугаар зүйл*

22 ба 24 дүгээр зүйлд заасан нөхцөлийн адил нөхцөлөөр, эрэг орчмын аврах ажиллагаанд зориулж тухайн улс буюу албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн аврах завины байгууллагын ашиглаж буй жижиг хөлөг онгоцыг тухайн ажиллагааны шаардлагын хүрээнд мөн хүндэтгэж, хамгаална.

Гагцхүү эдгээр хөлөг онгоц хүмүүнлэгийн зорилгот үүргээ биелүүлэхээр ашиглаж буй эрэг орчмын суурилуулсан төхөөрөмжийг боломжийн хүрээнд мөн адил хүндэтгэж, хамгаална.

*28 дугаар зүйл*

Тулалдаан байлдааны хөлөг онгоцон дээр гарсан тохиолдолд эмнэлгийн өрөөг аль болохоор хайрлаж, хамгаална. Эдгээр эмнэлгийн өрөө болон түүний тоног төхөөрөмжид дайны хууль үйлчлэх боловч шархтан, өвчтөнд шаардлагатай цагт тэдгээрийг өөр зорилгоор ашиглаж болохгүй. Гэсэн хэдий ч тэдгээр өрөө, тоног төхөөрөмж мэдэлд нь орсон ахмад нь тэнд байгаа шархтан, өвчтөнийг зохих асрамжаар хангасны дараа цэргийн яаралтай шаардлага гарсан тохиолдолд тэдгээр өрөө, тоног төхөөрөмжийг өөр зорилгоор ашиглаж болно.

*29 дүгээр зүйл*

Эмнэлгийн хөлөг онгоц зогсож байгаа боомт дайсны гарт орвол уг хөлөг онгоцонд дээрх боомтыг орхиж явахыг зөвшөөрнө.

*30 дугаар зүйл*

22, 24, 25 болон 27 дугаар зүйлд тодорхойлогдсон хөлөг онгоц нь шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдөд тэдний харьяаллаар үл ялгаварлан асрамж, тусламж үзүүлнэ.

Харилцан тохирогч эрхэм дээд талууд эдгээр усан онгоцыг цэргийн ямарваа зорилгоор хэрэглэхгүй байх үүрэг хүлээнэ.

Эдгээр усан онгоц нь байлдаж байгаа талуудын хөдөлгөөнд ямар ч байдлаар саад болох ёсгүй.

Тулалдааны үед болон дараа эдгээр хөлөг онгоц нь зориг шийдмэг ажиллана.

*31 дүгээр зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талууд 22, 24, 25 болон 27 дугаар зүйлд дурдсан хөлөг онгоцонд хяналт тавих, үзлэг хийх эрхтэй байна. Тэд эдгээр усан онгоцноос тусламж авахаас татгалзаж, холдож явахыг тушааж, аяллын тодорхой чиглэл зааж, шугаман бус болон харилцаа холбооны бусад хэрэгслийн ашиглалтад нь хяналт тавьж, түүнчлэн нөхцөл байдлын ноцтой байдлаас хамааран шаардлагатай бол зогсоосноос хойш долоо хоногоос хэтрэхгүй хугацаанд саатуулж ч болно.

Тэд өмнөх хэсгийн заалтын дагуу өгсөн тушаалыг биелүүлж байгаа эсэхийг хянах ганц үүрэг бүхий комиссарыг хөлөг онгоцонд түр хугацаагаар томилж болно.

Мөргөлдөөнд оролцогч талууд усан онгоцны ахмадад өгсөн тушаалаа түүний ойлгох хэлээр эмнэлгийн хөлөг онгоцны дэвтэрт бичнэ.

Мөргөлдөөнд оролцогч талууд энэхүү конвенцид орсон заалтыг хатуу дагаж мөрдөх явдлыг хянаж байх төвийг сахигч ажиглагчдыг дангаараа буюу тусгай хэлэлцээр байгуулан хөлөг онгоцондоо ажиллуулж болно.

*32 дугаар зүйл*

22, 24, 25 болон 27 дугаар зүйлд тодорхойлсон усан онгоцыг төвийг сахигч боомтод байгаа үед нь байлдааны хөлөг онгоцтой эн зэрэгцүүлэхгүй.

*33 дугаар зүйл*

Эмнэлгийн хөлөг онгоц болгон өөрчилсөн худалдааны усан онгоцыг дайтах ажиллагааны туршид өөр зорилгоор ашиглаж болохгүй.

*34 дүгээр зүйл*

Эмнэлгийн хөлөг онгоц, эмнэлгийн өрөөг хүмүүнлэгийн үүргээс гадуур дайсанд хортой үйлдэл хийхээр ашиглаагүй бол тэдгээрийн эдлэх хамгаалалтыг зогсоохгүй. Гэвч хамгаалалтыг зөвхөн тэдгээрт зохих бүх тохиолдолд боломжит хугацааны хязгаар зааж зохих ёсны сануулга өгсний дараа уг сануулгыг үл тоомсорлосон тохиолдолд зогсоож болно.

Ялангуяа эмнэлгийн хөлөг онгоцууд өөрсдийн шугаман бус буюу харилцаа холбооны бусад хэрэгсэлдээ нууц дугаартай байж, хэрэглэж болохгүй.

*35 дугаар зүйл*

Дараахь нөхцлийг эмнэлгийн хөлөг онгоц буюу эмнэлгийн өрөөнд олгох ёстой хамгаалалтыг үгүйсгэж байна гэж үзэхгүй:

(1) Хөлөг онгоцны баг буюу эмнэлгийн өрөөний ажилтнууд дэг журам хамгаалах, өөрийгөө хамгаалах буюу шархтан, өвчтөнг хамгаалах зорилгоор зэвсэгтэй байх.

(2) Гагцхүү навигац буюу харилцаа холбооны зорилгоор хөлөг онгоцонд аппарат хэрэгсэл онгоцонд байх.

(3) Шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдөөс авсан бөгөөд зохих зориулалтаар хараахан хураалгаагүй байсан хөнгөн гар зэвсэг, байлдааны сум хэрэгслийг эмнэлгийн хөлөг онгоц буюу эмнэлгийн өрөөнөөс илрүүлж олох.

(4) Эмнэлгийн хөлөг онгоц болон усан онгоцны эмнэлгийн өрөөний буюу багийн явуулж буй хүмүүнлэгийн үйл ажиллагаа нь шархадсан, өвчтэй буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөн энгийн иргэдэд хамаарч байгаа.

(5) Гагцхүү эмнэлгийн үүрэгт зориулан ердийн шаардлагаас илүү хэмжээний тоног төхөөрөмж, ажилтныг тээвэрлэх.

#### **IV бүлэг**

#### **АЖИЛТНУУД**

##### *36 дугаар зүйл*

Эмнэлгийн хөлөг онгоцонд байгаа шашны болон эмнэлгийн ажилтан, мөн багийнхныг хүндэтгэж, хамгаална; тэднийг эмнэлгийн хөлөг онгоцонд үүргээ гүйцэтгэж байхад нь хөлөг онгоцонд шархтан, өвчтөн байгаа эсэхээс үл хамааран баривчилж болохгүй.

##### *37 дугаар зүйл*

12, 13 дугаар зүйлд заасан этгээдэд эмнэлгийн болон санаа сэтгэлийн тусламж үзүүлэхээр томилогдсон шашны, эмнэлгийн албаны ажилтан дайсны гарт орвол тэднийг хүндэтгэж, хамгаална; тэд шархтан, өвчтөнг асрахад шаардлагатай бол үүргээ биелүүлсээр байж болно. Тэд эрх мэдэлд нь байгаа ерөнхий командлагч боломжтой гэж үзвэл тэднийг дараа нь буцаан илгээнэ. Тэд хөлөг онгоцыг орхих үедээ хувийн эд хөрөнгөө авч болно.

Гэвч хэрэв дайнд олзлогдогчдын эмнэлгийн буюу санаа сэтгэлийн хэрэгцээнд эдгээр ажилтны заримыг үлдээх шаардлагатай болбол тэднийг аль болох түргэн эрэг дээр гаргах талаар боломжтой бүхнийг хийнэ.

Үлдсэн ажилтнууд эрэг дээр гармагц Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн заалтад хамаарагдана.

**V бүлэг**

**ЭМНЭЛГИЙН ТЭЭВЭР**

*38 дугаар зүйл*

Уг зорилгоор хөлсөлсөн хөлөг онгоцонд гагцхүү зэвсэгт хүчний шархадсан болон өвчтэй этгээдийг эмчлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зориулсан тоног төхөөрөмжийг тээвэрлэх зөвшөөрөл олгох бөгөөд чингэхдээ аяллын талаархи мэдээллийг дайсагнагч гүрэнд мэдэгдэж, түүнээс зөвшөөрөл авсан байвал зохино. Дайсагнагч гүрэн тээвэрлэгч хөлөг онгоцонд гарах эрхийг хадгалах боловч хөлөг онгоц болон тээвэрлэж яваа тоног төхөөрөмжийг эзлэн авах эрхгүй.

Мөргөлдөөнд оролцогч талууд хоорондоо хэлэлцэн тохирох замаар хөлөг онгоцонд тээвэрлэж яваа тоног төхөөрөмжийг хянахаар хөлөг онгоцонд төвийг сахигч ажиглагч ажиллуулж болно. Эл зорилгоор тухайн тоног төхөөрөмжид чөлөөтэй хүрэх боломж олгоно.

*39 дүгээр зүйл*

Эмнэлгийн агаарын хөлөг, өөрөөр хэлбэл гагцхүү шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг шилжүүлэх, эмнэлгийн ажилтнууд болон тоног төхөөрөмжийг тээвэрлэх зорилгоор ашиглаж буй агаарын хөлөгт халдаж болохгүй, харин мөргөлдөөнд оролцогч тухайн талуудын хооронд тусгайлан тохиролцсон өндөр, хугацаа, замаар нисч байх үед мөргөлдөөнд оролцогч талууд түүнд хүндэтгэлтэй хандана.

Агаарын хөлгийг 41 дүгээр зүйлд заасан ялгах бэлгэ тэмдгээр тэдгээрийн доод, дээд, хажуу талд үндэсний далбааны өнгөний хамт тод тэмдэглэсэн байна. Тэдгээрт дайтах ажиллагаа эхлэх буюу явагдах үед мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд тохиролцсон аливаа бусад тэмдэг буюу таних хэрэгсэл хэрэглэж болно.

Өөрөөр тохиролцоогүй бол дайсны нутаг дэвсгэр буюу түүний эзэлсэн нутаг дэвсгэр дээгүүр нисэхийг хориглоно.

Эмнэлгийн агаарын хөлөг газардах буюу усан дээр буух аливаа шаардлагад захирагдана. Ийнхүү газардах буюу буух болсон тохиолдолд хэрэв үзлэг хийсэн бол үзлэг хийсний дараа агаарын хөлөг нь зорчигчдынхоо хамт нислэгээ үргэлжлүүлж болно.

Дайсны нутаг дэвсгэр буюу түүний эзэлсэн нутаг дэвсгэрт газардах буюу түүний усан дээр буухад хүрсэн тохиолдолд шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн агаарын хөлгийн багийнхан дайнд олзлогдогчид болно. Эмнэлгийн ажилтнуудтай 36, 37 дугаар зүйлийн дагуу харьцана.

*40 дүгээр зүйл*

Хоёр дахь догол мөрний заалтын дагуу мөргөлдөөнд оролцогч талуудын эмнэлгийн агаарын хөлөг төвийг сахисан гүрнүүдийн нутаг дэвсгэр дээгүүр нисэж өнгөрөх, шаардлагатай тохиолдолд газардах, эсхүл түр бууж болно. Тэд тухайн нутаг



дэвсгэр дээгүүр нь өнгөрөх талаар төвийг сахисан гүрэнд урьдчилан мэдэгдэх бөгөөд газардах буюу усан дээр буух аливаа шаардлагад захирагдана. Тэд зөвхөн мөргөлдөөнд оролцогч талууд болон төвийг сахисан холбогдох гүрэнтэй тохиролцсон зам, өндөр, хугацааг баримтлан нислэг хийх тохиолдолд халдлагаас хамгаалагдана.

Гэвч төвийг сахисан гүрнүүд эмнэлгийн агаарын хөлөг нутаг дэвсгэр дээгүүр нь нисэж өнгөрөх буюу нутаг дэвсгэрт нь газардахад болзол, хязгаар тогтоож болно. Ийнхүү тогтоож болох болзол, хязгаарыг мөргөлдөөнд оролцогч бүх талд адил тэгш хэрэглэнэ.

Төвийг сахисан гүрнүүд, мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд өөрөөр тохиролцоогүй бол орон нутгийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр төвийг сахигч нутаг дэвсгэрт эмнэлгийн агаарын хөлгөөр буусан шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг дайны ажиллагаанд дахин оролцуулахгүйгээр олон улсын эрх зүйн дагуу шаардлагатай тохиолдолд төвийг сахисан гүрэн саатуулна. Шархтан, өвчтөн буюу хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийг эмнэлэгт хэвтүүлэх, тусгаарлан хорихтой холбогдсон зардлыг тэднийг харьяалж буй гүрэн хариуцна.

## **VI бүлэг**

### **ЯЛГАХ БЭЛГЭ ТЭМДЭГ**

#### *41 дүгээр зүйл*

Цэргийн эрх бүхий байгууллагын удирдамжаар цагаан дэвсгэр дээрх улаан загалмайн бэлгэ тэмдгийг далбаа, гарын таних тэмдэг болон эмнэлгийн албанд хэрэглэх бүх тоног төхөөрөмжид тавина.

Гэсэн хэдий ч улаан загалмайн оронд цагаан дэвсгэр дээр улаан хавирган сар, улаан арслан болон нарыг бэлгэ тэмдэг болгон хэрэглэдэг орнуудын хувьд энэхүү конвенцийн нөхцөлөөр тэдгээр бэлгэ тэмдгийг мөн хүлээн зөвшөөрнө.

#### *42 дугаар зүйл*

36, 37 дугаар зүйлд заасан ажилтнууд цэргийн эрх бүхий байгууллагаас тамга дарж олгосон ялгах бэлгэ тэмдэг бүхий усанд гэмтэхгүй гарын таних тэмдгийг зүүн гартаа зүүнэ.

Эдгээр ажилтан нь 19 дүгээр зүйлд заасан таних пайз зүүхээс гадна ялгах бэлгэ тэмдэг бүхий тусгай үнэмлэх авч явах ёстой. Энэ үнэмлэх нь усанд гэмтэхгүй бөгөөд халаасанд авч явж болохуйц хэмжээтэй байна. Түүнд наад зах нь эзэмшигчийн овог, нэр, төрсөн он, сар, өдөр, цол, зэрэг болон цэргийн ангийн дугаарыг зааж үндэсний хэлээр бичих бөгөөд энэхүү конвенцоор ямар хэмжээгээр хамгаалагдах эрхтэй болохыг тодорхойлно. Уг үнэмлэхэд эзэмшигчийн гэрэл зураг, түүнчлэн гарын үсэг буюу хурууны хээ эсхүл аль аль нь байна. Тэр нь цэргийн эрх бүхий байгууллагын товгор тамгатай байна.

Нэг зэвсэгт хүчний үнэмлэх нь ижил байх бөгөөд хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын зэвсэгт хүчний үнэмлэх нь боломжийн хэрээр төсөөтэй хэлбэртэй байна. Мөргөлдөөнд оролцогч талууд энэхүү конвенцид жишээ болгон хавсаргасан загварыг удирдлага болгож болно. Тэд хэрэглэж буй загвараа дайтах ажиллагаа

эхлэхэд бие биедээ мэдээлнэ. Үнэмлэхийг боломжтой тохиолдолд наад зах нь хоёр хувь үйлдэж нэг хувийг тухайн этгээдийн эх оронд нь хадгална.

Дурдсан ажилтнуудыг таних тэмдэг буюу үнэмлэхээс нь, түүнчлэн гарын таних тэмдэг зүүх эрхээс нь ямар ч нөхцөл байдалд салгаж болохгүй. Тэдгээрийг гээж үрэгдүүлсэн тохиолдолд тэд үнэмлэхийн хувийг авч, таних тэмдгийг солих эрх эдлэнэ.

### 43 дугаар зүйл

22, 24, 25 болон 27 дугаар зүйлд заасан хөлөг онгоцыг дараахь байдлаар ялган тэмдэглэнэ:

(а) Гадна талаасаа бүхэлдээ цагаан өнгөтэй байна.

(б) Хүрэн улаан өнгөтэй нэг буюу хэд хэдэн загалмайг далайгаас болон агаараас хамгийн боломжтой сайн харагдахуйцаар хөлөг онгоцны ёроолын хэсгийн тал бүр болон хөлөг онгоцны хажуу талд дүрслэн харуулсан байна.

Эмнэлгийн бүх хөлөг онгоц үндэсний далбаагаа мандуулж өөрсдийгөө таниулах бөгөөд хэрэв төвийг сахисан улсад хамаарагдаж байвал удирдлаган доор нь орсон мөргөлдөөнд оролцогч талын далбааг мандуулна. Улаан загалмай бүхий цагаан далбааг хөлөг онгоцны сураг дээр аль болох өндөрт мандуулна.

Эмнэлгийн хөлөг онгоцны аврах завь, эргийн аврах завь болон эмнэлгийн албаны ашиглаж буй бүх жижиг хөлөг онгоц нь цагаан өнгөтэй байх бөгөөд тод харагдах хүрэн улаан өнгөтэй загалмайтай байхаас гадна эмнэлгийн хөлөг онгоцонд зориулан дээр заасан таних тогтолцоонд ерөнхийдөө нийцсэн байна.

Шөнийн цагт болон муу харагдах үед эдлэх эрхтэй хамгаалалтаараа хангуулахыг хүссэн дээр дурдсан хөлөг онгоцууд харьяалагдаж байгаа мөргөлдөөнд оролцогч талынхаа зөвшөөрөлтэйгээр өнгө будаг, ялгах бэлгэ тэмдгээ хангалттай харагдахуйцаар тодруулах талаар шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

Энэхүү конвенцийн 31 дүгээр зүйлийн дагуу дайсанд саатуулагдсан эмнэлгийн хөлөг онгоц нь албыг нь гүйцэтгэж, удирдлаган доор нь орсон мөргөлдөөнд оролцогч талын далбааг буулгах ёстой.

Хэрэв эргийн аврах завь эзлэгч гүрний зөвшөөрөлтэйгээр эзлэгдсэн баазаас үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулбал түүнийг баазаас хол явахад нь үндэснийхээ далбааг цагаан дэвсгэр дээрх улаан загалмай бүхий далбааны хамт мөргөлдөөнд оролцогч бүх талд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр үргэлжлүүлэн мандуулахыг зөвшөөрч болно.

Улаан загалмайн талаархи энэ зүйлийн бүх заалтыг 41 дүгээр зүйлд заасан бусад бэлгэ тэмдгийн хувьд адил тэгш хэрэглэнэ.

Мөргөлдөөнд оролцогч талууд эмнэлгийн хөлөг онгоцыг танихад тус дөхөм болох хамгийн орчин үеийн олдохуйц аргыг хэрэглэхийн тулд харилцан хэлэлцээр байгуулахыг ямагт чармайна.

*44 дүгээр зүйл*

Олон улсын аливаа өөр конвенцид, эсхүл тухайн мөргөлдөөнд оролцогч бүх талын хоорондын хэлэлцээрээр заасан байж болохоос бусад тохиолдолд 43 дугаар зүйлд дурдсан ялгах тэмдгүүдийг тайван цаг буюу дайны цагаас үл хамааран зөвхөн мөн зүйлд дурдсан хөлөг онгоцыг тэмдэглэх буюу хамгаалахад хэрэглэж болно.

*45 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд хэрэв хууль тогтоомж нь хараахан тохирохгүй байгаа бол 43 дугаар зүйлд заасан ялгах тэмдгүүдийг урвуулан хэрэглэхээс ямагт урьдчилан сэргийлж, таслан зогсоох талаар шаардлагатай арга хэмжээг авна.

**VII бүлэг**

**КОНВЕНЦИЙГ БИЕЛҮҮЛЭХ**

*46 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч тал бүр энэхүү конвенцийн нийтлэг зарчимд нийцүүлэн ерөнхий командлагчаараа дамжуулан өмнөх зүйлүүдийн нарийвчилсан биелэлтийг хангаж, урьдчилан харах боломжгүй тохиолдолд ч биелэлтийг хангана.

*47 дугаар зүйл*

Конвенцоор хамгаалсан шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсөд, түүнчлэн ажилтнууд, усан онгоц буюу тоног төхөөрөмжийн эсрэг өширхөн халдахыг хориглоно.

*48 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн зарчмыг нийт хүн ам, ялангуяа дайтаж байгаа зэвсэгт хүчин, эмнэлгийн ажилтан болон шашны төлөөлөгчдөд таниулах үүднээс энэхүү конвенцийн эх бичвэрийг өөрийн оронд аль болох өргөнөөр түгээн сурталчлах, тухайлбал түүний талаар цэргийн, боломжтой бол иргэний сургалтын хөтөлбөрт оруулах үүргийг дайны цагийн адил тайван цагт хүлээнэ.

*49 дүгээр зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн албан ёсны орчуулга болон түүнийг хэрэглэх явдлыг хангахын тулд баталж болох хууль, журмыг тайван цагт Швейцарийн холбооны зөвлөлөөр, дайтах ажиллагааны үед хамгаалагч гүрнээр дамжуулан өөр хоорондоо хүргүүлнэ.

### VIII бүлэг

## УРВУУЛАН ХЭРЭГЛЭХ, ЗӨРЧИХ ЯВДЛЫГ ТАСЛАН ЗОГСООХ

#### 50 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд дараагийн зүйлд тодорхойлсон энэхүү конвенцийн ноцтой зөрчлийг үйлдэж байгаа буюу үйлдэхийг тушаасан этгээдэд үр дүнтэй эрүүгийн ял хүлээлгэхэд шаардлагатай аливаа хууль тогтоомжийг батлах үүрэг хүлээнэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр ийм ноцтой зөрчлийг үйлдсэн буюу үйлдэхийг тушаасан гэж буруутгагдаж байгаа этгээдийг эрж олох, түүний харьяаллыг үл харгалзан өөрийн шүүхэд шилжүүлэх үүрэг хүлээнэ. Тухайн тал хүсвэл өөрийн хууль тогтоомжийн заалтад нийцүүлэн тийм этгээдийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд өөр холбогдох талын шүүхэд шилжүүлж болох бөгөөд чингэхдээ хэлэлцэн тохирогч эрхэм дээд тухайн тал нь *prima facie* хэрэг үүсгэсэн байвал зохино.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр дараагийн зүйлд тодорхойлсон ноцтой зөрчлөөс бусад энэхүү конвенцийн заалтад харш бүх үйлдлийг таслан зогсооход шаардлагатай арга хэмжээг авна.

Яллагдаж байгаа этгээд ямар ч нөхцөл байдалд Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 105 дугаар зүйл болон түүний дараагийн зүйлүүдэд зааснаас дордуулахааргүй шүүх болон өмгөөллийн зохих ажиллагааны баталгаа эдлэнэ.

#### 51 дүгээр зүйл

Өмнөх зүйлд дурдсан ноцтой зөрчил нь энэхүү конвенцоор хамгаалагдаж байгаа этгээд буюу эд хөрөнгийн эсрэг үйлдсэн дараахь аливаа үйлдлийг оролцуулсан зөрчил байна: санаатайгаар амийг нь хөнөөх, эрүүдэн шүүх буюу хүнлэг бусаар харьцах, түүний дотор биологийн туршилт хийх, бие махбодь буюу эрүүл мэндэд үлэмж шаналал буюу ноцтой гэмтэл санаатайгаар учруулах, түүнчлэн дайны шаардлагаар зөвтгөх боломжгүйгээр бөгөөд хууль бусаар болон дур зоргоор эд хөрөнгө их хэмжээгээр эвдэж сүйтгэх буюу ашиглан завших.

#### 52 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд аль ч талд өмнөх зүйлд дурдсан зөрчлийн талаар өөрөө хүлээсэн буюу хэлэлцэн тохирогч эрхэм дээд өөр талаас хүлээлгэх хариуцлагаас өөрийгөө буюу хэлэлцэн тохирогч эрхэм дээд өөр талыг чөлөөлөхийг зөвшөөрөхгүй.

#### 53 дугаар зүйл

Мөргөлдөөнд оролцогч талын хүсэлтээр мөрдөн байцаалтыг сонирхогч талуудын хооронд тохиролцсон журмаар Конвенцийн аливаа зөрчилтэй холбогдуулан эхлүүлнэ.

Хэрэв мөрдөн байцаалтын журмын талаар тохиролцоонд хүрч чадаагүй бол талууд дагаж мөрдөх журмыг шийдвэрлэх зуучлагчийг тохиролцон сонгоно.

Нэгэнт зөрчил гарсныг тогтоосон тохиолдолд мөргөлдөөнд оролцогч талууд түүнийг дуусгавар болгож, аль болох хойшлуулахгүй таслан зогсооно.

## **ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ**

### *54 дүгээр зүйл*

Энэхүү конвенцийг англи, франц хэлээр үйлдэв. Хоёр эх бичвэр нь адил хүчинтэй байна.

Швейцарийн холбооны зөвлөл Конвенцийн орос, испани хэлний албан ёсны орчуулгыг зохион байгуулна.

### *55 дугаар зүйл*

Энэ өдрийн он, сар, өдрөөр тэмдэглэгдэх энэхүү конвенц 1949 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Женев хотноо нээгдсэн бага хуралд оролцсон гүрнүүд, түүнчлэн уг бага хуралд оролцоогүй боловч 1906 оны Женевийн конвенцийн зарчмыг далайд дайтахад зохицуулан хэрэглэх 1907 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Гаагийн Х конвенц эсхүл Дайны талбарт цэргийн шархадсан ба өвчтэй этгээдэд тусламж үзүүлэх тухай 1864, 1906 буюу 1929 оны Женевийн конвенцуудад оролцогч болох гүрнүүдийн нэрийн өмнөөс 1950 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

### *56 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг аль болох түргэн соёрхон батлах бөгөөд батламж жуух бичгийг Берн хотноо хадгалуулна.

Швейцарийн холбооны зөвлөл хадгалуулахаар өгсөн батламж жуух бичиг бүрийн бүртгэл хөтөлж, энэ бүртгэлийн баталгаатай хуулбарыг нэрийн нь өмнөөс Конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсноо мэдэгдсэн бүх гүрэнд дамжуулна.

### *57 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь хоёроос доошгүй батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Түүнээс хойш энэ нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрийн хувьд батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

*58 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын хоорондын харилцаанд 1906 оны Женевийн конвенцийн зарчмыг далайд дайтахад зохицуулан хэрэглэх 1907 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Гаагийн X конвенцийг орлоно.

*59 дүгээр зүйл*

Энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш түүнд нэрийн нь өмнөөс гарын үсэг зураагүй аливаа гүрний хувьд нэгдэн ороход нээлттэй байна.

*60 дугаар зүйл*

Нэгдэж орсноо Швейцарийн холбооны зөвлөлд бичгээр мэдэгдэх бөгөөд ийнхүү нэгдэж орсон нь тухайн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Швейцарийн холбооны зөвлөл нэгдэн орсон талаар нэрийн нь өмнөөс Конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсноо мэдэгдсэн бүх гүрэнд мэдэгдэнэ.

*61 дүгээр зүйл*

Дайтах ажиллагаа буюу эзлэлт эхлэхээс өмнө буюу эхэлсний дараа мөргөлдөөнд оролцогч талуудын хадгалуулсан батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай мэдэгдэл 2, 3 дугаар зүйлд заасан тохиолдолд нэн даруй хүчин төгөлдөр болно. Швейцарийн холбооны зөвлөл мөргөлдөөнд оролцогч талуудаас хүлээн авсан соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай аливаа мэдэгдлийг хамгийн түргэн аргаар хүргүүлнэ.

*62 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр энэхүү конвенцийг цуцлах эрхтэй.

Цуцлах тухайгаа Швейцарийн холбооны зөвлөлд бичгээр мэдэгдэх бөгөөд түүнийг Швейцарийн холбооны зөвлөл хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талын засгийн газарт дамжуулна.

Цуцлалт нь цуцлах тухай Швейцарийн холбооны зөвлөлд мэдэгдсэнээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно. Гэвч цуцалж буй гүрэн мөргөлдөөнд оролцож байгаа үед цуцлах тухай мэдэгдсэн тохиолдолд цуцлалт нь энх тайван зарлах болон энэхүү конвенцоор хамгаалагдах этгээдүүдийг суллаж, эх оронд нь буцаах ажиллагаа дуусах хүртэл хүчин төгөлдөр болохгүй.

Цуцлалт нь зөвхөн цуцалж буй гүрний хувьд хүчинтэй байна. Энэ нь дэлхийн соёл иргэншилт ард түмнүүдийн хооронд тогтсон заншил, хүнлэг ёсны хууль болон олон нийтийн ухамсарт ёс суртахуунаас үндэстэй олон улсын эрх зүйн зарчмын дагуу мөргөлдөөнд оролцогч талуудын заавал биелүүлэх ёстой хэвээр байх үүрэгт хэрхэвч нөлөөлөхгүй.

*63 дугаар зүйл*

Швейцарийн холбооны зөвлөл энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ. Мөн Швейцарийн холбооны зөвлөл нь энэхүү конвенцийг соёрхон батласан, түүнд нэгдэж орсон болон түүнийг цуцалсан тухай мэдэгдлийг хүлээн авсан талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлнэ.

Хэмээснийг нотлон дор гарын үсэг зурагчид бүрэн эрхээ хадгалуулж энэхүү конвенцид гарын үсэг зурцгаав.


1949 оны 8 дугаар сарын арван хоёрны өдөр Женев хотноо англи, франц хэлээр үйлдэв. Жинхэнэ эхийг Швейцарийн Холбооны Улсын архивт хадгална. Швейцарийн холбооны зөвлөл түүний баталгаатай хуулбарыг гарын үсэг зурсан болон нэгдэж орсон улс бүрт дамжуулна.

**ХАВСРАЛТ**

Тэнгисийн зэвсэгт хүчний дэргэдэх  
эмнэлгийн болон шашны ажилтнуудад олгох үнэмлэх

**Нүүрэн тал**

(Энэ үнэмлэхийг олгож буй орон, цэргийн  
эрх бүхий байгууллагын нэр бичихэд зориулсан зай)



Тэнгисийн зэвсэгт хүчний дэргэдэх  
эмнэлгийн болон шашны ажилтнуудад олгох  
**ҮНЭМЛЭХ**

Овог .....  
Нэр .....  
Төрсөн он, сар, өдөр .....  
Цол, зэрэг .....  
Цэргийн ангийн дугаар .....

Энэхүү үнэмлэхийг эзэмшигч нь Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтөн  
болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах  
тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцоор  
..... хувьд хамгаалагдах болно.

.....  
Олгосон он, сар, өдөр

.....  
Үнэмлэхийн дугаар



**Ар тал**

Үнэмлэх  
эзэмшигчийн  
гэрэл зураг

Үнэмлэх эзэмшигчийн гарын үсэг буюу  
хурууны хээ, эсхүл аль аль нь

Үнэмлэх олгож  
буй цэргийн эрх  
бүхий  
байгууллагын  
товгор тамга

Өндөр

Нүд

Үс

Бусад содон тэмдэг

## **90. ДАЙНД ОЛЗЛОГДОГЧИДТОЙ ХАРЬЦАХ ТУХАЙ ЖЕНЕВИЙН (III) КОНВЕНЦ**

*1949 оны 8 дугаар сарын 12-ны өдөр баталж,  
1950 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон\**

### Удиртгал

Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1929 оны 7 дугаар сарын 27-ны Женевийн конвенцийг хянан өөрчлөх зорилгоор 1949 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс 8 дугаар сарын 12-ны өдөр хүртэл Женев хотноо болсон Дипломат бага хуралд засгийн газраа төлөөлж оролцон дор гарын үсэг зурсан бүрэн эрхт төлөөлөгчид дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

### **I АНГИ**

#### **НИЙТЛЭГ ЗААЛТ**

##### *1 дүгээр зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийг бүх нөхцөл байдалд хүндэтгэн сахих буюу хүндэтгэн сахих явдлыг хангах үүрэг хүлээнэ.

##### *2 дугаар зүйл*

Тайван цагт хэрэгжүүлэх заалтуудын сацуу хоёр буюу хэд хэдэн хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын хооронд үүсч болох зарласан дайн буюу аливаа бусад зэвсэгт мөргөлдөөний бүх тохиолдолд тэдгээр талын аль нэг нь дайны байдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан ч энэхүү конвенцийг хэрэглэнэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн буюу бүхэлд нь эзэлсэн бүх тохиолдолд тухайн эзлэлт нь зэвсэгт эсэргүүцэлтэй тулгараагүй байсан ч энэхүү конвенцийг мөн хэрэглэнэ.

Хэдийгээр мөргөлдөөнд оролцогч гүрнүүдийн аль нэг нь энэхүү конвенцид оролцогч тал биш байсан ч түүнд оролцогч тал болох гүрнүүд өөр хоорондын харилцаандаа энэхүү конвенцийг заавал биелүүлэх үүрэгтэй хэвээр байна. Үүнээс гадна хэрэв дээр дурдсан гүрэн энэхүү конвенцийн заалтыг хүлээн авч хэрэглэвэл түүний хувьд конвенцид оролцогч тал болох гүрнүүд энэхүү конвенцийг заавал биелүүлэх үүрэгтэй байна.

---

\* Монгол Улс 1958.11.05-нд нэгдэн орсон

*3 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нэгний нь нутаг дэвсгэрт үүсэх олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний тохиолдолд тухайн мөргөлдөөнд оролцогч тал бүр наад зах нь дараахь заалтыг хэрэглэх үүрэг хүлээнэ:

(1) Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй этгээд, түүний дотор байлдахаа зогсоосон болон өвчлөх, шархдах, саатуулагдах буюу аливаа бусад шалтгааны улмаас байлдаанд оролцоогүй зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний этгээдтэй арьс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, гарал үүсэл, эд хөрөнгийн байдал буюу бусад төсөөтэй шалгуурт үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр бүх нөхцөл байдалд хүнлэг харьцана.

Энэ үүднээс дараахь үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хийхийг хэзээ ч, хаана ч хориглоно:

а) амь нас, бие махбодид халдах, тухайлбал, бүхий л хэлбэрээр амийг нь хөнөөх, хүнд гэмтэл учруулах, харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;

б) барьцаанд авах;

с) хүний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах;

д) соёл иргэншилт ард түмнүүдийн зайлшгүй гэж хүлээн зөвшөөрсөн шүүхийн бүх баталгаагаар хангаж, байнгын ажиллагаатай шүүхээс урьдчилан гаргасан шийдвэргүйгээр ял шийтгэх болон ял эдлүүлэх.

(2) Шархтан болон өвчтөнг олж авч тусламж үзүүлнэ. Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хараат бус хүмүүнлэгийн байгууллага мөргөлдөөнд оролцогч талуудад өөрийн үйлчилгээг санал болгож болно.

Мөргөлдөөнд оролцогч талууд тусгай хэлэлцээр байгуулах замаар энэхүү конвенцийн бусад заалтыг бүгдийг буюу хэсэгчлэн хүчин төгөлдөр болгохыг цаашид чармайна.

Өмнөх заалтуудыг хэрэглэх явдал мөргөлдөөнд оролцогч талуудын эрх зүйн байдлыг хөндөхгүй.

*4 дүгээр зүйл*

А. Дор дурдсан ангилалд багтаж байгаа этгээд дайсагнагч талынхаа гарт орсон тохиолдолд тэднийг энэхүү конвенцид заасны дагуу дайнд олзлогдогчид гэж үзнэ:

(1) Мөргөлдөөнд оролцогч талын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, мөн зэвсэгт хүчний хэсэг болж буй журамт цэрэг буюу сайн дурын ангийн бие бүрэлдэхүүн.

(2) Мөргөлдөөнд оролцогч талд харьяалагдах бөгөөд энэ нутаг дэвсгэр нь эзлэгдсэн байсан ч өөрийн нутаг дэвсгэрт буюу түүний гадна үйл ажиллагаа явуулж буй бусад журамт цэргийн болон сайн дурын бусад ангийн бие бүрэлдэхүүн, түүний дотор эсэргүүцлийн зохион байгуулалттай хөдөлгөөний бие бүрэлдэхүүн, чингэхдээ эдгээр журамт цэрэг буюу сайн дурын анги, түүний дотор зохион байгуулалттай эсэргүүцлийн хөдөлгөөн нь дараахь нөхцөлийг хангасан байвал:

(a) захирагдагсдынхаа төлөө хариуцлага хүлээх этгээдээр удирдуулсан байх;

(b) алсаас танигдах тогтсон ялгах тэмдэгтэй байх;

(с) зэвсгээ ил авч явах;

(d) үйл ажиллагаагаа дайны хууль, заншилд нийцүүлэн явуулж байх.

(3) Олзлогч гүрэн хүлээн зөвшөөрөөгүй засгийн газар буюу эрх бүхий байгууллагыг дэмжиж буй байнгын зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн.

(4) Цэргийн агаарын хөлгийн багийн гишүүн болох энгийн иргэд, цэргийн сурвалжлагчид, хангамж түгээгчид, ажлын баг буюу зэвсэгт хүчний ахуйн үйлчилгээний гишүүд зэрэг зэвсэгт хүчний жинхэнэ бие бүрэлдэхүүн биш боловч тэднийг дагалдан яваа этгээд, чингэхдээ тэд дагалдаж яваа зэвсэгт хүчнээсээ зөвшөөрөл авсан, хавсралтад дурдсан зохих загварын хувийн үнэмлэхтэй байвал зохино.

(5) Олон улсын эрх зүйн аливаа бусад заалтын дагуу илүү тааламжтай нөхцөл эдэлдэггүй мөргөлдөөнд оролцогч талуудын худалдааны усан цэргийн багийн гишүүд, түүний дотор ахмад, замчин болон дагалдан сурагч, түүнчлэн иргэний агаарын хөлгийн баг.

(6) Дайсан ойртож ирэхэд, байнгын зэвсэгт нэгж болж бүрэлдэж амжилгүй, орж ирж буй хүчнийг эсэргүүцэхээр гэнэт зэвсэг барьж буй эзлэгдээгүй нутаг дэвсгэрийн оршин суугчид, чингэхдээ тэд зэвсгээ ил авч явж, дайны хууль, заншлыг хүндэтгэн сахивал зохино.

В. Энэхүү конвенцид заасны дагуу дор дурдсан этгээдтэй дайнд олзлогдогчдын нэгэн адил харьцана:

(1) Дайтах ажиллагаа эзлэгдсэн нутгийн гадна явагдаж байх үед эзлэгч гүрэн эхлээд чөлөөлсөн хэдий ч, ялангуяа эдгээр хүмүүс дайтах ажиллагаанд оролцож байгаа зэвсэгт хүчинтэйгээ нэгдэх бүтэлгүй оролдлого хийсэн, эсхүл тусгаарлан хорих зорилгоор хийсэн дуудлагад үл захирагдсан тохиолдолд эзлэгч гүрэн тэднийг цэргийн харъяллыг нь харгалзан тусгаарлан хорих шаардлагатай гэж үзсэн эзлэгдсэн орны зэвсэгт хүчинд харьяалагдаж байгаа эсхүл харьяалагдаж байсан хүмүүс.

(2) Төвийг сахисан болон дайнд оролцоогүй гүрнүүд өөрийн нутаг дэвсгэр дээрээ хүлээж авсан бөгөөд эдгээр хүмүүст илүү тааламжтай нөхцөл олгож болох боловч тэднийг олон улсын эрх зүйн дагуу тусгаарлан хорихыг шаардсан энэ зүйлд дурдсан ангиллын аль нэгэнд хамаарагдах хүмүүс. Эдгээр хүмүүст 8, 10, 15 дугаар зүйл, 30 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 58 -аас 67 дугаар зүйл, 92, 126 дугаар зүйлийн заалтууд хамаарахгүй бөгөөд мөргөлдөөнд оролцогч талууд болон холбогдох төвийг сахисан гүрэн, эсхүл дайнд оролцоогүй гүрний хооронд дипломат харилцаатай байвал тус конвенцийн хамгаалагч гүрний талаархи заалтууд ч эдгээр хүмүүст хамаарахгүй. Хоорондоо дипломат харилцаатай бөгөөд эдгээр хүмүүс харьяалалд нь багтаж байгаа мөргөлдөөнд оролцогч талууд энэхүү конвенцид заасан хамгаалагч гүрний эрх үүргийг өөрсдийн дипломат болон консулын практик, гэрээний дагуу биелүүлэх үүргээ хөндөхгүйгээр хэрэгжүүлнэ.

С. Энэ зүйл нь тус конвенцийн 33 дугаар зүйлд заасан эмнэлгийн болон шашны ажилтны эрх зүйн байдлыг ямар ч хэлбэрээр хөндөхгүй.

*5 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг 4 дүгээр зүйлд дурдсан этгээдийн хувьд дайсагнагч талынхаа гарт орсноос эхлээд бүрмөсөн чөлөөлөгдөх буюу солилцох үе хүртэл хэрэглэнэ.

Байлдаж байсан этгээд дайсагнагч талынхаа гарт орсны дараа тэднийг 4 дүгээр зүйлд дурдсан ангиллын аль нэгэнд хамааруулах талаар эргэлзээ төрөх тохиолдолд эрх зүйн байдлыг нь холбогдох шүүх тодорхойлох хүртэл тэд энэхүү конвенцийн хамгаалалтад байна.

*6 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн 10, 23, 28, 33, 60, 65, 66, 67, 72, 73, 75, 109, 110, 118, 119, 122 болон 132 дугаар зүйлд тусгайлан заасан хэлэлцээрээс гадна тусад нь зохицуулах шаардлагатай гэж үзсэн аливаа асуудлаар тусгай хэлэлцээр байгуулж болно. Харин тусгай хэлэлцээр нь энэхүү конвенцоор тогтоосон дайнд олзлогдогчдын байдалд хохирол учруулж тэдэнд олгосон эрхийг хязгаарлах ёсгүй.

Эдгээр хэлэлцээр болон дээр дурдсан зүйлүүдэд өөрчлөлт оруулах буюу мөргөлдөөнд оролцогч талуудын аль нэг нь үүнээс илүү тохиромжтой арга хэмжээ авахаас бусад тохиолдолд дайнд олзлогдогчид энэхүү конвенцийг хэрэглэж эхлэх хүртэл дээрх хэлэлцээрийн хөнгөлөлтийг эдэлсээр байх болно.

*7 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчид нь энэхүү конвенц болон өмнөх зүйлд дурдсан тусгай хэлэлцээрээр олгогдсон эрхийг эдлэхээс ямар ч нөхцөлд хэсэгчлэн буюу бүрэн татгалзаж болохгүй.

*8 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий хамгаалагч гүрний дэмжлэг, хяналтын дор энэхүү конвенцийг хэрэглэнэ. Эл зорилгоор хамгаалагч гүрнүүд өөрийн дипломат болон консулын ажилтнуудаас тусдаа өөрийн орны, эсхүл төвийг сахисан бусад гүрний харьяатаас бүрдсэн төлөөлөгчдийг томилж болно. Дурдсан төлөөлөгчдийг томилохдоо тэдний очиж ажиллах гүрний зөвшөөрлийг авна.

Мөргөлдөөнд оролцогч талууд хамгаалагч гүрний төлөөлөгчдийн ажлыг аль болох боломжтой хэмжээнд хөнгөвчлөн дэмжинэ.

Хамгаалагч гүрний төлөөлөгчид ажлаа явуулахдаа ямар ч тохиолдолд энэхүү конвенцийн дагуу хүлээсэн зорилгот үүргээсээ хэтэрч болохгүй. Ялангуяа тэд нутаг дэвсгэрт нь үүргээ биелүүлж байгаа улсын аюулгүй байдлын зайлшгүй шаардлагыг харгалзан үзнэ.

*9 дүгээр зүйл*

Энэхүү конвенцийн заалт нь Олон улсын улаан загалмайн хороо буюу аливаа бусад хүмүүнлэгийн хараат бус байгууллагаас олзлогдогчдыг асарч хамгаалах, тэдэнд тусламж үзүүлэх талаар тухайн мөргөлдөөнд оролцогч талуудын зөвшөөрөлтэйгөөр явуулах хүмүүнлэгийн үйл ажиллагаанд саад болохгүй.

*10 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн дагуу хамгаалагч гүрнүүдэд хүлээлгэсэн үүргийг хараат бус бөгөөд үр ашигтай байх бүх баталгааг гаргаж буй байгууллагад олгохоор хэдийд ч тохиролцож болно.

Дайнд олзлогдогчид аль нэг хамгаалагч гүрэн болон дээрх эхний хэсэгт заасан байгууллагын үйл ажиллагаанаас ямар нэгэн шалтгааны улмаас ашиг тус хүртэхгүй, эсхүл хүртэхээ болих тохиолдолд олзлогч гүрэн мөргөлдөөнд оролцогч талуудын томилсон хамгаалагч гүрний энэхүү конвенцийн дагуу биелүүлж буй чиг үүргийг хүлээхийг төвийг сахисан улс, эсхүл тийм байгууллагаас хүснэ.

Хэрэв хамгаалалтыг ийнхүү хэрэгжүүлж чадахгүй бол олзлогч гүрэн нь хамгаалагч гүрнүүдийн энэхүү конвенцийн дагуу биелүүлж буй хүмүүнлэгийн чиг үүргийг өөртөө хүлээх талаар Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хүмүүнлэгийн байгууллагаас санал болгохыг хүсэх буюу ийм саналыг энэ зүйлийн заалтын дагуу хүлээн авна.

Төвийг сахисан аливаа гүрэн, эсхүл холбогдох гүрний урьсан буюу эл зорилгоор өөрийгөө санал болгож буй байгууллага энэхүү конвенцоор хамгаалдаг этгээдийг харьяалж буй мөргөлдөөнд оролцогч талын өмнө хариуцлагаа ухамсарлан үйл ажиллагаа явуулах шаардлагатай, түүнчлэн зохих чиг үүрэг хүлээж, уг чиг үүргээ хараат бусаар биелүүлэх чадвартай гэсэн хангалттай баталгаа гаргах шаардлагатай.

Аль нэг гүрэн дайны үйл явдлаас шалтгаалан, ялангуяа түүний нутаг дэвсгэр бүхэлдээ, эсхүл түүний үлэмж хэсэг нь эзлэгдсэн тохиолдолд нөгөө гүрэн буюу түүний холбоотонтой хэлэлцээ хийх эрх чөлөө нь түр хугацаагаар ч гэсэн хязгаарлагдсан бол тэдгээрийн хооронд байгуулсан тусгай хэлэлцээрээр өмнөх заалтуудыг зөрчихгүй.

Энэхүү конвенцид хамгаалагч гүрэн гэж дурдах бүрд энэ нэр томъёог энэ зүйлийн дагуу түүнийг орлох байгууллагад ч мөн хэрэглэнэ.

*11 дүгээр зүйл*

Хамгаалагч гүрнүүд хамгаалагдсан хүмүүсийн ашиг сонирхолд хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд, ялангуяа энэхүү конвенцийн заалтыг хэрэглэх буюу тайлбарлах талаар мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд санал зөрөлдсөн тохиолдолд саналын зөрөлдөөнийг зохицуулах үүднээс асуудалд оролцоно.

Эл зорилгоор хамгаалагч гүрэн бүр аль нэг талын урилгаар буюу өөрийн санаачилгаар тэдгээрийн төлөөлөгчдийн, ялангуяа дайнд олзлогдогчдын асуудлыг хариуцаж буй эрх бүхий байгууллагын нь уулзалтыг зохион явуулах саналыг мөргөлдөөнд оролцогч талуудад тавьж болох бөгөөд чингэхдээ тохиромжтой гэж сонгож авсан төвийг сахигч нутагт дэвсгэрт боломжтой бол зохион байгуулна. Мөргөлдөөнд оролцогч талууд эл зорилгоор тэдэнд тавьсан саналыг хүчин төгөлдөр хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Шаардлагатай бол хамгаалагч гүрнүүд ийм уулзалтад оролцохыг урих төвийг сахисан гүрэнд харьяалагдах, эсхүл Олон улсын улаан

загалмайн хорооноос томилсон этгээдийг мөргөлдөөнд оролцогч талуудаар дэмжүүлэн батлуулахаар санал болгож болно.

## II АНГИ

### ДАЙНД ОЛЗЛОГДОГЧДЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ

#### ЕРӨНХИЙ ЗААЛТ

##### *12 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчид нь тэднийг олзолж авсан хүмүүс буюу цэргийн ангийн эрх мэдэлд бус зөвхөн дайсагнагч гүрний мэдэлд байна. Дайнд олзлогдогчидтой харьцах талаархи хариуцлагыг ямар нэгэн хувь хүмүүс хүлээхээс гадна олзолж авсан гүрэн бүрэн хариуцна.

Дайнд олзлогдогчдыг олзолж авсан гүрэн энэхүү конвенцийн оролцогч тал болох гүрэнд тэднийг шилжүүлж өгч болох боловч тэднийг хүлээн авахыг хүссэн гүрэн энэхүү конвенцийг хэрэглэх хүсэлтэй буюу хэрэглэж чадах эсэхийг нотлосны үндсэн дээр гүйцэтгэнэ. Дайнд олзлогдогчдыг ийм нөхцлийн дагуу хүлээн авснаас хойш конвенцийг хэрэглэх хариуцлагыг хүлээн авагч гүрэн тэднийг хараа хяналтандаа байлгах хугацаанд хүлээнэ.

Хэрэв тухайн гүрэн конвенцийн аливаа чухал заалтыг биелүүлээгүй бол хамгаалагч гүрнээс энэ тухай мэдээ хүлээн авмагц дайнд олзлогдогчдыг хүлээлгэн өгсөн гүрэн конвенц зөрчсөн тухайн байдлыг засч залруулах, эсхүл дайнд олзлогдогчдыг буцааж өгөхийг шаардах зэрэг үр дүнтэй арга хэмжээнүүдийг авна. Ийм шаардлагыг заавал биелүүлэх ёстой.

##### *13 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчидтой үргэлж хүнлэг энэрэнгүй харьцах ёстой. Олзлогч гүрэн өөрийн хараа хяналтанд байгаа олзлогдогчдын амь насыг хөнөөх, эсхүл эрүүл мэндэд ноцтой аюултай хууль бус аливаа үйлдэл буюу эс үйлдэл хийхийг хориглох бөгөөд ийм үйл ажиллагааг энэхүү конвенцийн ноцтой зөрчил гэж үзнэ. Тухайлбал дайнд олзлогдогчдын бие эрхтэнд гэмтэл учруулах, эсхүл тэдний ашиг сонирхолд нийцээгүй эмнэлгийн ёс зүйгээс гадуур аливаа төрлийн шинжлэх ухаан буюу анагаах ухааны туршилт үйлдэж болохгүй.

Түүнчлэн дайнд олзлогдогчид нь хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, эсхүл тэднийг элдвээр доромжлох, олны өмнө гутаах зэргээс үргэлж хамгаалагдсан байх ёстой.

Дайнд олзлогдогчдын эсрэг хонозогносон арга хэмжээ авахыг хориглоно.

##### *14 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчид нь бүх нөхцөл байдалд нэр төр болон хүнийхээ хувьд хүндэтгэл хүлээх эрхтэй.

Нийтээр хүлээн зөвшөөрч заншсаны дагуу эмэгтэйчүүдийг эрхэмлэн хүндэтгэх бөгөөд тэдэнтэй харьцахдаа бүх тохиолдолд эрэгтэйчүүдээс дордуулахгүй байвал зохино.

Дайнд олзлогдогчид олзлогдох үедээ эдэлж байсан иргэний эрх зүйн чадамжаа бүрэн хэмжээгээр хадгална. Дайнд олзлогдогчид өөрсдийн эрх зүйн чадамжийн дагуу олсон эрхээ хэрэгжүүлэх явдлыг олзлогч гүрэн зөвхөн олзлогдсон нөхцөл байдал шаардахаас бусад тохиолдолд өөрийн нутаг дэвсгэр дээр буюу түүний гадна хязгаарлахгүй.

#### *15 дугаар зүйл*

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчидтой холбогдох зардлыг хариуцаж даахын хамт тэдний эрүүл мэндийн байдал шаардаж байгаа тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх үүрэгтэй.

#### *16 дугаар зүйл*

Олзлогч гүрэн энэхүү конвенцийн цол хэргэм болон хүйстэй холбогдох заалтыг анхааралдаа авч, дайнд олзлогдогчид эрүүл мэндийн байдал, насны ялгаа, мэргэшил зэргийг нь үндэслэн тусгай дэглэм олгохоос бусад тохиолдолд арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил, эдгээртэй төсөөтэй шалгуурыг үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр бүх олзлогдогчидтой адил тэгш харьцана.

### **III АНГИ**

### **ОЛЗЛОЛТ**

### **I ХЭСЭГ**

#### **Олзлолтын эхний үе**

#### *17 дугаар зүйл*

Олзлогдогч бүр байцаалгахдаа зөвхөн овог нэр, цол хэргэм, төрсөн он, аль армид харьяагдах, түүнчлэн хорооны болон хувийн дугаарыг мэдээлэх, эсхүл эдгээртэй дүйцэхүйц мэдээлэл өгөх үүрэг хүлээнэ.

Олзлогдогч хэрэв энэ журмыг санаатай зөрчсөн тохиолдолд түүнд цол хэргэмийн дагуу олгох давуу эрхийг нь хязгаарлаж болно.

Мөргөлдөөнд оролцогч тал бүрээс дайнд олзлогдогч болж болох өөрийн орны харьят этгээдэд түүний овог нэр, цол хэргэм, арми, хорооны болон хувийн дугаар, эсхүл эдгээртэй дүйцэхүйц мэдээлэл болон төрсөн огноог заасан хувийн үнэмлэхийг олгохыг шаардана. Энэхүү хувийн үнэмлэх нь эзэмшигчдийн гарын үсэгтэй, эсхүл хурууны хээтэй, эсхүл хоёуланг байлгаж болох бөгөөд мөргөлдөөнд оролцогч тал өөрийн зэвсэгт хүчний хүмүүсийн талаар нэмж оруулсан өөр бусад мэдээллийг агуулж болно. Хувийн үнэмлэх нь аль болох 6.5 x 10 см-ийн хэмжээтэй байх бөгөөд хуулбартай байна. Дайнд олзлогдогчид хувийн үнэмлэхээ шаардсан тухай бүрт гаргаж үзүүлэх боловч түүнийг ямар ч нөхцөлд хураан авч болохгүй.

Олзлогдогчоос ямар нэгэн мэдээлэл олж авахын тулд тэдэнд хүч хэрэглэх буюу сэтгэл санааны дарамт, эрүү шүүлт тулгаж болохгүй. Дайнд олзлогдогчид асуултад



хариулахаас татгалзах тохиолдолд тэднийг айлган сүрдүүлж, доромжлон гутааж, ямар нэг хэлбэрээр мөрдөн мөшгөж, хязгаарлалт тогтоож болохгүй.

Дайнд олзлогдогчид өөрийн бие махбодь болон сэтгэл санааны байдлаас болж биеийн байцаалтын талаар хариулт өгч чадахгүй бол түүнийг эмнэлгийн албаны хяналтад шилжүүлнэ. Тэдгээрийн биеийн байцаалтыг энэ зүйлийн эхний хэсэгт дурдсан заалтыг баримтлан бүхий л бололцоотой арга замаар олж тогтооно.

Дайнд олзлогдогчдын байцаалтыг тэдэнд ойлгомжтой хэлээр явуулна.

### *18 дугаар зүйл*

Зэвсэг, унаа морь, цэргийн хэрэглэл, цэргийн баримт бичгүүдээс бусад хувийн хэрэглээний эд хогшил, зүйлс мөн түүнчлэн тэднийг хамгаалахаар тавьж олгосон төмөр дуулга, хорт утааны баг зэрэг зүйлийг дайнд олзлогдогчдын мэдэлд нь үлдээнэ. Түүнээс гадна цэргийн хувцас эдлэл, хүнс хоолонд зориулсан зүйлүүдийг тэдгээр нь цэргийн тоног төхөөрөмжид зориулсан байсан ч олзлогдогчдод өөрт нь үлдээнэ.

Дайнд олзлогдогчид хувийн үнэмлэхээ үргэлж өөртөө авч явна. Харин үнэмлэхгүй олзлогдогчдод олзлогч гүрэн хувийн үнэмлэх олгоно.

Дайнд олзлогдогчдын биед байгаа ялгах тэмдэг, харьяалах улсын тэмдэг, гавьяа шагнал зэрэг хувийн чанартай зүйлийг хурааж авч болохгүй.

Дайнд олзлогдогчдын биед байгаа мөнгийг гаргуулан авахдаа зөвхөн офицерийн өгсөн тусгай тушаалын дагуу гүйцэтгэх бөгөөд хэдий хэмжээний мөнгө байгаа болон түүнийг эзэмшигчийн тухай тодорхой бүртгэж, мөнгө авсан хүний нэр овог, цол хэргэм, цэргийн анги болон гарын үсэг зурсан бичгийг олгох үндсэн дээр гүйцэтгэнэ. Олзлогч гүрний валютаар байгаа мөнгө буюу дайнд олзлогдогчдын хүсэлтээр уг валютад шилжүүлэн сольсон мөнгийг 64 дүгээр зүйлд заасны дагуу дайнд олзлогдогчдын нэрийн дансанд шилжүүлнэ.

Дайнд олзлогдогчдын биед байгаа үнэт зүйлсийг олзлогч гүрэн зөвхөн аюулгүй байдлын үндэслэлээр хурааж авч болно. Чингэхдээ мөнгө гаргуулан авахад мөрдөх дээр дурдсан журмыг хэрэглэнэ.

Эдгээр зүйл болон дайнд олзлогдогчдын биед байгаа олзлогч гүрний валютаас өөр валютыг олзлогч гүрний валютад шилжүүлэхийг олзлогдогч өөрөө хүсээгүй тохиолдолд олзлогч гүрэн өөртөө хадгалах бөгөөд олзлолтын хугацаа дуусмагц дайнд олзлогдогчид анх хурааж авсан байдлаар нь буцааж олгоно.

### *19 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчдын аюулгүй байдлыг хангахын тулд тэднийг олзолсны дараа аль болох түргэн хугацаанд байлдааны талбараас алслагдсан газарт байрлах лагерьт нүүлгэн шилжүүлнэ.

Харин нүүлгэн шилжүүлэх үед амь насанд нь аюул учирч болзошгүй зөвхөн хүнд шархтай, өвчтэй олзлогдогчдыг аюултай бүсэд түр үлдээж болно.

Дайнд олзлогдогчдыг байлдааны талбараас нүүлгэн шилжүүлэхээр хүлээлгэж байх үед онц ноцтой шалтгаангүй бол аюулд өртүүлж болохгүй.

*20 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдыг нүүлгэн шилжүүлэхдээ байнга хүнлэг энэрэнгүй хандаж, олзлогч гүрэн өөрийнхөө цэргийг нүүлгэн шилжүүлэхтэй адил нөхцөл байдалд гүйцэтгэх ёстой.

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдыг нүүлгэн шилжүүлэхдээ ундны ус, хангалалттай хоол хүнсээр хангахын хамт шаардлагатай хувцас олгож эмнэлгийн туслалцаа үзүүлнэ. Мөн тэднийг нүүлгэн шилжүүлэх үед аюулгүй байдлыг нь хангахын тулд бүхий л боломжийн арга хэмжээг урьдчилан авч гүйцэтгэх бөгөөд нүүлгэн шилжүүлж буй дайнд олзлогдогчдын нэрсийн жагсаалтыг аль болох богино хугацаанд тодорхойлж гаргана.

Хэрэв дайнд олзлогдогчдыг нүүлгэн шилжүүлэхдээ дамжин өнгөрөх лагериудаар нэвтрүүлэх шаардлагатай бол тэнд байх хугацааг аль болох богиносгох арга хэмжээ авна.

## **II ХЭСЭГ**

### **Дайнд олзлогдогчдыг тусгаарлан хорих онцгой дэглэм**

#### **I бүлэг**

#### **Нийтлэг заалт**

*21 дүгээр зүйл*

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдыг тусгаарлан хорьж болох бөгөөд дайнд олзлогдогчдод байрлаж байгаа лагераа орхиж явахгүй байх, хэрэв лагерь хашаагаар хүрээлэгдсэн бол хашаанаас гарахгүй байх үүрэг хүлээлгэж болно. Эрүүгийн болон сахилгын арга хэмжээний талаархи энэхүү конвенцийн заалтуудад зааснаас бусад тохиолдолд олзлогдогчдыг цоожилж түгжсэн байранд хорьж, уг байрнаас гадагш явах эрхийг нь хасч болохгүй. Хэрэв олзлогдогчдын эрүүл мэндийг хамгаалах үүднээс ингэж хорих шаардлага байгаа бол зөвхөн уг шаардлага үүссэн нөхцөл байдал арилах хүртэлх хугацаанд хорьж болно.

Хэрэв харьяалах гүрний хуульд харшлахгүй бол олзлогдогчдын өгсөн тангараг буюу өөртөө авсан үүргийн нь үндсэн дээр тэдэнд бүрэн буюу хагас хязгаарлагдмал эрх чөлөө олгож болно. Энэ арга хэмжээг ихэвчлэн олзлогдогчдын эрүүл мэндийг сайжруулахад дөхөм үзүүлэх тохиолдолд хэрэглэнэ. Олзлогдогчоор чөлөөлөгдөхийг нь зөвшөөрүүлэхээр албадан тулгаж тангараг өргүүлж буюу үүрэг амлалт авахуулж болохгүй.

Мөргөлдөөнд оролцогч тал бүр өөрийн орныхоо иргэдийг тангараг өргүүлж, эсхүл үүрэг амлалт авхуулж чөлөөлөх явдлыг хууль тогтоомжоороо зөвшөөрдөг, эсхүл хориглодог талаар дайтах ажиллагаа эхлэх үед нөгөө талдаа мэдээлнэ. Тийнхүү мэдээлсэн хууль тогтоомжийн дагуу тангараг өргөж, эсхүл үүрэг амлалт авч чөлөөлөгдсөн дайнд олзлогдогч харьяалагдаж байгаа гүрэн, түүнчлэн олзлогч гүрний өмнө хүлээсэн үүргээ чин шударгаар чанд биелүүлэх үүрэгтэй. Харин энэ тохиолдолд харьяалах гүрэн нь дайнд олзлогдогчдоос хүлээсэн үүрэг, амлалтад нь харшлах өөр бусад зүйл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхийг шаардаж болохгүй.

### 22 дугаар зүйл

Дайнд олзлогдогчдын тусгаарлан хорих онцгой дэглэмд байлгахдаа гагцхүү тэдний эрүүл ахуйн болон эрүүл мэндийг хамгаалах баталгаатай хуурай газар байрлах байранд байлгана. Дайнд олзлогдогчдын ашиг сонирхолд нийцсэн онцгой шалтгаанаас бусад үед тэднийг шоронгийн байранд байлгаж болохгүй.

Эрүүл мэндэд муугаар нөлөөлөхүйц газар, эсхүл тэдний эрүүл мэндэд онцын тохиромжгүй уур амьсгалтай газарт тусгаарлан хорих онцгой дэглэмд байгаа олзлогдогчдыг аль болох богино хугацаанд тааламжтай газар шилжүүлнэ.

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдыг тусгай лагерьт тэдний үндэс угсаа, хэл, ёс заншлыг харгалзан, олзлогдох хүртлээ хамт алба хааж байсан зэвсэгт хүчний олзлогдогчдоос нь тусгаарлахгүйг бодолцон байрлуулна. Харин олзлогдогчид бие биеэсээ тусдаа байрлах талаар өөрсдөө санал илэрхийлбэл үүнийг нь харгалзана.

### 23 дугаар зүйл

Ямар ч үед дайнд олзлогдогчдыг байлдааны талбар, галын шугаманд өртөж болох газар уруу явуулах, эсхүл тэнд албадан саатуулж болохгүй бөгөөд тэднийг цэрэг дайны ямар нэгэн бэхлэлт районыг хамгаалуулах үйл ажиллагаанд ашиглаж болохгүй.

Дайнд олзлогдогчид нь орон нутгийн цэргийн бус хүн амын нэгэн адил агаарын довтолгоон болон дайны бусад аюулаас хамгаалахад зориулсан түр хоргодох байртай байна. Агаарын түгшүүрийн дохио өгмөгц олзлогдогчдын дотроос орон байраа хамгаалах үүрэгтэй этгээдээс бусад нь хоргодох байранд аль болох богино хугацаанд орсон байх хэрэгтэй. Цэргийн бус хүн амыг дайны аюулаас хамгаалах бусад арга хэмжээг дайнд олзлогдогчдын хувьд нэгэн адил хэрэглэх ёстой.

Олзлогч гүрнүүд дайнд олзлогдогчдыг байрлуулж буй лагерийн газар зүйн байрлалын талаархи шаардлагатай мэдээллийг хамгаалагч гүрнээр дамжуулан холбогдох гүрэнд өгнө.

Өдрийн цагт байлдааны цагийн боломжоор олзлогдогчдын лагерийг агаараас тод харагдах “PW” буюу “PG” гэсэн үсгээр онцлон тэмдэглэх ёстой. Холбогдох гүрнүүд өөр арга хэрэглэн тэмдэглэх тухайгаа хоорондоо тохиролцож болно. Зөвхөн дайнд олзлогдогчдын лагерь л ийм тэмдэгтэй байна.

### 24 дүгээр зүйл

Дамжин өнгөрөх болон түр байрлуулах байнгын ажилагаатай лагерь нь зохион байгуулалтынхаа хувьд энэ ангид заасан шаардлагад нийцсэн байх ёстой бөгөөд тэнд байгаа олзлогдогчдын хувьд бусад лагерьт тогтоосон дэглэмийг нэгэн адил баримтална.

## II бүлэг

### Дайнд олзлогдогчдын орон байр, хоол хүнс, хувцас

#### 25 дугаар зүйл

Лагерьт байгаа дайнд олзлогдогчдын ахуйн нөхцөл нь лагерийн орчим байрлаж байгаа олзлогч гүрний зэвсэгт хүчний ахуйн нөхцөлтэй адил таатай байх ёстой. Олзлогдогчдын байрлах орчин нөхцөл нь тэдний зан заншил, үндэсний өвөрмөц онцлогыг харгалзсан бөгөөд эрүүл мэндэд нь харшлахгүй байна.

Дайнд олзлогдогчдын байр болон түүний нийт талбай, нэг хүнд оногдох наад захын хэмжээ, нийтлэг тоноглол болон ор, хөнжил, дэвсгэр хэрэглэлийн тухайд дээр дурдсан заалтуудыг мөн хэрэглэнэ.

Дайнд олзлогдогчдын ганцаарчлан болон хамтаараа байрлах байр нь чийггүй хуурай, дулаан, гэрлээр зохих хэмжээнд хангагдсан байх бөгөөд ялангуяа бүрий болсноос хойш цахилгаан асаах тогтоосон цаг хүртэл харанхуй байлгаж болохгүй. Түүнчлэн гал түймрийн аюулаас хамгаалах бүх арга хэмжээг авсан байна.

Эрэгтэй, эмэгтэй олзлогдогчид хамтдаа байгаа лагерьт тэднийг унтах байраар тусад нь хангана.

#### 26 дугаар зүйл

Өдөр тутмын хоол хүнс, түүний найрлага бүтэц нь дайнд олзлогдогчдыг эрүүл байлгах, тураал болон хүнс тэжээлийн дутагдлаас үүсэх хүндрэлд орохоос урьдчилан сэргийлэх үүднээс тоо, чанар, төрлийн хувьд хангалттай байх ёстой. Мөн түүнчлэн олзлогдогчдын дадсан хооллох дэглэмийг анхааралдаа авна.

Олзлогч гүрэн нь ажиллаж байгаа дайнд олзлогдогчдын ажлын нөхцөл байдалд тохирсон зайлшгүй шаардлагатай нэмэлт хоол хүнсээр хангана.

Дайнд олзлогдогчдыг ундны усаар хангалттай хэмжээнд хангах хэрэгтэй. Тамхи татахыг зөвшөөрнө.

Дайнд олзлогдогчдыг хоол хүнс бэлтгэх ажилд аль болохоор өргөн оролцуулах хэрэгтэй. Энэ зорилгоор тэднийг гал тогоонд ажиллуулж болно. Өөртөө байгаа зүйлээр нэмэгдэл хоол хүнс бэлтгэх боломжийг тэдэнд мөн олгох ёстой.

Хоол хүнсээ хэрэглэх болон бэлтгэх тохиромжтой байраар хангах хэрэгтэй.

Хоол хүнсийг хөндсөн аливаа сахилгын хамтын шийтгэл ногдуулахыг хориглоно.

#### 27 дугаар зүйл

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдын байгаа газрын цаг уурын байдалд тохируулан тэдэнд гадуур, дотуур хувцас, гутал зэргийг хангалттай тоогоор тавьж олгоно. Дайсагнагч этгээдийн цэргийн дүрэмт хувцсыг эзлэн авсан олзлогч гүрэн тэр газрын уур амьсгалд тохиромжтой бол дайнд олзлогдогчдын хувцасны хэрэгцээнд тохируулан хэрэглэнэ.

Олзлогдогчдын эдэлж хэрэглэж байгаа хувцсыг олзлогч гүрэн байнга солих буюу засварлана. Түүнээс гадна ажиллаж байгаа дайнд олзлогдогчдод гүйцэтгэж буй ажлынх нь байдалд зохицсон хувцас олгоно.

*28 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдын байрлаж байгаа лагерьт тэдний хэрэгцээнд зориулж хүнсний бүтээгдэхүүн, саван, тамхи зэрэг өдөр тутмын хэрэгцээтэй бараа худалдаалах мухлагтай байна. Барааны үнэ нь орон нутгийн зах зээлийн үнээс өндөр байх ёсгүй.

Лагерийн мухлагаас олж байгаа ашгийг олзлогдогчдын хэрэгцээнд хэрэглэх бөгөөд энэ зорилгоор тусгай сан байгуулна. Олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч мухлагийн ажилд болон энэхүү санг захиран зарцуулахад оролцох эрх эдэлнэ.

Хэрэв лагерийг татан буулгавал тусгай сангийн үлдэгдэл балансыг олон улсын аль нэг хүмүүнлэгийн байгууллагад санг хуримтлуулахад оролцсон олзлогдогчдын харьяалах орны олзлогдогчдын хэрэгцээнд хэрэглэх зорилгоор шилжүүлж өгнө. Дайнд олзлогдогчдыг харилцан солилцож дууссаны дараа холбогдох гүрнүүдийн хооронд дээр дурдсан сангийн талаар аливаа хэлэлцээр байгуулаагүй бол уг сан нь олзлогч гүрний ашиг болж үлдэнэ.

### **III бүлэг**

#### **Эрүүл ахуй, эмнэлгийн тусламж**

*29 дүгээр зүйл*

Олзлогч гүрэн олзлогдогчдын лагерийг цэвэр байлгах, олзлогдогчдын эрүүл мэндийн байдлыг хамгаалах, элдэв халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай ариун цэвэр, эрүүл ахуйн бүх арга хэмжээг авах үүрэгтэй.

Дайнд олзлогдогчид өдөр, шөнийн аль ч цагт ашиглах ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн өрөөгөөр хангагдсан байна. Эмэгтэй олзлогдогчид байрладаг лагерьт тэдэнд зориулсан ариун цэврийн өрөөг тусгайлан гаргаж өгнө.

Дайнд олзлогдогчдын лагерьт халуун усны газар байгуулахаас гадна хувийн ариутгал, цэвэрлэгээ, угаалганд зориулан хангалттай хэмжээний ус, угаалгын савангаар хангана. Энэ зорилгоор тэдэнд зохих орон байр, боломж, цаг хугацаа олгох ёстой.

*30 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдод эмнэлгийн тусламж үзүүлэх буюу тэдэнд хоолны дэглэм сахиулах зорилгоор лагерь бүр өөртөө тохирсон эмчилгээний тасагтай байна. Сэтгэл мэдрэлийн болон халдварт өвчнөөр өвчилсөн олзлогдогчдыг шаардлагатай нөхцөлд тусгаарлах өрөөтэй байна.

Хүнд өвчтэй, эсхүл тусгай эмчилгээ болон мэс засал хийлгэх, эсхүл эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай дайнд олзлогдогчдыг ойрын үед нутагт нь буцаах байсан ч цэргийн болон иргэний эмнэлгийн байгууллагууд заавал хүлээн авч эмчлэх ёстой. Сохор, тахир дутуу хүмүүсийг нутагт нь буцаахын өмнө аль болохоор онцлон үзэж сувилна.

Дайнд олзлогдогчдод тэдгээрийг харьяалах гүрний нь, боломжтой тохиолдолд тэдэнтэй адил үндэсний эмнэлгийн ажилтнаар эмнэлгийн тусламж түлхүү үзүүлнэ.

Дайнд олзлогдогчид эмнэлгийн ажилтанд хандан үзлэг хийлгэх, эмнэлгийн тусламж авах явдалд саад хийж болохгүй. Олзлогч гүрний эрх бүхий байгууллагууд эмчлүүлж байгаа олзлогдогчдын хүсэлтийн дагуу өвчний шинж тэмдэг, гэмтлийн учир шалтгаан, хийсэн эмчилгээ, эмчлүүлсэн хугацаа зэргийг тодорхойлсон албан ёсны лавлагаа хийж өгөх үүрэгтэй. Энэ лавлагааны нэг хувийг дайнд олзлогдогчдын хэрэг эрхлэх төв агентлагт явуулна.

Дайнд олзлогдогчдыг эмчлэх буюу тэдний эмчилгээнд шаардагдах эмнэлгийн эм, хэрэгсэл, тухайлбал нүдний шил, хиймэл шүд зэрэг бусад хэрэглэлийг худалдаж авахад гарсан зардлыг олзлогч гүрэн хариуцна.

### *31 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчдыг сар бүр нэгээс доошгүй удаа эмнэлгийн үзлэгт хамруулна. Эмнэлгийн үзлэгийн үед дайнд олзлогдогч бүрийн жинг хэмжиж тэмдэглэнэ.

Энэхүү үзлэг нь олзлогдогчдын эрүүл мэнд, хоол хүнс, хувийн ариун цэврийн байдлыг шалгаж үзэх, түүнчлэн уушигны сүрьеэ, халуун хижиг, арьс өнгөний өвчин зэрэг халдварт өвчнийг илрүүлэх зорилготой болно. Үүний тулд үргэлж эмнэлгийн шалгарсан аргыг сонгон авч хэрэглэх хэрэгтэй. Тухайлбал, цэргийн олзлогдогчдыг нийтэд нь рентгений зураг үе үе авахуулах нь анхан шатны сүрьеэ өвчнийг илрүүлэх зорилготой байна.

### *32 дугаар зүйл*

Олзлогч гүрэн нь олзлогдогчдын дотор байгаа өөрийн зэвсэгт хүчинд алба хашдаггүй эмч, мэс заслын эмч, шүдний эмч, сувилагч нарт тэднийг харьяалах гүрний олзлогдогчдын эрх ашгийн үүднээс эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх тухай шаардлага тавьж болно. Энэ тохиолдолд тэд дайнд олзлогдогч хэвээр байх боловч олзлогч гүрэнд албадан саатуулагдаж байгаа эмнэлгийн ажилтны нэгэн адил эрх эдэлнэ. Тэднийг конвенцийн 49 дүгээр зүйлд заасны дагуу аливаа бусад ажлаас чөлөөлнө.

## **IV бүлэг**

### **Дайнд олзлогдогчдод тусламж үзүүлэх зорилгоор албадан саатуулагдсан эмнэлгийн болон шашны ажилтан**

### *33 дугаар зүйл*

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдод тусламж үзүүлэх зорилгоор албадан саатуулсан эмнэлгийн болон шашны ажилтныг дайнд олзлогдогчид тооцох ёсгүй. Харин тэд наад зах нь энэхүү конвенцийн ивээл, хөнгөлөлтийг эдлэхээс гадна дайнд олзлогдогчдод эмнэлгийн болон сэтгэл санааны тусламж дэмжлэг үзүүлэх, шашны зан үйлтэй холбоотой үйл ажиллагаа явуулахад нь шаардагдах бүх бололцоо нөхцөлөөр хангана.

Тэд олзлогч гүрний цэргийн хууль, тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагын хяналтын дор өөрсдийн мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн дайнд олзлогдогчдод эмнэлгийн

болон сэтгэл санааны тусламж үзүүлэх үүргээ гүйцэтгэнэ. Тэд эмнэлгийн болон сэтгэл санааны тусламж үзүүлэхдээ дор дурдсан хөнгөлөлтийг эдэлнэ:

(а) Лагериас гадна орших цэргийн эмнэлэгт буюу ажлын байранд байгаа дайнд олзлогдогчдыг тогтмол эргэж уулзахыг тэдэнд зөвшөөрнө. Энэ зорилгоор олзлогч гүрэн тээврийн хэрэгслээр хангана;

(б) Албадан саатуулагдсан эмнэлгийн ажилтнуудын бүхий л үйл ажиллагаатай холбогдсон хариуцлагыг лагерь бүрт эмнэлгийн ахлах эмч нь лагерийн цэргийн эрх баригчдын өмнө хүлээнэ. Эл зорилгоор мөргөлдөөнд оролцогч талууд дайтах ажиллагаа эхэлмэгц эмнэлгийн албаны ажилтнууд, түүнчлэн Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 26 дугаар зүйлд дурдсан нийгэмлэгүүдийн ажилтнуудын цол хэргэмийн харьцааны талаар хэлэлцэн тохирно. Энэ ахлах эмч болон шашны ажилтан нь мэргэжлийнхээ үйл ажиллагаатай холбогдох бүх асуудлаар лагерийн зохих эрх баригчтай харьцах эрхтэй. Лагерийн эрх баригчид тэдэнд дээрх асуудлаар захидал бичгээр харьцах бүх бололцоог олгоно;

(с) Албадан саатуулагдсан эмнэлгийн болон шашны ажилтан өөрсдийн байгаа лагерийн дотоод журамд захирагдах бөгөөд тэднээр эмнэлгийн болон шашин шүтлэгийн үүрэгтэй нь холбоогүй аливаа ажлыг албадан хийлгүүлж болохгүй.

Тэднийг ээлжлэн ажиллуулах журмын талаар мөргөлдөөнд оролцогч талууд дайтах ажиллагааны үеэр хэлэлцэн тохиролцож, энэ талаар журам тогтооно.

Өмнөх заалтууд нь дайнд олзлогдогчдын эмнэлгийн болон санаа сэтгэлийн эрэлт хэрэгцээг хангах талаар хүлээх үүргээс олзлогч гүрнийг чөлөөлөх үндэслэл болохгүй.

## **V бүлэг**

### **Шашин, оюун санааны болон биеийн тамирын үйл ажиллагаа**

#### *34 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчид цэргийн эрх баригчдаас тэдэнд тогтоосон сахилгын журмыг дагаж мөрдсөн нөхцөлд тэдэнд өөрсдийн шүтэн биширдэг шашныхаа зан үйлийг гүйцэтгэх, тухайлбал сүм хийдэд очиж мөргөл үйлдэх эрх чөлөөг бүрэн олгоно.

Шашны зан үйл гүйцэтгэхэд тохиромжтой тусгай өрөө тасалгаа бэлтгэж өгнө.

#### *35 дугаар зүйл*

Дайсагнагч этгээдийн гарт орсон шашны ажилтан дайнд олзлогдогчдод тусламж үзүүлэхээр үлдэх буюу албадан саатуулагдах тохиолдолд түүнд шашин нэгт олзлогдогчдынхоо дунд өөрийн шашны ёс журмын дагуу сүсэг бишрэлийн үйл ажиллагааг чөлөөтэй явуулахыг зөвшөөрнө. Тэднийг эх хэл нэгтэй болон нэг шашин шүтлэгт хамаардаг бөгөөд харьяалагдаж буй зэвсэгт хүчнээс нь олзлогдож ирсэн олзлогдогчид байрлаж байгаа лагерь, ажлын баг, хэсэгт хуваарилна. Тэднийг лагерийн гадна орших олзлогдогчидтой уулзахад нь 33 дугаар зүйлд заасны дагуу тээврийн хэрэгслээр үйлчлэх зэрэг шаардлагатай нөхцөлөөр хангана. Тэд олзлогч орны болон олон улсын шашны байгууллагуудтай шашны асуудлаар захидал бичгээр чөлөөтэй харилцах боловч түүнд нь олзлогч гүрний зүгээс хяналт тавина. Тэднээс илгээж болох

элдэв төрлийн бичиг захидал энэхүү конвенцийн 71 дүгээр зүйлээр тогтоосон хязгаарлалтад орохгүй.

*36 дугаар зүйл*

Харьяат армийнхаа шашны ажилтаны тоонд албан ёсоор ороогүй олзлогдогч-санваартанд шашин нэгтнийхээ дунд шашны үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулахыг зөвшөөрнө. Тэдэнтэй олзлогч гүрний мэдэлд албадан саатуулагдсан шашны ажилтны адил харьцах ёстой. Тэднээр өөр ямар нэгэн ажлыг албадан хийлгүүлж болохгүй.

*37 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчид албадан саатуулагдсан шашны ажилтан болон олзлогдогч-санваартны тусламжийг хүргэж чадахгүй байх тохиолдолд сонирхогч олзлогдогчдын өөрсдийн нь хүсэлтээр цэргийн санваартны үүрэг гүйцэтгүүлэхээр энгийн сүсэгтэнг томилж ажиллуулах бөгөөд хэрэв ийм боломжгүй бол шашин шүтлэгт нь харшлахгүй гэсэн тийм хүнийг томилон ажиллуулж болно. Олзлогч гүрэн нь олзлогдогчдын болон шаардлагатай тохиолдолд тэрхүү урсгалын орон нутгийн шашны байгууллагын саналыг харгалзан дээрх томилолтыг батламжилна. Ийнхүү томилогдсон этгээд сахилга бэхжүүлэх, цэргийн аюулгүй байдлыг хангахын тулд олзлогч гүрний тогтоосон бүхий л журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

*38 дугаар зүйл*

Олзлогч гүрэн нь дайнд олзлогдогч бүрийн хувийн авьяас, сонирхлыг хүндэтгэн үзэж тэдний оюун санаа, гэгээрэл боловсрол, спортын идэвх чадавх болон олзлогдогчдын дунд спортын тоглоом наадам зохион байгуулахыг хөхиүлэн урамшуулна. Энэ зорилгоор зохих спортын хэрэгсэл болон байраар хангана.

Олзлогдогчид нь ил гадаа биеийн тамирын дасгал хийж, элдэв төрлийн спорт, спортын тоглоомоор тоглох боломжтой байх ёстой. Бүх лагерьт үүнд зориулж хангалттай хэмжээний задгай талбай бэлтгэнэ.

**VI бүлэг**

**Сахилга**

*39 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчдын лагерийг олзлогч гүрний байнгын зэвсэгт хүчинд харьяалагдах тусгай томилолт бүхий хариуцлагатай офицер шууд удирдана. Уг офицерт энэхүү конвенцийн бичвэр байх ёстой бөгөөд түүний заалтуудыг лагерийн бүх ажилтанд сурталчилан таниулахын хамт засгийн газрынхаа хяналтын дор конвенцийг хэрэгжүүлэх талаар хариуцлага хүлээнэ.

Офицеруудаас бусад дайнд олзлогдогчид нь армийнхаа дүрэмд заасан ёсоор олзлогч гүрний дарга офицеруудад ёслож хүндэтгэл үзүүлэх ёстой.

Олзлогдсон офицерууд нь олзлогч гүрний өөрөөсөө өндөр цол хэргэм бүхий офицер, дарга нарт, түүнчлэн ямар ч цолтой байгааг үл харгалзан лагерийн захирагчид ёслож хүндэтгэл үзүүлэх үүрэг хүлээнэ.



*40 дүгээр зүйл*

Олзлогдогчдод өөрийн улсын цолны болон үндэсний ялгах тэмдгийг зүүж явахыг зөвшөөрнө.

*41 дүгээр зүйл*

Энэхүү конвенцийн бичвэр, түүний хавсралтууд болон 6 дугаар зүйлд заасан тусгай хэлэлцээрүүдийн утга агуулгыг олзлогдогчдын эх хэлээр бичиж бүх олзлогдогчид уншиж болох тод үзэгдэхүйц газар хадна. Эдгээр зүйлтэй танилцах бололцоогүй олзлогдогчид хэрэв хүсэлт гаргавал тэдэнд уншиж танилцах зорилгоор хуулбарлаж өгнө.

Дайнд олзлогдогчдод холбогдох янз бүрийн журам, тушаал, зарлал болон олзлогдогчдын биеэ авч явах тухай мэдээллийг тэдний ойлгох хэлээр нь бичиж дээр дурдсан газар хадах буюу олшруулсан хувийг нь итгэмжлэгдсэн төлөөлөгчид өгнө. Тодорхой олзлогдогчдод хамаарах тушаал, захирамжийг мөн нэгэн адил тэдэнд ойлгогдох хэлээр бичиж өгөх ёстой.

*42 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдын эсрэг, ялангуяа оргосон буюу оргохыг завдсан олзлогдогчдын эсрэг зэвсэг хэрэглэхийг онцгой арга хэмжээ гэж үзэх бөгөөд зохих нөхцөл байдлыг харгалзан заавал урьдчилан анхааруулах ёстой.

**VII бүлэг**

**Дайнд олзлогдогчдын цэргийн цол хэргэм**

*43 дугаар зүйл*

Нэг зиндааны цол хэргэм бүхий олзлогдогчид адил тэгш харьцах явдлыг хангах зорилгоор мөргөлдөөнд оролцогч талууд дайтах ажиллагаа эхэлмэгц энэхүү конвенцийн 4 дүгээр зүйлд дурдсан бүх этгээдийн цол хэргэм, албан тушаалын талаар харилцан өөр хоорондоо мэдээлнэ. Хэрэв цол хэргэм, албан тушаалыг үүнээс хожим тогтоовол энэ тухай нэгэн адил мэдээлнэ.

Олзлогдогчдыг харьяалах гүрэн олзлогдогчийн цол хэргэмийг ахиулсан тухай олзлогч гүрэнд албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд олзлогч гүрэн түүнийг хүлээн зөвшөөрнө.

*44 дүгээр зүйл*

Офицер болон түүнтэй адилтгах олзлогдогчидтой харьцахдаа тэдний цол хэргэм, насны байдлыг харгалзан хүндэтгэл үзүүлэх ёстой.

Офицер болон түүнтэй адилтгах олзлогдогчдын цол хэргэмийг анхааралдаа авч тэдний байрлаж байгаа лагерьт үйлчилгээний ажил хийлгэхээр харьяат цэргийн хүчнээс нь олзлогдож ирсэн хангалттай тооны, болж өгвөл эх хэлээр нь ярьдаг

цэргийг тусгайлан томилж ажиллуулна. Харин тэднийг өөр ямар нэгэн ажилд илгээж болохгүй.

Офицерууд өөрсдөө гал тогооны газартаа хяналт тавих явдлыг бүх талаар дэмжинэ.

*45 дугаар зүйл*

Офицер бус олзлогдогчид болон тэдэнтэй адилтгах олзлогдогчидтой харьцахдаа цол хэргэм болон насны байдлыг харгалзан хүндэтгэл үзүүлнэ.

Олзлогдогчид өөрсдөө гал тогооны газартаа хяналт тавих явдлыг бүх талаар дэмжинэ.

**VIII бүлэг**

**Олзлогдогчдыг лагерьт ирүүлсний дараа шилжүүлэх**

*46 дугаар зүйл*

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдыг шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ тэдний өөрсдийн нь эрх ашгийг харгалзах бөгөөд ялангуяа олзлогдогчдыг эх оронд нь буцаахад саад бэрхшээл учруулахгүй байхыг эрмэлзэнэ.

Дайнд олзлогдогчдыг шилжүүлэх нөхцөл нь хүнлэг энэрэнгүй байхаас гадна олзлогч гүрэн өөрийнхөө цэргийг шилжүүлэхээс дордуулахгүй нөхцөлд явагдах ёстой. Дайнд олзлогдогчдын зохицсон цаг уурын нөхцөлд байнга анхаарал хандуулах бөгөөд тэднийг шилжүүлэх нөхцөл нь ямар ч тохиолдолд эрүүл мэндэд нь гэм хор учруулах ёсгүй.

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдыг шилжүүлэхдээ тэдний эрүүл мэндийг хамгаалахад анхаарч хангалттай хэмжээний ундны ус, хоол хүнсээр хангахын хамт зайлшгүй шаардлагатай хувцас, оромж олгож, эмнэлгийн тусламж үзүүлнэ. Олзлогч гүрэн нь олзлогдогчдын аюулгүй байдлыг хангахын тулд ялангуяа тэднийг агаарын болон усан замаар зөөвөрлөхдөө бүхий л талын урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч гүйцэтгэсэн байх бөгөөд тэднийг явуулахын өмнө шилжиж байгаа олзлогдогчдын нэрсийн бүрэн жагсаалтыг гаргасан байна.

*47 дугаар зүйл*

Өвчтэй, эсхүл шархадсан дайнд олзлогдогчийг тэдний аюулгүй байдал шаардаж байгаагаас бусад тохиолдолд хэрэв тэднийг зөөвөрлөх нь эдгэж тэнхэрэхэд аюул учруулахаар байвал шилжүүлж болохгүй.

Дайнд олзлогдогчдын лагерьт фронтын шугам ойртож ирэх тохиолдолд тэнд байрлаж байгаа олзлогдогчдын аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд, эсхүл тэндээ байх нь нүүлгэн шилжүүлэх үеийнхээс илүү аюултай болох нөхцөлд тэднийг нүүлгэн шилжүүлнэ.

*48 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдыг шилжүүлэх тохиолдолд энэ тухай болон очих газрын шуудангийн хаягийг албан ёсоор урьдчилан мэдэгдэнэ. Энэ хугацаа нь олзлогдогчид өөрсдийн эд хогшлоо боож баглах болон нүүлгэн шилжүүлэх тухай ар гэрийнхэндээ мэдэгдэх боломжтой хугацаа байх ёстой.

Дайнд олзлогдогчдод хувийн эд хогшил болон гэр орноосоо хүлээж авсан эд зүйл, захидал бичгийг биедээ авч явахыг зөвшөөрнө. Олзлогдогчид биедээ авч явах зүйлийн жингийн хэмжээг цаг үеийн шаардлагаас болж багасгаж болох боловч нэг хүний авч явах зүйлийн хүндийн жин нь 25 кг-аас хэтрэх ёсгүй.

Лагерийн хуучин хаягаар ирүүлсэн бичиг захидал, илгээмж зэргийг шинэ хаягаар эздэд нь саадгүй хүргэх ёстой. Лагерийн захирагч олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй тохиролцсоны дагуу олзлогдогчдын лагерийн эд хогшил, түүнчлэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтэрч үлдсэн олзлогдогчдын эд хогшлыг тээвэрлэж явуулахад чиглэгдсэн бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Шилжүүлэх үеийн зардлыг олзлогч гүрэн хариуцна.

### **III ХЭСЭГ**

#### **Олзлогдогчдын хөдөлмөр**

*49 дүгээр зүйл*

Олзлогч гүрэн хөдөлмөрийн чадвартай олзлогдогчдыг нас, хүйс, цол хэргэм, биеийн эрүүл мэндийг харгалзан тэдний бие махбодь, санаа сэтгэлийн хэвийн байдлыг хангахын тулд ажиллах хүчнээр ашиглаж болно.

Дайнд олзлогдогч бага дарга нараас зөвхөн хяналт тавих ажил хийхийг шаардана. Ийм шаардлага тавигдаагүй бага дарга нар өөртөө тохирох өөр ажил өгөхийг хүсч болох бөгөөд түүнийг нь бололцооны хэрээр олж өгнө.

Хэрэв офицер болон түүнтэй адилтгах этгээд өөртөө тохирох ажил олгохыг хүсвэл тэр ажлыг нь олж өгнө. Харин тэднийг ямар ч тохиолдолд албадан ажиллуулж болохгүй.

*50 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдыг байрлаж байгаа лагерийн нь захиргааны болон тоноглох, хангалтын зэрэг дотоод ажлаас бусад зөвхөн дор дурдсан төрлийн ажлыг албадан хийлгэж болно:

- (a) хөдөө аж ахуй;
- (b) төмөрлөг, машины үйлдвэр, химийн үйлдвэрээс бусад аж үйлдвэрийн олзворлох болон боловсруулах салбар, түүнчлэн цэргийн зориулалтгүй байгууламжийн болон олон нийтийн ажил;
- (c) цэргийн зориулалтгүй ачаа тээвэр, ачиж буулгах болон агуулахын ажил;

- (d) худалдаа, урлаг, гар урлалын ажил;
- (e) гэр ахуйн үйлчилгээ;
- (f) цэргийн зориулалтгүй нийтийн ахуй үйлчилгээний ажил.

Хэрэв дээр дурдсан заалт зөрчигдсөн тохиолдолд дайнд олзлогдогчид энэхүү конвенцийн 78 дугаар зүйлд заасны дагуу давж заалдах, гомдол гаргах эрх эдлэхийг зөвшөөрнө.

#### *51 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчдыг ажлын зохих нөхцөл, ялангуяа орон сууц, хоол хүнс, хувцас болон багаж хэрэгслээр хангах ёстой бөгөөд энэ нөхцөл нь олзлогч гүрний иргэдийн адил төстэй ажлын нөхцөлөөс дор байж болохгүй. Түүнээс гадна ажиллах газрын цаг уурын нөхцөл байдлыг харгалзан үзэх хэрэгтэй.

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдын хөдөлмөрийг ашиглахдаа тэднийг ажлуулах газарт өөрийн улсын хөдөлмөр хамгааллын, тухайлбал аюулгүй ажиллагааны журмыг сахин хангуулна.

Дайнд олзлогдогчдыг олзлогч гүрний иргэдийн нэгэн адил хийх ажилд нь зохицох хөдөлмөр хамгааллын арга хэмжээний сургалтад хамруулна. 52 дугаар зүйлд заасан нөхцөлийг биелүүлэх үндсэн дээр олзлогдогчдыг энгийн хүн амын эрхэлдэг ажилд татан оролцуулж болно.

Ажлын нөхцөлийг ямар ч тохиолдолд сахилгын арга хэмжээ авах замаар хүндрүүлж болохгүй.

#### *52 дугаар зүйл*

Дайнд олзлогдогч сайн дураараа зөвшөөрөөгүй тохиолдолд түүнийг эрүүл мэндэд нь гэм хор учруулах буюу амь насанд аюултай ажил хийлгэж болохгүй.

Олзлогч гүрний цэргийн албан хаагчдын нэр хүндийг гутаахуйц ажилд олзлогдогчдыг ажиллуулж болохгүй.

Мина, тэсэрч дэлбэрэх адил төрлийн зэр зэвсгийг зөөж зайлуулах ажлыг амь насанд аюултай ажил гэж үзнэ.

#### *53 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдын ажилдаа очих болон буцаж ирэх хугацааг оролцуулан ажлын өдрийн үргэлжлэх хугацаа нь тухайн бүсэд ижил төрлийн ажил хийж байгаа олзлогч гүрний жирийн ажилтны ажилд тогтоосон хугацаанаас илт их буюу түүнээс ямар ч тохиолдолд урт байж болохгүй.

Ажлын өдрийн дунд үед дайнд олзлогдогчдод нэгээс доошгүй цагийн амралт олгоно. Хэрэв олзлогч гүрний ажилтны амрах хугацаа үүнээс илүү байвал олзлогдогчдын амрах хугацааг үүнтэй зохицуулан мөн нэмэгдүүлнэ. Ням гаригт буюу олзлогдогчдын эх оронд тогтоосон амралтын өдөр олзлогдогчдод долоо хоногт нэг удаа тасралтгүй 24 цагийн хугацаатай амралт олгоно. Түүнээс гадна нэг жилийн турш

ажилласан олзлогдогчдод 8 өдрийн тасралтгүй хугацаатай амралтыг ажлын хөлсний хамт олгоно.

Хэрэв норомчлогдоогүй ажил хийлгэх бол ажлын өдрийн цагийг хэт сунгаж болохгүй.

*54 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчдын хийсэн ажлын цалингийн хэмжээг энэхүү конвенцийн 62 дугаар зүйлийн заалтын дагуу тогтооно.

Ажиллаж байхдаа осолд орсон буюу өвчилсөн дайнд олзлогдогчдод шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлнэ. Түүнээс гадна харьяалах гүрэндээ өөрсдийн эрхээ тогтоолгоход шаардагдах эмнэлгийн магадлагааг олзлогч гүрнээс дайнд олзлогдогчдод олгох бөгөөд магадлагааны нэг хувийг 123 дугаар зүйлд дурдсан дайнд олзлогдогчдын хэрэг эрхлэх төв агентлагт шилжүүлнэ.

*55 дугаар зүйл*

Сард нэгээс доошгүй удаа эмнэлгийн үзлэг хийж дайнд олзлогдогчид тухайн ажилд тэнцэх эсэхийг тогтмол шалгана. Эмнэлгийн үзлэгийн үед дайнд олзлогдогчдын гүйцэтгэж байгаа ажлын шинж байдлыг онцгойлон анхаарч үзэх ёстой.

Дайнд олзлогдогч өөрийгөө хөдөлмөрийн чадваргүй гэж үзвэл лагерийнхаа эмнэлэгт очиж эрүүл мэндээ үзүүлэхийг зөвшөөрнө. Эмч нар тухайн дайнд олзлогдогчийг хөдөлмөрийн чадваргүй гэж үзвэл ажлаас чөлөөлөхийг санал болгож болно.

*56 дугаар зүйл*

Ажлын баг, хэсгийн дэглэм нь дайнд олзлогдогчдын лагерийнхтай адил байна.

Аль ч баг, хэсэг дайнд олзлогдогчдын лагерийн хяналтад байх бөгөөд захиргааны хувьд шууд түүний мэдэлд байна. Лагерийн захирагч, цэргийн удирдлагууд нь энэхүү конвенцийн заалтуудыг өөрсдийн засгийн газрын хяналтын дор ажлын баг, хэсэг бүрт дагаж мөрдүүлэх хариуцлага хүлээнэ.

Лагерийн захирагч лагерийнхаа мэдэлд байгаа ажлын баг, хэсгийн нэрсийн жагсаалтыг тухай бүр шинэчлэн бүртгэж хадгалах бөгөөд түүнийг олзлогдогчдод тусламж үзүүлж байгаа хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо буюу бусад байгууллагын төлөөлөгчид лагерьт ирэхэд нь үзүүлэх ёстой.

*57 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдыг хөлслөн авч ажиллуулж байгаа хувь этгээд тэднийг харгалзан хамгаалах, ивээлдээ авах хариуцлагыг өөртөө авсан нөхцөлд ч олзлогдогчидтой харьцахдаа энэ конвенцоор олгосон нөхцөлийг дордуулах ёсгүй. Дайнд олзлогдогчдын бүх зардлыг гаргах, тэднийг халамжлах, харьцах мөн тэдний ажлын хөлсийг олгож байх үүргийг олзлогч гүрэн, олзлогдогчдын байрлаж байгаа лагерийн захирагч болон цэргийн удирдлагууд өөртөө бүрэн хүлээнэ.

Эдгээр дайнд олзлогдогчид харьяагдах лагерийнхаа итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбоотой байх эрхтэй.

#### **IV ХЭСЭГ**

##### **Дайнд олзлогдогчдын мөнгөн хөрөнгө**

###### *58 дугаар зүйл*

Олзлогч гүрэн нь олзлогдогчдын гар дээр байж болох бэлэн болон бэлэн бус мөнгөний дээд хэмжээг дайтах ажиллагаа эхлэх үеээс хамгаалагч гүрэнтэй энэ асуудлаар хэлэлцээр байгуулах хүртэлх хугацаанд тогтоож болно. Олзлогдогчдоос хурааж авсан буюу өөрсдөө хураалгасан мөнгө нь тэдний хууль ёсны өмч болох учир тэдний нэрийн дансанд оруулах бөгөөд тэдний зөвшөөрөлгүйгээр өөр валютад шилжүүлж болохгүй.

Дайнд олзлогдогчид лагерийн гадна худалдаа хийх буюу үйлчилгээ авахыг зөвшөөрсөн тохиолдолд бэлэн мөнгөөр төлбөрийг өөрсдөө хийх буюу нэрийнхээ данснаас суутгуулах үндсэн дээр лагерийн захиргаагаар хийлгэнэ. Олзлогч гүрэн энэ асуудлыг зохицуулах журмыг боловсруулан гаргана.

###### *59 дүгээр зүйл*

Энэхүү конвенцийн 18 дугаар зүйлд заасны дагуу дайнд олзлогдогчдыг олзлох үед тэднээс хураан авсан олзлогч гүрний валютыг конвенцийн 64 дүгээр зүйлд заасны дагуу олзлогдогчид тус бүрийн нэрийн дансанд оруулна.

Тухайн үед дайнд олзлогдогчдоос хураан авсан бусад улсын валютаар байгаа мөнгийг олзлогч гүрний валютад шилжүүлэн сольсон тохиолдолд түүнийг мөн олзлогдогчид тус бүрийн нэрийн дансанд мөн оруулна.

###### *60 дугаар зүйл*

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдод сар тутам тухайн гүрний валютад шилжүүлэх хэлбэрээр дор дурдсан хэмжээгээр бодож мөнгөн хангалтын урьдчилгааг олгоно:

I зэрэглэл: Түрүүчээс доош цолтой олзлогдогчдод найман швейцар франк.

II зэрэглэл: Түрүүч болон бага дарга цолтой олзлогдогчид, тэдэнтэй адилтгах зиндааны олзлогдогчдод арван хоёр швейцар франк

III зэрэглэл: Ахмад хүртэлх цолтой офицерууд, тэдэнтэй адилтгах зиндааны олзлогдогчдод тавин швейцар франк

IV зэрэглэл: Хошууч, дэд хурандаа, хурандаа, тэдэнтэй адилтгах зиндааны олзлогдогчдод жаран швейцар франк

V зэрэглэл: Генерал, тэдэнтэй адилтгах зиндааны олзлогдогчдод далан таван швейцар франкийг тус тус олгоно.

Гэхдээ мөргөлдөөнд оролцогч холбогдох талууд тусгай хэлэлцээр байгуулж олзлогдогчдод олгох мөнгөн хангалтын урьдчилгааны дээр дурдсан хэмжээг өөрчлөн тогтоож болно.

Түүнээс гадна хэрэв 1 дэх хэсэгт дурдсан урьдчилгааны хэмжээ олзлогч гүрний зэвсэгт хүчний бүрэлдхүүний мөнгөн хангалтаас хавьгүй их байвал, эсхүл олзлогч гүрэнд ямар нэгэн шалтгаанаар ноцтой хүндрэл учруулахаар байвал уг хангалтын урьдчилгааны хэмжээг өөрчлөх талаар олзлогдогчдын харьяат гүрэнтэй тусгай хэлэлцээр байгуулах хүртэлх хугацаанд олзлогч гүрэн дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

(а) энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан хэмжээний мөнгийг олзлогдогчдын нэрийн дансанд үргэлжлүүлэн бичнэ;

(б) олзлогдогчдод тэдний зөвхөн хувийн хэрэгцээг хангахад олгох мөнгөн хангалтын урьдчилгааны хэмжээг хангалттай гэж үзсэн хэмжээнд түр хугацаагаар хязгаарлаж болох бөгөөд харин I зэрэглэлд багтсан олзлогдогчдын хувьд хэмжээ нь олзлогч гүрний зэвсэгт хүчний бүрэлдхүүнийхээс бага байж болохгүй.

Ийм хязгаарлалт тогтоосон шалтгааныг хамгаалагч гүрэнд нэн даруй мэдэгдэнэ.

#### *61 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчдын харьяат гүрнээс олзлогдогчиддоо зориулж нэмэлт мөнгөн хангалт болгон ирүүлж байгаа мөнгийг нэг зэрэглэлд багтаж байгаа олзлогдогчдод тэгш хуваарилах, тухайн зэрэглэлийн харьяат гүрний олзлогдогчдод бүгдэд нь хүртээх, 64 дүгээр зүйлд заасны дагуу тэдний нэрийн дансанд аль болох богино хугацаанд шилжүүлэх нөхцөлтэйгээр олзлогч гүрэн хүлээж авна. Энэхүү нэмэлт мөнгөн хангалт нь тус конвенцоор ногдуулсан бусад үүргээс олзлогч гүрнийг чөлөөлөхгүй.

#### *62 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчид хийсэн ажилдаа тохирсон хөлсийг олзлогч талын эрх бүхий байгууллагаас шууд авах бөгөөд цалингийн хэмжээг тухайн этгээд тогтооно. Чингэхдээ бүтэн өдөр ажилласны хөлс нь хэзээ ч нэг швейцарь франкны дөрөвний нэгээс доош байж болохгүй. Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдын өдрийн ажлын хөлсний хэмжээг тогтоомогц энэ тухайгаа хамгаалагч гүрнээр дамжуулан олзлогдогчид болон тэдгээрийг харьяалах гүрэнд мэдээлнэ.

Лагерийн захиргааны болон бусад дотоод ажилд байнга дайчлагдан ажиллаж байгаа, эсхүл халамж шаардлагатай байгаа бусад олзлогдогчдод эмнэлгийн болон сэтгэл санааны тусламж үзүүлэхээр дайчлагдан ажиллаж байгаа олзлогдогчдод олзолсон талын эрх бүхий байгууллага хөлс мөн олгоно.

Олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч, түүний туслах, зөвлөх нарын хийсэн ажлын хөлсийг лагерийн мухлагийн ашгаас бүрдүүлэх сангаас гаргана. Ажлын хөлсний хэмжээг олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч тогтоож лагерийн захирагч батална. Тийм сан байхгүй тохиолдолд тэдгээрийн ажлын хөлсийг олзлогч талын эрх бүхий байгууллага олгоно.

*63 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдод хувиараа болон хамтарч мөнгө гуйвуулж авахыг зөвшөөрнө.

Дайнд олзлогдогчид дараагийн зүйлд дурдсан нэрийнхээ дансанд байгаа мөнгөнөөс олзлогч гүрний тогтоосон хэмжээ хязгаарын хүрээнд шаардлагатай төлбөрийг хийж, уг мөнгийг бэлэн бус тооцоогоор захиран зарцуулах эрхтэй. Олзлогч гүрний шаардлагатай гэж үзэж тогтоосон санхүү, валютын хязгаарлалтыг сахин хангасан нөхцөлд олзлогдогчид гадаад төлбөр хийж болно. Энэ тохиолдолд олзлогдогчдын тэжээн тэтгэж буй хүмүүст зориулсан төлбөрийг тэргүүн ээлжинд хийнэ.

Олзлогдогчид харьяалах гүрнийхээ зөвшөөрөлтэйгээр доорх журмыг баримтлан өөрийн оронд мөнгөний гүйлгээ хийж болно. Олзлогч гүрэн хамгаалагч гүрнээр дамжуулан заасан гүрэнд төлбөр төлөгч олзлогдогчийн талаархи бүх мэдээлэл, мөнгө хүлээн авагч, олзлогч гүрний валютаар илэрхийлсэн мөнгөний хэмжээ зэргийг заавал тусгасан мэдэгдлийг илгээх ёстой. Уг мэдэгдэлд олзлогдогч гарын үсэг зурж лагерийн захирагч гарын үсэг зурж батламжилна. Гуйвуулсан мөнгийг олзлогдогчдын нэрийн данснаас олзлогч гүрэн зарлага болгоно. Тийнхүү зарлагадсан мөнгийг олзлогдогчдыг харьяалах гүрний тооцооны дансанд шилжүүлсэн бичилтийг хийнэ.

Өмнө дурдсан заалтуудыг хэрэглэх зорилгоор энэхүү конвенцийн 5 дугаар хавсралтад дурдсан үлгэрчилсэн журмыг олзлогч гүрэн ашиглаж болно.

*64 дүгээр зүйл*

Олзлогч гүрэн нь дайнд олзлогдогч тус бүрт нэрийн данс нээж хөтлөх бөгөөд тухайн дансанд дор дурдсан зүйлүүд орсон байна:

(1) Олзлогдогчдод олгож байгаа мөнгөний дүн, эсхүл түүний мөнгөн хангалтын урьдчилгаа, ажлын хөлс болон бусад орлого, олзлогдогчдоос хураан авсан олзлогч гүрний валютын хэмжээ, түүнчлэн түүнээс хураан аваад хүсэлтийн нь дагуу олзлогч гүрний нь валютад шилжүүлсэн мөнгө.

(2) Олзлогдогчдод бэлэн болон бэлэн бус хэлбэрээр олгосон мөнгө, түүний нэрийн өмнөөс буюу түүний хүсэлтийн дагуу хийсэн төлбөр, 63 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу шилжүүлсэн мөнгөний хэмжээ.

*65 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдын нэрийн дансанд орж байгаа баримтуудад олзлогдогчид өөрсдөө гарын үсэг зурах буюу үзэглэх, эсхүл түүний нэрийн өмнөөс ажиллаж байгаа итгэмжлэгдсэн төлөөлөгч гарын үсэг зурна.

Дайнд олзлогдогчдод нэрийнхээ данстай танилцах, тооцооны хуулбарыг үзэх хангалттай боломжийг үргэлж олгоно. Хамгаалагч гүрний төлөөлөгч лагерьт ирэх үедээ дээрх тооцоог шалгаж болно.

Дайнд олзлогдогчдыг нэг лагериас нөгөөд шилжүүлэхдээ тэдний нэрийн дансыг хойноос нь мөн илгээнэ. Олзлогдогчдыг нэг олзлогч гүрнээс өөр олзлогч гүрэнд шилжүүлэн өгөхдөө эхний олзлогч гүрний валютад шилжүүлээгүй мөнгийг нь



олзлогдогчдын хойноос явуулна. Харин тэдний нэрийн дансанд байгаа мөнгөний тухай баримтыг өөрсдөд нь олгоно.

Дайнд олзлогдогчдын нэрийн дансанд байгаа мөнгөний тухай тодорхой цаг хугацааны давтамжтайгаар хамгаалагч гүрнээр дамжуулан өөр хоорондоо мэдэгдэж байх талаар мөргөлдөөнд оролцогч талууд хоорондоо хэлэлцэн тохирч болно.

*66 дугаар зүйл*

Олзлогдогчдыг чөлөөлөх, эсхүл эх оронд нь буцаах үед олзлогч гүрэн бүрэн эрхт төлөөлөгчийнхөө гарын үсэг бүхий олзлогдогчдод олзонд байх хугацаанд олгож байсан мөнгөний тооцоог дурдсан баримт бичгийг тэдэнд олгоно. Олзлогч гүрэн нь эх оронд нь буцаасан, чөлөөлсөн, оргон зайлсан, нас барсан, эсхүл бусад шалтгааны улмаас хугацаа дууссан бүх олзлогдогчдын тухай мэдээлэл бүхий зохих нэрсийн жагсаалтыг үйлдэж тэдгээрийн нэрийн дансанд байгаа мөнгөний хэмжээний хамт хамгаалагч гүрнээр дамжуулан харьяат гүрэнд нь илгээнэ. Ийм нэрсийн жагсаалтын хуудас бүрийг олзлогч гүрний бүрэн эрхт төлөөлөгч гэрчилсэн байх ёстой.

Мөргөлдөөнд оролцогч хоёр тал өөр хоорондоо харилцан тохиролцсоноор дээр дурдсан заалтуудын алийг ч өөрчилж болно.

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдод олгосон мөнгөний тооцоог олзлолтын хугацаа дуусах үед тухайн олзлогдогчтой зохицуулах хариуцлагыг түүнийг харьяалах гүрэн хүлээнэ.

*67 дугаар зүйл*

60 дугаар зүйлд заасны дагуу дайнд олзлогдогчдод олгож байгаа мөнгөн хангалтын урьдчилгааг олзлогдогчдыг харьяалах гүрнээс олгож байгаа урьдчилгаа гэж үзнэ. Уг мөнгөн хангалтын урьдчилгаа болон 63 дугаар зүйлийн 3 дугаар хэсэг, мөн 68 дугаар зүйлд заасны дагуу харьяат гүрнээс хийсэн төлбөрүүд нь холбогдох гүрнүүд дайтах ажиллагаа дууссаны дараа хэлэлцэн тохиролцох асуудал болно.

*68 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчид ажил хийж байх үедээ эрүүл мэнд нь гэмтэх, осолдох буюу тахир дутуу болсонтой холбогдуулан нөхөх олговрын тухай түүний гаргасан гомдлын шаардлагыг хамгаалагч гүрнээр дамжуулан харьяалах гүрэнд нь илгээнэ. Конвенцийн 54 дүгээр зүйлд заасны дагуу олзлогч гүрэн нь олзлогдогчийн эрүүл мэндэд учирсан гэмтэл буюу тахир дутуу болсон шинж байдал, ийм учралд хүргэсэн нөхцөл байдал, түүнд үзүүлсэн эмнэлгийн тусламж, хэвтэж эмчлүүлсэн тухай мэдээллийг тусгасан баримт бичгийг бүх тохиолдолд тухайн этгээдэд олгоно. Энэ баримт бичигт олзлогч гүрний хариуцлагатай офицер гарын үсэг зурсан байхаас гадна эмнэлгийн мэдээллийг эмнэлгийн албаны эмч гэрчилж нотолсон байх ёстой.

Олзлогч гүрэн 18 дугаар зүйлд заасны дагуу дайнд олзлогдогчдын хувийн эд хогшил, мөнгө буюу үнэт зүйлсийг хурааж аваад нутаг буцахад нь эргүүлэн өгөөгүй тохиолдолд тэдгээрийн нөхөх олговрын тухай гаргасан гомдлын шаардлагын, мөн олзлогдогчийн үзэж байгаагаар олзлогч гүрэн болон түүний төлөөлөгчийн гэм буруутай үйлдлийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар олзлогдогчдоос тавьж байгаа шаардлагыг харьяалах гүрэнд нь тус тус илгээнэ. Тэгэхдээ олзонд байх хугацаанд нь зайлшгүй шаардлага бүхий хувийн тийм эд хогшлыг олзлогдогчдод олзлогч гүрний зардлаар нөхөн сольж өгнө. Хувийн эд хогшил, мөнгө буюу үнэт

зүйлсийг эзэнд нь буцааж өгөөгүй шалтгаантай холбогдох бүх мэдээллийг дурдсан бөгөөд олзлогч гүрний хариуцлагатай офицер гарын үсэг зурсан баримт бичгийг бүх тохиолдолд олзлогч гүрэн дайнд олзлогдогчдод олгоно. Энэ баримт бичгийн хуулбарыг конвенцийн 123 дугаар зүйлд дурдсан дайнд олзлогдогчдын хэрэг эрхлэх төв агентлагаар дамжуулан харьяалах гүрэнд илгээнэ.

## **V ХЭСЭГ**

### **Дайнд олзлогдогчид гадаад ертөнцтэй харьцах**

#### *69 дүгээр зүйл*

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдыг өөрийн мэдэлд авмагц энэ ангийн зүйлийн заалтуудыг биелүүлэхийн тулд авсан арга хэмжээнийхээ тухай хамгаалагч гүрнээр дамжуулан олзлогдогчдод болон тэдгээрийг харьяалах гүрэнд мэдэгдэнэ. Түүнчлэн эдгээр арга хэмжээний талаар гарсан өөрчлөлтийг холбогдох талуудад мөн мэдээлнэ.

#### *70 дугаар зүйл*

Олзлогдсон цагаас эхлэн, эсхүл лагерьт ирснээс хойш долоо хоногийн дотор лагерь нь дамжин өнгөрөх байсан, эсхүл олзлогдогчид өвчилсөн, эсхүл цэргийн эмнэлэгт хэвтсэн, эсхүл өөр лагерьт шилжсэн байсан ч олзлогдогчид олзлогдсон тухайгаа, эрүүл мэндийн байдал болон хаягаа мэдээлэх зорилгоор энэхүү конвенцид хавсаргасан маягтын дагуу үйлдсэн захидлыг нэг талаар гэр бүлдээ, нөгөө талаар 123 дугаар зүйлд дурдсан дайнд олзлогдогчдын хэрэг эрхлэх төв агентлагт илгээх боломжоор хангагдана. Ил захидлыг нэн даруй дамжуулах бөгөөд түүнийг ямар нэгэн байдлаар саатуулж болохгүй.

#### *71 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчдод захидал, ил захидал илгээх буюу хүлээн авахыг зөвшөөрнө. Хэрэв захидал харилцааг хязгаарлах нь зайлшгүй чухал гэж олзлогч гүрэн үзвэл энэхүү конвенцид хавсаргасан маягтын дагуу үйлдсэн 70 дугаар зүйлд дурдсан ил захидлыг оролцуулахгүйгээр сард 2 захидал, 4 ил захидал илгээхийг зөвшөөрнө. Хэрэв хамгаалагч гүрэн дайнд олзлогдогчдын эрх ашигт нийцсэн гэж үзэх үндэслэлтэй байгаа, эсхүл зайлшгүй шаардлагатай хяналтыг хэрэгжүүлэхэд мэргэшсэн орчуулагчдыг хангалттай тоогоор олоход олзлогч гүрэнд хүндрэл учирч буй тохиолдолд бусад хязгаарлалтыг тогтоож болно. Хэрэв олзлогдогчдод ирүүлж байгаа захидал харилцааг хязгаарлах шаардлагатай бол энэ талаар олзлогч гүрний хүсэлтээр зөвхөн харьяалах гүрэн шийдвэр гаргах эрхтэй. Эдгээр захидал, ил захидлыг олзлогч гүрэн өөрийн бололцооны хэрээр аль болох түргэн аргаар дамжуулах ёстой. Сахилгын арга хэмжээний шалтгаанаар тэдгээрийг хүргэх явдлыг удаашруулах буюу саатуулж болохгүй.

Удаан хугацаагаар гэр бүлээсээ мэдээ аваагүй, эсхүл тэдгээрийг ердийн арга замаар хүлээн авах, илгээх боломжгүй болсон, эсхүл төрөл төрөгсдөөсөө алслагдсан дайнд олзлогдогчдод цахилгаан мэдээ явуулахыг зөвшөөрөх бөгөөд төлбөрийг нь өөртөө байгаа бэлэн мөнгөөр төлөх, эсхүл олзлогч гүрэнд байгаа нэрийн данснаасаа хийж зарлага болгоно. Ийм боломжийг олзлогдогчдод онц шаардлагатай тохиолдолд мөн олгож болно.

Дайнд олзлогдогчид эх хэл дээрээ захидал харилцаа явуулах нийтлэг журмыг дагаж мөрдөнө. Мөргөлдөөнд оролцогч талууд өөр хэл дээр захидал харилцаа явуулахыг зөвшөөрч болно.

Дайнд олзлогдогчдын захидал харилцаа бүхий шуудан нь тоо, хэмжээг нарийн заасан шошго тэмдэгтэй байх бөгөөд түүнийг шуудангийн газрын хаягаар илгээх ёстой.

#### *72 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдод шуудангаар, эсхүл өөр бусад аргаар хувиараа буюу хамтарч илгээмж авахыг зөвшөөрнө. Тэдгээр нь хүнсний бүтээгдэхүүн, хувцас, эм, ном хэвлэл, шашин шүтлэгийн хэрэглэл, эд зүйлс, эрдэм шинжилгээний ажлын хэрэгсэл, шалгалтын материал, хөгжмийн зэмсэг, биеийн тамирын хэрэглэл зэрэг шашин шүтлэг, боловсрол, амралтын эрэлт хэрэгцээг хангаж сурч боловсрох болон уран бүтээлийн ажил эрхлэхэд шаардагдах элдэв материалыг агуулж болно.

Эдгээр илгээмж нь энэхүү конвенцийн дагуу ногдож байгаа үүргээс олзлогч гүрнийг чөлөөлөх үндэслэл болохгүй.

Илгээмжийн хувьд зөвхөн олзлогдогчдын эрх ашгийн үүднээс хамгаалагч гүрний санал болгосон хязгаарлалтаас өөр ямар нэгэн хязгаарлалт тогтоохгүй. Харин зам тээвэр, эсхүл харилцаа холбооны систем нь ачаалал ихтэй байх онцгой тохиолдолд Олон улсын улаан загалмайн хороо буюу олзлогдогчдод тусламж үзүүлэх бусад байгууллагууд олзлогдогчдод илгээх өөрийн илгээмжид хязгаар тогтоож болно.

Хувиараа буюу хамтарч илгээмж явуулах нөхцлийг шаардлагатай тохиолдолд холбогдох гүрнүүдийн хооронд байгуулах тусгай хэлэлцээрээр тогтоох бөгөөд олзлогдогчид тусламжийн илгээмж хүлээж авах явдалд ямар ч тохиолдолд саад учруулж болохгүй. Ном хэвлэлийг хүнсний бүтээгдэхүүн, хувцас, бусад зүйлтэй хамт нэг илгээмжинд хийж болохгүй. Эмнэлгийн материалыг хамтын илгээмжид хийж явуулна.

#### *73 дугаар зүйл*

Тусламжийн хамтын илгээмжийг хүлээж авах, хуваарилах нөхцлийн талаар холбогдох гүрнүүдийн хооронд тусгай хэлэлцээр байхгүй тохиолдолд энэхүү конвенцийн хавсралтад дурдсан хамтын илгээмжийн тухай журмыг баримтлана.

Дээр дурдсан тусгай хэлэлцээр нь ямар ч тохиолдолд дайнд олзлогдогчдод ирүүлж байгаа хамтын илгээмжийг олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээж авах, улмаар олзлогдогчдод хуваарилах, олзлогдогчдын эрх ашгийн үүднээс захиран зарцуулах эрхийг хягаарлаж болохгүй.

Эдгээр хэлэлцээр нь хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо, эсхүл олзлогдогчдод тусламж үзүүлж байгаа болон илгээмжийг дамжуулж өгөх үүрэг бүхий өөр байгууллагуудын төлөөлөгчдийн хамтын илгээмжийг хүлээн авагчдад хуваарилахад хяналт тавих эрхийг хязгаарлаж болохгүй.

74 дүгээр зүйл

Дайнд олзлогдогчдод зориулсан тусламжийн илгээмжүүд нь гаалийн татвар болон бусад хураамжаас бүрэн чөлөөлөгдөнө.

Дайнд олзлогдогчдод шуудангаар шууд ирүүлсэн буюу тэднээс шууд явуулсан, түүнчлэн энэхүү конвенцийн 122 дугаар зүйлд дурдсан лавлах товчоо, эсхүл 123 дугаар зүйлд дурдсан дайнд олзлогдогчдын хэрэг эрхлэх төв агентлагаар дамжуулан явуулсан захидал харилцаа, тусламжийн илгээмж, зөвшөөрөгдсөн мөнгөн шилжүүлэг илгээсэн улс, очих улс болон дайрч өнгөрөх улсын шуудангийн бүхий л төрлийн хураамжаас чөлөөлөгдөнө.

Жингээрээ буюу өөр ямар нэгэн шалтгаанаар шуудангаар илгээж үл болох дайнд олзлогдогчдод зориулсан тусламжийн илгээмжийн зардлыг олзлогч гүрэн өөрийн хяналтанд байгаа бүх нутаг дэвсгэр дээр хариуцна. Конвенцид оролцогч бусад гүрэн илгээмжийг өөрийн нутгаар тээвэрлэн өнгөрүүлэх зардлыг хариуцна. Хэрэв холбогдох гүрнүүдийн хооронд тусгай хэлэлцээр байхгүй тохиолдолд дээр дурдсан хөнгөлөлтөд хамрагдахгүй илгээмжийг тээвэрлэх зардлыг явуулагч этгээд хариуцна.

Дайнд олзлогдогчдоос явуулж байгаа буюу тэдэнд ирүүлж байгаа цахилгаан мэдээний үнийг аль болохоор хямдруулахыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд эрмэлзэнэ.

75 дугаар зүйл

Холбогдох гүрнүүд 70, 71, 72 болон 77 дугаар зүйлд дурдсан илгээмжийг тээвэрлэх үүргээ биелүүлэхэд нь цэрэг дайны ажиллагаа саад учруулах тохиолдолд хамгаалагч гүрнүүд, Олон улсын улаан загалмайн хороо болон мөргөлдөөнд оролцогч талуудын хүлээн зөвшөөрсөн өөр ямар нэгэн байгууллага тэдгээр илгээмжийг зохих тээврийн хэрэгслийн (галт тэрэг, ачааны машин, хөлөг онгоц буюу агаарын хөлөг зэрэг) тусламжтайгаар тээвэрлэх явдлыг хангаж болно. Энэ зорилгоор илгээмжийг тээвэрлэх тээврийн хэрэгслээр хангах, тэдэнд чөлөөтэй өнгөрүүлэх тусгай үнэмлэх олгож тээврийн хөдөлгөөнийг зохиоцуулах талаар хэлэлцэн тохирогч эрхэм талууд чармайн ажиллана.

Эдгээр тээврийн хэрэгслийг дараахь зүйлийг зөөвөрлөхөд ашиглана:

(а) 123 дугаар зүйлд дурдсан төв агентлаг болон 122 дугаар зүйлд дурдсан үндэсний товчоонуудын хооронд солилцох захидал харилцаа, нэрсийн жагсаалт, тайлан илтгэл;

(б) хамгаалагч гүрнүүд, Олон улсын улаан загалмайн хороо болон олзлогдогчдод тусламж үзүүлж буй бусад байгууллагаас өөрсдийн төлөөлөгчид, эсхүл мөргөлдөөнд оролцогч талуудтай солилцож байгаа дайнд олзлогдогчдын талаарх захидал харилцаа, илтгэл.

Эдгээр заалтууд нь мөргөлдөөнд оролцогч аль нэг тал өөрийн хүсэлтээр өөр ямар нэгэн тээврийн хэрэгслээр хангах буюу харилцан тохирсон болзлын үндсэн дээр үнэмлэх олгох эрхийг хязгаарлахгүй.

Тусгай хэлэлцээр байхгүй тохиолдолд тээврийн хэрэгслийг ашиглахтай холбогдсон зардлыг мөргөлдөөнд оролцогч талууд аль улсын эрх ашгийн үүднээс тээвэрлэлт хийснийг харгалзан хувь тэнцүүлэн хүлээнэ.

*76 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдод ирүүлсэн буюу тэднээс явуулж байгаа захидал харилцаанд тавих хяналтыг аль болохоор шуурхай гүйцэтгэх ёстой. Илгээгч болон хүлээн авагч улс тус бүрдээ нэг удаа хянаж үзнэ.

Дайнд олзлогдогчдод ирүүлсэн илгээмжид үзлэг хийхдээ дотор нь байгаа хүнсний бүтээгдэхүүнийг муудуулж гэмтээх нөхцөлд хийх ёсгүй бөгөөд хэвлэл, бичгийн материалаас бусад зүйлийг үзэхэд хүлээн авагч буюу түүнийг төлөөлөх бүрэн эрхтэй хүнийг байлцуулана. Хяналттай холбогдсон хүндрэлээр шалтаглаж олзлогдогчдын хувийн буюу хамтын илгээмжийг саатуулж болохгүй.

Мөргөлдөөнд оролцогч талууд цэрэг дайны болон улс төрийн шалтгаанаар захидал харилцааг хориглох явдал нь зөвхөн түр шинжтэй байх бөгөөд хугацаа нь аль болох богино байна.

*77 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдод ирүүлсэн, эсхүл тэднээс явуулж байгаа акт болон баримт бичиг, тухайлбал итгэмжлэл, гэрээслэлийг хамгаалагч гүрэн, эсхүл конвенцийн 123 дугаар зүйлд дурдсан дайнд олзлогдогчдын хэрэг эрхлэх төв агентлагаар дамжуулан илгээхэд олзлогч гүрнүүд бүх талын боломжийг олно.

Эдгээр баримт бичгийг үйлдэхэд болон хуульчдаас зөвлөлгөө авах бүх тохиолдолд олзлогч гүрнүүд дайнд олзлогдогчдод туслалцаа үзүүлэх бөгөөд олзлогдогчдын гарын үсэг гэрчилэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

## **VI ХЭСЭГ**

### **Дайнд олзлогдогчид болон цэргийн эрх мэдэлтний хоорондын харилцаа**

#### **I бүлэг**

#### **Олзны дэглэмийн талаархи дайнд олзлогдогчдын гомдол**

*78 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчид эрх мэдэлд нь байгаа цэргийн эрх баригчдад хандаж олзонд байхад тогтоосон дэглэмийн талаар хүсэлт гаргах эрхтэй.

Дайнд олзлогдогчид нь шаардлагатай гэж үзвэл олзонд байх үеийн дэглэмийн аливаа гомдолтой асуудалд тэдний анхаарлыг хандуулахын тулд хүсэлтээ шууд өөрөө, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан ямар ч хязгаарлалтгүйгээр хамгаалагч гүрний төлөөлөгчдөд гаргах эрхтэй.

Эдгээр хүсэлт гомдлыг хязгаарлаж болохгүй бөгөөд тэдгээрийг 71 дүгээр зүйлд дурдсан захидал харилцааны тоог хязгаарласан заалтын нэг хэсэг гэж үзэж болохгүй. Хүсэлт, гомдлыг нэн даруй дамжуулах ёстой. Хүсэлт гомдол нь үндэслэлгүй байсан ч аливаа шийтгэл хүлээлгэж болохгүй.

Олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч нь лагерийн байдал, дайнд олзлогдогчдын эрэлт хэрэгцээний талаар байнга илтгэл бичиж хамгаалагч гүрний төлөөлөгчдөд явуулж болно.

## **II бүлэг**

### **Дайнд олзлогдогчдын төлөөлөгчид**

#### *79 дүгээр зүйл*

Цэргийн эрх баригчид, хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо болон олзлогдогчдод тусламж үзүүлж байгаа бусад байгууллагын өмнө дайнд олзлогдогчдыг төлөөлж ажиллах итгэмжлэгдсэн төлөөлөгчийг офицероос бусад дайнд олзлогдогчид байрлаж байгаа газарт 6 сар тутам, эсхүл түүний орон тоо эзгүй болох тохиолдол бүрт олзлогдогчид өөрсдөө чөлөөтэй, саналаа нууцаар гаргах замаар сонгоно. Эдгээр итгэмжлэгдсэн төлөөлөгчийг дахин сонгож болно.

Офицерууд болон тэдгээртэй адилтгах олзлогдогчдын лагерь буюу холимог лагериудад цол хэргэм болон ажилласан хугацаагаараа ахмад офицерыг итгэмжлэгдсэн төлөөлөгч гэж үзнэ. Офицерын лагерьт офицеруудаас сонгогдсон нэг буюу хэд хэдэн зөвлөх түүний ажилд тусална. Харин холимог лагерьт офицер биш дайнд олзлогдогчдоос сонгогдсон туслах түүний ажилд тусална.

Олзлогдогчдын хөдөлмөрийн лагерьт дайнд олзлогдогчдод хүлээлгэсэн захиргааны үүргийг биелүүлэх зорилгоор тэдэнтэй харьяалал нэг улсын олзлогдсон офицерыг ажиллуулна. Тухайн офицер энэ зүйлийн эхний хэсэгт заасны дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчийн албан тушаалд сонгогдож болно. Ийм тохиолдолд тэдний туслагч нь офицер биш дайнд олзлогдогч байна.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр сонгогдсон этгээдийг үүргээ гүйцэтгэхийн өмнө олзлогч гүрэн батламжлах ёстой. Хэрэв түүнийг олзлогч гүрэн батламжлахаас татгалзвал тухайн шалтгааныг хамгаалагч гүрэнд танилцуулах ёстой.

Бүх тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгч нь дайнд олзлогдогчидтой иргэний харьяалал, хэл, заншил адил байх ёстой. Иймд иргэний харьяалал, хэл, заншлаараа адил дайнд олзлогдогчдыг лагерийн өөр өөр хэсэгт байрлуулсан бол дээр дурдсны дагуу хэсэг тус бүрт итгэмжлэгдсэн төлөөлөгч байж болно.

#### *80 дугаар зүйл*

Итгэмжлэгдсэн төлөөлөгч дайнд олзлогдогчдын бие махбодь, зан суртахуун, оюун санааны амгалан байдлыг хангахад тус дөхөм үзүүлэх ёстой.

Тухайлбал, энэхүү конвенцийн бусад заалтын дагуу итгэмжлэгдсэн төлөөлөгчид тусгай үүрэг хүлээлгэсэн байсан ч хэрэв олзлогдогчид хоорондоо харилцан туслалцах тогтолцоо зохион байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд тухайн байгууллагыг итгэмжлэгдсэн төлөөлөгч удирдана.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч дайнд олзлогдогчдын үйлдсэн эрх зүйн зөрчлийн төлөө хариуцлага хүлээхгүй.

*81 дүгээр зүйл*

Өөрийн үүргээ биелүүлэхэд нь хүндрэл учруулахаар байвал итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр өөр ямар нэгэн ажлыг албадан хийлгэж болохгүй.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчид өөрсдөд нь шаардлагатай туслагч нарыг дайнд олзлогдогчдын дундаас томилж болно. Тэдэнд бүхий л талын боломж олгох бөгөөд тухайлбал үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай зарим газарт чөлөөтэй зорчих эрхийг (ажлын баг, хэсгийг очиж үзэх, тусламжийн илгээмжийг хүлээн авах зэрэг) олгоно.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд дайнд олзлогдогчдын байрлаж байгаа орон байранд нэвтрэхийг зөвшөөрнө. Дайнд олзлогдогчид итгэмжлэгдсэн төлөөлөгчтэйгээ чөлөөтэй зөвлөлдөх эрхтэй.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд олзлогч гүрний эрх бүхий байгууллага болон хамгаалагч гүрнүүд, Олон улсын улаан загалмайн хороо болон тэдгээрийн төлөөлөгчид, эмнэлгийн хамтарсан комисс, түүнчлэн дайнд олзлогдогчдод тусламж үзүүлж байгаа бусад байгууллагатай шуудан, цахилгаан мэдээгээр харилцах бүх талын боломжийг олгоно. Ажлын баг, хэсгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч төв лагерийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй харилцахдаа дээрхийн адил боломжийг эдэлнэ. Ийнхүү харилцахад ямар нэгэн хязгаарлалт тогтоох ёсгүй бөгөөд үүнийг 71 дүгээр зүйлд дурдсан хязгаарлалтын хэсэг гэж үзэж болохгүй.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг өөр газарт шилжүүлэх тохиолдолд оронд нь ажиллах хүнд ажил хэргээ хүлээлгэх хангалттай хугацаа, боломж гаргаж өгнө.

Хэрэв итгэмжлэгдсэн төлөөлөгчийг ажлаас нь халах тохиолдолд ийнхүү халсан тухай шалтгааныг хамгаалагч гүрэнд мэдэгдэнэ.

### **III бүлэг**

#### **Эрүүгийн болон сахилгын шийтгэл**

##### **I. Нийтлэг заалт**

*82 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчид нь олзлогч гүрний хууль, түүний зэвсэгт хүчний дүрэм, тушаалд захирагдана. Эдгээр хууль, дүрэм, тушаалыг зөрчсөн дайнд олзлогдогчдод олзлогч гүрэн шүүхийн болон сахилгын арга хэмжээ авах эрхтэй. Гэхдээ энэхүү бүлгийн заалтуудад харшлах шүүн таслах ажиллагаа, ялыг хэрэглэж болохгүй.

Хэрэв олзлогч гүрний хууль, дүрэм, тушаалд дайнд олзлогдогчийн үйлдсэн хэрэгт ял ногдуулж болохоор тогтоосон боловч олзлогч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд адил үйлдлийн төлөө ял ногдуулахгүйгээр тогтоож байгаа тохиолдолд дайнд олзлогдогчдод зөвхөн сахилгын арга хэмжээ хүлээлгэнэ.

*83 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчийн үйлдсэн гэж сэжиглэгдэж буй гэмт хэрэгт шүүхийн, эсхүл сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулах тухай асуудлыг шийдвэрлэхдээ эрх бүхий байгууллага асуудалд дээд зэргийн хянуур нухацтай хандаж, аль болохоор шүүхийн арга хэмжээнээс зайлсхийж сахилгын арга хэмжээг сонгох боломжийг хангана.

*84 дүгээр зүйл*

Олзлогч гүрний хууль тогтоомжоор өөрийнхөө зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хамаарах этгээдийг иргэний шүүхээр шийтгэх тусгай эрх олгогдоогүй тохиолдолд ижил төрлийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй дайнд олзлогдогчийн хэргийг зөвхөн цэргийн шүүхээр шийдвэрлэнэ.

Нийтээр хүлээн зөвшөөрсөн, биеэ даасан, шударга байх, тухайлбал энэхүү конвенцийн 105 дугаар зүйлд заасан шүүгдэгчийн эрх, түүнийг хамгаалах хэрэглүүрийг хангаж чадаагүй аливаа төрлийн шүүхээр дайнд олзлогдогчийн хэргийг ямар ч нөхцөлд шийдвэрлэж болохгүй.

*85 дугаар зүйл*

Олзлогдохоосоо өмнө үйлдсэн гэмт хэргийн улмаас олзлогч гүрний хууль тогтоомжийн дагуу мөрдөгдөж байсан, түүнчлэн ял шийтгүүлж байсан дайнд олзлогдогч энэхүү конвенцийн ивээлд байна.

*86 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчид нь үйлдсэн тухайн нэг хэрэг зөрчилд зөвхөн нэг удаа нэг төрлийн ял шийтгүүлнэ.

*87 дугаар зүйл*

Олзлогч гүрний цэргийн эрх баригчид болон шүүх нь олзлогч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хамаарах этгээдийн үйлдсэн ижил төрлийн хэрэгт ногдуулахаар зааснаас өөр ялаар дайнд олзлогдогчийг шийтгэж болохгүй.

Олзлогч гүрний шүүх болон цэргийн эрх баригчид ял шийтгэхдээ шүүгдэгч нь олзлогч гүрний харьяат иргэн биш учраас түүнд үнэнч байх үүрэг өөртөө хүлээгээгүй гэдгийг, түүнчлэн түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас олзлогч гүрний мэдэлд байгаа гэдгийг дээд зэргээр харгалзан үзэх ёстой. Эдгээр шүүх болон цэргийн эрх баригчид зөрчил гаргасан гэм буруутай олзлогдогчдод ногдуулах ялыг хөнгөрүүлэх боломжтой байх бөгөөд харин тэгэхдээ уг ялын доод хэмжээг заавал баримтлах шаардлагагүй.

Ганцаараа үйлдсэн хэргийн төлөө хамтаар нь шийтгэх, бие махбодийг тарчлаах аливаа ял, нар салхи үзэхгүй харанхуй байранд хорих болон өөр ямар нэгэн хэлбэрийн эрүү шүүлт тулгах, харгис хэрцгий хандахыг хориглоно.

Олзлогч гүрэн нь дайнд олзлогдогчдын цол хэргэмийг хасах, эсхүл ялгах тэмдэг зүүх эрхийг хасч болохгүй.



*88 дугаар зүйл*

Сахилгын шийтгэл, эсхүл эрүүгийн ял эдлэж байгаа олзлогдсон офицерууд, бага дарга нар болон цэргүүдтэй олзлогч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд хамаарах тэдгээртэй адил зиндааны этгээд ижил төрлийн шийтгэл эдлэх үед харьцдагаас илүү хатуу ширүүн харьцаж болохгүй.

Дайнд олзлогдогч эмэгтэйчүүдэд олзлогч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний адил төстэй зөрчил үйлдсэн эмэгтэйчүүдэд ногдуулах ял, түүнийг эдлүүлэхээс илүү хүнд ял ногдуулж буюу илүү хатуу ширүүн харьцаж болохгүй.

Дайнд олзлогдогч эмэгтэйчүүдийг ямар ч тохиолдолд олзлогч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний адил төстэй зөрчил үйлдсэн эрэгтэйчүүдэд ногдуулах ял, түүнийг эдлүүлэхээс илүү хүнд ял ногдуулж буюу илүү хатуу ширүүн харьцаж болохгүй.

Сахилгын шийтгэл, эсхүл эрүүгийн ял эдлэж дууссан дайнд олзлогдогчидтой бусад олзлогдогчдын нэгэн адил харьцана.

**II. Сахилгын шийтгэл**

*89 дүгээр зүйл*

Дайнд олзлогдогчдод дор дурдсан сахилгын шийтгэл хүлээлгэнэ:

(1) Дайнд олзлогдогчдын мөнгөн хангалтын урьдчилгаа болон энэхүү конвенцийн 60, 62 дугаар зүйлд заасан ажлын хөлсний 50 хүртэлх хувийн хэмжээний торгуулийг 30 хоногоос илүүгүй хугацаанд ногдуулах.

(2) Энэхүү конвенцид заасан хөнгөлөлтүүд дээр нэмж олгосон хөнгөлөлтийг зогсоох.

(3) Өдөрт хоёр хүртэл цагаар ээлжийн бус ажил хийлгэх.

(4) Баривчлах.

3 дахь хэсэгт заасан шийтгэлийг офицерүүдэд ногдуулахгүй.

Сахилгын шийтгэл нь ямар ч тохиолдолд хүнлэг бус, харгис хэрцгий, эсхүл дайнд олзлогдогчдын эрүүл мэндэд аюултай байж болохгүй.

*90 дүгээр зүйл*

Нэг шийтгэлийн үргэлжлэх хугацаа ямар ч тохиолдолд гуч хоногоос хэтэрч болохгүй. Сахилгын зөрчил үйлдсэн дайнд олзлогдогчдын хэргийг хэлэлцэхээс өмнө, эсхүл сахилгын шийтгэл ногдуулахаас өмнө урьдчилан хоригдож байсан хугацааг шийтгэлийн хугацаанд оролцуулан тооцно.

Дайнд олзлогдогч нь түүнд шийтгэл ногдуулах үед хоорондоо холбоотой, эсхүл үл холбогдох хэд хэдэн сахилгын зөрчилд асуугдаж байсан ч дээр дурдсан гуч хоногийн шийтгэлийн дээд хугацааг уртасгаж болохгүй.

Сахилгын шийтгэл ногдуулах тухай шийдвэр гаргаснаас хойш нэг сарын дотор түүнийг хэрэгжүүлнэ.

Дайнд олзлогдогч сахилгын шийтгэлээр дахин шийтгэгдэх тохиолдолд хэрэв хоёр шийтгэлийн аль нэгний нь хугацаа арав буюу түүнээс дээш бол дараагийн шийтгэлийг хэрэгжүүлэхийн өмнө гурваас доошгүй хоног завсарлана.

*91 дүгээр зүйл*

Дор дурдсан тохиолдлыг дайнд олзлогдогч оргон зайлсан гэж үзнэ:

(1) өөрийг нь харьяалах гүрэн, эсхүл холбоотон гүрнийхээ зэвсэгт хүчинтэй нийлсэн байвал;

(2) олзлогч гүрэн, эсхүл түүний холбоотны хяналтад байгаа нутаг дэвсгэрээс гадагш гарсан байвал;

(3) олзлогч гүрний нутгийн усанд байгаа, гэхдээ олзлогч гүрний хяналтад ороогүй өөрийг нь харьяалах гүрний, эсхүл түүний холбоотны далбаатай хөлөг онгоцонд орсон бол.

Энэ зүйлийн утга агуулгын дагуу оргон зайлсан дайнд олзлогдогч дахин олзлогдвол түүнд өмнө нь оргон зайлсан хэргээр аливаа шийтгэл хүлээлгэхгүй.

*92 дугаар зүйл*

Оргон зайлахыг завдсан буюу 91 дүгээр зүйлд заасан утгаар оргож яваад баригдсан, түүнчлэн үүний өмнө оргох гэж хэд дахин оролдсон дайнд олзлогдогчид зөвхөн сахилгын шийтгэл ногдуулна.

Дайнд олзлогдогч дахин баригдсан тохиолдолд холбогдох цэргийн эрх баригчдын мэдэлд нэн даруй шилжүүлнэ.

Энэхүү конвенцийн 88 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үл харгалзан, оргохоор завдсан дайнд олзлогдогчдод онцгой хяналт тавьж болно. Харин энэ онцгой хяналтыг дайнд олзлогдогчдын лагерьт хэрэгжүүлэх бөгөөд олзлогдогчдын эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлөхгүйгээр, мөн энэхүү конвенцийн дагуу олгогдох нэг ч баталгаанд харшлахгүйгээр гүйцэтгэнэ.

*93 дугаар зүйл*

Оргосон, эсхүл оргохоор завдсан, эсхүл энэ үйлдлийг давтан хийсэн нь оргох, эсхүл оргохоор завдсан үедээ үйлдсэн хэргийн төлөө шүүхийн хариуцлагад татагдсан дайнд олзлогдогчийн гэм бурууг хүндрүүлэх нөхцөл байдал гэж үзэх ёсгүй.

Дайнд олзлогдогч нь хүний амь нас, эрүүл мэндэд хүч хэрэглэн халдаагүй, гагцхүү оргон зайлах зорилгоо хөнгөвчлөхийн тулд нийтийн өмчийн эсрэг гэмт хэрэг, баяжих зорилгогүйгээр хулгай хийсэн, хуурамч баримт бичиг бэлтгэсэн, эсхүл ашигласан, энгийн хувцас өмссөн зэрэг хэрэг үйлдсэн тохиолдолд 83 дугаар зүйлд заасан зарчмын дагуу түүнд зөвхөн сахилгын шийтгэл ногдуулна.

Түүнчлэн оргох, эсхүл оргохоор завдсан үйлдэлд тусалсан, эсхүл хамтран оролцсон дайнд олзлогдогчдод зөвхөн сахилгын шийтгэл хүлээлгэнэ.

*94 дүгээр зүйл*

Оргосон дайнд олзлогдогч дахин баригдсан тохиолдолд оргосон тухай өмнө нь мэдээлсэн бол 122 дугаар зүйлд заасны дагуу түүнийг харьяалах гүрэнд нь энэ тухай мөн мэдээлнэ.

*95 дугаар зүйл*

Сахилгын зөрчилд шийтгэгдэж буй дайнд олзлогдогчдыг шийтгэх тухай шийдвэр гаргахын өмнө, хэрвээ олзлогч гүрний өөрийн нь зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг адил төстэй зөрчил гаргахад урьдчилан хорьдог бол, эсхүл олзлогдогчдын лагерийн дэг журам, сахилгыг бэхжүүлэх сонирхолын үүднээс шаардлагатай байвал урьдчилан хорино.

Сахилгын зөрчил гаргасан дайнд олзлогдогчдыг урьдчилан хорих хугацааг аль болох богино байлгах бөгөөд энэ нь 14 хоногоос илүү байж болохгүй.

Сахилгын зөрчил гаргаж урьдчилан хоригдсон дайнд олзлогдогчдод энэ бүлгийн 97 болон 98 дугаар зүйлийн заалтыг хэрэглэнэ.

*96 дугаар зүйл*

Сахилгын зөрчилтэй холбоотой үйлдэл бүрийг удаашруулахгүйгээр мөрдөж байцаах ёстой.

Шүүхийн байгууллага болон цэргийн дээд тушаалтны эрх хэмжээнд хамаарахаас бусад сахилгын шийтгэлийг зөвхөн лагерийн захирагчийн үүрэг гүйцэтгэж буй офицер, эсхүл түүнийг орлож байгаа офицер, эсхүл тусгайлан эрхээ шилжүүлсэн офицер ногдуулна.

Ямар ч тохиолдолд дайнд олзлогдогчдод ийм бүрэн эрхийг олгохгүй бөгөөд тэд тэрхүү эрхийг хэрэгжүүлэхгүй.

Сахилгын ямар нэг шийтгэл ногдуулахын өмнө дайнд олзлогдогчид түүний шийтгэгдэж буй зөрчлийн нь талаар тодорхой танилцуулах бөгөөд тухайн этгээд үйлдсэн хэргийнхээ учир шалтгааныг тайлбарлах болон өөрийгөө хамгаалах бололцоогоор бүрэн хангагдах эрхтэй. Тухайлбал, гэрч дуудах болон шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн хэлмэрчтэй байхыг зөвшөөрнө. Гаргасан шийдвэрийг дайнд олзлогдогчид болон итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь танилцуулна.

Лагерийн захирагч ногдуулсан сахилгын шийтгэлийн талаар бүртгэл хөтлөх бөгөөд түүнтэй хамгаалагч гүрний төлөөлөгчид танилцах боломжтой байна.

*97 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдыг сахилгын шийтгэлийг нь эдлүүлэхээр ямар ч тохиолдолд засан хүмүүжүүлэх газарт (шорон, засан хүмүүжүүлэх газар, ганцаарчилсан хорих гяндан) шилжүүлж болохгүй.

Сахилгын шийтгэлийг эдлүүлэх бүх байр нь энэхүү конвенцийн 25 дугаар зүйлд дурдсан эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байх ёстой. Шийтгэлээ эдэлж байгаа дайнд

олзлогдогчдыг 29 дүгээр зүйлд заасны дагуу өөрийгөө цэвэр байлгах бололцоогоор хангасан байна.

Офицерууд болон тэдэнтэй адилтгах дайнд олзлогдогчдыг бага дарга нар болон цэргийн хамт нэг байранд байрлуулж болохгүй.

Сахилгын шийтгэл эдэлж байгаа дайнд олзлогдогч эмэгтэйчүүдийг дайнд олзлогдогч эрэгтэйчүүдээс тусгаарлах бөгөөд эмэгтэй харгалзагчийн шууд хяналтад байлгана.

*98 дугаар зүйл*

Сахилгын баривчлагдах шийтгэл эдэлж буй дайнд олзлогдогчид баривчлагдсантай нь холбогдуулан эдлүүлж болохгүйгээс бусад энэхүү конвенцийн заалтаар олгогдож буй нөхцлийг үргэлжлүүлэн эдлэнэ. Конвенцийн 78 болон 126 дугаар зүйлд заасан эрхийг ямар ч тохиолдолд хасч болохгүй.

Сахилгын шийтгэл хүлээсэн дайнд олзлогдогчдын цол хэргэмтэй нь холбогдох хөнгөлөлтийг хасч болохгүй.

Сахилгын шийтгэл хүлээсэн дайнд олзлогдогчдод өдөр бүр биеийн тамирын дасгал хийх, хоёр цагаас доошгүй нарлах боломж олгоно.

Тэдний хүсэлтээр өдөр бүр эмчид биеэ үзүүлэхийг зөвшөөрнө. Тэдэнд эрүүл мэндийн байдалд нь тохирох эмнэлгийн тусламж үзүүлэх буюу шаардлагатай тохиолдолд лагерийн эмнэлэг, эсхүл цэргийн эмнэлэгт хэвтүүлэн эмчилнэ.

Тэдэнд унших, бичих, түүнчлэн захидал илгээх, хүлээн авахыг зөвшөөрнө. Харин тэдэнд ирүүлсэн илгээмж, гуйвуулсан мөнгийг өгөх явдлыг шийтгэлээ эдэлж дуусах хүртэл нь хойшлуулж болно. Энэ хугацаанд уг зүйлийг итгэмжлэгдсэн төлөөлөгчид нь гардуулан өгөх бөгөөд түүний дотроос түргэн муудах хүнсний зүйлийг итгэмжлэгдсэн төлөөлөгч лагерийн эмнэлэгт дамжуулан өгнө.

### **III. Шүүхийн мөрдөлт**

*99 дүгээр зүйл*

Хэрэг үйлдэх үед мөрдөж байсан олзлогч гүрний хуулиар, эсхүл олон улсын эрх зүйн хэм хэмжээний дагуу ял шийтгэлгүйд тооцогдох хэргээр нэг ч дайнд олзлогдогчийг шүүхэд шилжүүлэх, эсхүл шийтгэхийг хориглоно.

Шүүгдэж буй хэргийг өөрт нь тулгаж хүлээлгэх зорилгоор дайнд олзлогдогчдод сэтгэл санааны талаар буюу биед нь хүч хэрэглэж, дарамт шахалт үзүүлж болохгүй.

Өөрийгөө өмгөөлөх бололцоо олгохгүйгээр, эсхүл мэргэжлийн өмгөөлөгчгүйгээр дайнд олзлогдогчдыг шийтгэж болохгүй.

*100 дугаар зүйл*

Ямар гэмт хэрэгт олзлогч гүрний хуулиар цаазаар авах ял оноодог болохыг дайнд олзлогдогчид болон хамгаалагч гүрэнд нэн даруй мэдэгдэх ёстой.

Дайнд олзлогдогчдыг харьяалах гүрний зөвшөөрөлгүйгээр өөр бусад гэмт хэрэгт цаазаар авах ял оноож болохгүй.

87 дугаар зүйлийн 2 дугаарт заасны дагуу дайнд олзлогдогч нь олзлогч гүрний харьяат иргэн биш учраас түүнд үнэнч байх үүрэг өөртөө хүлээгээгүй бөгөөд түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас олзлогч гүрний мэдэлд байгаа гэдэгт шүүх онцгой анхаарал тавьсан нөхцөлд цаазаар авах ял ногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол гаргаж болно.

*101 дүгээр зүйл*

Хэрэв дайнд олзлогдогчид цаазаар авах ял ногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол гарсан нөхцөлд энэ тухай 107 дугаар зүйлд заасны дагуу хамгаалагч гүрэнд мэдэгдсэнээс хойш 6 сар өнгөрсний дараа ялыг гүйцэтгэнэ.

*102 дугаар зүйл*

Олзлогч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд шүүхээс ял ногдуулах журмын дагуу, түүнчлэн энэхүү бүлгийн заалтуудыг мөрдлөг болгон гаргасан дайнд олзлогдогчид ял ногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг хууль ёсны гэж үзнэ.

*103 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчийг мөрдөн байцаах аливаа ажиллагааг нөхцөл байдлаас шалтгаалж аль болохоор түргэн шуурхай явуулж, шүүх хурлыг даруйхан эхлэх ёстой. Олзлогч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг адил төстэй эрх зүйн зөрчилд урьдчилан хоридоггүй бол, түүнчлэн үндэсний аюулгүй байдлын сонирхол үүнийг шаардаагүй тохиолдолд дайнд олзлогдогчдыг урьдчилан хорьж болохгүй. Ямар ч нөхцөл байдалд урьдчилан хорих хугацаа 3 сараас хэтэрч болохгүй.

Урьдчилан хоригдсон хугацааг хорих ялын хугацаанд оруулан тооцохын хамт ял ногдуулахдаа үүнийг анхаарч үзнэ.

Урьдчилан хоригдож буй дайнд олзлогдогч энэ бүлгийн 97 болон 98 дугаар зүйлд заасан эрхийг эдэлсээр байна.

*104 дүгээр зүйл*

Олзлогч гүрэн дайнд олзлогдогчийн эсрэг шүүхийн мөрдөлт үүсгэх аливаа тохиолдолд уг хэргийг шүүх хянан хэлэлцэхээс наад зах нь гурван долоо хоногийн өмнө энэ тухай хамгаалагч гүрэнд мэдэгдэнэ. Уг мэдэгдлийг хамгаалагч гүрэн олзлогч гүрнээс өмнө нь өгсөн хаягаар хүлээж авсан цагаас эхлэж гурван долоо хоногийн хугацааг тооцно.

Уг мэдэгдэлд дор дурдсан мэдээллийг агуулсан байна:

(1) дайнд олзлогдогчийн овог нэр, цол, арми, хорооны болон хувийн дугаар, төрсөн он, сар, өдөр, мэргэжил;

(2) тусгаарлагдан, эсхүл урьдчилан хоригдож байгаа газар;

(3) яллагдаж байгаа гэмт хэрэг, үндэслэл болгож буй хуулийн зүйл, заалтыг тодорхой заасан мэдээлэл;

(4) хэрэг хянан хэлэлцэх шүүхийн нэр, шүүх хурлыг хийхээр төлөвлөсөн газар, шүүх хурал эхлэх сар, өдөр.

Олзлогч гүрэн ийм мэдэгдлийг дайнд олзлогдогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид мөн илгээнэ.

Аливаа хэргийг хянан шийдвэрлэх хурал эхлэхээс наад зах нь гурван долоо хоногийн өмнө дээр дурдсан мэдэгдлийг хамгаалагч гүрэн, дайнд олзлогдогч болон итгэмжлэгдсэн төлөөлөгч хүлээж авсан гэх нотолгоо байхгүй бол хэргийг хянан хэлэлцэх явдлыг хойшлуулах ёстой.

#### *105 дугаар зүйл*

Дайнд олзлогдогч бусад дайнд олзлогдогчдын дотроос тэдний аль нэгний тусламжийг авах, өөрөө сонгож мэргэжлийн өмгөөлөгч авах, гэрч дуудуулах, хэрэв шаардлагатай бол албан ёсны хэлмэрч авах эрхээр хангагдана. Эдгээр эрхийн талаар олзлогч гүрэн шүүх хурал эхлэхээс тодорхой хугацааны өмнө дайнд олзлогдогчид мэдэгдсэн байх ёстой.

Хэрэв дайнд олзлогдогч өмгөөлөгчөө сонгож авч чадаагүй тохиолдолд хамгаалагч гүрэн түүнд нэг долоо хоногийн дотор өмгөөлөгч олж өгнө. Олзлогч гүрэн нь хамгаалагч гүрний хүсэлтээр, дайнд олзлогдогчийг өмгөөлөх мэргэшсэн этгээдийн нэрсийн жагсаалтыг гаргаж өгнө. Хэрэв дайнд олзлогдогч болон хамгаалагч гүрний аль аль нь өмгөөлөгч олж эс чадвал олзлогч гүрэн нь хэрэг өмгөөлөх чиглэлээр мэргэшсэн өмгөөлөгчийг томилно.

Дайнд олзлогдогчийн өмгөөлөгчид шүүгдэгчийг өмгөөлөхөд бэлтгэхийн тулд хэрэг хянан хэлэлцэхээс өмнө хоёр долоо хоногийн хугацаа олгож зайлшгүй шаардлагатай боломжоор хангана. Тухайлбал, шүүгдэгч дээр чөлөөтэй орох, түүнтэй гэрчгүйгээр уулзаж ярилцах эрхтэй. Өмгөөлөгч нь шүүгдэгчийг хамгаалан гэрчилж чадах дайнд олзлогдогчид болон бусад гэрчтэй чөлөөтэй уулзаж зөвлөх эрхийг мөн эдлэнэ. Эдгээр эрхийг давж заалдах хугацаа дуустал эдлэнэ.

Ялын төлөвлөгөө, мөн түүнчлэн олзлогч гүрний зэвсэгт хүчний дагаж мөрдөж буй хуулийн дагуу шүүгдэгчид заавал танилцуулах бусад баримт бичгийг шүүх хурал эхлэхээс хангалттай хугацааны өмнө шүүгдэгчид ойлгомжтой хэлээр үйлдэж гардуулж өгнө. Эдгээр баримт бичгийг адил нөхцөлд дайнд олзлогдогчийн өмгөөлөгчид мөн гардуулна.

Хамгаалагч гүрний төлөөлөгчид үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс хийх хаалттай хуралдаанаас бусад шүүх хуралдаанд оролцох эрхтэй. Хаалттай хуралдаан болох тухай бүр олзлогч гүрэн хамгаалагч гүрэнд урьдчилан мэдэгдэнэ.

*106 дугаар зүйл*

Дайнд олзлогдогч бүр олзлогч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний нэгэн адил таслан шийдвэрлэх тогтоолын талаар давж буюу айлтган заалдах, уг хэргийг дахин хянаж үзэх тухай хүсэлт гаргах эрхтэй. Түүний давж заалдах эрх, хугацааны талаар өөрт нь заавал бүрэн мэдээлсэн байх ёстой.

*107 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчид ял ногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол гаргасан тухай бүр хамгаалагч гүрэнд товч мэдээлэл хүргүүлнэ. Энэ мэдээлэлд дайнд олзлогдогч давж буюу айлтган заалдах эрхтэй эсэх, уг хэргийг дахин хянаж үзэх тухай хүсэлт гаргах эрхтэй эсэхийг дурдсан байна. Уг мэдээллийг дайнд олзлогдогчийн итгэмжлэгдсэн төлөөлгчид мөн явуулна. Хэрэв таслан шийдвэрлэх тогтоолыг дайнд олзлогдогчийг байхгүйд гаргасан бол дээрх мэдээллийг түүний ойлгох хэл дээр үйлдэж өөрт нь мөн явуулна. Түүнээс гадна дайнд олзлогдогч давж заалдах эрхээ эдлэх эсэх талаар ямар шийдвэр гаргасныг олзлогч гүрэн хамгаалагч гүрэнд нэн даруй мэдэгдэнэ.

Хэрэв анхан шатны шүүхээс дайнд олзлогдогчид цаазаар авах шийдвэр гаргасан, эсхүл дайнд олзлогдогчид ногдуулсан шийдвэр хүчин төгөлдөр болсон тохиолдолд дараахь утга бүхий дэлгэрэнгүй мэдээллийг олзлогч гүрэн хамгаалагч гүрэнд нэн даруй илгээнэ:

(1) Таслан шийдвэрлэх тогтоолын бүрэн эх бичвэр;

(2) Урьдчилсан мөрдөн байцаалт болон шүүх хурал дээр яригдсан ялын болон өмгөөллийн тухай товч тайлан;

(3) Ногдуулсан ялыг хаана гүйцэтгэх тухай мэдэгдэл.

Энэ зүйлийн эхний хэсэгт дурдсан мэдээллийг олзлогч гүрэн хамгаалагч гүрэнд өмнө нь өгсөн хаягаар явуулна.

*108 дугаар зүйл*

Хууль ёсоор хүчин төгөлдөр болсон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор ногдуулсан ялыг дайнд олзлогдогч нь олзлогч гүрний зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнтэй адил газар, нөхцөлд эдлэнэ. Эдгээр нөхцөл нь эрүүл ахуй, хүнлэг ёсны шаардлагыг бүрэн хангасан байна.

Ял шийтгүүлсэн дайнд олзлогдогч эмэгтэйчүүдийг тусгай байранд хорих бөгөөд эмэгтэй харгалзагчийн хяналтанд байлгана.

Хорих ял шийтгүүлсэн дайнд олзлогдогч ямар ч тохиолдолд энэхүү конвенцийн 78 болон 126 дугаар зүйлд заасан нөхцлийг эдлэнэ. Түүнээс гадна тэд захидлаар харилцах, сард нэгээс доошгүй удаа илгээмж авах, тогтмол нарлах, түүнчлэн өөрсдийн хүсэлтийн дагуу шаардлагатай эмнэлгийн болон сэтгэл санааны тусламж авах эрхтэй. Тэдэнд ногдуулсан ял нь конвенцийн 87 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөлтэй нийцсэн байх ёстой.

## **IV АНГИ**

### **ОЛЗЛОЛТЫН ХУГАЦАА ДУУСАХ**

#### **I ХЭСЭГ**

##### **Дайнд олзлогдогчдыг эх оронд нь шууд буцаах буюу төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлэх**

###### *109 дүгээр зүйл*

Энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд мөргөлдөөнд оролцогч талууд хүнд өвчтэй буюу хүндээр шархадсан дайнд олзлогдогчдыг тэдний цол хэргэм, тоог үл харгалзан, зөөвөрлөх боломж бүрдсэн үед дараахь зүйлийн эхний хэсэгт заасны дагуу эх оронд нь шууд буцаах үүрэг хүлээнэ.

Мөргөлдөөнд оролцогч талууд төвийг сахисан холбогдох гүрний туслалцаатайгаар дараахь зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан өвчтэй буюу шархадсан дайнд олзлогдогчдыг дайтах ажиллагааны туршид төвийг сахисан гүрэнд эмчлүүлэхээр шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг чармайна. Үүнээс гадна тухайн гүрнүүд удаан хугацаагаар олзлолтонд байгаа эрүүл олзлогдогчдыг эх оронд нь буцаах, эсхүл төвийг сахисан оронд тусгаарлан хорих талаар хэлэлцээр байгуулж болно.

Энэ зүйлийн эхний хэсэгт заасны дагуу эх оронд нь буцааж болох өвчтэй буюу шархадсан дайнд олзлогдогчдыг тэдний өөрсдийн хүслийг нь үл харгалзан дайтах ажиллагааны үед албадан буцааж болохгүй.

###### *110 дугаар зүйл*

Эх оронд нь шууд буцаах ёстой дайнд олзлогдогчид:

(1) эдгэршгүй шархадсан, оюун ухааны болон бие махбодийн чадвар нь үзтэл илэрхий хүчтэй дордож суларсан өвчтэй дайнд олзлогдогчид.

(2) эмчийн тавьсан оношоор нэг жилийн хугацаанд эдгэрэхгүй бөгөөд асрамж шаардлагатай, оюун ухааны болон бие махбодийн чадвар нь үзтэл илэрхий хүчтэй дордож суларсан шархтан, өвчтөн.



(3) эмчлэгдсэн боловч оюун ухааны болон бие махбодийн чадвар нь үзтэл илэрхий хүчтэй, бүрмөсөн сулран дордсон шархтан, өвчтөн.

Төвийг сахисан гүрэнд эмчлүүлэхээр шилжүүлэх дайнд олзлогдогчид:

(1) төвийг сахисан оронд эмчлүүлэх тохиолдолд түргэн эдгэрэх боломжтой, өвдсөн буюу шархадсанаас хойш нэг жилийн дотор эдгэрч болох өвчтөн, шархтан.

(2) олзолтонд цаашид байлгах нь түүний бие махбодь болон оюун ухаанд нь ноцтой аюултай бөгөөд харин төвийг сахисан оронд эмчлүүлснээр түүнийг уг аюулаас аварч болно гэж эмч үзэж байгаа дайнд олзлогдогчид.

Төвийг сахисан гүрэнд эмчлүүлэхээр шилжүүлэх дайнд олзлогдогчдыг эх оронд нь буцаах журам болон тэдний эрх зүйн байдлыг холбогдох гүрнүүд хоорондоо хэлэлцээр байгуулж тогтооно. Төвийг сахисан гүрэнд эмчлүүлэгсдийн дотроос дараахь ангилалд хамаарагдах дайнд олзлогдогчдыг эх оронд нь буцаана:

(1) биеийн эрүүл мэндийн байдал нь доройтсон бөгөөд эх оронд нь шууд буцаах шаардлагад тохирох дайнд олзлогдогчид;

(2) эмчлүүлсний дараа ч оюун ухаан болон бие махбодийн чадвар нь үлэмж доройтсон дайнд олзлогдогчид.

Хэрэв мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд тахир дутуу буюу өвчилснөөс болж эх оронд нь шууд буцаах, эсхүл төвийг сахисан оронд эмчлүүлэх тухай тодорхойлон заасан тусгай хэлэлцээр байгуулагдаагүй тохиолдолд асуудлыг Өвчтэй, шархадсан дайнд олзлогдогчдыг эх оронд нь шууд буцаах болон төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлэх тухай үлгэрчилсэн хэлэлцээр, энэхүү конвенцид хавсаргасан эмнэлгийн хамтарсан комиссын тухай заалтад дурдсан зарчмыг баримтлан шийдвэрлэнэ.

### *111 дүгээр зүйл*

Олзлогч гүрэн болон дайнд олзлогдогчдыг харьяалах гүрэн, түүнчлэн энэ хоёр гүрний тохиролцсон төвийг сахисан гүрэн дайтах ажиллагаа дуустал дайнд олзлогдогчдыг тухайн төвийг сахисан гүрний нутаг дээр тусгаарлан хорих талаар хэлэлцээр байгуулахыг чармайна.

### *112 дугаар зүйл*

Дайтах ажиллагаа эхэлмэгц өвчтэй, шархадсан дайнд олзлогдогчийг гэрчлэн нотлох, тэдний талаар шаардлагатай шийдвэр гаргах зорилгоор эмнэлгийн хамтарсан комисс томилж ажиллуулана. Эдгээр комиссыг томилох болон комиссын үүрэг, үйл ажиллагаа нь энэхүү конвенцид хавсаргасан журмын заалттай нийцсэн байна.

Олзлогч гүрний эмнэлгийн байгууллагын саналаар илт хүнд шархадсан, эсхүл хүндээр өвчилсөн дайнд олзлогдогчдыг эмнэлгийн хамтарсан комиссын үзлэгт оруулалгүйгээр эх оронд нь буцааж болно.

*113 дугаар зүйл*

Олзлогч гүрний эмнэлгийн байгууллагаас нэр заасан дайнд олзлогдогчдоос бусад дор дурдсан ангилалд хамаарах шархадсан, эсхүл өвчтэй дайнд олзлогдогчид өмнөх зүйлд заасан эмнэлгийн хамтарсан комиссын үзлэгт орж гэрчлүүлэх эрхтэй:

(1) Лагерьт ажиллаж байгаа адил үндэсний эмч, эсхүл дайнд олзлогдогчдыг харьяалах гүрний холбоотон болох гүрний иргэн эмчийн нэр заасан шархадсан буюу өвчтэй дайнд олзлогдогчид.

(2) Итгэмлэгдсэн төлөөлөгчийн нэр заасан шархтан, өвчтөн.

(3) Шархадсан буюу өвчтэй дайнд олзлогдогчдыг харьяалах гүрэн, эсхүл уг гүрний зөвшөөрлийн дагуу дайнд олзлогдогчдод тусламж үзүүлж буй байгууллагын нэр заасан шархан, өвчтөн.

Дээр дурдсан гурван ангилалын алинд ч хамаарахгүй дайнд олзлогдогчид эмнэлгийн хамтарсан комисст ирж дээрх гурван ангилалд хамаарагдагсдын дараа үзлэгт орж гэрчлүүлж болно.

Дайнд олзлогдогчид эмнэлгийн хамтарсан комиссын гэрчлэлтэд орох үед тэдэнтэй адил үндэсний эмч болон итгэмжлэгдсэн төлөөлөгч нь уг гэрчлэлтэд байлцах эрхтэй.

*114 дүгээр зүйл*

Энэхүү конвенцийн дагуу эх оронд нь буцаах, эсхүл төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлэх нөхцлийг бие эрхтнээ зориудаар гэмтээснээс бусад гэнэтийн осолд нэрвэгдсэн дайнд олзлогдогчид эдлэнэ.

*115 дугаар зүйл*

Эх оронд нь буцаах, эсхүл төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлэх нөхцөлд хамаарах боловч сахилгын шийтгэл хүлээсэн дайнд олзлогдогчийг уг сахилгын шийтгэлээ эдлэж дуусаагүй гэсэн үндэслэлээр саатуулж болохгүй.

Мөрдөгдөж байгаа, эсхүл шүүхээс ял шийтгүүлсэн дайнд олзлогдогчийг эх оронд нь буцаах, эсхүл төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлэх болсон тохиолдолд олзлогч гүрний зөвшөөрөлтэйгээр мөрдөн байцаалтыг дуусгах, эсхүл ялын хугацаа дуусахаас өмнө эх оронд нь буцаах буюу эмчлүүлэхээр шилжүүлж болно.

Мөргөлдөөнд оролцогч талууд хэргийг нь хянан хэлэлцэж дуусгах, эсхүл ялыг нь эдлүүлэх шалтгаанаар албадан саатуулагдах этгээдийн нэрсийг харилцан мэдээлнэ.

*116 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдыг эх оронд нь буцаах, эсхүл төвийг сахисан орон руу шилжүүлэх зардлыг дайнд олзлогдогчийг харьяалах гүрэн, олзлогч гүрний хилийн шугамнаас эхлэн хариуцна.

*117 дугаар зүйл*

Эх оронд нь буцаасан ямар ч этгээдийг цэргийн жинхэнэ албанд дахин дайчилж болохгүй.

## II ХЭСЭГ

### **Дайтах ажиллагаа дууссаны дараа дайнд олзлогдогчийг чөлөөлөх буюу эх оронд нь буцаах**

*118 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчдыг дайтах ажиллагаа зогсмогц шууд чөлөөлөх буюу эх оронд нь буцаана.

Мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд дайтах ажиллагааг зогсоох зорилгоор байгуулсан хэлэлцээрт дээрх асуудлын талаар заасан заалт байхгүй, эсхүл тийм хэлэлцээр байгуулаагүй тохиолдолд дайнд олзлогдогчдыг олзлогч гүрэн өмнөх хэсэгт заасан зарчмын дагуу эх оронд нь буцаах төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ шуурхай хэрэгжүүлнэ.

Ямар ч тохиолдолд авсан арга хэмжээний талаар дайнд олзлогдогчдод мэдээлнэ.

Дайнд олзлогдогчдыг эх оронд нь буцаах зардлыг бүх тохиолдолд олзлогч гүрэн болон дайнд олзлогдогчдыг харьяалах гүрэн хоорондоо тэгш хувааж гаргана. Энэ зорилгоор зардлыг хуваарилахад дараахь зарчмыг баримтална:

(а) Хэрэв хоёр гүрэн хөрш зэргэлдээ оршдог бол дайнд олзлогдогчдыг харьяалах гүрэн олзлогч гүрний хилийн шугамаас эхлэн дайнд олзлогдогчийн эх орондоо буцах зардлыг хариуцна.

(b) Хэрэв хоёр гүрэн хиллэдэггүй бол олзлогч гүрэн дайнд олзлогдогчдыг өөрийн нутаг дэвсгэрээр хил хүртэл, эсхүл дайнд олзлогдогчдыг харьяалах гүрний нутаг дэвсгэрт ойролцоо байрлах боомт хүртэл тээвэрлэх зардлыг хариуцна. Дайнд олзлогдогчдыг эх оронд нь буцаах асуудалтай холбогдсон бусад зардлын талаар холбогдох талууд шударгаар хуваарилах талаар хэлэлцэн тохирно. Тийм хэлэлцээр байгуулах нь ямар ч нөхцөлд дайнд олзлогдогчдыг эх оронд нь буцаах ажлыг саатуулах үндэслэл болохгүй.

### 119 дүгээр зүйл

Дайнд олзлогдогчдыг эх оронд нь буцаахдаа тэднийг шилжүүлэх тухай энэхүү конвенцийн 46 - 48 дугаар зүйлд заасан адил нөхцөлд, түүнчлэн 118 дугаар зүйл болон энэ зүйлийн дараахь заалтуудыг харгалзан гүйцэтгэнэ.

Эх оронд нь буцаах үед 18 дугаар зүйлд заасны дагуу дайнд олзлогдогчдоос хурааж авсан үнэт зүйлс, түүнчлэн олзлогч гүрний валютад шилжүүлээгүй тэдний гадаад валютыг эзэнд нь буцааж өгнө. Дайнд олзлогдогчдыг эх оронд нь буцаах үед ямар нэг шалтгаанаар тэдэнд буцааж өгөөгүй үнэт зүйлс, гадаад валютыг 122 дугаар зүйлд дурдсан лавлах товчоонд шилжүүлнэ.

Дайнд олзлогдогчдод хувийн эд хогшил, бичиг захидал, хүлээн авсан илгээмж зэргийг авч явахыг зөвшөөрнө. Эх оронд нь буцаах нөхцөл байдлын шаардлагаар дайнд олзлогдогчдын авч явах зүйлийн жинг нэг хүн барьж явахаар хөнгөн байх хэмжээнд хязгаарлаж болно. Бүх тохиолдолд дайнд олзлогдогч бүрт наад зах нь 25 килограмм тээш авч явахыг зөвшөөрнө.

Эх орондоо буцаж байгаа дайнд олзлогдогчдын хувийн бусад эд хогшлыг олзлогч гүрэн хадгалан үлдэнэ. Олзлогч гүрэн дайнд олзлогдогчдыг харьяалах гүрэнтэй эдгээр эд хогшлыг тээвэрлэх болон холбогдох зардлыг төлөх нөхцөлийн талаар хэлэлцээр байгуулмагц даруй эзэнд нь хүргүүлнэ.

Гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хэрэгт татагдсан дайнд олзлогдогчийг шүүх хурал дуустал буюу шаардлагатай тохиолдолд эдэлбэл зохих ялын хугацааг дуустал албадан саатуулж болно. Энэ заалт нь эрүүгийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн дайнд олзлогдогчид нэгэн адил хамаарна.

Мөргөлдөөнд оролцогч талууд хэргийг нь хянан хэлэлцэж дуусгах, эсхүл ялыг нь эдлүүлэх шалтгаанаар албадан саатуулагдаж байгаа дайнд олзлогдогчдын нэрсийг харилцан мэдээлнэ.

Мөргөлдөөнд оролцогч талууд хэлэлцээр байгуулах замаар өөрсдийн орны дотор тарсан дайнд олзлогдогчийг эрэн сурвалжлах, эх оронд нь аль болох богино хугацаанд буцаах ажлыг гүйцэтгэх үүрэгтэй комисс байгуулна.

### III ХЭСЭГ

#### Дайнд олзлогдогчид нас барах

##### 120 дугаар зүйл

Дайнд олзлогдогчийн гэрээслэлийг төрөлх улсынх нь хууль тогтоомжийн шаардлагын дагуу хүчин төгөлдөр болох нөхцөлд нийцүүлэн үйлдэнэ. Тухайн улс эдгээр нөхцөлийн талаар шаардлагатай мэдээллийг олзлогч гүрэнд ирүүлэх арга хэмжээг авна. Дайнд олзлогдогчийн хүсэлтээр болон тэднийг нас барсны дараа бүх тохиолдолд гэрээслэлийг саадгүйгээр хамгаалагч гүрэнд шилжүүлж, баталгаат хуулбарыг төв агентлагт явуулна.

Энэхүү конвенцид хавсаргасан маягтын дагуу үйлдсэн нас барсан тухай гэрчилгээ, эсхүл хариуцагч офицерийн баталгаажуулсан олзлолтонд нас барсан дайнд олзлогдогчдын нэрсийн жагсаалтыг аль болох богино хугацаанд 122 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан олзлогдогчдын лавлах товчоонд шилжүүлнэ. Нас барсан тухай гэрчилгээ болон баталгаажуулсан жагсаалтад 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан дайнд олзлогдогчдын хувийн байдалд хамаарах тодорхой мэдээлэл, түүнчлэн нас барсан газар, он, сар, өдөр, шалтгаан, оршуулсан газар, хугацаа, булшийг таньж олох бүх тэмдгүүд зэргийг дурдсан байна.

Нас барсан шалтгааныг тогтоох, акт үйлдэх, түүнчлэн нас барсан дайнд олзлогдогчдыг таньж тогтоохын тулд олзлогдогчдыг оршуулах буюу чандарлахын өмнө цогцост эмчийн үзлэг хийнэ.

Олзлогч гүрний эрх бүхий байгууллага нас барсан дайнд олзлогдогчдыг ёс төртэй, боломжтой бол өөрсдийнх нь шашны зан үйлийн дагуу оршуулж булшийг хэзээ ч олж болохуйцаар тэмдэг тавих, арчлах арга хэмжээ авна. Нэг гүрэнд харьяалагдах нас барсан дайнд олзлогдогчдыг боломжтой бол нэг газар хамт оршуулна.

Гарцаагүй нөхцөл байдалд хамтад нь оршуулахаас бусад тохиолдолд нас барсан дайнд олзлогдогчдыг бололцооны хэрээр тус тусад нь оршуулна. Цогцсыг гагцхүү эрүүл ахуйн шаардлага буюу шашин шүтлэг хийгээд нас барагчийн тодорхой хүсэлтийг баримтлан чандарлана. Хэрэв цогцсыг чандарлах тохиолдолд энэ тухай болон чандарлах болсон шалтгааныг нас барсан тухай гэрчилгээнд бичнэ.

Булшийг ямар ч үед таньж олохын тулд олзлогч гүрний байгуулсан булшны асуудал эрхлэх алба тэднийг оршуулсан тухай болон булшнуудын тухай бүх мэдээллийг бүртгэнэ. Олзлогч гүрэн булшны жагсаалт, оршуулгын болон бусад газар оршуулсан дайнд олзлогдогчдын тухай мэдээллийг олзлогдогчдыг харьяалах гүрэнд шилжүүлнэ. Эдгээр булшнуудыг харж хамгаалах, дараа нь шарилыг шилжүүлэх явлыг бүртгэх хариуцлагыг тухайн нутаг дэвсгэрийг хянаж байгаа гүрэн, хэрэв тухайн гүрэн энэхүү конвенцид оролцогч тал бол, хариуцна. Дээрх заалтууд нь дайнд олзлогдогчдын эх орны хүсэлтийн дагуу чандарыг хэрхэх асуудлыг шийдвэрлэх хүртэл булшны асуудал эрхлэх алба чандрыг хадгалахад нэгэн адил хамаарна.

*121 дүгээр зүйл*

Харуул манааны албаныхан, эсхүл өөр олзлогдогч, эсхүл өөр ямар нэг этгээд үйлдсэн, эсхүл үйлдсэн гэж сэжиглэгдэх дайнд олзлогдогчдын нас барах болон хүнд гэмтэл авах тохиолдол бүрт, түүнчлэн үл мэдэгдэх шалтгаанаар хүн нас барах тохиолдол бүрт олзлогч гүрэн нэн даруй албан ёсны мөрдөн байцаалт явуулна.

Энэ тухай хамгаалагч гүрэнд нэн даруй мэдэгдэнэ. Гэрчийн мэдүүлэг, ялангуяа дайнд олзлогдогчийн мэдүүлэг, эдгээрийн агуулгыг нэгтгэсэн тайланг хамгаалагч гүрэнд явуулна.

Хэрэв мөрдөн байцаалтын үр дүнд нэг буюу хэд хэдэн этгээдийн гэм бурууг тогтоовол олзлогч гүрэн холбогдох гэм буруутныг шүүхэд шилжүүлэх талаар бүх арга хэмжээг авна.

**V АНГИ**

**ЛАВЛАХ ТОВЧОО БОЛОН ДАЙНД ОЛЗЛОГДОГЧДОД  
ТУСЛАХ НИЙГЭМЛЭГ**

*122 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч тал бүр мөргөлдөөн дөнгөж эхлэх үеэс болон эзлэгдэх бүх тохиолдолд өөрийн мэдэлд байгаа дайнд олзлогдогчдын хэргийг эрхлэх албан ёсны лавлах товчоог байгуулна. 4 дүгээр зүйлд дурдсан ангиллын аль нэгэнд багтах этгээдийг өөрийн нутаг дэвсгэрт хүлээн авсан төвийг сахисан болон байлдаанд оролцоогүй гүрнүүд тэдгээр этгээдийн талаар дээрх арга хэмжээг мөн авна. Холбогдох гүрэн дайнд олзлогдогчдын лавлах товчоог өөрийн ажил хэргийг үр дүнтэй явуулахын тулд шаардлагатай орон байр, тоног төхөөрөмж болон ажилтнаар хангана. Тухайн гүрэн дайнд олзлогдогчдыг ажиллуулах тухай энэхүү конвенцийн холбогдох заалтын дагуу тус товчоонд дайнд олзлогдогчдыг авч ажиллуулах эрхтэй.

Мөргөлдөөнд оролцогч талууд өөрийн эрхшээлд орсон 4 дүгээр зүйлд дурдсан ангиллын аль нэгэнд хамаарах дайсагнагч талын этгээдтэй холбогдох энэ зүйлийн 4, 5, 6 дугаар хэсэгт заасан бүх мэдээллийг аль болох богино хугацаанд өөрийн лавлах товчоонд өгнө. Өөрийн нутаг дэвсгэрт хүлээн авсан дээрх ангилалд хамаарах этгээдийн хувьд төвийг сахисан болон байлдаанд оролцоогүй гүрнүүд мөн адил ийм арга хэмжээ авна.

Тус товчоо нь хамгаалагч гүрэн болон 123 дугаар зүйлд дурдсан төв агентлагаар зуучлуулан уг мэдээллийг маш яаралтайгаар холбогдох гүрнүүдэд илгээнэ.

Эдгээр мэдээлэл нь гэр бүлийн хүмүүст нь шуурхай мэдээ хүргэх боломж олгоно. Уг мэдээлэлд 17 дугаар зүйлийн заалтын дагуу, түүнчлэн лавлах товчоонд байгаа мэдээлэлд үндэслэн дайнд олзлогдогч бүрийн овог нэр, цол, арми, хорооны болон хувийн дугаар, төрсөн газар, он, сар, өдөр, харьяалах гүрэн, эцэг эхийн нэр, мэдээлэл хүргэвэл зохих хүний хаяг, дайнд олзлогдогчтой харилцах хаяг зэргийг дурдсан байна.

Лавлах товчоо холбогдох эрх бүхий байгууллагаас дайнд олзлогдогчийг шилжүүлсэн, чөлөөлсөн, эх оронд нь буцаасан, оргон зайлсан, эмнэлэгт хэвтүүлсэн, нас барсан тухай мэдээллийг авч дээр дурдсан 3 дахь хэсэгт заасан журмаар шилжүүлнэ.

Хүндээр шархадсан буюу хүнд өвчтэй дайнд олзлогдогчдын эрүүл мэндийн талаар тогтмол, боломжтой бол долоо хоног бүр мэдээлж байна.

Олзолтын үед нас барсан зэрэг дайнд олзлогдогчтой холбогдох бүх асуулгад лавлах товчоо хариу өгөх, мөн өөртөө байхгүй мэдээллийг олж авах талаар ямар ч асуулга тавьж болно.

Товчооноос явуулж буй бүх бичиг баримтууд нь гарын үсэг буюу тамгатай байна.

Үүнээс гадна лавлах товчоо нь дайнд олзлогдогчид эх орондоо буцах, чөлөөлөгдөх, оргон зайлах буюу нас барахдаа үлдээсэн бөгөөд гэр бүлийн нь хүмүүст чухал баримт бичиг, олзлогч гүрний валютаас бусад валют, мөнгө, хувийн бүх үнэт зүйлийг цуглуулан холбогдох гүрэнд өгч байх үүрэгтэй. Эдгээр эд хогшлыг тусгайлан боож товчооны тамга даран, эзэмшигчийн талаарх тодорхой мэдээлэл болон дотор нь байгаа зүйлсийн тухай дэлгэрэнгүй жагсаалтыг хавсарган явуулна. Дайнд олзлогдогчийн хувийн бусад зүйлийг мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд тохиролцсоны дагуу шилжүүлнэ.

### *123 дугаар зүйл*

Дайнд олзлогдогчийн хэрэг эрхлэх төв агентлагийг төвийг сахисан оронд байгуулна. Хэрэв шаардлагатай гэж үзвэл Олон улсын улаан загалмайн хороо холбогдох гүрэнд хандаж тийм агентлаг байгуулах санал тавина.

Энэхүү агентлаг дайнд олзлогдогчдын талаар албан ёсны болон хувийн шугамаар цуглуулсан бүх мэдээллийг төвлөрүүлэх үүрэгтэй. Уг агентлаг тэдгээр мэдээллийг дайнд олзлогдогчийн эх оронд эсхүл тэдгээрийг харьяалах гүрэнд нэн даруй илгээнэ. Мөргөлдөөнд оролцогч талууд агентлагаас дурдсан мэдээллийг дамжуулах ажилд бүх талаар туслан дэмжинэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудаас, ялангуяа төв агентлагаас үйлчилгээ авч байгаа иргэдийг харьяалж буй талаас шаардлагатай тохиолдолд төв агентлаг санхүүгийн тусламж үзүүлэхийг хүсч болно.

Эдгээр заалтыг Олон улсын улаан загалмайн хороо болон 125 дугаар зүйлд дурдсан тусламжийн нийгэмлэгүүдийн хүмүүнлэгийн үйл ажиллагааг хязгаарлаж байгаагаар тайлбарлаж болохгүй.

### *124 дүгээр зүйл*

Үндэсний лавлах товчоо болон төв агентлаг шуудангийн хураамж төлөх явдлаас чөлөөлөгдөх бөгөөд 74 дүгээр зүйлд заасан бүх хөнгөлөлтийг эдэлнэ. Тэдгээрт мөн боломжийн хэмжээнд цахилгаан мэдээг төлбөргүй ашиглах буюу наад зах нь хамгийн хямд үнээр ашиглах эрх олгоно.

*125 дугаар зүйл*

Олзлогч гүрнүүд өөрийн аюулгүй байдлыг хангах буюу бусад үндэслэлтэй шаардлагын үүднээс арга хэмжээ авахаас бусад тохиолдолд шашны байгууллагын төлөөлөгчдөд, тусламжийн нийгэмлэгүүд, эсхүл дайнд олзлогдогчдод тусламж үзүүлэх өөр аль нэг байгууллагад, түүнчлэн тэдний бүрэн эрхт төлөөлөгчдөд дайнд олзлогдогчидтой уулзах, тэдний дунд тусламжийн илгээмж болон шашин шүтлэг, хүмүүжил, түүнчлэн амралт, дайнд олзлогдогчдоос лагерь дотроо спортын тоглоом тэмцээн зохиоход зориулагдсан төрөл бүрийн материалуудыг хуваарилах ажилд шаардлагатай бүх боломжийг олгоно. Дээр дурдсан нийгэмлэг буюу байгууллагыг олзлогч гүрний нутаг дэвсгэрт, эсхүл өөр оронд үүсгэн байгуулж болох бөгөөд, эсхүл эдгээр нийгэмлэг болон байгууллага нь олон улсын байгууллагын шинж чанартай байж болно.

Олзлогч гүрэн нь дайнд олзлогдогчдод бүрэн хэмжээний хангалттай тусламж үзүүлэхэд нь саад учруулахгүй нөхцөлд нутаг дэвсгэр дээрээ буюу өөрийн хяналтад ажиллуулах нийгэмлэг болон байгууллагын тоог хязгаарлаж болно.

Энэ салбар дахь Олон улсын улаан загалмайн хорооны онцгой үйл ажиллагааг үргэлж хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй хандана.

Дээр дурдсан зорилгоор ирүүлсэн илгээмж, материалуудыг дайнд олзлогдогчдод хүлээлгэн өгсөн даруйд, эсхүл богино хугацааны дотор тусламжийн бараа материалыг хүлээн авсан тухай тусламж үзүүлсэн нийгэмлэг буюу байгууллагад мэдэгдсэн олзлогдогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэгтэй бичгийг илгээмж тус бүрээр үйлдэж явуулна. Үүний зэрэгцээ олзлогдогчдын хянаж буй засаг захиргааны эрх бүхий байгууллага уг илгээмж, материалыг хүлээн авсан тухай мөн нотлоно.

## **VI АНГИ**

### **КОНВЕНЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

#### **I ХЭСЭГ**

##### **Нийтлэг заалт**

*126 дугаар зүйл*

Хамгаалагч гүрнүүдийн төлөөлөгчид буюу элч нарт дайнд олзлогдогчдын байрлаж байгаа бүх газарт очих, тухайлбал тусгаарлах байр, хорих байр, ажиллаж байгаа газарт нэвтрэн орох, түүнчлэн шилжүүлж буй дайнд олзлогдогчдыг явуулах, дамжин өнгөрүүлэх, хүлээн авах газарт очихыг зөвшөөрнө. Тэдэнд олзлогдогчидтой уулзаж ярилцах, тэдний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй гэрчгүйгээр ганцаарчлан, эсхүл орчуулагчтай хамт уулзаж ярилцахыг зөвшөөрнө.

Хамгаалагч гүрний төлөөлөгчид буюу элчид очиж үзэх газраа шилж сонгох бүрэн эрх чөлөө олгоно. Уулзалтын хугацаа, тоог хязгаарлахгүй. Уулзалтыг зөвхөн цэрэг дайны аргагүй шаардлагаас болж хориглож болох бөгөөд энэ нь түр зуурын онцгой арга хэмжээ байна.



Олзлогч гүрэн болон дайнд олзлогдогчдыг харьяалах гүрэн шаардлагатай гэж үзвэл олзлогдогчдын эх орон нэгтнийг уулзалтад оролцуулахыг зөвшөөрөх талаар тохиролцож болно.

Олон улсын улаан загалмайн хорооны төлөөлөгчид мөн ийм эрхийг эдэлнэ. Дайнд олзлогдогчидтой уулзахаар очих төлөөлөгчдийг томилохдоо олзлогч гүрний зөвшөөрлийг авна.

*127 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн эх бичвэрийг тайван цагт болон дайны цагт аль болохоор улс орондоо өргөн дэлгэр сурталчилах, ялангуяа зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн болон нийт хүн амд түүний зарчмуудыг таниулах зорилгоор түүнийг цэргийн сургууль болон хэрэв боломжтой бол иргэний сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулна.

Дайны цагт дайнд олзлогдогчдын төлөө хариуцлага хүлээсэн цэргийн болон бусад эрх бүхий тушаалтнууд энэ конвенцийг өөртөө авч явах бөгөөд түүний агуулгатай тусгайлан танилцсан байна.

*128 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн албан ёсны орчуулгыг болон энэхүү конвенцийн хэрэгжилтийг хангах зорилгоор гаргаж болох хууль тогтоомжийг тайван цагт Швейцарын Холбооны Зөвлөлөөр, харин дайтах ажиллагааны үед хамгаалагч гүрнүүдээр дамжуулан харилцан өөр хоорондоо илгээнэ.

*129 дүгээр зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд дараагийн зүйлд тодорхойлсончлон энэхүү конвенцийг ноцтой зөрчсөн, эсхүл зөрчихийг тушаасан этгээдэд эрүүгийн үр дүнтэй ял шийтгэл хүлээлгэхэд шаардагдах хууль тогтоомжийг батлаж мөрдүүлэх үүрэг хүлээнэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр дурдсан ноцтой зөрчлийг үйлдсэн буюу үйлдэхийг тушаасан этгээдийг эрж олох, аль улсын харьяат эсэхийг харгалзахгүйгээр өөрийн шүүхэд шилжүүлэх үүргийг өөртөө хүлээнэ. Холбогдох хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал тэрхүү этгээдийг шилжүүлэхийг хүсч байгаа нөхцөлд, өөрийн хууль тогтоомжийнхоо дагуу тухайн этгээдийг яллах үндэслэл болох нотлох баримт байгаа хэлэлцэн тохирогч өөр талд түүнийг шилжүүлж болно.

Дараагийн зүйлд дурдсан ноцтой зөрчлөөс бусад энэхүү конвенцид харшилсан зөрчлийг таслан зогсооход шаардлагатай арга хэмжээг хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд авч гүйцэтгэнэ.

Шүүгдэгч этгээд бүх нөхцөл байдалд энэхүү конвенцийн 105 дугаар зүйл болон дараагийн зүйлд зааснаас доргүй шүүхийн зохих ёсны байцаан шийтгэх ажиллагааны баталгаа, өмгөөлүүлэх эрхтэй байна.

*130 дугаар зүйл*

Өмнөх зүйлд дурдсан ноцтой зөрчил гэж энэхүү конвенцийн ивээлд байгаа этгээд болон түүний эд хөрөнгийн эсрэг чиглэсэн дараахь үйлдлийн аль нэгийг үйлдсэнийг хэлнэ: санаатайгаар хүний амь хөнөөх, эрүү шүүлт тулгах, биологийн туршилт үйлдэх зэргээр хүнлэг бус харьцах, тухайлбал хүнд гэмтэл, зовиур санаатай учруулах, эрүүл мэндийг нь хохироох, дайнд олзлогдогчийг дайсагнагч гүрний зэвсэгт хүчинд алба хаалгахаар албадах буюу энэхүү конвенцид заасан шударга, хэвийн шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрхийг нь хасах.

*131 дүгээр зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нь ч өмнөх зүйлд заасан зөрчил үйлдсэний улмаас хүлээх хариуцлагаас өөрийгөө буюу хэлэлцэн тохирогч аль нэг эрхэм дээд талыг чөлөөлөхийг зөвшөөрөхгүй.

*132 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч тал конвенцийг зөрчсөн гэж сэжиглэн хүсэлт гаргах тохиолдолд сонирхогч талуудын хооронд зохих ёсоор тохиролцсон журмыг баримтлан мөрдөн байцаалтыг эхлүүлнэ.

Хэрэв уг хэргийг мөрдөн байцаах журмын талаар талууд хоорондоо харилцан тохирч чадаагүй тохиолдолд журам тогтоох асуудлыг шийдвэрлэх арбитражийг тохиролцон сонгоно.

Конвенцийг зөрчсөн нь тогтоогдвол мөргөлдөөнд оролцогч талууд зөрчлийг таслан зогсоох, зөрчил гаргагчид нэн даруй ял ногдуулах арга хэмжээ авна.

## **II ХЭСЭГ**

### **Төгсгөлийн заалт**

*133 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг англи, франц хэлээр үйлдэв. Хоёр эх бичвэр нь адил хүчинтэй байна.

Конвенцийн орос, испани хэлээрх албан ёсны орчуулгыг Швейцарын холбооны зөвлөл хийж гүйцэтгэнэ.

*134 дүгээр зүйл*

Энэхүү конвенц нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын хоорондын харилцаанд 1929 оны долдугаар сарын 27-ны өдөр байгуулсан конвенцийг орлоно.

*135 дугаар зүйл*

1899 оны 7 дугаар сарын 29-ний өдөр болон 1907 оны 10 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан Хуурай газрын дайны хууль болон заншлын тухай Гаагийн конвенцоор үүрэг хүлээсэн гүрнүүд болон энэхүү конвенцид оролцогч тал болох гүрнүүдийн хоорондын харилцаанд энэхүү конвенц нь Гаагийн конвенцуудад хавсаргасан журмын II бүлэгт нэмэлт болно.

*136 дугаар зүйл*

Энэ өдрөөр тэмдэглэх энэхүү конвенц 1949 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Женев хотноо нээгдсэн бага хуралд оролцсон гүрнүүд, түүнчлэн уг бага хуралд оролцоогүй боловч 1929 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн конвенцид оролцогч тал болох гүрнүүдийн нэрийн өмнөөс 1950 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

*137 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг аль болох түргэн соёрхон батлах бөгөөд батламж жуух бичгийг Берн хотноо хадгалуулна.

Швейцарийн холбооны зөвлөл хадгалуулахаар өгсөн батламж жуух бичиг бүрийн бүртгэл хөтөлж, энэ бүртгэлийн баталгаатай хуулбарыг нэрийн нь өмнөөс конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсноо мэдэгдсэн бүх гүрэнд дамжуулна.

*138 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь хоёроос доошгүй батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Түүнээс хойш энэ нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрийн хувьд батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

*139 дүгээр зүйл*

Энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш түүнд нэрийн нь өмнөөс гарын үсэг зураагүй аливаа гүрний хувьд нэгдэн ороход нээлттэй байна.

*140 дүгээр зүйл*

Нэгдэж орсноо Швейцарийн холбооны зөвлөлд бичгээр мэдэгдэх бөгөөд ийнхүү нэгдэж орсон нь тухайн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Швейцарийн холбооны зөвлөл нэгдэн орсон талаар нэрийн нь өмнөөс конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсноо мэдэгдсэн бүх гүрэнд мэдэгдэнэ.

*141 дүгээр зүйл*

Дайтах ажиллагаа буюу эзлэлт эхлэхээс өмнө буюу эхэлсний дараа мөргөлдөөнд оролцогч талуудын хадгалуулсан батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай мэдэгдэл 2, 3 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу нэн даруй хүчин төгөлдөр болно. Швейцарийн холбооны зөвлөл мөргөлдөөнд оролцогч талуудаас хүлээн авсан соёрхон батласан буюу нэгдэн орсон тухай аливаа мэдэгдлийг хамгийн түргэн аргаар хүргүүлнэ.

*142 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр энэхүү конвенцийг цуцлах эрхтэй.

Цуцлах тухайгаа Швейцарийн холбооны зөвлөлд бичгээр мэдэгдэх бөгөөд түүнийг Швейцарийн холбооны зөвлөл хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талын засгийн газарт дамжуулна.

Цуцлалт нь цуцлах тухай Швейцарийн холбооны зөвлөлд мэдэгдсэнээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно. Гэхдээ цуцалж буй гүрэн мөргөлдөөнд оролцож байгаа үед цуцлах тухай мэдэгдсэн тохиолдолд цуцлалт нь тайван байдлыг тогтоох болон энэхүү конвенцоор хамгаалагдах этгээдүүдийг суллаж, эх оронд нь буцаах ажиллагаа дуусах хүртэл хүчин төгөлдөр болохгүй.

Цуцлалт нь зөвхөн цуцалж буй гүрний хувьд хүчинтэй байна. Энэ нь дэлхийн соёл иргэншилт ард түмнүүдийн хооронд тогтсон заншил, хүнлэг ёсны хууль болон олон нийтийн ухамсарт ёс суртахуунаас үндэстэй олон улсын эрх зүйн зарчмын дагуу мөргөлдөөнд оролцогч талуудын заавал биелүүлэх ёстой хэвээр байх үүрэгт хэрхэвч нөлөөлөхгүй.

*143 дугаар зүйл*

Швейцарийн холбооны зөвлөл энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ. Швейцарийн холбооны зөвлөл нь энэхүү конвенцийг соёрхон батласан, түүнд нэгдэж орсон болон түүнийг цуцалсан тухай мэдэгдлийг авсан тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт мөн мэдээлнэ.

Үүнийг нотлон дор гарын үсэг зурагсад бүрэн эрхээ хадгалуулж энэхүү конвенцид гарын үсэг зурав.

1949 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Женев хотноо англи, франц хэлээр үйлдэв. Жинхэнэ эхийг Швейцарийн Холбооны Улсын архивт хадгална. Швейцарийн холбооны зөвлөл түүний баталгаатай хуулбарыг гарын үсэг зурсан болон нэгдэж орсон улс бүрт дамжуулна.

## I ХАВСРАЛТ

### ӨВЧТЭЙ, ШАРХАДСАН ДАЙНД ОЛЗЛОГДОГЧДЫГ ЭХ ОРОНД НЬ ШУУД БУЦААХ БОЛОН ТӨВИЙГ САХИСАН ОРОНД ЭМЧЛҮҮЛЭХЭЭР ШИЛЖҮҮЛЭХ ТУХАЙ ҮЛГЭРЧИЛСЭН ХЭЛЭЛЦЭЭР

(110 дугаар зүйлийг үз)

#### I. Эх оронд нь шууд буцаах болон төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлэх зарчмууд

##### A. Эх оронд нь шууд буцаах

Дараахь дайнд олзлогдогчдыг эх оронд нь шууд буцаана:

(1) Гэмтэснээс болж дараахь бэртэнг авсан бүх дайнд олзлогдогчид; Үүнд: гар, хөл зэрэг үе мөчнийхөө нэгийг алдах, саа өвчин тусах, үе мөчөө гэмтээх, хамгийн наад зах нь өрөөсөн гар буюу хөлгүй болох, эсхүл нэг гар буюу хөлгүй болсонтой тэнцэх үе мөчний болон бусад гэмтлүүд орно. Эдгээр тохиолдлуудыг өргөн утгаар нь тайлбарлаж болох боловч дор дурдсан тохиолдолд гар буюу хөлгүй болсонд тооцно:

- (a) гар, эсхүл бүх хуруунууд, эсхүл нэг гарын эрхий болон долоовор хуруугүй болох, хөл, эсхүл хөлийн бүх хуруунууд, нэг хөлийн өлмийн тулгуур ясгүй болох.
- (b) *ankylosis* болон ясны эд эс гэмтэх, гол үеүүдийн аль нэгний буюу өрөөсөн гарын бүх үеүүдийн хөдөлгөөнийг эвдсэн сорвийн агшилт.
- (c) урт ясны *pseudarthrosis*.
- (d) яс хугарах буюу бусад гэмтлийн улмаас хүнд зүйл өргөж зөөх чадварыг мэдэгдэхүйцээр алдах гэмтэл.

(2) Эмчийн оношилж байгаагаар гэмтэл, эмгэг нь архагшсан шинжтэй болсон бөгөөд эмчилгээ хийсэн ч нэг жилийн дотор эдгэрэх боломжгүй гэж үзсэн шархадсан дайнд олзлогдогчид дараахь тохиолдолд:

- (a) эмнэлгийн хамтарсан комисс үзлэг хийх үедээ ноцтой хүндрэл олж тогтоогоогүй ч, зүрхэнд сумны хэлтэрхий орсон байх тохиолдол.
- (b) эмнэлгийн хамтарсан комисс үзлэг хийх үедээ биеийн тодорхой хэсэгт болон бүхэл биед гэмтэл олж тогтоогоогүй ч, хожим тархи буюу уушигт төмрийн хэлтэрхий орсон байх нь мэдэгдэх.
- (c) шархдаснаас хойш жилийн турш эмчилгээ хийсэн ч эдгэрэх шинжгүйгээр барахгүй цаашдаа үеийн хөдөлгөөнийг зогсоох буюу хөл, гаргүй болсонтой тэнцэх өөр гэмтэлд хүргэх төлөвтэй *osteomyelitis*.
- (d) томоохон үе мөчид орсон шархнаас болж үе идээлэх.
- (e) ясны эд эсийн ажиллагаа өөрчлөгдсөнөөс гавлын яс гэмтэх.

- (f) нүүрний шарх буюу түлэгдэлтээс эд эсүүд гэмтэж ажиллагаагүй болох.
  - (g) нурууны нугас гэмтэх.
  - (h) захын мэдрэлийн судас гэмтсэнээс болж хөл, гаргүй болсонтой тэнцэх гэмтэл учрах, уг гэмтэл нь шархадсанаас хойш бүтэн жилээс илүү хугацаанд эмчилгээ шаардах, үүнд жишээлбэл мөрний болон олон ясны уулзварын мэдрэлийн системийн шархдалт, бүсэлхий болон өгзөгний мэдрэлийн зангилааны шархдалт, шуу, тохойн мэдрэлийг болон өвдөг, шилбэний их, бага мэдрэлийг нийтэд нь хамарсан шархдалт зэрэг орно. Шуу, тохойн болон өвдөг, шилбэний их, бага мэдрэл тус тусдаа гэмтсэн тохиолдолд шархтнуудыг эх оронд нь буцаахгүй бөгөөд харин үе агшилт буюу мэдрэл тэжээлийн хүнд хямралуудын тохиолдолд буцаах нөхцөлд хамрагдана.
  - (i) шээсний замын эрхтэн гэмтэж ажиллагаа нь ноцтой муудах.
- (3) Эмчийн оношилж байгаагаар өвдсөнөөс хойш нэг жилийн турш эмчилгээ хийсэн ч эдгэрэхгүй, архагшсан өвчтэй дайнд олзлогдогчид дараахь өвчтэй бол:
- (a) эмчийн оношилж байгаагаар төвийг сахисан оронд эмчилгээ хийгээд ч эдгэрэхгүй, олигтой засал олохгүй шинж байдалтай аль нэг эрхтний даамжирч байгаа сүрьеэ.
  - (b) цээжний гялтангийн шүүрэлт үрэвсэл.
  - (c) эдгэрэх шинжгүй сүрьеэгийн төрлийн бус амьсгалын замын хүнд өвчнүүд: үүнд жишээ нь уушигны хүнд тэлэгдэл (мөгөөрсөн хоолойн бронхиттой эсхүл бронхитгүй үрэвсэл) архагшсан багтраа, олзлогдож ирснээс хойш жил гаруй үргэлжилсэн мөгөөрсөн хоолойн архаг бронхит, мөгөөрсөн хоолойн үрэвсэл.
  - (d) цусны эргэлтийн эрхтнүүдийн архагшсан хүнд гэмтлүүд: эмнэлгийн хамтарсан комисс үзлэг хийх үедээ эдгээр өвчний тэмдгийг олж тогтоогоогүй ч, олзолтонд байх үед муудах тэмдэг илэрсэн зүрхний хавхлагын гэмтэл, миокардит, перикарт болон судасны гэмтлүүд (Бюргерийн өвчин, том судаснуудын бүдүүрэл).
  - (e) хоол боловсруулах эрхтнүүдийн архагшсан хүнд гэмтлүүд: ходоодны буюу арван хоёр нугалаа гэдэсний шархлаа, олзолтонд байх үедээ ходоодны орчим хийлгэсэн мэс заслын үр дагаварууд, жил гаруй үргэлжилж эрүүл мэндийг доройтуулсан архагшсан ходоодны үрэвсэл, нарийн болон бүдүүн гэдэсний үрэвслүүд, элэг хатуурах өвчин, цэсний архаг өвчин.
  - (f) шээсний болон бэлгийн замын эрхтнүүдийн архагшсан хүнд гэмтлүүд, жишээ нь: цааш даамжрах бөөрний архаг үрэвсэл, сүрьеэтэй бөөрийг авч хаях, бөөрний аяганы архаг үрэвсэл буюу давсагны үрэвсэл, бөөрний усжилт болон идээлэлт, эмэгтэй хүний бэлгийн архагшсан хүнд өвчин, жирэмсэн байдал болон төвийг сахисан оронд эмчлүүлэх боломжгүй эдгээртэй холбогдох өвчнүүд.
  - (g) төв болон захын мэдрэлийн системийн архагшсан хүнд өвчнүүд, жишээ нь: хурц психоз болон психоневроз, үүнд эмчийн\* гэрчилснээр

олзлолтонд байгаагын улмаас үүссэн хүнд хийрхэл, хүнд психоневроз, лагерийн эмчийн\* тогтоосон янз бүрийн эпилепси өвчин, тархины судасны хатуурал, жилээс илүү хугацаанд архагшсан неврит.

- (h) бие махбодийн болон оюун ухааны чадварыг доройтуулж биеийн жинг үлэмж бууруулан тамиргүй болгодог дотор болон бодисын солилцооны эрхтнүүдийн мэдрэлийн системийн архагшсан хүнд өвчин.
- (i) хоёр нүд сохрох, эсхүл нэг нүдний харааг засах шил хийсэн ч түүний хараа нэгждээ хүрч чадахгүйгээр нэг нүд сохрох, харааны хурц чанар багасч түүнийг наад зах нь нэг нүдэнд 50 хувь хүртэл сэргээх боломжгүй болох, нүдний бусад ноцтой гэмтлүүд, жишээ нь: нүдний даралт ихэсгэх өвчин, нүдний цацрагт болон судаст бүрхүүлийн өвчин, нүдний халдварт өвчин.
- (k) сонсголын гэмтэл, жишээ нь: нэг чих бүрэн дүлийрэх, нөгөө чихэнд нэг метрийн зайнаас ердийн байдлаар хэлсэн үгийг сонсож ялгахгүй болох.
- (l) бодисын солилцооны хүнд өвчин, жишээ нь: инсулинээр хийх эмчилгээ шаардах чихрийн өвчин.
- (m) дотоод шүүрлийн булчирхайн хүнд өвчин, жишээ нь: бамбай булчирхайны ажиллагаа ихэдсэний болон багадсаны хордлого, Адрисоны өвчин, Симмондсын тураал, татран.
- (n) цус үүсгэгч эрхтнүүдийн архагшсан хүнд өвчин.
- (o) архагшсан хүнд хордлого: хар тугалганы хордолт, мөнгөн усны хордолт, морфин, мансууруулах бодис болон согтууруулах ундаанд донтох өвчин, хий болон олон төрлийн цацраг туяаны хордлого.
- (p) ажиллагаа нь хэт өөрчлөгдсөн хөдлөх эрхтнүүдийн архагшсан өвчин, жишээ нь: үе мөчний хэлбэр дүрс алдагдах өвчин, нэг болон хоёрдугаар үедээ орж даамжирсан үе мөчний архаг үрэвсэл, үе мөчний удааширсан өвчин.
- (q) эмчилгээ авахгүй болсон арьсны архагшсан хүнд өвчин.
- (r) янз бүрийн хорт хавдрууд.
- (s) халдвар авснаас хойш жил үргэлжилж байгаа ноцтой халдварт архагшсан өвчнүүд, жишээ нь: бие организмд гүнзгий өөрчлөлт өгдөг хумхаа өвчин, ноцтой үгширсэн савханцартай цусан суулга, гуравдугаар үедээ орсон эмчилгээгүй тэмбүү, яр, эмчилгээгүй арьсны хүнд өвчнүүд.
- (t) витаминь хүндэрсэн дутагдал болон тураал.

\* Эмнэлгийн хамтарсан комиссын шийдвэрийг лагерийн эмч, дайнд олзлогдогчдын ижил үндэсний эмч нар болон олзлогч гүрний мэргэжилтэн эмч нарын гэрчилсэн баримтад үндэслэнэ.



## **В. Төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлэх**

Дараахь этгээдийг төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлнэ:

(1) Олзлолтонд байх үедээ эмчилгээ хийлгэсэн ч эдгэрэхгүй байгаа, харин төвийг сахисан оронд эмчилгээ хийлгэх тохиолдолд биеийн байдал нь илт сайжрах буюу эдгэрч болох шархадсан дайнд олзлогдсон.

(2) Олзлогдохоос өмнө эдгэрээд дахин өвчилсөн, төвийг сахисан оронд эмчилгээ хийлгэх тохиолдолд бүрэн эдгэрэх буюу нэлээд сайжрах төлөвтэй нэгдүгээр үедээ байгаа сүрьеэгээс бусад янз бүрийн эрхтэнд туссан аливаа хэлбэрийн сүрьеэтэй дайнд олзлогдсон.

(3) Амьсгалын замын, цусны эргэлтийн болон хоол боловсруулах эрхтнүүд, мэдрэлийн системн эрхтэн, шээс болон бэлгийн замын эрхтний, арьсны гадарга, хөдлөх эрхтний эмчилгээ шаардах өвчин туссан, олзлолтонд бус төвийг сахисан оронд эмчилгээ хийлгэх нь үр дүнд хүргэх дайнд олзлогдсон.

(4) Олзлолтонд байх үедээ сүрьеэгийн бус өвчний улмаас бөөрөө авахуулсан, далд хэлбэрийн буюу эдгэрэх үедээ орсон *osteomyelitis* өвчтэй, инсулин шаардахгүй чихрийн өвчтэй дайнд олзлогдсон.

(5) Дайн буюу олзлогдосны улмаас невротой болсон дайнд олзлогдсон. Олзлолтонд байх үедээ неврозээр өвдөж, төвийг сахисан оронд гурван сар эмчлүүлээд эдгэрээгүй буюу эдгэрэх шинж тэмдэг тодроогүй өвчтөнг эх оронд нь буцаана.

(6) Төвийг сахисан оронд эмчлүүлээд эдгэрэх төлөвтэй архаг интоксикац (хий, төмөр болон алколоид гэх мэт) өвчтэй бүх дайнд олзлогдсон.

(7) Олзлогдсон жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл болон балчир насны хүүхэдтэй эхчүүд.

Дараахь этгээдийг төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлэхгүй:

(1) Зохих ёсоор нотолсон бүх төрлийн психоз өвчтэй өвчтөн.

(2) Эмчилгээ авахгүй мэдрэлийн янз бүрийн өвчтэй өвчтөн.

(3) Сүрьеэгээс бусад халдварт үедээ байгаа халдварт өвчтөн.

## **II. Ерөнхий тайлбар**

(1) Дээр дурдсан бүх нөхцөлийг хамгийн өргөн утгаар нь тайлбарлан ойлгож хэрэглэнэ. Дайны улмаас буюу олзлолтонд байснаас, түүнчлэн бүх үеийн сүрьеэгийн уршгаас үүссэн невропати буюу психопати өвчний тухайд мөн өргөн утгаар ойлгоно. Олон тооны шарх олсон ч тэдгээрийн аль нэг нь эх оронд нь буцаах үндэслэл болохгүй байгаа дайнд олзлогдсдын тухайд олон тооны шарх олсны улмаас сэтгэл санааны гүнзгий хямралд орсныг нь анхааран дээрх зарчмыг хэрэглэнэ.

(2) Эх оронд нь шууд буцах үндэслэлтэй бүх маргаангүй тохиолдолд, тухайлбал, үе мөчөө тайруулах, бүтэн сохрох, сонсголгүй болох, уушигны халдварт сүрьеэ, сэтгэл мэдрэлийн өвчин, хорт хавдар гэх мэт тохиолдолд лагерийн эмч буюу олзлогч гүрнээс томилсон цэргийн эмч нар дайнд олзлогдогчдыг аль болох түргэн гэрчилж эх оронд нь буцаана.

(3) Дайнаас өмнө олсон бөгөөд цааш хүндрээгүй шарх, өвчин, түүнчлэн эргэж цэргийн алба хаахад саад болохооргүй дайны үед олсон шарх зэрэг нь эх оронд нь шууд буцаах үндэслэл болохгүй.

(4) Мөргөлдөөнд оролцогч бүх гүрнүүд энэхүү хавсралтын заалтуудыг нэг адилаар ойлгож хэрэглэнэ. Холбогдох гүрэн болон эрх бүхий байгууллага эмнэлгийн хамтарсан комиссоос эдгээр зорилтыг биелүүлэхэд шаардлагатай бололцоог олгоно.

(5) Дээр 1 дэх хэсэгт дурдсан тохиолдлууд нь зөвхөн түгээмэл тохиолдлууд болно. Эдгээр заалтуудад бүрэн тохирохгүй тохиолдлыг энэхүү конвенцийн 110 дугаар зүйл болон энэхүү хэлэлцээрийн зарчмуудын дагуу авч үзнэ.

**II ХАВСРАЛТ**  
**ЭМНЭЛГИЙН ХАМТАРСАН**  
**КОМИССУУДЫН ТУХАЙ ЗААЛТ**

*(112 дугаар зүйлийг үз)*

*1 дүгээр зүйл*

Конвенцийн 112 дугаар зүйлд дурдсан эмнэлгийн хамтарсан комиссууд гурван гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хоёр нь төвийг сахисан улсын харьяат байхын хамт гурав дахийг нь олзлогч гүрэн томилно. Энд дурдсан төвийг сахисан орны хоёр гишүүний нэг нь комиссыг даргална.

*2 дугаар зүйл*

Төвийг сахисан хоёр гишүүнийг Олон улсын улаан загалмайн хороо олзлогч гүрний хүсэлтээр хамгаалагч гүрэнтэй хэлэлцэн тохирч томилно. Тэд өөрийн эх орон, төвийг сахисан өөр нэг орон, эсхүл олзлогч гүрний нутаг дэвсгэрт байрлана.

*3 дугаар зүйл*

Нэр дэвшигдсэн төвийг сахисан гишүүдийг мөргөлдөөнд оролцогч холбогдох талууд хүлээн зөвшөөрөх ёстой бөгөөд ийнхүү хүлээн зөвшөөрснөө Олон улсын улаан загалмайн хороо болон хамгаалагч гүрэнд мэдэгдэнэ. Мэдэгдлийг хүлээн авсан цагаас эхлэн тэднийг комиссын жинхэнэ гишүүнд томилогдсонд тооцно.

*4 дүгээр зүйл*

Зайлшгүй шаардлагатай тохиолдолд орлуулан ажиллуулахын тулд комиссын жинхэнэ гишүүдийн хангалттай тооны орлогчдыг мөн томилно. Тэднийг жинхэнэ гишүүдийн хамт, эсхүл тэднийг томилсны дараа аль болох богино хугацаанд томилно.

*5 дугаар зүйл*

Хэрэв Олон улсын улаан загалмайн хороо ямар нэг шалтгаанаар төвийг сахисан гишүүдийг томилж чадахгүй тохиолдолд тэдгээрийг хамгаалагч гүрэн томилно.

*6 дугаар зүйл*

Боломжтой тохиолдолд төвийг сахисан хоёр гишүүний нэг нь мэс засалч, нөгөө нь дотрын эмч байна.

*7 дугаар зүйл*

Төвийг сахисан гишүүд мөргөлдөөнд оролцогч талуудаас хамааралгүй байх бөгөөд харин тухайн талууд тэдэнд үүргээ гүйцэтгэх бүх бололцоог олгоно.

*8 дугаар зүйл*

Энэхүү заалтын 2 болон 4 дүгээр зүйлд дурдсан томилолтыг хийх үедээ Олон улсын улаан загалмайн хороо олзлогч гүрэнтэй хэлэлцээр байгуулах замаар тэдгээр хүмүүсийн ажиллах нөхцлийг тодорхойлно.

*9 дүгээр зүйл*

Эмнэлгийн хамтарсан комисс төвийг сахисан гишүүдийг батласан даруйд, цаад зах нь түүнээс хойш 3 сарын дотор ажлаа эхлүүлнэ.

*10 дугаар зүйл*

Эмнэлгийн хамтарсан комиссууд конвенцийн 113 дугаар зүйлд дурдсан дайнд олзлогдогч бүрийг гэрчлэн эх оронд нь буцаах, эх оронд нь буцаасан олзлогдогчдын жагсаалтаас хасах болон гаргасан шийдвэрийг дараагийн гэрчлэлт хийх хүртэл хойшлуулах талаар санал гаргана. Шийдвэрийг олонхийн саналаар батална.

*11 дүгээр зүйл*

Гэрчилснээс хойш нэг сарын дотор эмнэлгийн хамтарсан комисс гаргасан шийдвэр бүрийнхээ тухай олзлогч гүрэн, хамгаалагч гүрэн болон Олон улсын улаан загалмайн хороонд мэдэгдэнэ. Түүнчлэн эмнэлгийн хамтарсан комисс нь эмнэлгийн гэрчлэлтийн талаар гаргасан шийдвэрээ дайнд олзлогдогчдод мөн мэдэгдэж эх орон нь буцаахыг санал болгож буй олзлогдогчдод энэхүү конвенцид хавсаргасан маягтаар гэрчилгээ оолгоно.

*12 дугаар зүйл*

Олзлогч гүрэн гаргасан шийдвэрийн талаархи албан ёсны мэдэгдлийг хүлээн авснаас хойш гурван сарын дотор эмнэлгийн хамтарсан комиссын шийдвэрийг биелүүлнэ.

*13 дугаар зүйл*

Хэрэв эмнэлгийн хамтарсан комисс ажиллуулах шаардлага гарсан оронд төвийг сахисан улсын харьяат нэг ч эмч байхгүй буюу ямар нэг шалтгаанаар өөр нэг оронд суугаа төвийг сахисан улсын харьяат эмчийг тухайн орон руу явуулах боломжгүй тохиолдолд олзлогч гүрэн, хамгаалагч гүрний зөвшөөрөлтэйгээр, эмнэлгийн хамтарсан комиссын үүргийг гүйцэтгэх эмнэлгийн комисс байгуулна. Уг эмнэлгийн комисст энэхүү хавсралтын 1, 2, 3, 4, 5 болон 8 дугаар зүйлийн заалтууд хамаарахгүй.

*14 дүгээр зүйл*

Эмнэлгийн хамтарсан комиссууд байнгын ажиллагаатай байх бөгөөд лагерь бүрт зургаан сард нэгээс доошгүй удаа очиж ажиллана.

**III ХАВСРАЛТ**

**ДАЙНД ОЛЗЛОГДОГЧДОД ҮЗҮҮЛЭХ  
ТУСЛАМЖИЙН ХАМТЫН ИЛГЭЭМЖИЙН ТУХАЙ ЖУРАМ**

*(73 дугаар зүйлийг үз)*

*1 дүгээр зүйл*

Итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд өөрийн лагерьт байгаа дайнд олзлогдогчдын дунд, түүнчлэн эмнэлэг, шорон буюу засан хүмүүжүүлэх бусад газарт байгаа олзлогдогчдын дунд тусламжийн хамтын илгээмжийг хуваарилж өгөхийг зөвшөөрнө.

*2 дугаар зүйл*

Тусламжийн хамтын илгээмжийг ивээн тэтгэгчдийн заавар болон дайнд олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн боловсруулсан төлөвлөгөөний дагуу хуваарилна. Эмнэлгийн материал бүхий илгээмжийг эмнэлгийн ерөнхий эмчтэй тохиролцсоны үндсэн дээр хуваарилна. Уг илгээмжийг нэгдсэн эмнэлэг болон цэргийн ангийн эмнэлэгт хуваарилахдаа тэнд байгаа өвчтөнүүдийн эрэлт хэрэгцээг харгалзан дээр дурдсан журмаас өөрөөр хандаж болно. Илгээмжийг тогтоосон хязгаарлалтын дагуу шударгаар хуваарилна.

*3 дугаар зүйл*

Ивээн тэтгэгчдээс илгээсэн тусламжийн илгээмжийн тоо, чанарыг шалган үзэх, ивээн тэтгэгчдэд дэлгэрэнгүй илтгэл бичих зорилгоор дайнд олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчид болон тэдний орлогчдод тусламжийн илгээмжийг хүлээн авах лагерийн ойролцоох цэгт биеэр байлцахыг зөвшөөрнө.

*4 дүгээр зүйл*

Олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд лагерийн бүх салбар хэсэгт тусламжийн илгээмжийг тэдгээрийн зааврын дагуу хуваарилж байгаа эсэхийг биеэр очиж шалгах бололцоогоор хангана.

*5 дугаар зүйл*

Илгээмж явуулсан ивээн тэтгэгчдэд зориулж тусламжийн илгээмжийн хуваарилалт, хэрэгцээ, тоо хэмжээ зэрэг холбогдох мэдээллийг тусгасан маягт буюу анкетыг бөглөж явуулах, мөн ажлын баг, хэсэг дэх итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл цэргийн нэгдсэн эмнэлгийн болон лагерийн эмнэлгийн ерөнхий эмч нараар дээрх

маягт буюу анкетийг бөглүүлэхийг дайнд олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд зөвшөөрнө. Зохих ёсоор бөглөсөн маягт буюу анкетийг ивээн тэтгэгчдэд даруй илгээнэ.

*6 дугаар зүйл*

Тусламжийн хамтын илгээмжийг лагерьт байгаа дайнд олзлогдогчдод тогтмол хуваарилах болон шинээр ирэх дайнд олзлогдогчдод тусламжийн барааг хуваарилах хэрэгцээг хангах үүднээс тусламжийн хамтын илгээмжийн хангалттай хэмжээний нөөцийг бий болгон хадгалахыг дайнд олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд зөвшөөрнө. Энэ зорилгоор шаардагдах агуулахыг барих бөгөөд агуулах бүрийг хоёр давхар цоожилж, нэг түлхүүрийг олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд, харин нөгөө түлхүүрийг лагерийн захирагч тус тус хадгална.

*7 дугаар зүйл*

Тусламжийн хамтын илгээмжийн журмаар хувцас ирүүлсэн тохиолдолд дайнд олзлогдогч тус бүрт түүний хувийн өмч болгон нэг иж бүрдэл хувцас олгоно. Хэрэв дайнд олзлогдогч нь нэг иж бүрдлээс илүү тооны хувцастай байвал тэрхүү илүү хувцас хэрэглэлийг авч хувцас хэрэглэлээр дутагдаж байгаа дайнд олзлогдогчдод өгөхийг олзлогдогчдын итгэмжлэгдсэн төлөөлөгчдөд зөвшөөрнө. Чингэхдээ дотуур хувцас, оймс, гутлын хоёр дахь иж бүрдлийг зөвхөн эдгээр эд зүйлс огт байхгүй дайнд олзлогдогчдыг хангахаас бусад тохиолдолд хураан авч болохгүй.

*8 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд, ялангуяа олзлогч гүрнүүд хүн амын хоол хүнсний хангамжийг зохицуулах журмыг харгалзан, өөрсдийн нутаг дэвсгэр дээр дайнд олзлогдогчдод зориулагдсан тусламжийн хамтын илгээмжийн барааг худалдан авахыг бололцооныхоо хэрээр зөвшөөрч болно. Дээрх талууд болон гүрнүүд тусламжийн барааг худалдан авахад зориулсан мөнгөн санг шилжүүлэх, техникийн болон захиргааны шинжтэй санхүүгийн арга хэмжээг авахад туслалцаа үзүүлнэ.

*9 дүгээр зүйл*

Дээр дурдсан заалтууд нь дайнд олзлогдогчдын лагерьт ирэхээсээ өмнө буюу шилжин явахдаа тусламжийн хамтын илгээмж хүлээн авах эрхийг нь хөндөхгүй бөгөөд хамгаалагч гүрнүүд, Олон улсын улаан загалмайн хороо болон дайнд олзлогдогчдод тусламж үзүүлж буй, эдгээр илгээмжийг дамжуулан өгөх үүрэгтэй бусад ямар нэг байгууллагын төлөөлөгчдийн илгээмжийг боломжтой бусад аливаа арга замаар дайнд олзлогдогчдод хүргэж хуваарилах ажилд саад болох ёсгүй.

**IV ХАВСРАЛТ**

**A. ХУВИЙН ҮНЭМЛЭХ**

(4 дүгээр зүйлийг үз)

**Нүүрэн тал**

(Энэхүү хувийн үнэмлэхийг олгосон улс орон болон цэргийн эрх бүхий байгууллагын нэрийг бичнэ)

**ХУВИЙН ҮНЭМЛЭХ**

Зэвсэгт хүчнийг дагалдан яваа хүмүүст олгоно.

Эзэмшиг-  
чийн зураг

Овог.....  
Нэр.....  
Төрсөн газар болон он, сар, өдөр .....  
..... Зэвсэгт хүчнийг  
дагалдан яваа .....  
.....  
..... үүрэгт ажилтай

үнэмлэх олгосон  
он, сар, өдөр.....

Эзэмшигчийн гарын үсэг  
.....

Тайлбар: Үнэмлэхийг хоёр буюу гурван хэлээр үйлдэх бөгөөд эдгээрийн нэг нь олон улсын чанартай хэл байна. Цэглэсэн зураасаар нугалсан үнэмлэхний хэмжээ 13 x 10 см байна.

..... Нугалах зураас .....

**Ар тал**

Өндөр	Биеийн жин	Нүд	Үс
.....	.....	.....	.....
Өөр тэмд- гүүд	Хурууны хээ (заавал бус)	Цусны бүлэг .....	Үнэмлэх олгосон газрын тамга
		шашин .....	

-----  
Зүүн гарын долоовор хуруу

**АНХААРУУЛГА:**

Энэ үнэмлэхийг ..... зэвсэгт  
хүчнийг дагалдан яваа ..... үүрэгт  
ажилтай, тухайн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнд  
ордоггүй орон тооны бус хүмүүст олгоно.

-----  
Баруун гарын долоовор хуруу

Үнэмлэхийг үргэлж биедээ авч явна.  
Үүнийг үзүүлэгч олзлогдох тохиолдолд олзлогч талын  
захиргаанд үнэмлэхээ нэн даруй үзүүлж хэн  
болохоо тэмдэглүүлнэ.



**IV ХАВСРАЛТ**

**В. ОЛЗЛОГДСОН ТУХАЙ МАЯГТ**

(70 дугаар зүйлийг үз)

**Нүүрэн тал**

Дайнд олзлогдогчийн шуудан

Үнэ төлбөргүй

**ОЛЗЛОГДСОН ТУХАЙ МАЯГТ**

**АНХААРУУЛГА:**

Энэ маягтыг олзлогдогч бүр олзлогдсон даруйдаа эсхүл эмнэлэг болон өөр лагерьт шилжсэнээс хаяг өөрчлөгдөх бүрт яаралтай бөглөх ёстой.

Энэ маягт нь олзлогдогчид гэр бүлдээ явуулахад зориулагдсан тусгай маягтад үл хамаарна.

Дайнд олзлогдогчдын хэрэг эрхлэх төв агентлаг

Олон улсын улаан загалмайн хороо

Женев хот

Швейцарь улс

**Ар тал**

Татлахгүйгээр  
том үсгээр бич

1. Дайнд олзлогдогчийн харьяалах гүрэн  
.....

2. Овог  
.....

3. Нэр (бүтнээр)  
.....

4. Эцгийн нэр  
.....

5. Төрсөн он, сар өдөр .....  
7. Цол .....

6. Төрсөн газар.....

8. Хувийн дугаар.....

9. Гэр бүлийн хаяг .....

10. Олзлогдсон ..... буюу ..... дугаар лагерь, эмнэлгээс  
ирсэн.....

\* 11. (a) Эрүүл..... (b) Шархдаагүй ..... (c) Эдгэрсэн  
.....

(d) Эдгэрч буй..... (e) Өвчтэй.....(f) Хөнгөн шархадсан  
..... (g) Хүндээр шархадсан.....

12. Миний одоогийн хаяг: Олзлогдогчийн дугаар .....  
Лагерийн нэр.....

13. Он, сар, өдөр..... 14. Гарын үсэг.....

\* Хэрэггүйг дар. Илүү юм бүү нэм. Тайлбарыг үз.

Тайлбар: Энэхүү маягтыг хоёр буюу гурван хэлээр үйлдэх бөгөөд  
эдгээрийн нэг нь олзлогдогчийн төрөлх хэл, нөгөө нь  
олзлогч гүрний хэл байна.  
Хэмжээ 15 x 10.5 см.

**IV ХАВСРАЛТ**

**С. ШУУДАНГИЙН МАЯГТ БОЛОН ЗАХИДАЛ**

(71 дүгээр зүйлийг үз)

**I. Шуудангийн маягт**

**Нүүрэн тал**

Дайнд олзлогдогчийн  
захидал харилцаа

Үнэ төлбөргүй

Шуудангийн маягт

Хэнд.....

Илгээгчийн овог, нэр.....

Очих газар.....

Төрсөн газар, он, сар, өдөр.....

Гудамж.....

Дайнд олзлогдогчийн №.....

Улс.....

Лагерийн нэр..... Муж.....

Явуулсан улсын нэр .....

**Ар тал**

Лагерийн нэр

-----

он, сар, өдөр

Зөвхөн шугам дээгүүр тод бич

Тайлбар: Энэхүү маягтыг хоёр буюу гурван хэлээр үйлдэх бөгөөд  
эдгээрийн нэг нь олзлогдогчийн төрөлх хэл, нөгөө нь

**IV ХАВСРАЛТ**

**С. ШУУДАНГИЙН МАЯГТ БОЛОН ЗАХИДАЛ**

(71 дүгээр зүйлийг үз)

**II. Захидал**

**Нүүрэн тал**

Дайнд олзлогдогчийн  
захидал харилцаа

Үнэ төлбөргүй

Хэнд.....  
Очих газар.....  
Гудамж.....  
Улс.....  
Муж.....

---

Илгээгчийн  
Овог нэр .....  
Төрсөн он, сар, өдөр болон газар .....  
Дайнд олзлогдогчийн № .....  
Лагерийн нэр .....  
Явуулсан улсын нэр .....

Тайлбар: Энэхүү маягтыг хоёр буюу гурван хэлээр үйлдэх бөгөөд эдгээрийн нэг нь олзлогдогчийн төрөлх хэл, нөгөө нь олзлогч гүрний хэл байна. Энэхүү маягтыг цэглэсэн шугамаар нугалж дээд захыг тэмдэгт газар шургуулж дугтуй болгоно. Ард талыг шуудангийн маягтын (Хавсралт IV, С. I) ар талтай адил шугамдан олзлогдогчдын захидалд зориулна. Түүнд ойролцоогоор 250 үг багтана. Хэмжээ нь дэлгэсэн байдлаараа 29 х 15 см байна.

**IV ХАВСРАЛТ**

**D. НАС БАРСАН ТУХАЙ МАЯГТ**

(120 дугаар зүйлийг үз)

**Нүүрэн тал**

Холбогдох эрх бүхий байгууллагын нэр	Нас барсан тухай
Олзлогдогчийн харьяалах гүрэн	.....
Овог, нэр	.....
Эцгийн нэр	.....
Төрсөн газар, он, сар, өдөр	.....
Нас барсан газар, он, сар, өдөр	.....
Цол болон хувийн дугаар /таних тэмдэг дээр бичсэн/	.....
Гэр бүлийн хаяг	.....
Хэдийд, хаана олзлогдсон	.....
Нас барсан нөхцөл байдал, шалтгаан	.....
Оршуулсан газар	.....
Булшийг тэмдэглэсэн эсэх, дараа нь гэр бүлийн хүмүүс олж болох эсэх	.....
Олзлогч гүрэн талийгаачийн өв залгамжлуулах эд хогшлыг хадгалж буй эсэх буюу энэ маягтын хамт явуулсан эсэх	.....
Явуулсан бол хэнээр дамжуулсан	.....
Өвчтөнтэй буюу түүний амьд байх сүүлчийн цаг мөчид хамт байсан /эмч, сувилагч, шашны ажилтан, хамт олзлогдогч зэрэг/ оршуулсан тухай ямар нэг тодорхой зүйл мэдээлэх чадах эсэх	.....
/холбогдох эрх бүхий газрын тамга, гарын үсэг, он, сар, өдөр/	Гэрч хоёр хүний гарын үсэг болон хаяг

Тайлбар: Энэхүү маягтыг хоёр буюу гурван хэлээр үйлдэх бөгөөд эдгээрийн нэг нь олзлогдогчийн төлөлх хэл нөгөө нь олзлогч гүрний хэл байна. Маягтын

**IV ХАВСРАЛТ**

**Е. ЭХ ОРОНД НЬ БУЦААСАН ТУХАЙ ГЭРЧИЛГЭЭ**

*(II Хавсралт, 11 дүгээр зүйлийг үз)*

**ЭХ ОРОНД НЬ БУЦААСАН ТУХАЙ ГЭРЧИЛГЭЭ**

Он, сар, өдөр:

Лагерь:

Эмнэлэг:

Овог нэр:

Эцгийн болон өөрийн нэр:

Төрсөн он, сар, өдөр:

Цол:

Хувийн дугаар:

Дайнд олзлогдогчийн дугаар:

Шарх, өвчин:

Комиссын шийдвэр:

Эмнэлгийн хамтарсан  
комиссын дарга

А – Эх оронд нь шууд буцаах,

В – Төвийг сахисан оронд эмчлүүлэхээр шилжүүлэх,

НС – Хоёр дахь удаа гэрчилсэн тохиолдол

**V ХАВСРАЛТ**

**ДАЙНД ОЛЗЛОГДОГЧООС ӨӨРИЙН ОРОНД  
МӨНГӨ ГҮЙВУУЛАХ ҮЛГЭРЧИЛСЭН ЖУРАМ**

*(63 дугаар зүйлийг үз)*

(1) 63 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан мэдэгдэл нь дараахь зүйлийг агуулна:

- (a) төлбөр хийж буй дайнд олзлогдогчийн 17 дугаар зүйлд дурдсан дугаар, овог, нэр, цол хэргэм;
- (b) өөрийн нь улсад илгээмж хүлээн авах хүний овог, нэр болон хаяг;
- (c) дайнд олзлогдогчийн байрлаж байгаа орны валютаар хэмжигдэх гуйвуулж буй мөнгөний тоо, хэмжээ.

(2) Мэдэгдэлд дайнд олзлогдогч өөрөө гарын үсэг зурах буюу хэрэв өөрөө зурж чадахгүй бол өөрийнхөө тэмдгийг дараад, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр гэрчлүүлнэ.

(3) Дайнд олзлогдогчийн нэрийн дансанд байгаа мөнгө нь хийж буй төлбөрийн хэмжээнээс багагүй болохыг баталсан гэрчилгээг лагерийн захирагч үйлдэж уг мэдэгдэлд хавсаргана.

(4) Уг мэдэгдлийг жагсаалт маягаар үйлдэж болно. Тийм жагсаалтын хуудас бүрийг итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрчилэн, лагерийн захирагч батламжилна.

## **91. ДАЙНЫ ҮЕД ЭНГИЙН ИРГЭДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ЖЕНЕВИЙН (IV) КОНВЕНЦ**

*1949 оны 8 дугаар сарын 12-ны өдөр баталж,  
1950 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болсон\**

### Удиртгал

Дайны үед энгийн хүн амыг хамгаалах тухай конвенцийг байгуулах зорилгоор 1949 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс 8 дугаар сарын 12-ны өдөр хүртэл Женев хотноо болсон Дипломат бага хуралд засгийн газраа төлөөлж дор гарын үсэг зурсан бүрэн эрхт төлөөлөгчид дараахь зүйлийг хэлэлцэн тохиров:

### **I АНГИ**

#### **НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

##### *1 дүгээр зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийг бүх нөхцөл байдалд хүндэтгэн сахих буюу хүндэтгэн сахих явдлыг хангах үүрэг хүлээнэ.

##### *2 дугаар зүйл*

Тайван цагт хэрэгжүүлэх заалтын сацуу хоёр буюу хэд хэдэн хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын хооронд үүсч болох зарласан дайн буюу аливаа бусад зэвсэгт мөргөлдөөний бүх тохиолдолд тэдгээр талын аль нэг нь дайны байдлыг хүлээн зөвшөөрөөгүй байсан ч энэхүү конвенцийг хэрэглэнэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын нутаг дэвсгэрийг хэсэгчлэн буюу бүхэлд нь эзэлсэн бүх тохиолдолд тухайн эзлэлт нь зэвсэгт эсэргүүцэлтэй тулгараагүй байсан ч энэхүү конвенцийг мөн хэрэглэнэ.

Хэдийгээр зэвсэгт мөргөлдөөнд оролцогч гүрнийн аль нэг нь энэхүү конвенцид оролцогч тал биш байсан ч түүнд оролцогч тал болох гүрэн өөр хоорондын харилцаандаа энэхүү конвенцийг заавал биелүүлэх үүрэгтэй хэвээр байна. Үүнээс гадна хэрэв дээр дурдсан гүрэн энэхүү конвенцийн заалтыг хүлээн авч хэрэглэвэл түүний хувьд тэд энэхүү конвенцийг заавал биелүүлэх үүрэгтэй байна.

---

\* Монгол Улс 1958.11.05-нд нэгдэн орсон



### 3 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нэгний нь нутаг дэвсгэрт үүсэх олон улсын бус шинж чанартай зэвсэгт мөргөлдөөний тохиолдолд тухайн мөргөлдөөнд оролцогч тал бүр наад зах нь дараахь заалтыг хэрэглэх үүрэг хүлээнэ:

3) Дайтах ажиллагаанд шууд оролцоогүй этгээд, түүний дотор байлдахаа зогсоосон болон өвчлөх, шархдах, саатуулагдах буюу аливаа бусад шалтгааны улмаас байлдаанд оролцоогүй зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний этгээдтэй арьс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэг, хүйс, гарал үүсэл, эд хөрөнгийн байдал буюу бусад төсөөтэй шалгуурт үндэслэн ялгаварлан гадуурхалгүйгээр бүх нөхцөл байдалд хүнлэг харьцана.

Энэ үүднээс дараахь үйлдлийг дээр дурдсан этгээдийн хувьд хийхийг хэзээ ч, хаана ч хориглоно:

(a) амь нас, бие махбодид халдах, тухайлбал, бүхий л хэлбэрээр амийг нь хөнөөх, хүнд гэмтэл учруулах, харгис хэрцгийгээр харьцах, эрүүдэн шүүх;

(b) барьцаанд авах;

(c) хүний нэр төр, алдар хүндэд халдах, тухайлбал, доромжлон гутаах;

(d) соёл иргэншилт ард түмний зайлшгүй гэж хүлээн зөвшөөрсөн шүүхийн бүх баталгаагаар хангаж байнгын ажиллагаатай шүүхээс урьдчилан гаргасан шийдвэргүйгээр ял шийтгэх болон ял эдлүүлэх.

4) Шархтан болон өвчтөнийг олж тусламж үзүүлнэ. Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хараат бус хүмүүнлэгийн байгууллага мөргөлдөөнд оролцогч талд өөрийн үйлчилгээг санал болгож болно.

Мөргөлдөөнд оролцогч талууд тусгай хэлэлцээрийн замаар энэхүү конвенцийн бусад заалтыг бүгдийг буюу хэсэгчлэн хүчин төгөлдөр болгохыг цаашид чармайна.

Өмнөх заалтуудыг хэрэглэх нь мөргөлдөөнд оролцогч талуудын эрх зүйн байдлыг хөндөхгүй.

### 4 дүгээр зүйл

Мөргөлдөөнд оролцогч талуудын мөргөлдөөн буюу эзлэх үед тэдний эрхшээлд орсон, түүнчлэн эзлэгч гүрний эрхшээлд орсон бөгөөд эзлэгч гүрний харьяат бус иргэдийг энэхүү конвенцоор ямар ч үед, ямар ч нөхцөл байдалд хамгаална.

Конвенцид холбогдолгүй аливаа улсын иргэнийг энэхүү конвенцоор хамгаалахгүй. Мөргөлдөөнд оролцогч улсын нутаг дэвсгэрт төвийг сахисан улсын иргэд болон дайнд оролцогч аль нэг улсын иргэдийг харьяалах улс нь нөгөө улсад дипломат төлөөлөгчийн газраа хэвээр байлгаж байгаа цагт хамгаалагдсан хүмүүсийн тоонд хамааруулахгүй.

Гэвч II хэсгийн заалтыг 13 дугаар зүйлд зааснаас өргөн утгаар хэрэглэнэ.

Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенц, Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгдөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенц мөн Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцоор хамгаалагдсан хүмүүсийг энэхүү конвенцоор хамгаалагдсан хүн гэж үзэхгүй.

#### *5 дугаар зүйл*

Энэхүү конвенцоор хамгаалагдсан хүмүүс мөргөлдөөнд оролцогч талын нутаг дэвсгэр дээр тухайн улсын аюулгүй байдалд дайсагнасан үйл ажиллагаа явуулсан гэж сэжиглэх хууль ёсны үндэслэл байгаа, эсхүл үйлдэсэн нь тогтоогдсон бол тухайн улсын аюулгүй байдалд хохирол учруулсан гэж үзэн уг хүнд энэхүү конвенцоор олгогдсон эрх болон эрх ямбыг эдлүүлэхгүй.

Хамгаалагдсан хүмүүс эзлэгдсэн нутаг дэвсгэр дээр тагнуулын буюу хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан, эсхүл эзлэгч гүрний аюулгүй байдалд заналхийлсэн гэсэн хууль ёсны үндэслэл байгаа гэж сэжиглэгдэж байгаа буюу цэргийн аюулгүй байдал гарцаагүй шаардсан гэж уг хүнийг үзэж байгаа бол энэхүү конвенцоор олгогдсон холбоо барих эрхийг эдлэх эрхгүй.

Өмнөх хэсэгт дурдсан хүмүүст хүмүүнлэгээр хандаж, шүүн таслах ажиллагаа явуулах тохиолдолд энэхүү конвенцид заасан шударга, хэвийн шүүхээр шийдвэрлүүлэх эрхийг нь хязгаарлаж болохгүй. Эдгээр хүнд улсын аюулгүй байдал буюу эзлэгч гүрний зохих нөхцөл байдалд нийцүүлэн аль болох богино хугацаанд энэхүү конвенцийн дагуу хамгаалагдсан хүмүүст олгох эрх, эрх ямбыг бүрэн хэмжээгээр эдлүүлнэ.

#### *6 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг 2 дугаар зүйлд заасан аливаа мөргөлдөөн буюу эзлэн авах үед хэрэглэнэ.

Мөргөлдөөнд оролцогч талуудын нутаг дэвсгэр дээр байлдааны ажиллагаа бүрэн зогсоосны дараа энэхүү конвенцийг дагаж мөрдөхгүй.

Энэхүү конвенцийг эзлэгдсэн нутаг дэвсгэрт цэргийн ажиллагаа бүрэн зогссон цагаас хойш нэг жилийн дараа дагаж мөрдөхгүй хэдий ч энэ нутаг дэвсгэр дээр засгийн газрын үүргийг гүйцэтгэж байгаа эзлэгч гүрний ажиллагаа нь энэхүү конвенцийн 1-12, 27, 29-34, 47, 49, 51, 52, 53, 59, 61-77 дугаар зүйл болон 143 дугаар зүйлтэй эзлэгдсэн хугацаатай холбоотой байна.

Хамгаалагдсан хүмүүсийг чөлөөлөх, эх оронд нь буцаах буюу нөхөн сэргээх хүртэл энэхүү конвенцийн хамгаалалтад байлгана.

#### *7 дугаар зүйл*

Энэхүү конвенцийн 11, 14, 15, 17, 36, 108, 109, 132, 133 болон 149 дугаар зүйлд шууд заасан хэлэлцээрийн сацуу хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тусгай заалтаар

зохицуулах нь тохиромжтой гэж үзэж болох бүх асуудлаар өөр тусгай хэлэлцээр байгуулж болно. Тусгай хэлэлцээр нь энэхүү конвенцид тодорхойлсон хамгаалагдсан хүмүүсийг байдалд сөргөөр нөлөөлөхгүй буюу тэдэнд олгосон эрхийг хязгаарлахгүй.

Дээр дурдсан хэлэлцээр, эсхүл дараа дараагийн хэлэлцээрт эсрэгээр шууд зааснаас бусад тохиолдолд, эсхүл мөргөлдөөнд оролцогч талуудын хамгаалагдсан хүмүүсийн хувьд илүү тааламжтай арга хэмжээ авснаас бусад тохиолдолд тэдгээр хэлэлцээрээр олгогдсон давуу байдлыг энэхүү конвенцийг тэдний хувьд хэрэглэх хугацаанд үргэлжлүүлэн эдэлнэ.

#### *8 дугаар зүйл*

Хамгаалагдсан хүмүүс нь энэхүү конвенц болон хэрэв өмнөх зүйлд дурдсан тусгай хэлэлцээр байгаа бол түүгээр хангагдсан эрхээсээ ямар ч нөхцөл байдалд хэсэгчлэн буюу бүрэн татгалзаж болохгүй.

#### *9 дүгээр зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий хамгаалагч гүрний дэмжлэг, хяналтын дор энэхүү конвенцийг хэрэглэнэ. Эл зорилгоор хамгаалагч гүрэн өөрийн дипломат болон консулын ажилтнаас тусдаа өөрийн орны, эсхүл төвийг сахисан бусад гүрний харьяатаас бүрдсэн төлөөлөгчдийг томилж болно. Дурдсан төлөөлөгчдийг томилохдоо тэдний очиж ажиллах гүрний зөвшөөрлийг авна.

Мөргөлдөөнд оролцогч талууд хамгаалагч гүрний төлөөлөгчдийн ажлыг боломжтой дээд хэмжээнд хөнгөвчлөн дэмжинэ.

Хамгаалагч гүрний төлөөлөгчид ажлаа явуулахдаа ямар ч тохиолдолд энэхүү конвенцийн дагуу хүлээсэн зорилгот үүргээсээ хэтэрч болохгүй. Ялангуяа тэд нутаг дэвсгэрт нь үүргээ биелүүлж байгаа улсын аюулгүй байдлын зайлшгүй шаардлагыг харгалзан үзнэ.

#### *10 дугаар зүйл*

Энэхүү конвенцийн заалт нь Олон улсын улаан загалмайн хороо буюу аливаа хүмүүнлэгийн хараат бус бусад байгууллагаас энгийн хүн амыг хамгаалж, тэдэнд тусламж үзүүлэх талаар тухайн мөргөлдөөнд оролцогч талуудын зөвшөөрөлтэйгөөр явуулах хүмүүнлэгийн үйл ажиллагаанд саад болохгүй.

#### *11 дүгээр зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн дагуу хамгаалагч гүрэнд хүлээлгэсэн үүргийг хараат бус бөгөөд үр ашигтай байх бүх баталгааг гаргаж буй байгууллагад олгохоор хэдийд ч тохиролцож болно.

Энэхүү конвенцоор хамгаалагдсан хүмүүс аль нэг хамгаалагч гүрэн буюу дээрх эхний хэсэгт заасан байгууллагын үйл ажиллагаанаас ямар нэгэн шалтгааны улмаас ашиг тус хүртэхгүй, эсхүл хүртэхээ болих тохиолдолд олзлогч гүрэн мөргөлдөөнд

оролцогч талуудын томилсон хамгаалагч улсын энэхүү конвенцийн дагуу биелүүлж буй чиг үүргийг хүлээхийг төвийг сахисан улс, эсхүл тийм байгууллагаас хүснэ.

Хэрэв хамгаалалтыг ийнхүү хэрэгжүүлж чадахгүй бол олзлогч гүрэн нь хамгаалагч гүрний энэхүү конвенцийн дагуу биелүүлж буй хүмүүнлэгийн чиг үүргийг өөртөө хүлээх талаар Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хүмүүнлэгийн байгууллагаас санал болгохыг хүсэх буюу ийм саналыг энэ зүйлийн заалтыг мөрдөхийн хамт хүлээн авна.

Төвийг сахисан аливаа гүрэн, эсхүл холбогдох гүрний урьсан буюу эл зорилгоор өөрийгөө санал болгож буй байгууллага энэхүү конвенцоор хамгаалагдсан хүмүүсийг харьяалж буй мөргөлдөөнд оролцогч талтай хариуцлагаа ухамсарлан үйл ажиллагаа явуулах шаардлагатай бөгөөд, түүнчлэн зохих чиг үүрэг хүлээж, уг чиг үүргээ хараат бусаар биелүүлэх чадвартай гэсэн хангалттай баталгаа гаргах шаардлагатай.

Аль нэг гүрэн дайны үйл ажиллагаанаас шалтгаалан, ялангуяа түүний нутаг дэвсгэр бүхэлдээ, эсхүл түүний үлэмж хэсэг нь эзлэгдсэн тохиолдолд нөгөө гүрэн буюу түүний холбоотонтой хэлэлцээ хийх эрх чөлөө нь түр хугацаагаар ч гэсэн хязгаарлагдсан бол тэдгээрийн хооронд байгуулсан тусгай хэлэлцээрээр өмнөх заалтуудыг зөрчихгүй.

Энэхүү конвенцид хамгаалагч гүрэн гэж дурдах бүрд энэ нэр томъёог энэ зүйлийн дагуу түүнийг орлох байгууллагад ч мөн хэрэглэнэ.

Энэ зүйлийн заалт нь эзлэгдсэн буюу мөргөлдөж буй улсын нутаг дэвсгэр дээр байгаа дипломат хэвийн харилцаагүй төвийг сахигч улсын иргэдэд нэгэн адил хамаарна.

### *12 дугаар зүйл*

Хамгаалагч гүрэн хамгаалагдсан хүмүүсийн ашиг сонирхолд хэрэгтэй гэж үзсэн тохиолдолд, ялангуяа энэхүү конвенцийн заалтыг хэрэглэх буюу тайлбарлах талаар мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд санал зөрөлдсөн тохиолдолд саналын зөрөлдөөнийг зохицуулах үүднээс асуудалд оролцоно.

Эл зорилгоор хамгаалагч гүрэн бүр аль нэг талын урилгаар буюу өөрийн санаачилгаар өөрсдийн төлөөлөгчдийн, ялангуяа хамгаалагдсан хүмүүсийн хариуцаж буй эрх бүхий байгууллагын уулзалтыг зохион явуулах саналыг мөргөлдөөнд оролцогч талуудад тавьж болох бөгөөд чингэхдээ тохиромжтой гэж сонгож авсан төвийг сахигч нутагт дэвсгэрт боломжтой бол зохион байгуулна. Мөргөлдөөнд оролцогч талууд эл зорилгоор тэдэнд тавьсан саналыг хүчин төгөлдөр хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. Шаардлагатай бол хамгаалагч гүрэн ийм уулзалтад оролцохыг урих төвийг сахисан гүрэнд харьяалагдах, эсхүл Олон улсын улаан загалмайн хорооноос томилсон этгээдийг мөргөлдөөнд оролцогч талуудаар дэмжүүлэн батлуулахаар санал болгож болно.

## II АНГИ

### ХҮН АМЫГ ДАЙНЫ ЗАРИМ УРШГААС ХАМГААЛАХ НИЙТЛЭГ ЗААЛТУУД

#### 13 дугаар зүйл

Энэхүү ангийн заалтууд нь мөргөлдөөнд оролцогч талуудаас нийт хүн амыг арьсны өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг буюу улс төрийн итгэл үнэмшлийн шалтгаанаар алагчилахгүйгээр дайны уршгаар үүссэн зовлонг хөнгөлөхөд тус дөхөм үзүүлэхэд чиглэнэ.

#### 14 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тайван цагт буюу дайтах ажиллагаа эхэлсний дараа түүнд оролцогч талууд өөрийнхөө нутаг дэвсгэрт, түүнчлэн зайлшгүй шаардлагатай тохиолдолд эзлэгдсэн нутаг дэвсгэрт шархдагсад, өвчтөн, тахир дутуу бологсод, өндөр настай буюу арван тав хүртэлх настай хүүхэд, жирэмсэн эмэгтэй болон долоо хүртэлх настай хүүхэдтэй эхчүүдийг дайны ажиллагаанаас хамгаалахын тулд эмнэлгийн болон аюулгүйн бүс болон газрыг байгуулж болно.

Дайтах ажиллагаа эхлэх буюу түүний явцад холбогдох талууд байгуулсан бүс, газрыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай хэлэлцээр байгуулж болно. Эл зорилгын үүднээс талууд шаардлагатай гэж үзвэл энэхүү конвенцид хавсаргасан хэлэлцээрийн төслийг хэрэглэж зохих өөрчлөлт оруулж болно.

Эмнэлгийн болон аюулгүйн ажиллагааны эдгээр бүс, газрыг хүлээн зөвшөөрч байгуулахад нь сайн санааны үүднээс туслалцаа үзүүлэхийг хамгаалагч гүрэн болон Олон улсын улаан загалмайн хорооноос уриалж байна.

#### 15 дугаар зүйл

Мөргөлдөөнд оролцогч нэг талаас шууд буюу төвийг сахигч гүрнээр, эсхүл хүмүүнлэгийн байгууллагаар дамжуулан дайн болж байгаа бүсэд байлдааны аюулаас дор дурдсан хүмүүсийг гадуурхахгүйгээр хамгаалахын тулд төвийг сахисан бүс байгуулах саналыг мөргөлдөөнд оролцогч нөгөө талд тавьж болно:

- (a) шархтан болон өвчтэй байлдагч болон байлдагч бус;
- (b) байлдаанд оролцоогүй буюу эдгээр бүсэд байх үед цэргийн шинжтэй ажил эрхлээгүй энгийн иргэд.

Төвийг сахисан бүс байгуулах газар, удирдлага, хангамж болон тавих хяналтын талаар дайтагч талууд тохиролцмогц бичгээр хэлэлцээр байгуулж, дайтагч талуудын төлөөлөгчид гарын үсэг зурна. Хэлэлцээр төвийг сахисан бүсийг хэдийгээс эхлэн ямар хугацаагаар байгуулахыг тогтооно.

*16 дугаар зүйл*

Шархтан, өвчтөн, мөн түүнчлэн тахир дутуу хүмүүс, жирэмсэн эмэгтэйчүүд онцгой хамгаалалт болон хүндэтгэлд байна.

Мөргөлдөөнд оролцогч талууд цэргийн шаардлагад нийцүүлэн алагдсан, шархадсан хүмүүсийг эрэн сурвалжлахыг хөнгөвчлөх, хөлөг онгоцны сүйрэлд өртсөн болон бусад ноцтой аюулд нэрвэгдсэн хүмүүст туслах, тэднийг дээрэм болон зүй бусаар харьцахаас хамгаална.

*17 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч тал нь хориглогдсон буюу бүслэгдсэн бүсээс шархтан, өвчтөн, тахир дутуу бологсод, өндөр настан, хүүхэд, төрөх дөхсөн эхчүүдийг нүүлгэх болон уг бүсэд бүх төрлийн шашны төлөөлөгч, эмнэлгийн ажилтан, эмнэлгийн багаж хэрэгсэл нэвтрүүлэх талаар орон нутгийн хэлэлцээр байгуулахыг чармайна.

*18 дугаар зүйл*

Өвчтөн, шархдагсад, тахир дутуу хүмүүс, төрөх дөхсөн эхчүүдэд тусламж үзүүлэхээр байгуулсан иргэний эмнэлгийг ямар ч үед довтолж болохгүй бөгөөд мөргөлдөөнд оролцогч талууд тэдгээрийг цаг ямагт хүндэтгэн хамгаална.

Мөргөлдөөнд оролцож буй улс иргэний эмнэлэг бүрт иргэний эмнэлэг гэсэн гэрчилгээ олгох бөгөөд эзлэн авсан барилга нь 19 дүгээр зүйлд заасны дагуу эдгээр эмнэлгийг хамгаалалтаас салгах аливаа зорилгоор ашиглахгүй.

Иргэний эмнэлэгт улсын зөвшөөрөлтэйгээр Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн конвенцийн 38 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдэг олгоно.

Мөргөлдөөнд оролцогч тал гэнэтийн довтолгооноос сэргийлэх зорилгоор цэргийн шаардлагад нийцүүлэн иргэний эмнэлгийг дайсны дайсагнасан аливаа үйлдлээс зайлах үүднээс тэднийг хуурай зам, агаарын болон тэнгисийн цэргийн хүчинд тод харагдах ялгах тэмдгээр хангах талаар шаардлагатай арга хэмжээ авна.

Цэрэг дайны газарт ойролцоо байгаа эмнэлэг аюулд орж болохыг харгалзан тийм эмнэлгийг цэргийн дайны газраас аль болох хол байгуулахыг зөвлөмж болгоно.

*19 дүгээр зүйл*

Иргэний эмнэлэгт үзүүлэх хамгаалалт хүмүүнлэгийн зорилгоос гадуур дайсагнагч талын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанд ашиглах хүртэл хүчинтэй байна. Гэвч тогтоосон боломжит хугацаанд үр дүн өгөөгүй бол хамгаалалтыг холбогдох бүх тохиолдолд урьдчилан сануулсны дараагаар хүчингүй болгоно.

Шархтай болон өвчтэй цэргийн хүмүүсийг дээрх эмнэлэгт эмчлэх буюу тэднээс хурааж аваад зохих байгууллагад шилжүүлээгүй байгаа зэвсэг хэрэгслийг дайсны эсрэг чиглэсэн гэж үзэхгүй.

*20 дугаар зүйл*

Шархтай, өвчтэй энгийн хүмүүс, тахир дутуу бологсад болон төрөх дөхсөн эхчүүдийг эрэн сурвалжлах, ялгах, тээвэрлэх, эмчлэх ажилд оролцож байгаа иргэний эмнэлгийн асран сувилах байнгын буюу захиргааны ажилтай хүмүүсийг хүндэтгэн хамгаалалтад авна.

Дээр дурдсан хүмүүс эзлэгдсэн нутаг дэвсгэр, байлдааны ажиллагааны бүсэд байхдаа хариуцаж буй байгууллагын тод тамга, гэрэл зураг бүхий албан үүргийг тодорхойлсон үнэмлэхээр танигдах бөгөөд үүргээ гүйцэтгэхдээ ус нэвтэрдэггүй туузан тэмдгийг зүүн гартаа уяж явна. Энэ тэмдгийг улсаас олгох бөгөөд Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн конвенцийн 38 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдэгтэй байна.

Иргэний эмнэлгийн захиргаа болон үйл ажиллагаанд оролцож байгаа бусад хүмүүс хүндэтгүүлэх, хамгаалалтад байх бөгөөд энэхүү зүйлийн дагуу туузан тэмдгийг ийм үүрэг гүйцэтгэж байхдаа зүүнэ. Тэдгээр хүмүүсийн үнэмлэх дээр гүйцэтгэж буй үүргийн заасан байна.

Иргэний эмнэлэг бүрийн захиргаа нь эдгээр хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хөтлөж байнга шинэчлэн үндэсний буюу эзлэгч гүрэнд өгнө.

*21 дүгээр зүйл*

Шархтай, өвчтэй, энгийн хүмүүс, тахир дутуу хүмүүс, төрөх дөхсөн эхчүүдийг хуурай замд хөсгөөр тээх, эмнэлгийн галт тэргээр зөөх буюу далайгаар тээвэрлэх нь 18 дугаар зүйлд заасан эмнэлгийн нэгэн адил хүндэтгэл хамгаалалтад байх бөгөөд тээврийн хэрэгслийг тухайн улсын зөвшөөрлөөр Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн конвенцийн 38 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдгээр тэмдэглэсэн байна.

*22 дугаар зүйл*

Шархтай, өвчтэй энгийн хүмүүс, тахир дутуу хүмүүс, төрөх дөхсөн эхчүүд буюу эмнэлгийн ажилтан болон тоног төхөөрөмжийг зөөхөд зориулагдсан агаарын хөлгийг довтлож болохгүй бөгөөд мөргөлдөөнд оролцож буй сонирхогч талуудын хооронд байгуулсан хэлэлцээрт тусгайлан заасан чиглэл, тогтсон өндөрт, цагаар нисч байвал түүнийг хүндэтгэн үзнэ.

Эдгээр агаарын хөлөг нь Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн конвенцийн 38 дугаар зүйлд заасан бэлгэ тэмдгээр тэмдэглэгдсэн байж болно.

Өөрөөр хэлэлцэн тохиролцоогүй тохиолдолд дайсны талын буюу дайсны эзэлсэн нутаг дэвсгэр дээр нисэхийг хориглоно.

Эдгээр агаарын хөлөг газардах аливаа шаардлагад захирагдана. Шаардлагын дагуу газардсан агаарын хөлөгт зохих үзлэг хийсний дараа зорчигчдын хамт нислэгээ үргэлжлүүлнэ.

### 23 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх тал өөрийн дайсан ч байсан хэлэлцэн тохирогч эрхэм дээд нөгөө талын зөвхөн энгийн хүмүүст зориулагдсан эмчилгээ болон эмнэлгийн бүх эд зүйл, шашны ёс үйлтэй холбоотой зүйлийг чөлөөтэй нэвтрүүлнэ. Түүнчлэн арван тав хүртэлх настай хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд болон төрөх дөхсөх эхчүүдэд зориулсан хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүн, хувцас болон хүч оруулагч зүйл бүхий илгээмжийг чөлөөтэй нэвтрүүлнэ.

Дээрх хэсэгт заасан бүх илгээмжийг чөлөөтэй нэвтрүүлэхээр хэлэлцэн тохирогч эрхэм дээд талын авсан үүрэг нь тухайн тал болгоомжлох ноцтой шалтгаан байхгүй гэж гэрчилсэн нөхцөлөөс шалтгаална:

- (a) илгээмж өөрийн хүрэх газраа хүрч чадахгүй;
- (b) хяналт үр нөлөөгүй байж болох;
- (c) эдгээр нь дайсан этгээдийн үйлдвэрлэсэн буюу бэлтгэн нийлүүлсэн эд зүйл буюу эдгээр эд зүйлийг үйлдвэрлэхэд хэрэгцээтэй түүхий эд, эд зүйл, ажиллах хүчийг гаргах замаар дайсны цэргийн буюу эдийн засгийн хүч чадалд ямар нэг талаар нөлөөлнө гэж үзэх үндэстэй бол хамаарна.

Энэ зүйлийн эхний хэсэгт зааснаар илгээмжийг нэвтрүүлэхийг зөвшөөрсөн гүрэн нь илгээмжийг хамгаалагч гүрний орон нутгийн хяналтын дор зохих хүмүүст тарааж өгөх болзол тавьж болно.

Эдгээр илгээмжийг аль болох түргэн хугацаанд хүргэх бөгөөд түүнийг чөлөөтэй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн гүрэн зөвшөөрөл олгох техникийн нөхцөлийг тогтоох эрхтэй.

### 24 дүгээр зүйл

Мөргөлдөөнд оролцогч талууд нь дайны уршгаар өнчирсөн буюу гэр бүлээсээ тусгаарлагдсан арван таван нас хүртэлх хүүхдийг гаргуунд нь хаяхгүй байх, ямар ч нөхцөлд тэднийг дэмжиж, шашны болон боловсролын үүргийг гүйцэтгүүлэх арга хэмжээг авна. Боломжтой бол тэдний боловсролыг адил соёлын уламжлалтай хүнд даатгана.

Мөргөлдөөнд оролцогч талууд дайн болж байх хугацаанд тэдгээр хүүхдийг хамгаалагч гүрний зөвшөөрөлтэйгээр 1 дэх догол мөрөнд дурдсан хамгаалах зарчмыг сахих баталгаагаар төвийг сахисан улс хүлээн авахад дэмжлэг үзүүлнэ.

Түүнчлэн арван хоёр нас хүртэлх хүүхдүүдэд таних тэмдэг зүүлгэх буюу өөр ямар нэг аргаар таниулах арга хэмжээ авахыг эрмэлзэнэ.



*25 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талын нутаг дэвсгэрт буюу түүнд эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа хүн бүр хаана ч байсан гэр бүлийн гишүүндээ мэдээлэл өгөх, түүнчлэн тэднээс зөвхөн гэр бүлийн чанартай мэдээлэл авч болно. Эдгээр захидлыг түргэн буюу саадгүйгээр явуулна.

Хэрэв тухайн нөхцөл байдлаас болж гэр бүлийн захидал харилцаа энгийн шуудангаар явах нь саатах буюу боломжгүйд хүрвэл мөргөлдөөнд оролцож байгаа холбогдох талууд 140 дүгээр зүйлд зааснаар төвийг сахисан зуучлагч Төв агентлагт хандаж, өөрийн үүргийг ямар нөхцөлд илүү биелүүлэх арга замыг олж Үндэсний улаан загалмайн (Улаан хавирган сар, Улаан арслан болон нар) нийгэмлэгийн туслалцаатайгаар захидал харилцааг түргэтгэх арга эрэлхийлнэ.

Хэрэв мөргөлдөөнд оролцогч талууд гэр бүлийн захидал харилцааг хязгаарлах нь зүйтэй гэж үзвэл хорин таван сонгосон үг багтах хэмжээтэй цаасыг ашиглуулж, захидал бичүүлэн сард нэг удаа явуулж байна.

*26 дугаар зүйл*

Мөргөлдөөнд оролцогч тал бүр дайны уршгаар сарнисан гэр бүлтэйгээ холбоо тогтоолгох зорилгоор хайхад хөнгөвчлөх, хэрэв боломжтой бол тэднийг нийлүүлэхэд тус дөхөм үзүүлнэ. Энэхүү үйл хэрэгт ажил үйлсээ зориулж байгаа болон тэр гүрний хувьд хүлээн зөвшөөрсөн, түүний аюулгүй байдалд нийцсэн байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.

**III АНГИ**

**ХАМГААЛАГДСАН ХҮМҮҮСИЙН ЭРХ ЗҮЙН  
БАЙДАЛ, ТЭДЭНТЭЙ ХАРЬЦАХ**

**I ХЭСЭГ**

**МӨРГӨЛДӨӨНД ОРОЛЦОГЧ ТАЛУУД БОЛОН ЭЗЛЭГДСЭН НУТАГ  
ДЭВСГЭРТ ХАМААРАГДАХ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

*27 дугаар зүйл*

Хамгаалагдсан хүмүүс өөрсдийн амь нас, эрүүл мэнд, нэр төр, гэр бүлийн эрх, шашин шүтлэгийн итгэл үнэмшил болон дадал, өөрсдийн уламжлалт ёс, зан заншлыг ямар ч нөхцөл байдалд хүндэтгүүлэх эрхтэй. Хамгаалагдсан хүмүүстэй үргэлж хүнлэг ёсоор харьцаж, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, доромжлох, олны тохуу болгох бүх хэлбэрээс тэднийг хамгаална.

Эмэгтэйчүүдийн нэр төрд халдах, ялангуяа хүчиндэх, хүчээр биеийг нь үнэлүүлэх буюу бусад хэлбэрийн зүй бус халдлагаас тэднийг онцгойлон хамгаална.

Хамгаалагдсан хүмүүсийн эрүүл мэндийн байдал, нас, хүйсийн байдалд гэм хор учруулалгүйгээр тэднийг эрхэндээ байлгагч мөргөлдөөнд оролцогч тал тэдэнтэй арьсны өнгө, шашин шүтлэг буюу улс төрийн үзэл бодлоор ялгаварлан гадуурхалгүйгээр нэгэн адил харьцана.

Гэхдээ мөргөлдөөнд оролцогч талууд дайны нөхцөл байдлын дагуу хамгаалагдсан хүмүүсийг шаардлагатай бол хяналтад авах буюу аюулгүй байдлыг нь хангах арга хэмжээ авч болно.

*28 дугаар зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийн байрлаж байгаа тодорхой газар буюу нутгийг цэрэг, дайны ажиллагаанаас хамгаалах газар болгон ашиглаж үл болно.

*29 дүгээр зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийг эрх мэдэлдээ байлгаж буй мөргөлдөөнд оролцогч тал өөрийн төлөөлөгчдийн зүгээс хамгаалагдсан хүмүүстэй харьцсанаас үүсэх хариуцлагыг хүлээх бөгөөд харин энэ нь тухайн төлөөлөгчийг хувийн хариуцлага хүлээх явдлаас үл чөлөөлнө.

*30 дугаар зүйл*

Хамгаалагдсан хүмүүст хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо, тэдгээр хүмүүсийн оршин суугаа орны Үндэсний улаан загалмайн (Улаан хавирган сар, улаан арслан болон нар) нийгэмлэг, түүнчлэн тэдэнд тусламж үзүүлж болох аливаа байгууллагад харилцах бүхий л бололцоог олгоно.

Эрх бүхий этгээдээс эдгээр байгууллагад эл зорилгыг биелүүлэхэд нь цэрэг дайны буюу аюулгүй байдлын үүднээс тогтоосон зарим хязгаарлалтын хүрээнд бүхий л бололцоог олгож байна.

Энэхүү конвенцийн 143 дугаар зүйлд заасны дагуу хамгаалагч гүрнүүд болон Олон улсын улаан загалмайн хорооны төлөөлөгчдийг очуулахаас гадна олзлогч, эсхүл эзлэгч гүрнүүд дээрхи хүмүүст сэтгэл санааны болон эд материалын тусламж үзүүлэх зорилго бүхий бусад байгууллагын төлөөлөгчдийг хамгаалагдсан хүмүүстэй очиж уулзах бололцоог аль болох бүрдүүлнэ.

*31 дүгээр зүйл*

Хамгаалагдсан хүмүүс тэднийг эрхэндээ байлгагч талаас, эсхүл гуравдагч этгээдээс мэдээлэл олж авахад тэдэнд бие махбодийн буюу ёс суртахууны албадлагын аргыг хэрэглэж болохгүй.

*32 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд эрх мэдэлдээ байгаа хамгаалагдсан хүмүүсийн бие махбодид хохирол учруулах буюу тэдний амийг хөнөөхөд хүргэх аливаа

арга хэмжээ авахыг хориглох талаар тусгайлан хэлэлцэн тохирно. Эдгээр хориглолтод амийг хөнөөх, эрүү шүүлт тулгах, бие махбодийг зовоон тарчлаах, тахир дутуу болгох болон хамгаалагдсан хүмүүст шаардлагагүй эмнэлгийн буюу шинжлэх ухааны туршилт хийх зэрэг хамаарагдахаас гадна бас энгийн иргэд, эсхүл зэвсэгт хүчний зүгээс хийж болох бүх төрлийн хүчирхийлэл хамаарагдана.

*33 дугаар зүйл*

Аливаа үйлдээгүй гэмт хэргийнхээ төлөө хамгаалагдсан хүмүүс нь ял шийтгэл хүлээхгүй. Хэсэг бүлгээр хамааруулан ял шийтгэх, айлган сүрдүүлэх буюу терроризмын бүх хэлбэрийг хориглоно.

Хамгаалагдсан хүмүүсийг дээрэмдэн тонохыг хориглоно.

Хамгаалагдсан хүмүүс, тэдний эд хөрөнгийн эсрэг хариу арга хэмжээ авахыг хориглоно.

*34 дүгээр зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийг барьцаанд авахыг хориглоно.

**II ХЭСЭГ**

**МӨРГӨЛДӨӨНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН НУТАГ ДЭВСГЭРТ  
БАЙГАА ГАДААДЫН ИРГЭН**

*35 дугаар зүйл*

Хамгаалагдсан бүх хүн дайн эхлэхээс өмнө, эсхүл дайны явцад тухайн дайтагч нутаг дэвсгэрээс явах хүсэлтэй бөгөөд ийнхүү явах нь тухайн улсын үндэсний ашиг сонирхолд харшлахгүй тохиолдолд уг улсаас явах эрхтэй. Тухайн улсаас явахыг хүссэн хамгаалагдсан хүмүүсийн хүсэлтийг тухайн улсад тогтсон журмын дагуу хянан үзэж аль болох богино хугацаанд шийдвэрлэнэ. Гарах зөвшөөрөл авсан хүмүүс нь өөрсдийн аялалд зайлшгүй шаардлагатай замын зардлын мөнгө, хувийн хэрэгцээний эд зүйлсийг хүрэлцэхүйц хэмжээгээр бэлтгэн авч явна.

Хэрэв тухайн хүнийг нутаг дэвсгэрээс нь гарч явах зөвшөөрөл олгоогүй бол тухайн хүнийг олзлогч гүрний шүүхэд болон гомдол барагдуулах зорилгоор байгуулагдсан засаг захиргааны холбогдох байгууллагад хандаж, аль болох богино хугацаанд хүсэлтээ дахин хянуулах эрхтэй.

Гаргасан хүсэлтийн дагуу хамгаалагч гүрний төлөөлөгчид нь урьдчилан сэргийлэх аюулгүй байдлын шалтгаанаар, эсхүл сонирхогч этгээд зөвшөөрсөн тохиолдолд аливаа хүсэлтэд татгалзсан хариу өгсөн шалтгаан, түүнчлэн гарах зөвшөөрөл олгогдоогүй бүх хүмүүсийн нэрсийн талаарх мэдээллийг аль болох шуурхай авна.

*36 дугаар зүйл*

Дээрх зүйлд заасан зөвшөөрлийн дагуу гарахдаа аюулгүй байдал, эрүүл ахуй, эрүүл мэнд, хоол хүнсний зохих шаадлагын нөхцлийг хангасан байна. Олзлогч гүрний нутаг дэвсгэрийн хилийн цэгээс гаран цааш явахтай холбогдсон бүх зардлыг тухайн хүнийг хүлээн авах улс хариуцах бөгөөд хэрэв төвийг сахисан оронд очвол энэ боломжийг ашиглаж байгаа иргэнийг харьяалагч гүрэн хариуцна. Шаардлагатай тохиолдолд ийнхүү зорчин явах нөхцөлийг сонирхогч гүрнүүдийн хооронд байгуулсан тусгай хэлэлцээрээр зохицуулж болно.

Дээрх зүйл нь мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд эсрэг талын гарт орсон өөрсдийн иргэдийг харилцан солилцох, буцаахтай холбоотой асуудлаар байгуулж болох тусгай хэлэлцээрүүдэд үл харшлана.

*37 дугаар зүйл*

Урьдчилан хоригдож байгаа буюу хорих ял шийтгүүлсэн аливаа хамгаалагдсан хүмүүстэй хоригдож байх хугацаанд нь хүнлэг ёсоор харьцана.

Тухайн хамгаалагдсан хүмүүс нь суллагдсаныхаа дараа өмнөх зүйлүүдэд заасны дагуу тухайн улсын нутаг дэвсгэрээс гарах зөвшөөрөл хүсч болно.

*38 дугаар зүйл*

Энэхүү конвенц, ялангуяа түүний 27, 41 дүгээр зүйлд заасан тусгай арга хэмжээнээс гадна хамгаалагдсан хүмүүсийн байдлыг зарчмын хувьд тайван цагт гадаадын иргэдийн асуудалтай холбоотой журмаар үргэлжлүүлэн зохицуулна. Аль ч тохиолдолд хамгаалагдсан хүмүүст дараахь эрхийг олгоно:

1. Тусгайлсан, эсхүл хамтын журмаар илгээсэн тусламжийг тэд авч болно;
2. Эрүүл мэндийн байдлаас шалтгаалж эмнэлгийн асаргаа сувилгаа авах болон эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхдээ тухайн улсын иргэдийн нэг адил нөхцөлөөр хангагдах;
3. Шашин шүтэх, шашны санваартан нараас сэтгэл санааны дэмжлэг авах;
4. Хэрэв тэд дайн байлдааны аюул бүхий газар оршин сууж байвал тухайн улсын иргэдийн нэгэн адил нөхцөлөөр тэрхүү газар нутгаас гарах;
5. Арван тав хүртэлх настай хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, долоо хүртэлх настай хүүхэдтэй эхчүүд нь тухайн улсын ижил нөхцөлд буй иргэдийн нэгэн адил хөнгөлөлөлтэй нөхцөлөөр хангагдана.

*39 дүгээр зүйл*

Дайн мөргөлдөөний улмаас ажилгүй болсон хамгаалагдсан хүмүүс нь хөлстэй хөдөлмөр эрхлэх боломжоор хангагдана. Аюулгүй байдлын нөхцөл байдал болон

энэхүү конвенцийн 40 дүгээр зүйлд дурдсаны дагуу тухайн улсын нутаг дэвсгэрт буй иргэдтэй нэгэн адил боломжоор хангагдана.

Хамгаалагдсан хүмүүс өөрийгөө тэжээн тэтгэж чадахгүйд хүрвэл мөргөлдөөнд оролцогч тал тухайн хүмүүсийг хяналтандаа байлгах арга хэмжээ авах, ялангуяа тухайн хүмүүс нь аюулгүй байдлын үүднээс хөлстэй хөдөлмөр эрхлэх боломжгүйд хүрвэл мөргөлдөөнд оролцогч тал тухайн хүмүүс болон тэдний асрамжид байгаа хүмүүсийг амьдрах эх сурвалжаар хангана.

Хамгаалагдсан хүмүүс зохих тусламжийг эх орноосоо буюу хамгаалагч улс, түүнчлэн 30 дугаар зүйлд дурдсан тусламж үзүүлэх зорилго бүхий хүмүүнлэгийн байгууллагаас ямар ч тохиолдолд авч болно.

#### *40 дүгээр зүйл*

Нутаг дэвсгэрт нь оршин байгаа хамгаалагдсан хүмүүсийг мөргөлдөөнд оролцогч талын иргэний нэгэн адил хэмжээгээр албадан хөдөлмөрлүүлж болно.

Хэрэв хамгаалагдсан хүмүүс мөргөлдөөнд оролцогч улсын дайсангагч талын иргэн бол тэднээр зөвхөн хүний хоол хүнс, орон байр, хувцас, тээвэр болон эрүүл мэндийг хэвийн хангах болон цэрэг дайны үйл ажиллагаа явуулахад шууд хамааралгүй ажлыг гүйцэтгүүлж болно.

Өмнөх хоёр догол мөрөнд заасны дагуу албадан хөдөлмөрлөж байгаа хүмүүс нь тухайн орны хөдөлмөр эрхлэгчийн нэгэн адил цалин хөлс, ажлын цагийн үргэлжлэл, хувцас, багаж хэрэгсэл, урьдчилсан сургалт, үйлдвэрлэлийн осол болон өвчний үед эдлэх нөхөн олговрын ижил нөхцөл, хамгаалалтаар хангагдана.

Хэрэв дээр дурдсан заалт зөрчигдсөн тохиолдолд хамгаалагдсан хүмүүс энэхүү конвенцийн 30 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргах эрх эдлэхийг зөвшөөрнө.

#### *41 дүгээр зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийг ивээлдээ авсан гүрэн хэрэв энэхүү хэлэлцээрт заасан хяналтын арга хэмжээг шаардлага хангахгүй гэж үзвэл хамгаалагдсан хүмүүсийг энэхүү конвенцийн 42 болон 43 дугаар зүйлд заасны дагуу албадан суурьшуулах, эсхүл тусгаарлан хорих газрынхаас илүү хатуу хяналтын арга хэмжээ авч болохгүй.

Тодорхой газар албадан суурьшуулах тухай шийдвэрийн дагуу оршин сууж буй газраа орхих шаардлагатай болсон хамгаалагдсан хүмүүст энэхүү конвенцийн 39 дүгээр зүйлийн 2 дахь догол мөрийн заалтыг хэрэглэхдээ олзлогч гүрэн энэхүү конвенцийн IV хэсгийн III бүлэгт заасан нийгмийн халамж, хамгааллын хэм хэмжээг аль болох баримтална.

#### *42 дугаар зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийг тусгаарлан хорих буюу тусгай газар албадан суурьшуулах тухай шийдвэрийг зөвхөн олзлогч гүрний аюулгүй байдлын зайлшгүй шаардлагад үндэслэн гаргаж болно.

Хэрэв аливаа хүмүүс өөрийн хувийн нөхцөл байдал нь тусгаарлан хорих газар аваачих нь зайлшгүй чухал гэж үзэн хамгаалагч гүрний төлөөлөгчөөр дамжуулан сайн дураараа хүсэлт гаргавал тухайн хүмүүсийг ивээлдээ байлгаж буй гүрэн уг хүмүүсийг тусгаарлан хорьж болно.

#### *43 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдсон, эсхүл тусгай газар албадан суурьших болсон аливаа хамгаалагдсан хүмүүс нь олзлогч гүрний зохих шатны шүүх буюу энэ зорилгоор байгуулагдсан захиргааны холбогдох байгууллагаар хүсэлтээ аль болох богино хугацааны дотор дахин хянуулах эрх олгогдоно. Хэрэв тусгаарлан хорих буюу тусгай газар албадан суурьшуулах шийдвэр хүчин төгөлдөр үлдвэл уг шүүх буюу захиргааны байгууллага шаардлагатай гэж үзвэл анхан шатны шийдвэрийг хөнгөрүүлэн өөрчлөх зорилгоор жилд хоёроос доошгүй удаа тухайн хүмүүсийн хэргийг тогтмол хянан үзэж байна.

Хэрэв хамгаалагдсан хүмүүс үл татгалзвал олзлогч гүрэн хамгаалагч гүрэнд тусгаарлан хоригдсон, эсхүл тусгай газар албан суурьшсан хүмүүс, эсхүл тусгаарлан хоригдсон буюу тусгай газар албадан суурьших явдлаас чөлөөлөгдсөн аливаа хүмүүсийн нэрийг аль болох хурдан мэдээлнэ. Энэ зүйлийн I хэсэгт заасан шүүхийн буюу байгууллагын шийдвэрийг аль болох богино хугацааны дотор дурдсан нөхцлийн дагуу хамгаалагч гүрэнд мөн мэдээлнэ.

#### *44 дүгээр зүйл*

Энэхүү конвенцид заасан хяналтын арга хэмжээг хэрэглэхдээ олзлогч гүрэн дайсагнагч улсын иргэдтэй харьцдагтай нэгэн адилаар аль ч засгийн газрын хамгаалалд үл хамаарагдах дүрвэгсэдтэй дайсагнагч улсын харьяат хэмээн харьцаж үл болно.

#### *45 дугаар зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийг энэхүү конвенцид нэгдэн ороогүй гүрэнд шилжүүлж үл болно.

Энэ заалтыг хамгаалагдсан хүмүүсийг нутагт нь буцаах, эсхүл дайн дууссаны дараа тэднийг оршин сууж байсан оронд нь эргүүлэн авчрахад саад болгон ашиглаж үл болно.

Хамгаалагдсан хүмүүсийг олзлогч гүрэн гагцхүү энэхүү конвенцийн оролцогч гүрэнд шилжүүлж болох бөгөөд шилжүүлэн авч буй гүрэн нь энэхүү конвенцийг хэрэгжүүлэх хүсэлтэй буюу боломжтой байгааг олзлогч гүрэн нотолсон байна. Хэрэв хамгаалагдсан хүмүүсийг энэ нөхцлийн дагуу шилжүүлсэн бол тэднийг хүлээн авагч гүрэн тухайн хүмүүсийг тусгаарлан хоригдох байранд байх үеэс нь энэхүү конвенцийг хэрэглэх хариуцлага хүлээнэ. Хэрэв тухайн гүрэн нь энэхүү конвенцийн гол заалтыг биелүүлээгүй бол хамгаалагдсан хүмүүсийг шилжүүлж өгсөн гүрэн хамгаалагч гүрний мэдэгдсэнээр нөхцөл байдлыг засах талаар үр нөлөөтэй арга хэмжээ авах буюу шилжүүлсэн хүмүүсээ эргүүлэн авах шаардлагыг тавих ёстой. Энэ хүсэлтийг заавал ханган биелүүлбэл зохино.

Хамгаалагдсан хүмүүсийг улс төрийн буюу шашны итгэл үнэмшлээр нь мөрдөн мөшгиж болохуйц оронд ямар ч тохиолдолд шилжүүлэн өгч үл болно.

Энэ зүйлийн заалт нь гэмт этгээдийг шилжүүлэх талаар дайн эхлэхээс өмнө байгуулсан гэрээний дагуу эрүүгийн ердийн гэмт хэрэгт яллагдаж буй хамгаалагдсан хүмүүсийг шилжүүлж өгөхөд саад учруулахгүй.

*46 дугаар зүйл*

Хамгаалагдсан хүмүүст хязгаарлалтын арга хэмжээ авч түүнийг хүчингүй болгоогүй нөхцөлд дайн дууссаны дараа аль болох богино хугацаанд тэрхүү хязгаарлалтын арга хэмжээг хүчингүй болгоно.

Хамгаалагдсан хүмүүсийн эд хөрөнгийн талаар тогтоосон хязгаарлалтын арга хэмжээг дайн дууссаны дараа олзлогч гүрний хууль тогтоомжийн дагуу аль болох богино хугацааны дотор хүчингүй болно.

### **III ХЭСЭГ**

#### **ЭЗЛЭГДСЭН НУТАГ ДЭВСГЭР**

*47 дугаар зүйл*

Эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа хамгаалагдсан хүмүүст энэхүү конвенцоор олгосон давуу эрхийг тухайн нутаг дэвсгэрт тогтоосон журам буюу эзлэгдсэнээс болж эл нутаг дэвсгэрийн засгийн газар, төрийн байгууллагад өөрчлөлт гарсан, эзлэгдсэн нутаг дэвсгэрийн болон эзлэгч гүрний засаг захиргааны хооронд байгуулсан хэлэлцээр өөрчлөгдсөн, эсхүл эзлэгч гүрний эзлэн авсан нутаг дэвсгэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчээр нэгтгэсэн зэрэг шалтгаанаар ямар ч тохиолдолд хязгаарлаж болохгүй.

*48 дугаар зүйл*

Нутаг дэвсгэр нь эзлэгдсэн гүрний харъяат иргэн бус хамгаалагдсан хүмүүс нь энэхүү конвенцийн 35 дугаар зүйлд заасны дагуу тухайн нутаг дэвсгэрээс гарч явах эрх эдлэх бөгөөд үүнтэй холбоотой шийдвэрийг эзлэгч гүрнээс дурдсан зүйлтэй нийцүүлэн тогтоох журмын дагуу гаргана.

*49 дүгээр зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийг эзлэгдсэн нутаг дэвсгэрээс эзлэгч гүрний нутаг дэвсгэрт буюу эзлэгдсэн, эсхүл эзлэгдээгүй эсэхийг үл харгалзан аль нэгэн улсын нутаг дэвсгэр рүү ямар нэг шалтгаанаар тэдний хүсэл зоригийг үл харгалзан дангаар нь болон бөөнөөр нь нүүлгэн шилжүүлэх, цөлөхийг хориглоно.

Гэвч эзлэгч гүрэн хүн амын аюулгүй байдал, цэрэг дайны онц байдлаас болж ямар нэг тодорхой эзлэгдсэн газар нутгаас хүмүүсийг бүгдийг нь буюу зарим хэсгийг

нь нүүлгэн шилжүүлж болно. Ингэж нүүлгэн шилжүүлэх үед эд материалын шаардлагаас болон нүүлгэн шилжүүлэх нь зайлшгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд хамгаалагдсан хүмүүсийг эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хил хязгаараас гадна нүүлгэн шилжүүлж үл болно. Ийм журмаар нүүлгэн шилжүүлсэн хүн амыг уг нутаг дэвсгэрт дайны ажиллагаа дуусмагц богино хугацааны дотор орон гэрт нь буцаана.

Ийнхүү хамгаалагдсан хүмүүсийг нүүлгэн шилжүүлж буй эзлэгч гүрэн тэдгээр хүмүүсийг зохих орон байраар боломжийнхоо хэрээр хангах бөгөөд энэхүү нүүлгэн шилжүүлэлт нь тэдний аюулгүй байдал, эрүүл ахуй, эрүүл мэнд, хоол хүнсний хэвийн нөхцөлийг хангах үүрэгтэй бөгөөд нэг гэр бүлийн хүмүүсийг салгаж болохгүй.

Энэхүү нүүлгэн шилжүүлэх ажил дуусмагц тэр тухай хамгаалагч гүрэнд мэдэгдэнэ.

Эзлэгч тал нь хүн амын аюулгүй байдал буюу цэрэг дайны онц байдал шаардаагүй бол хамгаалагдсан хүмүүсийг цэрэг дайны аюул учирч болзошгүй газарт албадан саатуулж болохгүй.

Эзлэгч гүрэн хүн амынхаа зарим хэсгийг эзэлсэн нутаг дэвсгэр рүү нүүлгэн шилжүүлэх, эсхүл цөлөхийг хориглоно.

#### *50 дугаар зүйл*

Эзлэгч гүрэн үндэсний болон орон нутгийн засаг захиргааны тусламжтайгаар хүүхдүүдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх үүрэгтэй байгууллагын хэвийн ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлнэ.

Эзлэгч гүрэн хүүхдүүдийн нэр овгийг тогтоон, садан төрлийн холбоог тодотгоход зайлшгүй шаардлагатай бүхий л арга хэмжээ авна. Эзлэгч гүрэн тэдгээр хүүхдүүдийн иргэний эрх зүйн байдлыг ямар ч тохиолдолд өөрчилж болохгүй бөгөөд өөрт хамаарах байгууллагын бүртгэлт оруулах ёсгүй.

Хэрэв орон нутгийн байгууллага эдгээр үүргийг биелүүлж чадахгүйд хүрвэл өнчин хүүхдүүд буюу дайны уршгаар эх эцгээсээ салсан бөгөөд ойрын садан, найз нөхдөөсөө тусламж, халамж авч чадахгүй хүүхдүүдийг боломжтой бол тэдгээртэй ижил үндэс угсаа, хэл, шашин шүтлэгтэй хүмүүсээр тэжээн тэтгүүлэх, асруулах, сургах арга хэмжээг эзлэгч гүрэн авах ёстой.

Энэхүү конвенцийн 136 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан товчооны тусгай хэлтэс нэр овог нь тодорхой бус хүүхдүүдийг тодорхой болгох талаарх шаардлагатай бүх арга хэмжээ авна. Ялангуяа, хүүхдүүдийн эцэг эх буюу ойрын садан төрлийн хүмүүсийн тухай мэдээллийг ямагт бүртгэх үүрэгтэй.

Арван тав хүртэлх насны хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, долоо хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдэд эзлэгдэх хүртэл хангаж байсан хоол хүнс, үзүүлэх эмнэлгийн туслалцаа, дайны аюулаас хамгаалах гэх мэт хөнгөлөлтийн арга хэмжээ авахад эзлэгч гүрэн саад учруулах ёсгүй.



*51 дүгээр зүйл*

Эзлэгч гүрэн хамгаалагдсан хүмүүсийг өөрийн зэвсэгт хүчин буюу түүнд туслах хүчинд алба хаалгахаар албадаж болохгүй. Тэднийг өөрийн зэвсэгт хүчинд сайн дураараа оруулахын тулд элдэв дарамт шахалт үзүүлэх буюу суртал нэвтрүүлэг хийж болохгүй.

Эзлэгч гүрэн зөвхөн арван наймаас дээш насны хамгаалагдсан хүмүүсийг зөвхөн зайлшгүй шаардлагатай буюу эзлэгч талын армийн хэрэгцээт ажил, эсхүл эзлэгдсэн газар нутгийн нийтийн аж ахуй, үйлчилгээ, хоол хүнс, орон сууц, хувцас, тээвэр, хүн амын эрүүл мэндтэй холбоотой ажил хөдөлмөрийг албадан хийлгэхээр явуулж болно. Хамгаалагдсан хүмүүсийг цэрэг дайны ажиллагаанд оролцуулахад чиглэсэн аливаа ажлыг гүйцэтгүүлж болохгүй. Тэдгээрийн албадлагын хөдөлмөр эрхэлж байгаа газрынх нь аюулгүй байдлыг хамгаалагдсан хүмүүсээр хангуулах замаар хүчээр ажиллуулж үл болно.

Тухайн хүмүүсийг зөвхөн оршин суугаа эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хүрээнд ажиллуулна. Хүн бүрийг өмнө нь ажиллаж байсан газарт нь бололцооны хэрээр ажиллуулна. Ажилтны бие махбодь, оюун санааны чадавхид нийцсэн шударга хөлсийг түүнд олгоно. Эзлэгдсэн улсын мөрдөж буй хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөлийн талаарх хууль тогтоомж, тухайлбал цалин хөлс, ажлын цаг, багаж хэрэгсэл, урьдчилсан сургалт, үйлдвэрлэлийн осол, хүнд өвчинд нэрвэгдэхэд олгох нөхөн олговор зэрэгт холбогдох хууль тогтоомжийг энэ зүйлд заасан хөдөлмөр эрхэлж буй хамгаалагдсан хүмүүст нэгэн адил хэрэглэнэ.

Тэднийг албадан хөдөлмөрт татан оролцуулах аливаа тохиолдлыг цэргийн буюу цэргийн хагас зохион байгуулалттай байгууллагын ажлын дайчилгаа болгож үл болно.

*52 дугаар зүйл*

Ажиллагсад хаана ч сайн дурын, эсхүл сайн дураараа бус хөдөлмөр эрхэлж буй эсэхээс үл хамааран хамгаалагч гүрний төлөөлөгчдөд хандан ивээл хамгаалал хүсэх эрхийг нь ямар ч гэрээ, хэлэлцээр буюу зохицуулалтаар хязгаарлаж болохгүй.

Эзлэгдсэн нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхэлж буй хамгаалагдсан хүмүүсийн ажиллах бололцоог хязгаарлах буюу ажилгүйдэлд хүргэх, түүнчлэн эзлэгч гүрний эрх ашгийн тулд хөдөлмөр эрхлүүлэх зорилгод чиглэсэн аливаа арга хэмжээг авахыг хориглоно.

*53 дугаар зүйл*

Эзлэгч гүрэн цэрэг дайны зайлшгүй ажиллагааны улмаас үйлдэхээс бусад тохиолдолд хувь хүн, төр, эсхүл төрийн байгууллагын, эсхүл нийгмийн буюу хоршооллын байгууллагын хувийн болон дундын хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийг устгах аливаа хэлбэрийг хориглоно.

*54 дүгээр зүйл*

Эзлэгч гүрэн эзлэгдсэн нутаг дэвсгэрийн албан тушаалтан буюу шүүгчдийн эрх зүйн байдлыг өөрчлөх буюу тэдэнд шийтгэл ногдуулах, тулган хавчих арга хэмжээ

авах буюу шударгаар үүргээ биелүүлэхээс түдгэлзүүлэх, тэднийг алагчилахад чиглэсэн аливаа арга хэмжээг хэрэгжүүлэхийг хориглоно.

Энэхүү конвенцийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг биелүүлэхэд уг хориглолт нь саад учруулахгүй. Энэ нь эзлэгч гүрнээс албан тушаалтныг үүрэгт ажлаас нь чөлөөлөх эрхийг хөндөхгүй.

*55 дугаар зүйл*

Эзлэгч гүрэн хүн амыг хоол хүнс, эмнэлгийн материалаар хангахад бүх бололцоогоо дайчлах үүрэгтэй. Эзлэгч гүрэн нь эзлэгдэгч нутгийн нөөц хүрэлцэхгүй үед хоол хүнсний зүйлс, эмнэлгийн материал зэрэг бусад шаардлагатай зүйлсийг тээвэрлэн авчирна.

Эзлэгч гүрэн зөвхөн өөрийн цэрэг, захиргааны албаны хүмүүст зориулан, энгийн хүн амын эрэлт хэрэгцээг харгалзан хоол хүнсний болон бусад шаардлагатай материал, түүнчлэн эзлэгдсэн нутаг дэвсгэрт буй эмнэлгийн материалыг дайчлан авч болно. Эзлэгч гүрэн олон улсын бусад конвенцийн нөхцлийн дагуу дайчлан авсан эд зүйлсийг шударгаар нөхөн төлөх явдлыг хангах арга хэмжээ авна.

Хамгаалагч гүрэн цаг ямагт цэрэг дайны зайлшгүй шаардлагаас болон түр хязгаарлалт тогтоосон эзлэгдсэн нутаг дэвсгэрт хоол хүнсний болон эмнэлгийн материалын хангамжийн байдлыг саадгүй шалгах эрхтэй.

*56 дугаар зүйл*

Эзлэгч гүрэн өөртөө байгаа бололцоог дээд хэмжээгээр ашиглан үндэсний болон орон нутгийн эрх бүхий байгууллага, эмнэлгийн байгууллага, албадын дэмжлэгтэйгээр эзлэгдсэн нутаг дэвсгэрт олон нийтийн эрүүл мэнд, ариун цэврийг ханган сахиулах үүрэгтэй бөгөөд чингэхдээ халдварт өвчин, тахал тархахтай тэмцэхэд шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах болон хэрэглэхэд онцгой анхаарна. Бүх зэрэглэлийн эмнэлгийн ажилтанд үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрнө.

Хэрэв эзлэгдсэн нутаг дэвсгэрт шинэ эмнэлэг байгуулагдаж, эзлэгдсэн улсын эрх бүхий байгууллага тэнд үйл ажиллагаа явуулахгүй байгаа бол тэдгээр эмнэлгийг эзлэгч гүрний эрх бүхий байгууллага 18 дугаар зүйлд зааснаар хэрэв шаардлагатай бол хүлээн зөвшөөрнө. Үүнтэй төсөөтэй нөхцөл байдалд эзлэгч гүрний эрх бүхий байгууллага 20, 21 дүгээр зүйлийн дагуу эмнэлгийн ажилтан болон тээврийн хэрэгслийг мөн хүлээн зөвшөөрнө.

Эрүүл мэнд, эрүүл ахуйн арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ эзлэгч гүрэн эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хүн амын зан суртахуун, ёс зүйн шаардлагыг харгалзан үзнэ.

*57 дугаар зүйл*

Эзлэгч гүрэн зөвхөн цэргийн шархтан, өвчтөнг асрах шаардлага яаралтай гарсан тохиолдол, түүнчлэн эмнэлэгт хэвтэж байгаа өвчтөнүүдийг асран эмчлэх болон энгийн иргэдийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх хэрэгцээг хангах талаар тохирох арга

хэмжээг зохих цаг хугацаанд авах нөхцөлд энгийн эмнэлгийг түр хугацаагаар дайчилж болно.

Энгийн эмнэлгийн материал, агуулахыг энгийн иргэдийн хэрэгцээнд шаардлагатай байгаа цагт дайчилж болохгүй.

*58 дугаар зүйл*

Сүсэг нэгтэндээ оюун санааны тусламж үзүүлэхийг шашны санваартанд эзлэгч гүрэн зөвшөөрнө.

Эзлэгч гүрэн нь шашны хэрэгцээг хангахад шаардлагатай ном, хэрэгсэлтэй ачааг хүлээн авч, эзлэгдсэн нутаг дэвсгэрт түгээхийг хөнгөвчлөн дэмжинэ.

*59 дүгээр зүйл*

Хэрэв эзлэгдсэн нутаг дэвсгэрийн нийт хүн ам буюу тэдний зарим хэсэгт хангамж дутуу байвал эзлэгч гүрэн нь тухайн хүн амд тусламж үзүүлэх арга хэмжээг зөвшөөрөх бөгөөд тэдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхийг мэдэлдээ байгаа бүхий л аргаар хөнгөвчлөн дэмжинэ.

Улс, эсхүл Олон улсын улаан загалмайн хороо зэрэг хүмүүнлэгийн хараат бус байгууллагаас хэрэгжүүлж болох тэдгээр арга хэмжээнд, тухайлбал, хүнсний бүтээгдэхүүн, эмнэлгийн хангамж, хувцсаар хангах явдал багтана.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд эдгээр ачааг чөлөөтэй өнгөрүүлэхийг зөвшөөрч, тэдгээрийг хамгаалах баталгаагаар хангана.

Гэвч ачааг мөргөлдөөнд оролцогч дайсагнагч талын эзэлсэн нутаг дэвсгэр рүү чөлөөтэй өнгөрүүлэх баталгаагаар хангаж буй гүрэн нь тэдгээр ачаанд үзлэг хийх, тэдгээрийг заасан хугацаанд заасан чиглэлээр өнгөрүүлэхийг зохицуулах, түүнчлэн тэдгээр ачааг эзлэгч гүрний ашиг тусад бус, харин тусламж хэрэгтэй байгаа хүн амд тусламж үзүүлэхэд хэрэглэж байгаа гэж хамгаалагч гүрнээр дамжуулан үндэслэлтэйгээр нягтлах эрхтэй.

*60 дугаар зүйл*

Тусламжийн ачаа нь эзлэгч гүрнийг 55, 56, 59 дүгээр зүйлийн дагуу хүлээсэн аливаа хариуцлагаас хэрхэвч чөлөөлөхгүй. Эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хүн амын ашиг сонирхлын үүднээс болон хамгаалагч гүрний зөвшөөрөлтэйгөөр яаралтай шаардлагатайгаас бусад тохиолдолд эзлэгч гүрэн тусламжийн ачааг өөр ямарваа зорилгоор хэрхэвч ашиглаж болохгүй.

*61 дүгээр зүйл*

Өмнөх зүйлд дурдсан тусламжийн ачааг хамгаалагч гүрний дэмжлэг, хяналтын дор түгээнэ. Энэ үүргийг мөн эзлэгч гүрэн болон хамгаалагч гүрний хооронд байгуулсан хэлэлцээрээр төвийг сахисан гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо, эсхүл хараат бус хүмүүнлэгийн өөр байгууллагад шилжүүлж болно.

Тухайн нутаг дэвсгэрийн эдийн засгийн ашиг сонирхолд шаардлагатайгаас бусад тохиолдолд тэдгээр ачааг эзлэгдсэн нутаг дэвсгэрт бүх хураамж, татвар буюу гаалийн татвараас чөлөөлнө. Эзлэгч гүрэн эдгээр ачааг шуурхай хуваарилахад дэмжлэг үзүүлнэ.

Хэлэлцэн тохирогч бүх тал эзлэгдсэн нутаг дэвсгэр рүү явуулж байгаа тусламжийн тэдгээр ачааг үнэ төлбөргүйгээр дамжин өнгөрүүлж, тээвэрлүүлэхийг чармайна.

#### *62 дугаар зүйл*

Аюулгүй байдлын зайлшгүй шаардлагад харшлахгүй бол эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгаа хамгаалагдсан хүмүүст тэдэнд тус бүрт нь илгээсэн ачааг хүлээн авахыг зөвшөөрнө.

#### *63 дугаар зүйл*

Эзлэгч гүрний аюулгүй байдлын яаралтай шаардлагаар түр бөгөөд онцгой арга хэмжээг мөрдөхийн хамт:

а) хүлээн зөвшөөрөгдсөн Үндэсний улаан загалмайн (Улаан хавирган сар, Улаан арслан болон нарны) нийгэмлэг нь Олон улсын улаан загалмайн бага хурлаас гаргасан зарчимд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна. Тусламжийн бусад нийгэмлэгт адил нөхцөлийн дагуу хүмүүнлэгийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийг зөвшөөрнө;

б) эзлэгч гүрэн хэрэв дээр дурдсан үйл ажиллагаанд хор уршиг учруулахуйц байвал эдгээр нийгэмлэгийн ажилтан буюу бүтцэд ямарваа өөрчлөлт оруулахыг шаардаж болохгүй.

Нийтэд зайлшгүй үйлчилгээний албадыг ажиллуулах, тусламж түгээх, аврах ажил зохион байгуулах замаар энгийн иргэдийн амьдралын нөхцөлийг хангах зорилгоор байгуулагдсан буюу байгуулагдаж болох цэргийн бус шинжтэй тусгай байгууллагын үйл ажиллагаа, ажилтанд мөн адил зарчмыг хэрэглэнэ.

#### *64 дүгээр зүйл*

Эзлэгдсэн нутаг дэвсгэрийн эрүүгийн хууль тогтоомж нь эзлэгч гүрний аюулгүй байдалд заналхийлж буюу энэхүү конвенцийг хэрэглэхэд саад болж буй тохиолдолд эзлэгч гүрэн түүнийг хүчингүй болгох буюу үйлчлэлийг нь түр зогсоож болохоос бусад тохиолдолд энэ хууль тогтоомж нь хүчин төгөлдөр хэвээр байна.

Дээр дурдсаныг болон шударга шүүхийн үр нөлөөтэй ажиллагааг хангах шаардлагыг харгалзан эзлэгдсэн нутаг дэвсгэрийн шүүхийн байгууллага дээр дурдсан хууль тогтоомжид хамрагдсан эрх зүйн бүх зөрчлийн хувьд чиг үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

Гэвч эзлэгч гүрэн нь энэхүү конвенцийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой болох, тухайн нутаг дэвсгэрийг хэвийн удирдлагаар хадгалах, эзлэгч гүрэн, эзлэгч хүчин буюу захиргааны бие бүрэлдэхүүн буюу эд хөрөнгө, түүнчлэн тэдний

ашиглаж буй объект, харилцаа холбооны шугамын аюулгүй байдлыг хангахад зайлшгүй заалтын үйлчлэлд эзлэгдсэн нутаг дэвсгэрийн хүн амыг хамруулж болно.

*65 дугаар зүйл*

Эзлэгч гүрний гаргасан эрүүгийн хариуцлагыг хүлээх заалтыг хэвлэн нийтэлж, оршин суугчдад тэдний хэлээр сонордуулахаас өмнө тухайн заалт хүчин төгөлдөр болохгүй. Эрүүгийн хариуцлагын тухай эдгээр заалтын үйлчлэлийг буцаан хэрэглэхгүй.

*66 дугаар зүйл*

64 дүгээр зүйлийн хоёр дахь догол мөрийг үндэслэн эзлэгч гүрний батлан гаргасан эрүүгийн хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд эзлэгч гүрэн яллагдагчийг зохих ёсоор байгуулагдсан улс төрийн бус цэргийн шүүхэд тухайн шүүх нь эзлэгдсэн нутаг дэвсгэрт хуралдах нөхцөлд шилжүүлнэ. Давж заалдах шатны шүүх нь аль болох эзлэгдсэн нутаг дэвсгэрт хуралдана.

*67 дугаар зүйл*

Шүүх тухайн эрх зүйн зөрчил гарахаас өмнө хэрэглэж байсан бөгөөд эрх зүйн нийтлэг зарчим, ялангуяа ял гэмт хэрэгтээ тохирсон байх зарчимд нийцсэн хуулийн заалтыг зөвхөн хэрэглэнэ. Яллагдагч нь эзлэгч гүрний харьяат биш байгааг шүүх харгалзан үзнэ.

*68 дугаар зүйл*

Хэрэв хамгаалагдсан хүмүүсийн үйлдсэн эрх зүйн зөрчил нь гагцхүү эзлэгч гүрэнд гэм хор учруулах зорилготой бөгөөд эзлэгч хүчин буюу захиргааны бие бүрэлдэхүүний амь нас, бие махбодид халдаагүй, хамт олонд ноцтой аюул учруулаагүй, эзлэгч хүчин буюу захиргааны эд хөрөнгөд хийгээд тэдний ашиглаж буй байгууламжид ноцтой хохирол учруулаагүй бол тухайн хүмүүсийг тусгаарлан хорих буюу ердийн журмаар шоронд хорино, чингэхдээ тийнхүү тусгаарлан хорих буюу шоронд хорих хугацаа нь үйлдсэн эрх зүйн зөрчилтэй тохирвол зохино. Үүнээс гадна эрх зүйн ийм зөрчил үйлдсэний төлөө тусгаарлан хорих буюу шоронд хорих нь хамгаалагдсан хүмүүсийн эрх чөлөөг хязгаарлахаар авах цорын ганц арга хэмжээ байна. Энэхүү конвенцийн 66 дугаар зүйлд заасан шүүх нь шоронд хорих ялыг мөн адил хугацаагаар тусгаарлан хорих ялаар өөрийн үзэмжээр сольж болно.

64, 65 дугаар зүйлд нийцүүлэн эзлэгч гүрний батлан гаргасан эрүүгийн хуулийн заалт нь хамгаалагдсан хүн тагнуул хийх, эзлэгч гүрний цэргийн байгууламжийн эсрэг хорлон сүйтгэх ноцтой үйлдэл хийх, нэг буюу хэд хэдэн хүнийг үхэлд хүргэх эрх зүйн зөрчлийг санаатай үйлдсэн тохиолдолд л тухайн хүмүүст цаазаар авах ял оногдуулж болох бөгөөд чингэхдээ ийм зөрчилд цаазаар авах ял оногдуулахаар эзлэгдсэн нутаг дэвсгэрт эзлэхээс өмнө үйлчилж байсан хуульд заасан байвал зохино.

Яллагдагч нь эзлэгч гүрний иргэн биш учраас эзлэгч гүрэнд үнэнч байх үүрэг хүлээгээгүй гэдэгт шүүх онцгой анхаарал тавиагүй бол цаазаар авах ялыг хамгаалагдсан хүнд оногдуулж болохгүй.

Эрх зүйн зөрчил үйлдэх үедээ арван наймаас доош настай байсан хамгаалагдсан хүнд ямар ч тохиолдолд цаазаар авах ял оногдуулж болохгүй.

*69 дүгээр зүйл*

Хамгаалагдсан хүн эрх зүйн зөрчил үйлдсэн гэж шүүх буюу шийтгэлийн өмнө цагдан хоригдсон хугацааг ямар ч тохиолдолд шийтгэгдэх хорих ялын хугацаанд оруулан тооцно.

*70 дугаар зүйл*

Дайны хууль, заншлыг зөрчсөнөөс бусад тохиолдолд хамгаалагдсан хүмүүсийг эзлэхээс өмнө буюу эзлэлт түр зогсох үед үйлдсэн эрх зүйн зөрчил буюу илэрхийлж байсан үзэл бодлынх нь төлөө эзлэгч гүрэн баривчилж, мөрдөж, эсхүл шийтгэж болохгүй.

Дайтах ажиллагаа эхэлсний дараа үйлдсэн эрх зүйн зөрчил эсхүл, эзлэгдсэн улсын хуулиар тайван цагт шилжүүлэн өгөх үндэс болох байсан дайтах ажиллагааны өмнө үйлдсэн эрх зүйн зөрчлөөс бусад тохиолдолд дайтах ажиллагаа эхлэхээс өмнө эзлэгдсэн улсын нутаг дэвсгэрт орогнол хүссэн эзлэгч гүрний харьяатыг баривчилж, мөрдөж, шийтгэж, эсхүл эзлэгдсэн нутаг дэвсгэрээс хөөн гаргаж болохгүй.

*71 дүгээр зүйл*

Тогтоосон журмаар шүүх ажиллагаа явуулаагүй бол эзлэгч гүрний эрх бүхий шүүх нэг ч ял оногдуулж болохгүй.

Эзлэгч гүрний мөрдөж байгаа аливаа яллагдагч хүмүүст түүний эсрэг яллагааг тодорхой тайлбарлан ойлгох хэлээр нь бичгээр яаралтай мэдээлж, аль болох шуурхай шүүнэ. Хамгаалагдсан хүмүүсийн эсрэг цаазаар авах ял, эсхүл хоёр буюу түүнээс дээш жилээр хорих ял оногдуулахаар эзлэгч гүрний үүсгэсэн бүх ажиллагааны тухай хамгаалагч гүрэнд мэдэгдэх бөгөөд хамгаалагч гүрэн эдгээр ажиллагааны явцын байдлын талаар хэдийд ч мэдээлэл авах боломжтой байна. Түүгээр зогсохгүй, хамгаалагч гүрэн нь хамгаалагдсан хүмүүсийн эсрэг эзлэгч гүрний үүсгэсэн эдгээр болон аливаа бусад бүх ажиллагааны тухай тодорхой мэдээллийг өөрийн хүсэлтээр авч байх эрх эдлэнэ.

Дээрх хоёр дахь догол мөрд зааснаар хамгаалагч гүрэнд өгөх мэдэгдлийг нэн даруй илгээх бөгөөд ямар ч тохиолдолд хэргийг анх хэлэлцэх өдрөөс гурван долоо хоногийн өмнө хамгаалагч гүрэнд хүргүүлнэ. Энэ зүйлийн заалтыг бүрэн биелүүлсэн тухай нотолгоог шүүх ажиллагаа эхлэх үед өгөөгүй бол шүүх хурлыг эхлэхгүй. Мэдэгдэлд дараахь мэдээлэл баримт багтана:

- а) яллагдагчийн тухай мэдээлэл баримт;
- б) оршин сууж байгаа буюу хоригдож байгаа газар;
- с) яллааганы тухай тодорхой мэдээлэл (ийнхүү яллах болсон эрүүгийн хуулийн заалтыг дурдана);

- d) хэргийг хэлэлцэх шүүхийн нэр, хаяг;
- e) хэргийг анх хэлэлцэх газар, он, сар, өдөр.

*72 дугаар зүйл*

Яллагдаж буй хүмүүс өөрийгөө өмгөөлөхөд шаардлагатай нотлох баримт гаргана, тухайлбал гэрчийг дуудаж болно. Тэд өөрөө сонгосон мэргэжлийн өмгөөлөгч буюу зөвлөхийн туслалцаа авах эрхтэй бөгөөд тэдгээр өмгөөлөгч буюу зөвлөх нь тэдэнтэй чөлөөтэй уулзах болон өмгөөлөхөд бэлтгэхэд шаардлагатай боломж нөхцөлөөр хангагдсан байна.

Хэрэв яллагдагч өмгөөлөгчөө сонгон авч чадахгүйд хүрвэл хамгаалагч гүрэн түүнд өмгөөлөгч буюу зөвлөх олж өгнө. Хэрэв яллагдагч онц хүнд гэмт хэрэгт яллагдаж байгаа бөгөөд хамгаалагч гүрэн байхгүй байвал эзлэгч гүрэн яллагдагчийн зөвшөөрснөөр түүнд өмгөөлөгч буюу зөвлөх олж өгнө.

Урьдчилсан мөрдөн байцаалтын болон шүүх хурлын үед яллагдаж буй хүмүүс өөрөө сайн дураараа татгалзаагүй бол түүнд орчуулагчийн туслалцаа үзүүлэх ёстой. Тэд хэдийд ч орчуулагчаас татгалзах, түүнийг солих хүсэлт гаргах эрхтэй.

*73 дугаар зүйл*

Ял шийтгүүлсэн хүмүүс тухайн шүүхийн хэрэглэсэн хуульд зааснаар давж заалдах эрхтэй. Түүнд давж заалдах буюу гомдол гаргах эрх болон тийнхүү давж заалдах буюу гомдол гаргах хугацааны талаар бүрэн мэдээлнэ.

Давж заалдах тохиолдолд энэ ангид заасан эрүүгийн байцаан шийтгэх журмыг боломжийн хэрээр хэрэглэнэ. Хэрэв шүүхийн хэрэглэсэн хуульд давж заалдах тухай заалт байхгүй бол ял шийтгүүлсэн хүмүүс эзлэгч гүрний эрх бүхий байгууллагад шүүхийн шийдвэр болон ялын талаар гомдол гаргах эрхтэй.

*74 дүгээр зүйл*

Эзлэгч гүрний аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс онцгой арга хэмжээ болгон шүүх хурлыг хаалттай явуулаагүй бол хамгаалагч гүрний төлөөлөгчид нь хамгаалтад байдаг аливаа хүмүүсийн шүүх хуралд байлцах эрхтэй. Шүүх хурлыг хаалттай явуулах тохиолдолд эзлэгч гүрэн нь хамгаалагч гүрэнд дараа нь мэдэгдэнэ. Шүүх хурал болох он, сар, өдөр, газрын тухай мэдэгдлийг хамгаалагч гүрэнд илгээнэ.

Цаазаар авах ял, эсхүл хоёр буюу түүнээс дээш жилээр хорих ял оногдуулах шийдвэрийн талаар хамгаалагч гүрэнд шийдвэр гарах болсон үндэслэлийн хамт аль болох шуурхай мэдэгдэнэ. Мэдэгдэлд 71 дүгээр зүйлийн дагуу хийсэн мэдэгдлийн талаар дурдаж, хорих ял оногдуулсан тохиолдолд уг ялыг эдлэх газрын нэрийг заана. Дээр дурдсанаас бусад шийдвэрийн бүртгэлийг шүүх хадгалах бөгөөд хамгаалагч гүрний төлөөлөгчид шалгахад нээлттэй байна. Цаазаар авах ял, эсхүл хоёр буюу түүнээс дээш жилээр хорих ял оногдуулах тохиолдолд давж заалдаж болох хугацаа нь уг шийдвэрийн тухай мэдэгдлийг хамгаалагч гүрэн хүлээн авах хүртэл тоологдож эхлэхгүй.

*75 дугаар зүйл*

Цаазаар авах ял шийтгүүлсэн хүмүүсийг өршөөл буюу уучлал үзүүлэх хүсэлт гаргах эрхээс нь ямар ч тохиолдолд салгахгүй.

Цаазаар авах ялыг батласан эцсийн шийдвэрийн талаархи мэдэгдлийг, эсхүл өршөөл буюу уучлал үзүүлэхээс татгалзсан зарлигийг хамгаалагч гүрэн хүлээн авснаас хойш наад зах нь зургаан сарын хугацаа өнгөрөхөөс өмнө нэг ч тийм ялыг гүйцэтгэж болохгүй.

Эзлэгч гүрэн буюу түүний хүчний аюулгүй байдлын эсрэг зохион байгуулалттай аюул учрахуйц онц ноцтой нөхцөл байдалд тодорхой тохиолдолд энд заасан цаазаар авах ялыг түдгэлзүүлэх зургаан сарын хугацааг богиносгож болох бөгөөд чингэхдээ хамгаалагч гүрэнд хугацааг тийнхүү богиносгосон талаар мэдэгдэж, цаазаар авах ялын талаар эзлэгч эрх бүхий байгууллагад хандах боломжит хугацаа, боломж олговол зохино.

*76 дугаар зүйл*

Гэмт хэрэгт яллагдаж буй хамгаалагдсан хүмүүсийг эзлэгдсэн нутаг дэвсгэрт саатуулах бөгөөд тэд ял шийтгүүлсэн тохиолдолд тэндээ ялаа эдлэнэ. Боломжтой бол тэднийг бусад хоригдлоос тусгаарлаж, тэдний эрүүл байлгахад хангалттай бөгөөд наад зах нь эзлэгч гүрний шоронд өгдөгтэй адил тэгш байх, хоол хүнс, эрүүл ахуйн нөхцөлөөр хангана.

Тэд эрүүл мэндийн шаардлагын дагуу эмнэлгийн тусламж авна.

Тэд мөн шаардагдаж болох сэтгэл санааны тусламж авах эрхтэй.

Эмэгтэйчүүдийг тусгай хуаранд хорьж, эмэгтэй хүний харгалзаанд шууд байлгана.

Насанд хүрээгүй хүмүүст зориулсан тусгай дэглэмд зохих анхаарал тавина.

Саатуулагдаж буй хамгаалагдсан хүмүүс 143 дугаар зүйлийн дагуу хамгаалагч гүрэн болон Олон улсын улаан загалмайн хорооны төлөөлөгчидтэй уулзах эрхтэй.

Эдгээр хүн сард наад зах нь тусламжийн нэгээс доошгүй илгээмж авах эрхтэй.

*77 дугаар зүйл*

Эзлэгдсэн нутаг дэвсгэрт гэмт хэрэгт яллагдсан буюу шүүхээс ял шийтгүүлсэн хамгаалагдсан хүмүүсийг эзлэлт дууссаны дараа холбогдох хэргийн хамт чөлөөлөгдсөн нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.



*78 дугаар зүйл*

Хэрэв аюулгүй байдлын зайлшгүй шаардлагаас болж эзлэгч гүрэн хамгаалагдсан хүмүүсийн талаар аюулгүйн арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл цаад зах нь тэднийг тусгай газар зааж суурьшуулах буюу тусгаарлан хорьж болно.

Тийнхүү тусгай газар зааж суурьшуулах буюу тусгаарлан хорих талаархи шийдвэрийг энэхүү конвенцид нийцүүлэн эзлэгч гүрнээс тогтоосон ердийн журмаар гаргана. Уг журамд сонирхогч хүмүүс давж заалдах эрхийг багтаана. Давж заалдсан хүсэлтийг аль болох богино хугацаанд гаргана. Шийдвэрийг хэвээр үлдээсэн тохиолдолд түүнийг тухайн гүрнээс байгуулсан эрх бүхий байгууллага тогтмол, боломжтой бол зургаан сар тутамд хянан үзэж байна.

Тусгай газар заалгаж суурьшсан бөгөөд тиймээс гэрээ орхих шаардлагатай болсон хамгаалагдсан хүмүүс энэхүү конвенцийн 39 дүгээр зүйлийн ашиг тусыг бүрэн эдлэнэ.

**IV ХЭСЭГ**

**ТУСГААРЛАН ХОРИГДОГСДОТой ХАРЬЦАХ ЖУРАМ**

**I бүлэг**

**Нийтлэг заалт**

*79 дүгээр зүйл*

41, 42, 43, 68 болон 78 дугаар зүйлийн заалтын дагуу тусгаарлан хорихоос бусад тохиолдолд мөргөлдөөнд оролцогч талууд хамгаалагдсан хүмүүсийг тусгаарлан хорихгүй.

*80 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсод иргэний эрх зүйн бүрэн чадамжаа хадгалах бөгөөд уг байдалтай нь нийцэж болох холбогдох эрхийг хэрэгжүүлнэ.

*81 дүгээр зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийг тусгаарлан хорьж буй мөргөлдөөнд оролцогч талууд тэднийг үнэ төлбөргүй байлгаж, тэдний эрүүл мэндийн байдлын шаардлагын дагуу эмнэлгийн тусламж үзүүлнэ.

Тусгаарлан хоригдогсод олгох тэтгэмж, хөлс буюу зээлээс эдгээр зардлыг нөхөн төлөх зорилгоор суутгаж болохгүй.

Хэрэв тусгаарлан хоригдогсдын тэжээн тэтгүүлэгч нь амьдрах хангалттай арга хэрэгсэлгүй буюу амьжиргаагаа залгуулж чадахгүй бол олзлогч гүрэн тэдгээр тэжээн тэтгүүлэгчдэд дэмжлэг үзүүлнэ.

*82 дугаар зүйл*

Олзлогч гүрэн тусгаарлан хоригдогсдыг боломжийн хэрээр иргэний харьяалал, хэл, ёс заншлаар нь тусгаарлан хорино. Нэг орны харьяат болох тусгаарлан хоригдогсдыг хэлний ялгаагаар нь салган тусгаарлаж болохгүй.

Тусгаарлан хоригдох хугацааны туршид нэг гэр бүлийн гишүүд, ялангуяа эцэг эх болон хүүхдүүдийг ажил буюу эрүүл мэндийн шалтгаанаар, эсхүл энэ хэсгийн IX бүлгийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор түр шинжтэйгээр салгах шаардлага гарснаас бусад тохиолдолд тусгаарлан хорих нэг газарт хамтад нь байрлуулна. Тусгаарлан хоригдогсод эцэг эхийн асрамжгүйгээр эрх чөлөөтэй үлдсэн хүүхдүүдийг тэдэнтэй хамтад нь тусгаарлан хорихыг хүсч болно.

Нэг гэр бүлийн тусгаарлан хоригдсон гишүүдийг боломжтой бол нэг байранд байрлуулж, гэр бүлийн амьдралаа эрхлэх нөхцөл боломж олгон бусад тусгаарлан хоригдогсдоос тусад нь байрлуулна.

**II бүлэг**

**Тусгаарлан хорих газар**

*83 дугаар зүйл*

Олзлогч гүрэн дайны аюулд онцгой өртөгдөх газар нутагт тусгаарлан хорих газрыг байгуулж болохгүй.

Олзлогч гүрэн хамгаалагч гүрнээр зуучлуулан дайсагнагч гүрэнд тусгаарлан хорих газрын газар зүйн байрлалын талаар хэрэгтэй бүх мэдээллийг дайсагнагч гүрэнд өгнө.

Тухайн байдалд боломжтой бол цэргийн тусгаарлан хорих лагерийг өдрийн цагт агаараас тод харагдахаар “IC” үсгээр тэмдэглэнэ. Гэвч сонирхогч гүрнүүд тэмдэглэгээ хийх аливаа өөр хэлбэрийн талаар тохиролцож болно. Тусгаарлан хорих лагераас өөр ямар ч газрыг тийнхүү тэмдэглэхгүй.

*84 дүгээр зүйл*

Тусгаарлан хоригдогсдыг дайнд олзлогдогчид болон аливаа бусад шалтгаанаар эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсээс тусад нь байрлуулж, тусгай захиргаатай байлгана.

*85 дугаар зүйл*

Олзлогч гүрэн хамгаалагдсан хүмүүсийг тусгаарлан хорьж эхлэхдээ эрүүл ахуй болон эрүүл мэндийн хувьд боломжтой бүх хамгаалалт, түүнчлэн цаг уурын хатуу нөхцөл, дайны аюулын эсрэг үр ашигтай хамгаалалтаар хангах барилга буюу хуаранд байрлуулах явдлыг хангах талаар шаардлагатай бөгөөд боломжтой бүх арга хэмжээг авах үүрэгтэй. Ямар ч тохиолдолд тусгаарлан хорих байнгын газрыг эрүүл мэндэд аюултай газар нутаг буюу цаг уурын нөхцөл нь тусгаарлан хоригдогсдод хортой газарт

байрлуулж болохгүй. Хамгаалалтад байгаа хүнийг тусгаарлан түр хорьж байгаа газар нь эрүүл мэндэд аюултай газар нутаг бөгөөд цаг уурын нөхцөл нь тухайн хүмүүсийн эрүүл мэндэд хортой бүх тохиолдолд нөхцөл байдал боломжтой болмогц түүнийг тусгаарлан хорих илүү тохиромжтой газарт шуурхай шилжүүлнэ.

Байрыг чийгнээс бүрэн хамгаалж, хангалттай халаалт, гэрэлтүүлэгтэй байлгах бөгөөд ялангуяа харанхуй болох болон гэрэл унтраахын хооронд гэрэлтүүлэгтэй байлгана. Унтах хуаран хангалттай цэлгэр, сайн агааржуулалттай байх бөгөөд цаг уурын нөхцөл болон тусгаарлан хоригдогсдын нас, хүйс, эрүүл мэндийн байдлыг харгалзан тэднийг тохирох ор, хангалттай хөнжлөөр хангана.

Тусгаарлан хоригдогсод өдөр болон шөнө эрүүл ахуйн журамд нийцсэн бөгөөд байнга цэвэр байх ариун цэврийн хэрэглэлтэй байна. Тэднийг өдөр тутам нүүр гараа угаах болон өөрийн хувцсаа угаах хангалттай ус, савангаар хангах бөгөөд энэ зорилгоор шаардлагатай хэрэглэл, нөхцөл боломжоор хангана. Мөн шүршүүр, халуун усны газар байгуулна. Тэдэнд угааж цэвэрлэхэд шаардлагатай цаг гаргаж өгнө.

Онцгой буюу түр арга хэмжээ болгон нэг гэр бүлийн гишүүн бус тусгаарлан хоригдсон эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй хамт нэг газарт байрлуулах шаардлагатай бол унтах хуарангаар тусад нь хангаж, тусгаарлан хоригдсон тэдгээр эмэгтэйчүүдийг ариун цэврийн хэрэглэлээр тусад нь хангах үүрэгтэй.

#### *86 дугаар зүйл*

Олзлогч гүрэн шашны урсгалаас нь үл хамааран шашны ёслол үйлдэхэд тохирох байрыг тусгаарлан хоригдсон хүмүүсийн мэдэлд гаргаж өгнө.

#### *87 дугаар зүйл*

Зохих тохиромжтой нөхцөл боломж байгаагаас бусад тохиолдолд тусгаарлан хорих газар бүрт мухлаг байрлуулна. Эдгээр мухлаг нь тусгаарлан хоригдогсдын хувийн аж байдал, тохь тухыг сайжруулахуйц өдөр тутмын хэрэглээний хоол хүнс, барааны зүйл, түүний дотор саван, тамхийг орон нутгийн зах зээлийн үнээс илүүгүй үнээр худалдаж авах боломжийг тэдэнд олгоно.

Мухлагийн олсон ашгийг тусгаарлан хорих газар бүрт байгуулах халамжийн санд шилжүүлж, тусгаарлан хорих ийм газарт байгаа тусгаарлан хоригдогсдын эрх ашигт зориулан зарцуулна. 102 дугаар зүйлд заасан Тусгаарлан хоригдогсдын хороо нь мухлагийн үйл ажиллагаа болон дээрх сангийн зарцуулалтыг шалгах эрхтэй.

Тусгаарлан хорих газрыг хаавал тусламжийн сангийн үлдэгдлийг өөр газарт байрлах тухайн нэг үндэстний тусгаарлан хоригдогсдын тусгаарлан хорих газрын халамжийн санд шилжүүлэх, эсхүл хэрэв тийм газар байхгүй бол олзлогч гүрний хамгаалалтад байгаа бүх тусгаарлан хоригдогсдын ашиг тусын тулд зарцуулагдах халамжийн төв санд шилжүүлнэ. Нийтээр суллах тохиолдолд сонирхогч гүрний хооронд энэ талаар аливаа эсрэг хэлэлцээр байхгүй бол дээрх ашгийг олзлогч гүрэнд үлдээнэ.

*88 дугаар зүйл*

Агаарын довтолгоо, дайны бусад аюулд өртөгдөхүйц тусгаарлан хорих бүх газарт шаардлагатай хамгаалалтаар хангахуйц тооны болон бүтцийн хоргодох байр байгуулна. Түгшүүрийн дохио өгсөн үед дээр дурдсан аюулаас хуарангаа хамгаалахаар үлдэх хүмүүсээс бусад бүх тусгаарлан хоригдогсад хоргодох байранд аль болох түргэн орох боломжтой байна. Хүн амын тусын тулд авах аливаа арга хэмжээг тэдэнд мөн хэрэглэнэ.

Тусгаарлан хорих газарт гал түймрийн аюулаас сэргийлэх зохих бүх арга хэмжээг авах ёстой.

**III бүлэг**

**Хоол хүнс, хувцас**

*89 дүгээр зүйл*

Тусгаарлан хоригдогсдын өдөр тутмын хоол нь тэдний эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах, тэжээлийн дутагдал үүсэхээс урьдчилан сэргийлэхэд тоо хэмжээ, чанар, төрөл зүйлийн хувьд хангалттай байна. Тусгаарлан хоригдогсдын заншсан хоолны дэглэмийг харгалзана.

Тусгаарлан хоригдогсад мөн өөрт байгаа хүнсний аливаа нэмэлт бүтээгдэхүүнээр өөрсөддөө хоол хийх хэрэгслээр хангагдана.

Тусгаарлан хоригдогсдыг хангалттай ундны усаар хангана. Тамхи татахыг зөвшөөрнө.

Ажил хийж буй тусгаарлан хоригдогсад хийж байгаа ажлынхаа төрөлд нийцсэн хэмжээний нэмэлт хоол авна.

Жирэмсэн, төрсөн эмэгтэйчүүд, арван таваас доош насны хүүхдүүдэд тэдний бие махбодийн хэрэгцээнд нийцүүлэн нэмэлт хоол өгнө.

*90 дүгээр зүйл*

Хамгаалалатад авахад тусгаарлан хоригдогсдод шаардлагатай хувцас, гутал, солих дотуур хувцастай байх, түүнчлэн цашид шаардлагатай бол бусад зүйлийг авах бүх нөхцөл боломжийг олгоно. Олзлогч гүрэн хэрэв тусгаарлан хоригдогсдод цаг уурын нөхцөлд тохирсон хувцас хүрэлцэхгүй, түүнчлэнд аливаа тийм хувцас авч чадахгүй байвал тэднийг хувцсаар үнэ төлбөргүй хангана.

Олзлогч гүрнээс тусгаарлан хоригдогсдод олгох хувцас болон тэдний өөрсдийнх нь хувцасны гадна тавих тэмдэг нь гутаан доромжлох, доог тохуу хийхээр байж болохгүй.

Ажил хийж байгаа хүмүүс ажлын шинж чанараас хамааран шаардлага гарах бүрийд ажлын тохирох хувцас, түүний дотор хамгаалах хувцас авна.

#### **IV бүлэг**

#### **Эрүүл ахуй, эмнэлгийн тусламж**

##### *91 дүгээр зүйл*

Тусгаарлан хорих газар бүр тусгаарлан хоригдогсад шаардлагатай тусламж болон зохих хоол авч болох мэргэжлийн эмчийн удирдлаган дор ажиллах зохих тусгай өрөөтэй байна. Халдварт, эсхүл сэтгэл мэдрэлийн өвчний тохиолдолд тусгаарлах өрөө байгуулна.

Төрөх дөхсөн эмэгтэйчүүд, түүнчлэн хүндээр өвчилсөн буюу эрүүл мэндийн байдал нь тусгай эмчилгээ, мэс засал, хэвтэж эмчлүүлэх шаардлагатай тусгаарлан хоригдогсдыг зохих эмчилгээ хийж чадах аливаа байгууллага хүлээн авах ёстой бөгөөд тэд нийт хүн амд үзүүлдгээс дутуугүй тусламж авна.

Тусгаарлан хоригдогсад аль болох өөрийн улсын харьяат эмнэлгийн ажилтнаас тусламж авбал зохино.

Тусгаарлан хоригдогсад эмнэлгийн байгууллагад үзүүлэхээр очиход нь саад хийж болохгүй. Олзлогч гүрний эмнэлгийн байгууллага эмчилгээ хийлгэсэн тусгаарлан хоригдогч бүрт хүсэлтээр нь тэдний өвчин буюу гэмтлийн шинж, эмчилгээний хугацаа, шинж чанарыг харуулсан албан ёсны гэрчилгээ олгоно. Гэрчилгээний нэг хувийг 140 дүгээр зүйлд заасан Төв агентлагт хүргүүлнэ.

Тусгаарлан хоригдогсдод эмчилгээг үнэ төлбөргүй үзүүлнэ, түүний дотор тусгаарлан хоригдогсдын хэвийн эрүүл мэндийг хангахад шаардагдах аливаа хэрэгсэл, тухайлбал хиймэл шүд, бусад хиймэл эрхтэн, нүдний шилийг үнэ төлбөргүй олгоно.

##### *92 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсдыг наад зах нь сард нэг удаа эрүүл мэндийн үзлэгт оруулна. Үзлэгийн зорилго нь тухайлбал тусгаарлан хоригдогсдын эрүүл мэндийн ерөнхий байдал, хооллолт, ариун цэврийг хянах бөгөөд халдварт өвчин, ялангуяа сүрьеэ, хумхаа, бэлгийн замын халдварт өвчнийг илрүүлэхэд оршино. Энэ үзлэгт ялангуяа тусгаарлан хоригдогч бүрийн биеийн жинг хэмжиж, наад зах нь жилд нэгээс доошгүй удаа рентгент харах нь энэ үзлэг багтана.

#### **V бүлэг**

#### **Шашны, оюуны болон биеийн тамирын үйл ажиллагаа**

##### *93 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсд олзлогч эрх бүхий байгууллагаас тогтоосон сахилгын журмыг дагаж мөрдсөн нөхцөлд өөрийн шашны зан үйлийг гүйцэтгэх, түүний дотор өөрийн шүтлэгийн мөргөлд оролцох эрх чөлөөг бүрэн эдлэнэ.

Тусгаарлан хоригдсон шашны санваартанд сүсэг нэгтнийхээ дунд үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулахыг зөвшөөрнө. Эл зорилгоор олзлогч гүрэн нь эх хэл нэгтэй, нэг шашин шүтлэгт хамаардгийг нь харгалзан тусгаарлан хоригдогсдыг тусгаарлан хорих янз бүрийн газарт тэднийг шударга хуваарилах явдлыг хангана. Хэрэв ийм санваартан хэт цөөн байвал олзлогч гүрэн тэдэнд нэг газраас нөгөө газарт очиход шаардлагатай нөхцөл боломж олгох, түүний дотор тээврийн хэрэгслээр хангах бөгөөд эмнэлэгт байгаа тусгаарлан хоригдогсдыг эргэх зөвшөөрөл олгоно. Шашны санваартан тусгаарлан хоригдогсод байгаа орны шашны байгууллага болон боломжтой бол олон улсын адил шашны байгууллагатай өөрийн үйл ажиллагааны талаар захидал бичгээр чөлөөтэй харилцана. Ийм захидал харилцааг 107 дугаар зүйлд дурдсан тоо хэмжээнд багтана гэж үзэхгүй. Гэвч энэ нь 112 дугаар зүйлийн заалтад захирагдана.

Тусгаарлан хоригдогсод өөрийн шашны санваартны тусламж авах боломжгүй, эсхүл ийм санваартан хэт цөөн байгаа нөхцөлд орон нутгийн адил шашны байгууллага нь олзлогч гүрэнтэй тохиролцон тусгаарлан хоригдогсдын шашны санваартан, эсхүл хэрэв шашны урсгалын байр сууринаас авч үзэхэд боломжтой бол төсөөтэй шашны санваартан буюу шашны мэдлэг бүхий сүсэгтэнг томилж болно. Төсөөтэй шашны санваартан буюу шашны мэдлэг бүхий сүсэгтэн хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь олгосон нөхцөл боломжийг эдлэнэ. Тийнхүү томилогдсон хүмүүс сахилга, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс олзлогч гүрний тогтоосон бүх журмыг дагаж мөрдөнө.

#### *94 дүгээр зүйл*

Олзлогч гүрэн тусгаарлан хоригдогсдын дунд оюуны, боловсролын, амралт цэнгээний сонирхол, спорт, тоглоомыг хөхиүлэн дэмжих, чингэхдээ эдгээр арга хэмжээнд оролцох эсэх сонголтыг тэдэнд олгоно. Тухайн гүрэн нь эдгээрийг хэрэгжүүлэх талаар боломжтой бүх арга хэмжээ, тухайлбал тохиромжтой байраар хангах арга хэмжээ авна.

Тусгаарлан хоригдогсдод үргэлжлүүлэн суралцах буюу шинэ хичээл заах талаар зохих бүх нөхцөл боломжийг олгоно. Хүүхэд болон өсвөрийн үеийнхний суралцах явдлыг хангах бөгөөд тэдэнд тусгаарлан хорих газарт буюу түүнээс гадна сургуульд явахыг зөвшөөрнө.

Тусгаарлан хоригдогсдод биеийн тамирын дасгал хийх, спортоор хичээллэх, гадаа тоглох боломж олгоно. Эл зорилгоор тусгаарлан хорих бүх газарт хангалттай хэмжээний задгай талбай гаргаж өгнө. Хүүхэд болон өсвөрийн үеийнхэнд зориулан тоглоомын тусгай талбай гаргаж өгнө.

#### *95 дугаар зүйл*

Олзлогч гүрэн тусгаарлан хоригдогсдоор хэрэв тэд өөрсдөө хүсээгүй бол ажил хийлгэж болохгүй. Тусгаарлан хоригдоогүй хамгаалалтад байгаа хүн албадан хөдөлмөр хийвэл энэхүү конвенцийн 40 буюу 51 дүгээр зүйлийг зөрчих бөгөөд доромжлох буюу гутаах шинжтэй ажил хийлгэхийг ямар ч тохиолдолд хориглоно.

Зургаан долоо хоног ажилласны дараа тусгаарлан хоригдогсод найм хоногийн өмнө урьдчилан мэдэгдэл өгөх нөхцөлөөр ажлаа хэдийд ч орхих эрхтэй.

Эдгээр заалт нь тусгаарлан хоригдсон эмч, шүдний эмч, эмнэлгийн бусад ажилтныг хамт тусгаарлан хоригдогсдынх нь өмнөөс мэргэжлийн дагуу ажиллуулах, эсхүл тусгаарлан хоригдогсдыг тусгаарлан хорих газарт захиргааны болон дэг журам сахиулах ажилд авч, эдгээр хүнд гал зуух буюу аж ахуйн бусад ажил даалгах, эсхүл тусгаарлан хоригдогсдод агаарын довтолгоо буюу дайны бусад аюулаас хамгаалахтай холбоотой үүрэг хүлээлгэх талаар тэднээс шаардах олзлогч гүрний эрхэд саад болохгүй. Гэвч эмнэлгийн албан тушаалтны дүгнэлтээр бие бялдрын хувьд хийх боломжгүй ажил гүйцэтгэхийг тусгаарлан хоригдогчоос шаардаж болохгүй.

Олзлогч гүрэн хөдөлмөрийн бүх нөхцөл, эмнэлгийн тусламж, цалин хөлс, түүнчлэн ажил хийж буй бүх тусгаарлан хоригдогч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний хохирлын нөхөн төлбөр авах явдлыг хангах талаар бүрэн хариуцлага хүлээнэ. Дээр дурдсан хөдөлмөрийн нөхцөл, нөхөн төлбөрт хэрэглэх жишиг нь үндэсний хууль тогтоомж, түүнчлэн тогтсон дадалтай нийцсэн байх бөгөөд эдгээр жишиг нь адил газар нутагт адилхан ажил хийсний төлөө авдгаас ямар ч тохиолдолд доргүй байна. Хийсэн ажлын хөлсийг тусгаарлан хоригдогсод, олзлогч гүрэн болон тухайн тохиолдолд олзлогч гүрнээс өөр ажил олгогчдын хооронд тусгаарлан хоригдогсдыг үнэ төлбөргүй тэжээн тэтгэж, эрүүл мэндийн байдалд нь шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлж байхаар байгуулсан тусгай хэлэлцээрээр шударга үндсэн дээр тодорхойлно. Энэ зүйлийн гурав дахь догол мөрд дурдсан ангиллын ажлыг байнга хийхээр томилогдсон тусгаарлан хоригдогсдод олзлогч гүрэн шударга хөлс олгоно. Ийнхүү томилогдсон тусгаарлан хоригдогсдын хөдөлмөрийн нөхцөл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ нь адил газар нутагт адилхан ажилд олгодгоос доргүй байна.

#### *96 дугаар зүйл*

Ажлын бүх хэсэг, баг нь тусгаарлан хорих газрын бүрэлдүүн байж, түүнээс хамаарна. Олзлогч гүрний холбогдох эрх бүхий байгуулага болон тусгаарлан хорих газрын захирагч нь энэхүү конвенцийн заалтыг ажлын хэсэг, багаар мөрдүүлэх явдлыг хариуцна. Захирагч нь өөрт захирагдах ажлын хэсэг, багийнхны жагсаалтыг цаг тухайд нь хөтөлж, түүнийхээ талаар хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо, хүмүүнлэгийн бусад байгууллагын тусгаарлан хорих газарт ирж болох төлөөлөгчдөд мэдээлж байна.

### **VI бүлэг**

#### **Хувийн эд хөрөнгө, санхүүгийн нөөц**

#### *97 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсдод хувийн хэрэглээнд ашиглах зүйлсийг өөртөө байлгахыг зөвшөөрнө. Тэдэнд байгаа мөнгө, чек, бонд зэрэг зүйлс, түүнчлэн үнэт зүйлсийг гагцхүү тогтоосон журамд нийцүүлэн гаргуулан авч болно. Эдгээр зүйлийг гаргуулан авсан талаар тодорхой баримт өгнө.

98 дугаар зүйлд заасны дагуу тусгаарлан хоригдогч бүрийн нэрийн дансанд мөнгө шилжүүлнэ. Энэ мөнгийг өмчлөгч болох тусгаарлан хоригдогч оршин байгаа нутаг дэвсгэрийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар шаардаагүй, эсхүл тусгаарлан хоригдогч зөвшөөрөөгүй бол өөр валютад хөрвүүлж болохгүй.

Хувийн болон сэтгэл санааны хувьд хамгийн үнэт зүйлсийг гаргуулан авч болохгүй.

Тусгаарлан хоригдсон эмэгтэй хүнийг гагцхүү эмэгтэй хүн нэгжинэ.

Тусгаарлан хоригдогсдыг суллах буюу эх оронд нь буцаахад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу олзлогч гүрний авч үлдэх аливаа зүйл буюу мөнгөнөөс бусад тусгаарлан хоригдох хугацаанд тэднээс гаргуулан авсан бүх зүйл, мөнгө буюу бусад үнэт зүйлийг өгөх бөгөөд тэд 98 дугаар зүйлийн дагуу нэрийн дансанд байгаа аливаа мөнгөний үлдэгдлийг бэлнээр авна. Хэрэв тусгаарлан хоригдогчийн эд хөрөнгийг ийнхүү авч үлдэх бол түүнийг өмчлөгч энэ талаар тодорхой баримт авна.

Тусгаарлан хоригдогсод байгаа гэр бүлийн буюу хувийн баримт бичгийг баримт өгөхгүйгээр гаргуулан авч болохгүй. Тусгаарлан хоригдогсдыг хэдийд ч хувийн баримт бичиггүй орхиж болохгүй. Хэрэв тэдэнд ийм баримт бичиг байхгүй бол тусгаарлан хорих хугацаа дуусах хүртэл хувийн баримт бичиг нь болох тусгай баримт бичгийг олзлогч эрх бүхий байгууллагаас олгоно.

Тусгаарлан хоригдогсод эд зүйл худалдан авах зорилгоор өөртөө тодорхой хэмжээний бэлэн мөнгө буюу бараа худалдан авах тасалбартай байж болно.

#### *98 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдсон бүх хүн тамхи, ариун цэврийн хэрэглэл зэрэг бараа, бусад зүйл худалдан авахад хангалттай тэтгэмж байнга авна. Ийм тэтгэмж нь зээллэг буюу худалдан авах тасалбарын хэлбэртэй байж болно.

Түүгээр зогсохгүй тусгаарлан хоригдогсод өөрийг нь харьяалах гүрэн, хамгаалагч гүрнүүд, тэдэнд тусламж үзүүлж болох байгууллага буюу өөрсдийн гэр бүлээс тэтгэмж, мөн олзлогч гүрний хуульд нийцүүлэн өөрсдийн эд хөрөнгийн орлогыг авч болно. Өөрийг нь харьяалах гүрнээс олгож буй тэтгэмжийн хэмжээ нь тусгаарлан хоригдогсдын ангилал (тэнхэлгүй, өвчтэй, жирэмсэн эмэгтэйчүүд гэх мэт) бүрт адил байх боловч тухайн гүрэн буюу олзлогч гүрэн энэхүү конвенцийн 27 дугаар зүйлээр хориглосон тусгаарлан хоригдогсдыг алагчилах үндсэн дээр хуваарилж болохгүй.

Олзлогч гүрэн тусгаарлан хоригдогч бүрийн нэр дээр байнгын данс нээх бөгөөд энэ дансанд энэ зүйлд заасан тэтгэмж, ажлын хөлс, авсан мөнгөний гуйвуулгыг тухайн хүмүүсээс гаргуулан авсан бөгөөд тусгаарлан хоригдсон нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу хэрэглэж болох мөнгөн дүнгийн хамт шилжүүлнэ. Тусгаарлан хоригдогсод гэр бүл, бусад тэжээн тэтгүүлэгчдээ мөнгө шилжүүлэх талаар уг нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцэх нөхцөл боломжийг олгоно. Тэд олзлогч гүрний тогтоосон хязгаарын дотор хувийн зардалд шаардлагатай мөнгийг данснаасаа авч болно. Тэдэнд өөрсдийн данстай танилцах болон дансны хуулбар хийж авах боломжит нөхцөл боломжийг ямагт олгоно. Дансны байдлыг хамгаалагч гүрэнд хүсэлтээр нь мэдээлэх бөгөөд тусгаарлах хоригдогч шилжих тохиолдолд дансыг нь хамт шилжүүлнэ.



## **VII бүлэг**

### **Захиргаа, сахилгын тухай**

#### *99 дүгээр зүйл*

Тусгаарлан хорих газар бүр олзлогч гүрний байнгын зэвсэгт хүчин, эсхүл иргэний байнгын захиргаанаас сонгосон хариуцлагатай албан тушаалтны удирдлаган дор байна. Тусгаарлах хорих газрыг хариуцах албан тушаалтан нь энэхүү конвенцийн өөрийн орны албан ёсны хэл буюу албан ёсны хэлний аль нэгээр хэвлэгдсэн хувьтай байх ёстой бөгөөд түүнийг хэрэглэхийг хариуцна. Тусгаарлан хоригдогсдыг хянах ажилтанд энэхүү конвенцийн заалт, түүнчлэн түүнийг хэрэглэх талаар авах захиргааны арга хэмжээний талаар заана.

Энэхүү конвенцийн эх бичвэр болон дээрх конвенцийн дагуу байгуулсан тусгай хэлэлцээрийн эх бичвэрийг тусгаарлан хоригдогсдын ойлгох хэлээр бичиж тусгаарлан хорих газар дотор өлгөх, эсхүл Тусгаарлан хоригдогсдын хорооны мэдэлд байлгана.

Аливаа төрлийн журам, тушаал, зарлал, хэвлэлийг тусгаарлан хоригдогсдод мэдээлж тусгаарлан хорих газар дотор тэдний ойлгох хэлээр бичиж өлгөнө.

Тусгаарлан хоригдогсдод зориулж гаргасан бүх тушаал, захирамжийг мөн адил тэдний ойлгох хэлээр өгнө.

#### *100 дугаар зүйл*

Тусгаарлан хорих газар дахь сахилгын дүрэм нь хүмүүнлэгийн зарчимд нийцэж байх бөгөөд түүнд тэдний эрүүл мэндэд аюултай буюу бие махбодийн буюу сэтгэл санааны талаар дарамт учруулах журам ямар ч тохиолдолд багтах ёсгүй. Хүний биед тэмдэг шивэх, тамгалах зэргээр таних тэмдэг хийхийг хориглоно.

Ялангуяа, удаан хугацаагаар зогсоох болон нэр дуудан бүртгэх, залхаах зорилгоор дасгал хийлгэх, цэргийн дасгал, сургууль хийлгэх, хоолыг нь хасахыг хориглоно.

#### *101 дүгээр зүйл*

Тусгаарлан хоригдогсод мэдэлд нь байгаа эрх бүхий байгууллагадаа тэдний хувьд тогтоосон тусгаарлан хорих нөхцөлийн талаар гомдол гаргах эрхтэй.

Тэд мөн тусгаарлан хоригдож буй нөхцөлийн талаар гомдолтой байж болох аливаа асуудлаар ямар нэг хязгаарлалтгүйгээр Тусгаарлан хоригдогсдын хороогоор дамжуулан, эсхүл хэрэв шаардлагатай гэж үзвэл хамгаалагч гүрний төлөөлөгчдөд шууд хандах эрхтэй.

Эдгээр өргөдөл, гомдлыг нэн даруй ямарваа өөрчлөлтгүйгээр дамжуулах бөгөөд өргөдөл, гомдол нь үндэслэлгүй байсан ч ямарваа шийтгэл хүлээлгэх үндэс болохгүй.

Тусгаарлан хоригдогсдын хорооноос тусгаарлан хорих газрын нөхцөл байдал болон тусгаарлан хоригдогсдын хэрэгцээний талаар тогтмол илтгэлийг хамгаалагч гүрний төлөөлөгчдөд илгээж болно.

*102 дугаар зүйл*

Тусгаарлан хорих газар бүрт тусгаарлан хоригдогсод олзлогч болон хамгаалагч гүрнүүд, Олон улсын улаан загалмайн хороо болон тэдэнд тусламж үзүүлж болох аливаа өөр байгууллагын өмнө тэднийг төлөөлөх эрх бүхий хорооны гишүүдийг нууц санал хураалтаар зургаан сар тутамд чөлөөтэй сонгоно. Хорооны гишүүдийг дахин сонгож болно.

Ийнхүү сонгогдсон тусгаарлан хоригдогсод тэднийг сонгосон олзлогч эрх бүхий байгууллага батласны дараа үүрэгт ажилдаа орно. Хорооны гишүүдийг батлахаас татгалзсан буюу чөлөөлсөн шалтгааныг сонирхогч хамгаалагч гүрнүүдэд мэдэгдэнэ.

*103 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсдын хороо нь тусгаарлан хоригдогсдын бие махбодь, оюун санаа, оюун ухааны сайн сайхны төлөө дэмжлэг үзүүлнэ.

Тусгаарлан хоригдогсод, тухайлбал, хоорондоо харилцан туслалцаа үзүүлэх байгууллага байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд энэ байгууллага нь хороодын эрх хэмжээнд энэхүү конвенцийн бусад заалтын дагуу тэдэнд хүлээлгэсэн тусгай үүргээс гадна байх болно.

*104 дүгээр зүйл*

Тусгаарлан хоригдогсдын хорооны гишүүдийн хүлээсэн үүргийг гүйцэтгэхэд илүү хүндрэл учруулахаар байвал аливаа өөр ажил хийхийг тэднээс шаардаж болохгүй.

Тусгаарлан хоригдогсдын хорооны гишүүд тусгаарлан хоригдогсод дотроос шаардлагатай байж болох туслахыг томилж болно. Тэдэнд шаардлагатай бүх материаллаг боломж нөхцөл, ялангуяа үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай чөлөөтэй хөдлөх (ажлын хэсэг, багт очих, ачаа хүлээн авах гэх мэт) тодорхой эрх чөлөө олгоно.

Олзлогч эрх бүхий байгууллага, хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо, тэдний төлөөлөгчид болон тусгаарлан хоригдогсод тусламж үзүүлдэг байгууллагатай шуудангаар болон цахилгаан холбоогоор харилцах бүх боломж нөхцөлийг Тусгаарлан хоригдогсдын хорооны гишүүдэд мөн адил олгоно. Ажлын баг дахь Хорооны гишүүд тусгаарлан хорих үндсэн газартай адил харилцаа холбооны нөхцөл боломж эдэлнэ. Ийм харилцаа холбоог хязгаарлахгүй бөгөөд 107 дугаар зүйлд дурдсан тоонд багтана гэж үзэхгүй.

Тусгаарлан хоригдогсдын хорооны шилжсэн гишүүдэд дараагийн хүндээ ажлаа хүлээлгэж өгөх боломжит хугацаа өгнө.

## **VIII бүлэг**

### **Гадаад ертөнцтэй харилцах**

#### *105 дугаар зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийг тусгаарлан хорьсон даруй олзлогч гүрэн нь энэ бүлгийн заалтыг биелүүлэх талаар авсан арга хэмжээний тухай эдгээр хүмүүс, тэдний харьяалагдаж байгаа гүрэн болон тэдний хамгаалагч гүрэнд мэдээлнэ. Олзлогч гүрэн эдгээр арга хэмжээнд цаашид оруулсан аливаа өөрчлөлтийн талаар сонирхогч талуудад мөн адил мэдээлнэ.

#### *106 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдсон даруй, эсхүл тусгаарлан хорих газарт ирснээс хойш цаад зах нь нэгээс илүүгүй долоо хоногийн дараа, түүнчлэн өвчлөх, тусгаарлан хорих өөр газар буюу эмнэлэгт шилжсэн тохиолдолд мөн адил нэг талаар гэр бүлдээ шууд, нөгөө талаар 140 дүгээр зүйлд заасан Төв агентлагт, боломжтой бол энэхүү конвенцид хавсаргасан загвартай адил тусгаарлан хорих баримтыг илгээж саатуулагдсан тухайгаа, түүнчлэн хаяг болон эрүүл мэндийн байдлынхаа талаар мэдээлэх боломжийг тусгаарлан хоригдогч бүрт олгоно. Энэ баримтыг аль болох шуурхай илгээх бөгөөд түүнийг ямар нэгэн байдлаар саатуулж болохгүй.

#### *107 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсод захидал, ил захидал илгээх, хүлээн авахыг зөвшөөрнө. Хэрэв олзлогч гүрэн тусгаарлан хоригдогч бүрийн илгээх захидал, ил захидлын тоог хязгаарлах шаардлагатай гэж үзвэл энэ тоо нь сард хоёроос доошгүй захидал, дөрвөөс доошгүй ил захидал байх бөгөөд эдгээрийг энэхүү конвенцид хавсаргасан загвартай аль болох нийцэхээр үйлдсэн байна. Хэрэв тусгаарлан хоригдогсод ирж байгаа захидал харилцааг хязгаарлах ёстой бол ийм хязгаарлалтыг зөвхөн тухайн тусгаарлан хоригдогсдыг харьяалж байгаа гүрэн, боломжтой бол олзлогч гүрний хүсэлтээр гаргасан тушаалаар тавьж болно. Ийм захидал, ил захидлыг боломжит хугацаанд түргэн явуулах бөгөөд тэдгээрийг сахилгын хариуцлагын шалтгаанаар хойшлуулж буюу саатуулж болохгүй.

Удаан хугацаагаар ямарваа мэдээлэлгүй байгаа, эсхүл төрөл садангаасаа мэдээлэл сураг авах буюу ердийн шуудангаар тэдэнд мэдээлэл сураг өгөх бололцоогүй тусгаарлан хоригдогсод, түүнчлэн гэр орноосоо үлэмж хол байгаа тусгаарлан хоригдогсод өөрийн мэдэлд байгаа мөнгөөр төлбөр хийн цахилгаан мэдээ илгээхийг зөвшөөрнө. Яаралтай гэж үзсэн тохиолдолд тэд мөн адил энэ заалтын хөнгөлөлтийг эдэлж болно.

Тусгаарлан хоригдогсдын захидал харилцаа ер нь тэдний хэлээр явагдана. Мөргөлдөөнд оролцогч талууд захидал харилцааг өөр хэлээр явуулахыг зөвшөөрч болно.

*108 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсдод тухайлбал хүнсний бүтээгдэхүүн, хувцас, эмнэлгийн зүйл, түүнчлэн тэдний хэрэгцээг хангах сүсэг бишрэл, боловсрол буюу амралт цэнгээний шинжтэй ном, эд зүйлс бүхий хувийн илгээмж буюу хамтын ачааг шуудангаар буюу аливаа бусад аргаар авахыг зөвшөөрнө. Ийм ачаа нь олзлогч гүрнийг энэхүү конвенцийн дагуу ногдож байгаа үүргээс хэрхэвч чөлөөлөхгүй.

Цэргийн шаардлагаас болж ийм ачааны тоог хязгаарлах болбол энэ тухай хамгаалагч гүрэн болон Олон улсын улаан загалмайн хороонд, эсхүл тусгаарлан хоригдогсдод тусламж үзүүлдэг бөгөөд ийм ачаа илгээх үүрэгтэй аливаа өөр байгууллагад зохих мэдэгдэл өгнө.

Хувийн илгээмж болон хамтын ачаа илгээх нөхцөлийг шаардлагатай бол сонирхогч гүрнүүдийн хоорондын тусгай хэлэлцээрээр тогтоох бөгөөд эдгээр гүрэн нь тусгаарлан хоригдогсдод тусламжийн илгээмж авахыг ямар ч тохиолдолд саатуулж болохгүй. Хувцас, хүнсний бүтээгдэхүүн бүхий илгээмжид ном хийж болохгүй. Эмнэлгийн тусламжийн илгээмжийг хамтын илгээмжээр илгээнэ.

*109 дүгээр зүйл*

Мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд тусламжийн хамтын ачааг хүлээн авах, түгээх нөхцөлийн талаар тусгай хэлэлцээр байхгүй бол энэхүү конвенцид хавсаргасан хамтын тусламжийн тухай журмыг хэрэглэнэ.

Дээр заасан тусгай хэлэлцээр нь тусгаарлан хоригдогсдод зориулсан тусламжийн хамтын ачааг авах, түгээх болон хүлээн авагчдын ашиг сонирхолд нийцүүлэн захиран зарцуулах талаархи Тусгаарлан хоригдогсдын хорооны эрхийг ямар ч тохиолдолд хязгаарлахгүй. Эдгээр хэлэлцээр нь хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо, эсхүл тусгаарлан хоригдогсдод тусламж үзүүлж, хамтын ачааг илгээх үүрэг бүхий аливаа өөр байгууллагын төлөөлөгчдийн ачааг хүлээн авагчдад түгээхийг хянах эрхийг хязгаарлахгүй.

*110 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсдод зориулсан тусламжийн бүх ачааг импортын, гаалийн болон бусад татвараас чөлөөлнө.

Бусад орноос тусгаарлан хоригдогсдод хаягласан, эсхүл тусгаарлан хоригдогсдын шуудангийн салбараар явуулсан шуудангаар шууд, эсхүл 136 дугаар зүйлд заасан Лавлах товчоо болон 140 дүгээр зүйлд заасан Лавлах төв агентлагаар дамжуулан илгээсэн бүх зүйл, түүний дотор илгээмжээр илгээсэн тусламжийн илгээмж болон мөнгөн гуйвуулгыг илгээгч болон хүлээн авагч орны аль алинд, түүнчлэн дамжин өнгөрүүлэх оронд шуудангийн бүх хураамжаас чөлөөлнө. Энэ үүднээс 1947 оны Дэлхийн шуудангийн конвенц болон лагерь буюу энгийн шоронд байгаа дайсны талын иргэдийн төлөө байгуулсан Дэлхийн шуудангийн холбооны хэлэлцээрээр шуудангийн хураамжаас чөлөөлсөн нь энэхүү конвенцоор хамгаалдаг бусад хүмүүст хамаарна. Дээр дурдсан хэлэлцээрт гарын үсэг зураагүй улс адил нөхцөл байдалд хураамжаас чөлөөлөх үүрэгтэй.

Тусгаарлан хоригдогсдод зориулсан бөгөөд жин буюу аливаа бусад шалтгаанаар шуудангийн салбараар илгээх боломжгүй тусламжийн ачааг тээвэрлэх зардлыг олзлогч гүрэн өөрийн хяналтад байгаа бүх нутаг дэвсгэрт хариуцна. Энэхүү конвенцийн тал болох бусад гүрэн тээвэрлэлтийн зардлыг тус тусын нутаг дэвсгэрт хариуцна.

Дээрх догол мөрд хамрагдаагүй ачааг тээвэрлэхтэй холбогдох зардлыг илгээгч төлнө.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд нь тусгаарлан хоригдогсдын илгээсэн буюу тэдэнд хаягласан цахилгаан мэдээний төлбөрийг боломжийн хэрээр багасгахыг чармайна.

### *111 дүгээр зүйл*

Хэрэв цэргийн ажиллагаа нь холбогдох гүрний 106, 107, 108 болон 113 дугаар зүйлд заасан шуудан, тусламжийн ачааг тээвэрлэх явдлыг хангах үүргээ биелүүлэхэд саад болбол холбогдох хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо буюу мөргөлдөөнд оролцогч талуудын зохих ёсоор зөвшөөрсөн аливаа өөр байгууллага нь уг ачааг тээврийн тохирох хэрэгслээр (төмөр зам, хөдөлгүүрт тээврийн хэрэгсэл, усан онгоц буюу агаарын хөлөг гэх мэт) тээвэрлэх үүрэг хүлээж болно. Эл зорилгоор хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тэднийг ийм тээврийн хэрэгслээр хангах болон хөдөлгөөнийг нь, ялангуяа шаардлагатай нэвтрэх үнэмлэх олгох замаар зөвшөөрөхийг чармайна.

Тээврийн ийм хэрэгслийг мөн дараахь зүйлийг тээвэрлэхэд хэрэглэж болно:

а) 140 дүгээр зүйлд дурдсан Лавлах төв агентлаг болон 136 дугаар зүйлд дурдсан Үндэсний товчооны хооронд солилцох захидал харилцаа, жагсаалт, илтгэл;

б) хамгаалагч гүрэн, Олон улсын улаан загалмайн хороо буюу тусгаарлан хоригдогсдод тусламж үзүүлдэг аливаа өөр байгууллага өөрийн төлөөлөгчид эсхүл мөргөлдөөнд оролцогч талуудтай солилцох тусгаарлан хоригдогсдын талаархи захидал харилцаа, илтгэл.

Эдгээр заалт нь мөргөлдөөнд оролцогч аливаа тал илүүтэй гэж үзвэл тээврийн өөр хэрэгсэл хэрэглэх эрхийг ямар ч байдлаар хязгаарлахгүй бөгөөд харилцан тохиролцсон нөхцөлөөр тээврийн ийм хэрэгсэлд нэвтрэх үнэмлэх олгохыг саатуулахгүй.

Тээврийн ийм хэрэгслийг хэрэглэхтэй холбогдон гарсан зардлыг харьяат нь уг тээвэрлэлтээс ашиг тус хүртэж буй мөргөлдөөнд оролцогч талууд ачааны хувь тэнцүүлэн хариуцна.

### *112 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсдод ирүүлсэн буюу тэдний илгээх захидал, харилцааг шалгах үзлэгийг аль болох богино хугацаанд хийнэ.

Тусгаарлан хоригдогсдод очих илгээмжийн шалгалтыг түүний дотор байгаа барааны чанарыг муудуулахад хүргэх нөхцөл байдалд гүйцэтгэхгүй. Үүнийг хүлээн авагч буюу түүний төлөөний хүнийг байлцуулан гүйцэтгэнэ. Тусгаарлан хоригдогсдод

очих хувийн буюу хамтын илгээмжийг шалгах үзлэг бэрхшээлтэй байна гэсэн шалтгаар саатуулахгүй.

Мөргөлдөөнд оролцогч талуудаас цэргийн буюу улс төрийн шалтгаанаар бүх захидал, харилцааг хориглох нь зөвхөн түр зуурын шинжтэй бөгөөд энэ нь аль болох богино хугацаагаар үргэлжилнэ.

*113 дугаар зүйл*

Олзлогч гүрнүүд тусгаарлан хоригдогсдод ирсэн, эсхүл тэдний илгээх гэрээслэл, итгэмжлэл, бүрэн эрхийн итгэмжлэл буюу бусад аливаа бичиг баримтуудыг хамгаалагч гүрэн буюу 140 дүгээр зүйлд заасан Төв агентлагаар дамжуулан илгээх бүх боломжит нөхцөлийг олгоно.

Бүх тохиолдолд олзлогч гүрнүүд тусгаарлан хоригдогсдын нэрийн өмнөөс ийм бичиг баримтыг эрх зүйн зохих ёсоор үйлдэх, гэрчлэх нөхцөл боломжийг олгож, тухайлбал, хуульчдаас зөвлөлгөө авахыг зөвшөөрнө.

*114 дүгээр зүйл*

Тусгаарлан хорих нөхцөл болон хэрэглэж болох хуульд нийцэж байгаа тохиолдолд олзлогч гүрэн тусгаарлан хоригдогсдод эд хөрөнгөө захиран зарцуулах бололцоо олгох бүх нөхцөл боломжийг олгоно. Эл зорилгоор зайлшгүй шаардлага гарсан болон нөхцөл байдал зөвшөөрч байвал тэдэнд тусгаарлан хоригдож байгаа газраа орхин явахыг дурдсан гүрэн зөвшөөрч болно.

*115 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсод аливаа шүүхийн байцаан шийтгэх ажиллагааны оролцогч болж байгаа бүх тохиолдолд түүний хүссэнээр түүнийг саатуулсан тухай шүүхэд мэдэгдэх бөгөөд хэрэгт бэлтгэх, шүүн таслах буюу шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд түүнийг тусгаарлан хоригдсон шалтгаанаар ямар нэгэн байдлаар хохироохоос урьдчилан сэргийлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг хууль ёсны хүрээнд олзлогч гүрэн авна.

*116 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогч бүрт зочин, ялангуяа ойрын төрөл саданг тогтмол бөгөөд аль болох ойр хугацаанд хүлээж авахыг зөвшөөрнө.

Зайлшгүй шаардлага гарсан, тухайлбал, төрөл садан нас барах буюу ноцтой өвдсөн тохиолдолд тусгаарлан хоригдогсдод гэртээ очихыг боломжийн хирээр зөвшөөрнө.

## IX бүлэг

### Эрүүгийн болон сахилгын шийтгэл

#### 117 дугаар зүйл

Энэ бүлгийн заалтыг мөрдөхийн хамт, тэдний тусгаарлан хоригдож буй нутаг дэвсгэрт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг тусгаарлан хоригдох хугацаанд эрх зүйн зөрчил гаргасан тусгаарлан хоригдогсдод үргэлжлүүлэн хэрэглэнэ.

Нийтлэг хууль, журам буюу тушаалаар тусгаарлан хоригдогсдын хийсэн үйлдэлд шийтгэл оногдуулах, харин ижил үйлдлийг тусгаарлан хоригдогч бус хүмүүс үйлдэх тохиолдолд түүнд шийтгэл оногдуулахгүй байх тохиолдолд ийм үйлдэлд зөвхөн сахилгын шийтгэл оногдуулна.

Тусгаарлан хоригдогсдын хийсэн нэг хэрэгт нэг удаа яллаж, нэгээс илүү шийтгэхгүй.

#### 118 дугаар зүйл

Шүүх буюу эрх бүхий байгууллагууд шийтгэл оногдуулахдаа яллагдагч олзлогч гүрний харьяат биш гэдгийг боломжийн хэрээр анхаарч үзнэ. Тэд тусгаарлан хоригдогсдын хариуцах эрх зүйн зөрчилд оногдуулах ялыг чөлөөтэй хөнгөрүүлэх бөгөөд эл зорилгоор тухайн ялын доод хэмжээг заавал баримтлах үүрэг хүлээхгүй.

Өдрийн гэрэлгүй байранд хорих болон ерөнхийдөө аливаа харгис хэрцгий хэлбэрийг чанд хориглоно.

Сахилгын буюу шүүхийн шийтгэл хүлээсэн тусгаарлан хоригдогсодтой бусад тусгаарлан хоригдогсодтой харьцдагаас өөрөөр харьцахгүй.

Тусгаарлан хоригдогсдыг урьдчилан саатуулсан хугацааг түүнд оногдуулсан цагдан хорих шийтгэлийг оролцуулан аливаа сахилгын буюу шүүхийн шийтгэлээр оногдуулсан хугацаанаас хасна.

Тусгаарлан хоригдогсдын эсрэг үүсгэсэн бүх шүүх ажиллагааны талаарх мэдээллийг тэдгээрийг төлөөлж буй Тусгаарлан хоригдогсдын хороонд мэдэгдэнэ.

#### 119 дүгээр зүйл

Тусгаарлан хоригдогсдод дараахь сахилгын шийтгэлийг хэрэглэнэ:

1. 95 дугаар зүйлийн дагуу тусгаарлан хоригдогсдын гучаас дээшгүй хоногийн хугацаанд авах цалингийн 50 хувиас хэтрэхгүй хэмжээний торгууль;
2. Энэхүү конвенцоор олгосон эрх ямба, тэдэнтэй харьцах давуу байдлыг зогсоох;

3. Суух байраа цэвэрлэхтэй холбогдсон ажлыг өдөр бүр хоёр цагаас дээшгүй хугацаанд хийлгүүлэх;
4. Цагдан хорих шийтгэл.

Сахилгын шийтгэл нь ямар ч нөхцөлд хүнлэг бус, хэрцгий буюу тусгаарлан хоригдогсдын эрүүл мэндэд аюултай байж болохгүй. Тусгаарлан хоригдогсдын нас, хүйс, эрүүл мэндийн байдлыг анхааран үзнэ.

Тусгаарлан хоригдогсдод сахилгын хэд хэдэн зөрчилд хариуцлага хүлээлгэсэн ч, эдгээр зөрчил нь хоорондоо холбоотой эсэхээс үл хамааран аливаа нэг удаагийн шийтгэлийн хугацаа үргэлжилсэн гуч хоногоос ямар ч тохиолдолд хэтрэхгүй.

#### *120 дугаар зүйл*

Оргосны дараа буюу оргохоор завдаж байгаад баригдсан тусгаарлан хоригдогсод энэ эрх зүйн зөрчлийг давтан гаргасан байсан ч тэдэнд энэ үйлдэлд зөвхөн сахилгын шийтгэл оногдуулна.

118 дугаар зүйлийн гурав дахь догол мөрийг баримтлахгүйгээр, оргосон буюу оргохыг завдсанд шийтгүүлсэн тусгаарлан хоригдогсдыг тусгай хяналтад авч болох бөгөөд ийм хяналт нь тусгайлан хорих газарт эдэлдэг байсны адил тэдний эрүүл мэндийн байдалд нөлөөлөхгүй бөгөөд энэхүү конвенцоор олгосон аливаа баталгааг хязгаарлахгүй нөхцөлтэй байна.

Оргох буюу оргохыг завдахад тусалсан буюу турхирсан тусгаарлан хоригдогсдод зөвхөн сахилгын шийтгэл оногдуулна.

#### *121 дүгээр зүйл*

Тусгаарлан хоригдогсдын оргосон хугацаанд гаргасан эрх зүйн зөрчлийг мөрдөх тохиолдолд оргосон буюу оргохыг завдсан нь давтан эрх зүйн зөрчил байсан ч үүнийг хүндрүүлэх нөхцөл байдал гэж үзэхгүй.

Эрх зүйн зөрчилд сахилгын буюу шүүхийн шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэхдээ, ялангуяа оргосон буюу оргохыг завдахтай холбогдсон үйлдлийн хувьд эрх бүхий байгууллагууд нигүүлсэнгүй хандах явдлыг мөргөлдөөнд оролцогч талууд хангана.

#### *122 дугаар зүйл*

Сахилга зөрчсөн үйлдлийг нэн даруй мөрдөж байцаана. Энэ дүрмийг оргосон буюу оргохыг завдсан тохиолдолд мөн хэрэглэнэ. Баригдсан оргосон тусгаарлан хоригдогсдыг аль болох богино хугацаанд эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

Сахилгын зөрчлийн тохиолдолд шүүхийн өмнө цагдан хоригдох хугацааг бүх тусгаарлан хоригдогсдод хамгийн доод хэмжээгээр тогтоох бөгөөд энэ нь арван



дөрвөн хоногоос хэтрэхгүй. Энэ хугацааг ямар ч тохиолдолд цагдан хорих шийтгэлийн хугацаанаас хасна.

Сахилгын зөрчилд шүүхийн өмнө цагдан хоригдож буй тусгаарлан хоригдогсдод 124 болон 125 дугаар зүйлийг хэрэглэнэ.

*123 дугаар зүйл*

Шүүх болон дээд байгууллагуудын эрх хэмжээнд хохирол учруулахгүйгээр сахилгын шийтгэлийг зөвхөн тусгаарлан хоригдогсдын байрласан газрын захирагч буюу хариуцлагатай офицер, эсхүл түүнийг орлож буй албан тушаалтан оногдуулна.

Сахилгын шийтгэл оногдуулахаас өмнө буруутгаж буй тусгаарлан хоригдогсдод түүнийг буруутгаж буй эрх зүйн зөрчлийн талаар тодорхой мэдээлэл өгөх бөгөөд түүнд үйлдлээ тайлбарлах болон өөрийгөө өмгөөлөх боломж олгоно. Тухайлбал, түүнд гэрч дуудах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн орчуулагчийн туслалцаа авахыг зөвшөөрнө. Шийдвэрийг буруутгаж буй хүмүүс болон Тусгаарлан хоригдогсдын хорооны гишүүнийг байлцуулан сонсгоно.

Сахилгын шийтгэл оногдуулах болон түүнийг биелүүлэх хоорондын хугацаа нэг сараас хэтэрч болохгүй.

Тусгаарлан хоригдогсдод сахилгын шийтгэл дахин оногдуулах үед хоёр шийтгэлийн аль нэгийн хугацаа нь арав буюу түүнээс дээш хоног байвал түүнийг биелүүлсэн хугацаанаас хойш наад зах нь гурван хоног өнгөрөх ёстой.

Тусгаарлан хоригдогсод байрласан газрын захирагч оногдуулсан сахилгын шийтгэлийн бүртгэл хөтлөх бөгөөд энэ нь хамгаалагч гүрний төлөөлөгчдийн шалгалтад нээлттэй байна.

*124 дүгээр зүйл*

Тусгаарлан хоригдогсдыг ямар ч тохиолдолд засан хүмүүжүүлэх газарт (шорон, засан хүмүүжүүлэх газар, ганцаарчлан хорих шорон гэх мэт) шилжүүлж сахилгын шийтгэлийг тэнд эдлүүлэхгүй.

Сахилгын шийтгэл эдлүүлэх байр нь эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна, тухайлбал тохиромжтой ор дэвсгэртэй байна. Шийтгэл эдэлж байгаа тусгаарлан хоригдогсдыг өөрсдийгөө цэвэр авч явах бололцоогоор хангана.

Сахилгын шийтгэл эдэлж байгаа эмэгтэй тусгаарлан хоригдогсдыг эрэгтэй тусгаарлан хоригдогсдоос тусдаа хуаранд байрлуулж, эмэгтэй хүний шууд хяналтад байлгана.

*125 дугаар зүйл*

Сахилгын шийтгэл эдэлж байгаа тусгаарлан хоригдогсод дасгал хийх бөгөөд өдөр бүр наад зах нь хоёроос доошгүй цаг цэвэр агаарт гарахыг тэдэнд зөвшөөрнө.

Тэд хүсвэл өдөр бүр эмчийн үзлэгт орохыг тэдэнд зөвшөөрнө. Тэдэнд эрүүл мэндийн нь байдлын шаардлагын дагуу анхаарал тавьж, шаардлагатай тохиолдолд тусгаарлан хорих газрын тусгай өрөөнд, эсхүл эмнэлэгт шилжүүлнэ.

Унших, бичих, түүнчлэн захидал илгээх, хүлээн авахыг тэдэнд зөвшөөрнө. Гэхдээ шийтгэлийн хугацаа дуусах хүртэл тэдэнд илгээмж явуулах болон мөнгө гуйвуулахыг зөвшөөрөхөөс татгалзаж болно. Ийм илгээлтийг Тусгаарлан хоригдогсдын хороонд шилжүүлэх бөгөөд тус хороо нь илгээмжид буй түргэн мууддаг барааг тусгай өрөөнд оруулна.

Сахилгын шийтгэл авсан нэг ч тусгаарлан хоригдогчийг энэхүү конвенцийн 107 болон 143 дугаар зүйлд дурдсан эрхийг үгүйсгэж болохгүй.

#### *126 дугаар зүйл*

71-ээс 76 дугаар зүйлийг олзлогч гүрний үндэсний нутаг дэвсгэрт байгаа тусгаарлан хоригдогсдын эсрэг шүүх ажиллагаанд мөн адилаар хэрэглэнэ.

### **Х бүлэг**

#### **Тусгаарлан хоригдогсдыг шилжүүлэх**

#### *127 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсдыг ямагт хүнлэг ёсоор шилжүүлнэ. Үүнийг галт тэргээр буюу тээврийн бусад хэрэгслээр наад зах нь олзлогч гүрний цэрэг шилжүүлэн нүүлгэхтэй адил нөхцөлтэйгөөр гүйцэтгэнэ. Зайлшгүй арга хэмжээ болгон ийм шилжүүлгийг явганаар гүйцэтгэхэд хүрвэл үүнийг тусгаарлан хоригдогсдын эрүүл мэндийн тохиромжтой байдалтай байхаас наана хийхгүй бөгөөд тэднийг ямар ч тохиолдолд туйлдуулж болохгүй.

Олзлогч гүрэн тусгаарлан хоригдогсдыг шилжүүлэх үед эрүүл мэндийн хэвийн байдалд байлгах хэмжээ, чанар, төрөл зүйлийн хувьд хангалттай ундны ус болон хоол хүнсээр хангах бөгөөд түүнчлэн шаардлагатай хувцас, тохиромжтой байр болон шаардлагатай эмнэлгийн тусламжаар хангана. Олзлогч гүрэн тэднийг шилжүүлэх үед тэдний аюулгүй байдлыг хангахад шаардагдах бүх тохиромжтой арга хэмжээ авч, тэднийг явахаас өмнө шилжүүлсэн бүх тусгаарлан хоригдогсдын жагсаалтыг гаргана.

Өвчтэй, шархтан буюу тэнхэл муутай тусгаарлан хоригдогсод болон төрөх дөхсөн эмэгтэйчүүдэд аялал нь хүндрэлтэй байх тохиолдолд тэдний аюулгүйн байдлын үүднээс зайлшгүй шаардлагатай биш бол тэднийг шилжүүлэхгүй.

Тусгаарлан хоригдогсдын байранд фронтын шугам ойртон ирвэл тэдний үлдэх нь илүү эрсдэлд өртөхөд хүргэхээр биш буюу шилжүүлгийг тэдний аюулгүйн байдлын тохиромжтой нөхцөлд гүйцэтгэхээс бусад нөхцөлд дурдсан газарт байгаа тусгаарлан хоригдогсдыг шилжүүлэхгүй.

Тусгаарлан хоригдогсдыг шилжүүлэх талаар шийдвэр гаргах үед олзлогч гүрэн тэдний ашиг сонирхлыг анхааран үзэх бөгөөд ялангуяа тэднийг эх оронд нь буюу гэрт нь буцаахад учрах хүндрэлийг нэмэгдүүлэх зүйл хийхгүй байх талаар анхаарна.

*128 дугаар зүйл*

Шилжүүлэх тохиолдолд тусгаарлан хоригдогсдод шилжүүлэх талаар болон шуудангийн шинэ хаягийн талаар албан ёсоор мэдэгдэнэ. Тухайн мэдэгдлийг тэдгээр хүмүүс ачаагаа бэлдэх болон ойрын төрөл садандаа мэдэгдэх бололцоо олгохын тулд урьдаар хийнэ.

Хувийн эд хогшил болон тэдэнд ирсэн захидал, харилцаа болон илгээмж авч явахыг тэдэнд зөвшөөрнө. Шилжүүлгийн нөхцөл байдал тийнхүү шаардаж байвал ийм ачааны жинг хязгаарлах боловч үүнд тусгаарлан хоригдогч бүрийн ачаа хорин таван килограмаас илүүгүй байна.

Өмнө нь тэдний тусгаарлан хоригдож байсан газрын хаягаар ирсэн захидал болон илгээмжийг тэдэнд цаг алдалгүй дамжуулна.

Тусгаарлан хорих газрын захирагч Тусгаарлан хоригдогсдын хороотой тохиролцон тусгаарлан хоригдогсдын хамтын эд хөрөнгө болон хоёр дахь догол мөрд заасны дагуу тогтоосон хязгаарлалтын улмаас тусгаарлан хоригдогсдод биедээ авч явж чадахаа байсан хязгаарласан ачааны тээвэрлэлтийг хангах шаардлагатай арга хэмжээ авна.

## **XI бүлэг**

### **Нас баралт**

*129 дүгээр зүйл*

Тусгаарлан хоригдогсдын гэрээслэлийг холбогдох эрх бүхий этгээд аюулгүй байдалд хадгалахаар хүлээн авах бөгөөд тусгаарлан хоригдогч нас барах тохиолдолд гэрээслэлийг түүний нэр заасан хүнд нь цаг алдалгүй өгнө.

Тусгаарлан хоригдогсдын нас баралтыг бүх тохиолдолд эмч гэрчилж, нас баралтын шалтгаан болон нас барсан нөхцөл байдлыг тусгасан нас барсны гэрчилгээ үйлдэнэ.

Нас барсан тухай албан ёсны тэмдэглэлийг тусгаарлан хорих газар байрлаж буй нутаг дэвсгэрт нь хүчин төгөлдөр үйлчилж буй журамд нийцүүлэн үйлдэх бөгөөд ийм тэмдэглэлийн зохих ёсоор баталгаажуулсан хуулбарыг хамгаалагч гүрэн болон 140 дүгээр зүйлд дурдсан Төв агентлагт нэн даруй хүргүүлнэ.

*130 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдогсдод тусгаарлан хоригдох хугацаанд нас барах тохиолдолд олзлогч байгууллагууд тэднийг ёс төртэй, боломжтой бол шашны нь зан үйлийн дагуу оршуулах, булшийг хүндэтгэх, зохих ёсоор хадгалах болон тэдгээрийг хэзээд олж болохуйцаар тэмдэглэх явдлыг хангана.

Нас барсан тусгаарлан хоригдогсдыг тус тусад нь оршуулах бөгөөд зайлшгүй нөхцөл байдлын улмаас нийтийн булшинд оршуулна. Эрүүл ахуйн зайлшгүй

шалтгаан, нас барагсдын шашин шүтлэгийн шаардлага буюу нас барагч өөрөө хүссэн бол цогцсыг чандарлаж болно. Чандарлах тохиолдолд чандарлах нөхцөл байдал болон шалтгааныг нас барсны гэрчилгээнд нарийвчлан заана. Чандрыг аюулгүй байдлын улмаас олзлогч байгууллага хадгалж ойрын төрөл саданд тэдний хүсэлтээр цаг алдалгүй шилжүүлнэ.

Тухайн нөхцөл байдалд боломжтой болмогц, мөн дайтах ажиллагаа дуусмагц олзлогч гүрэн нас барсан тусгаарлан хоригдогсдын булшны жагсаалтыг тэднийг харьяалж байсан гүрнүүдэд 136 дугаар зүйлд заасан Мэдээллийн товчоогоор дамжуулан өгнө. Ийм жагсаалтад нас барсан тусгаарлан хоригдогсдыг хэн болохыг тогтооход шаардлагатай мэдээлэл болон тэдний булшны байрлалыг тодорхой тусгана.

### *131 дүгээр зүйл*

Харгалзагч буюу тусгаарлан хоригдсон хэн нэгэн этгээд, эсхүл өөр этгээдэд алуулсан өююу хүндээр шархдсан гэх сэжиг төрөх, түүнчлэн учир шалтгаан нь мэдэгдэхгүй байгаа нас баралт бүрийн талаар олзлогч гүрэн мөрдөн байцаалтыг даруй эхлүүлнэ.

Энэ талаархи мэдэгдлийг хамгаалагч гүрэнд цаг алдалгүй илгээнэ. Гэрч бүрээс мэдүүлэг авах бөгөөд ийм мэдүүлгүүдийг нэгтгэсэн илтгэл бэлтгэж дурдсан хамгаалагч гүрэнд хүргүүлнэ.

Мөрдөн байцаалтаар нэг буюу түүнээс илүү хүмүүсийг гэм буруутай болохыг тогтоовол холбогдох хүмүүсийг шүүхэд шилжүүлэх бүхий л арга хэмжээг олзлогч гүрэн авна.

## **XII бүлэг**

### **Суллах, эх оронд нь буцаах болон төвийг сахигч оронд байрлуулах**

### *132 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдож буй хүмүүсийг тусгаарлан хорих шаардлагатай болсон шалтгаан байхгүй болонгуут түүнийг олзлогч гүрэн суллана.

Мөргөлдөөнд оролцогч талууд дайтах ажиллагаа үргэлжлэх хугацаанд зарим тусгаарлан хоригдогч, ялангуяа хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд болон нялх болон бага насны хүүхэдтэй эхчүүд, өвчтөн, шархтан болон удаан хугацаагаар саатуулагдсан тусгаарлан хоригдогсдыг суллах, эх оронд нь буцаах, байнга оршин суудаг болон төвийг сахисан оронд хүргэх тухай хэлэлцээр байгуулахыг чармайна.

### *133 дугаар зүйл*

Дайтах ажиллагаа дууссаны дараа аль болох богино хугацаанд тусгаарлан хорихыг дуусгавар болгоно.

Хууль зөрчсөний улмаас шүүхэд шилжиж, сахилгын шийтгэл хүлээх төдийгүй, мөргөлдөөнд оролцогч талын нутаг дэвсгэрт байгаа тусгаарлан хоригдогсдыг шүүн таслах ажиллагаа буюу ялаа эдэлж дуусгах хүртэл нөхцөл байдал тийнхүү шаардвал албадан саатуулна. Энэ нь урьд хорих ял шийтгүүлсэн тусгаарлан хоригдогсдод мөн хамаарна.

Дайтах ажиллагаа дуусах буюу нутаг дэвсгэрийн эзлэлт дууссаны дараа олзлогч гүрэн болон холбогдох гүрний хоорондын тохиролцсоноор янз бүрийн газар байгаа тусгаарлан хоригдогсдыг эрж хайх хороонуудыг байгуулж болно.

#### *134 дүгээр зүйл*

Дайтах ажиллагаа буюу эзлэлт дууссаны дараа хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд бүх тусгаарлан хоригдогчийг хамгийн сүүлд оршин сууж байсан газарт нь буцаах буюу эх оронд нь буцах нөхцөл боломжийг олгох явдлыг хангах талаар хүчин чармайлт гаргана.

#### *135 дугаар зүйл*

Олзлогч гүрэн суллагдсан тусгаарлан хоригдогсдыг тусгаарлан хоригдохдоо оршин сууж байсан газарт нь буцаах зардал, эсхүл тэднийг шилжүүлэх үед буюу их далайд явж байх үед саатуулсан тохиолдолд аяллыг дуусгах хүртэлх, эсхүл буцах газартаа очих хүртэлх зардлыг хариуцна.

Хэрэв олзлогч гүрэн нутаг дэвсгэрт нь өмнө байнга оршин суухыг зөвшөөрч байсан тусгаарлан хоригдогсдыг сулласны дараа нутаг дэвсгэртээ оршин суухыг зөвшөөрөхөөс татгалзвал олзлогч гүрэн дурдсан тусгаарлан хоригдогсдыг нутагт нь буцаах зардлыг олгоно. Хэрэв тусгаарлан хоригдогч нутаг буцахдаа зардлаа өөрөө хариуцах, эсхүл өөрийг нь харьяалах гүрний засгийн газрын өмнө хүлээсэн үүрэгтээ үнэнч байх үүднээс зардлаа өөрөө хариуцах тохиолдолд олзлогч гүрэн өөрийн нутаг дэвсгэрээс цааш явах тэдний зардлыг хариуцах үүрэггүй. Өөрийн хүсэлтээр тусгаарлан хоригдсон хүмүүсийн нутагтаа буцах зардлыг олзлогч гүрэн хариуцахгүй.

Тусгаарлан хоригдогсдыг 45 дугаар зүйлийн дагуу шилжүүлэх тохиолдолд шилжүүлэгч гүрэн болон хүлээн авагч гүрэн дээрх зардлыг хариуцах тус бүрийн зардлын хувь хэмжээг тохиролцоно.

Дээрх заалтууд мөргөлдөөнд оролцогч талуудын хооронд байгуулж болох дайсны гарт буй тэдний харьяатыг солилцох болон эх оронд нь буцаах талаархи тусгай хэлэлцээрийг хөндөхгүй.

## **V ХЭСЭГ**

### **Мэдээллийн товчоо болон төв агентлаг**

#### *136 дугаар зүйл*

Мөргөлдөөн үүсэх болон эзлэх бүх тохиолдолд мөргөлдөөнд оролцогч тал бүр өөрийн мэдэлд байгаа хамгаалагдсан хүмүүстэй холбогдолтой мэдээллийг хүлээн авах болон дамжуулах үүрэг бүхий албан ёсны Мэдээллийн товчоог байгуулна.

Мөргөлдөөнд оролцогч тал бүр хоёр долоо хоногоос илүү хугацаагаар саатуулагдаж байгаа, тодорхой газарт албадан суурьшуулсан буюу тусгаарлан хоригдсон хамгаалагдсан хүмүүсийн талаар авсан арга хэмжээний тухай мэдээллийг аль болох богино хугацаанд уг товчоонд өгнө. Цашилбал, тухайн тал шилжүүлсэн, сулласан, эх оронд нь буцаасан, тэдний оргосон, эмнэлэгт хэвтүүлсэн, төрөлт болон нас баралт зэрэг эдгээр хамгаалагдсан хүнтэй холбогдолтой бүх өөрчлөлтийн талаархи мэдээллийг дээр дурдсан товчоонд түргэн мэдэгдэж байхыг ийм асуудал эрхэлдэг өөрийн салбаруудаас шаардана.

#### *137 дугаар зүйл*

Үндэсний мэдээллийн товчоо бүр хамгаалагдсан хүмүүстэй холбогдолтой мэдээллийг хамгаалагч гүрэн болон 140 дүгээр зүйлд заасан Төв агентлагаар дамжуулан нутаг дэвсгэрт нь оршин сууж байсан гүрэнд хамгийн шуурхай аргаар дамжуулна. Товчоо нь түүнчлэн хамгаалагдсан хүмүүсийн талаар ирүүлсэн бүх лавлагаанд хариу өгнө.

Мэдээллийн товчоо хамгаалагдсан хүмүүстэй холбогдолтой мэдээлэл нь холбогдох хүмүүс буюу тэдний төрөл саданд хор учруулахааргүй бол дамжуулна. Ийм тохиолдолд ч гэсэн Төв агентлагт өгөх нөхцөл байдлын талаархи зохих мэдээллийг саатуулж болохгүй бөгөөд 140 дүгээр зүйлд заасны дагуу урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээ авна.

Товчооноос бичгээр үйлдсэн бүх мэдэгдлийг гарын үсэг буюу тамгаар баталгаажуулна.

#### *138 дугаар зүйл*

Үндэсний мэдээллийн товчооны хүлээн авсан болон түүний дамжуулсан мэдээлэл нь хамгаалагдсан хүнийг хэн болохыг тодорхойлох бөгөөд түүний ойрын төрөл саданд түргэн мэдэгдэх шинж чанартай байна. Хүн бүрт холбогдох мэдээлэл нь наад зах нь түүний овог, нэр, төрсөн газар болон төрсөн он, сар, өдөр, иргэний харьяалал, сүүлд оршин сууж байсан газар болон онцлог шинж тэмдгүүд болон эцэг, эхийн багын нэр, тухайн хүний талаар арга хэмжээ авсан газар болон он, сар, өдөр, авсан арга хэмжээний шинж чанар, түүнд захидал, харилцаа илгээж болох хаяг болон мэдэгдэх хүний нэр, хаягийг заана.

Түүнчлэн, хүнд өвчтэй буюу шархадсан тусгаарлан хоригдогсдын эрүүл мэндийн байдлын талаархи мэдээллийг тогтмол буюу боломжтой бол долоо хоног бүр өгч байна.

*139 дүгээр зүйл*

Үндэсний мэдээллийн товчоо бүр 136 дугаар зүйлд дурдсан хамгаалагдсан, тухайлбал эх оронд нь буцаасан буюу сулласан, эсхүл оргосон буюу нас барсан хүмүүсийн үлдээсэн үнэт зүйлийг олж авах явдлыг хариуцах бөгөөд уг товчоо нь дурдсан үнэт зүйлийг холбогдох этгээдэд шууд буюу шаардлагатай бол Төв агентлагаар дамжуулан өгнө. Товчоо эдгээр зүйлийг лацадсан боодолд хийж тэдгээрийн эзнийг нь тогтооход шаардлагатай бүх мэдээлэл, түүнчлэн боодолд байгаа зүйлийн бүрэн жагсаалтыг дагалдуулан илгээнэ. Ийм үнэт зүйлсийг хүлээн авсан болон илгээсэн тухай дэлгэрэнгүй бүртгэл хөтөлнө.

*140 дүгээр зүйл*

Хамгаалагдсан хүмүүсийн асуудал эрхэлсэн Төв агентлаг, ялангуяа Тусгаарлан хоригдсон хүмүүсийн мэдээллийн төв агентлагийг төвийг сахисан оронд байгуулна. Олон улсын улаан загалмайн хороо шаардлагатай гэж үзвэл холбогдох гүрнүүдэд ийм агентлаг байгуулахыг санал болгох бөгөөд энэ нь Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 123 дугаар зүйлд заасан агентлагтай адил байж болно.

Энэ агентлаг нь албан ёсны буюу хувийн шугамаар олж авч болох 136 дугаар зүйлд заасан төрлийн бүх мэдээллийг олж цуглуулах үүрэгтэй байна. Ийм мэдээллийг дамжуулах нь холбогдох хүмүүс буюу тэдний төрөл саданд хор учруулахаас бусад тохиолдолд мэдээллийг холбогдох хүмүүсийн гарлын буюу оршин суудаг оронд аль болох шуурхай дамжуулна. Мөргөлдөөнд оролцогч талууд мэдээллийг дамжуулах явдлыг хангах боломжит бүх нөхцөл олгоно.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудаас, ялангуяа Төв агентлагийн тусламжийг авдаг иргэдийг харьяалах талуудаас шаардлагатай үед дурдсан агентлагт санхүүгийн туслалцаа үзүүлэхийг хүснэ.

Дээрх заалтыг Олон улсын улаан загалмайн хороо болон 142 дугаар зүйлд заасан тусламжийн байгууллагуудын хүмүүнлэгийн үйл ажиллагааг хязгаарлаж байгаагаар хэрхэвч тайлбарлахгүй.

*141 дүгээр зүйл*

Үндэсний мэдээллийн товчоонууд болон Мэдээллийн төв агентлаг нь шуудангийн бүх илгээмжийн зардлаас чөлөөлөгдөх, түүнчлэн 110 дугаар зүйлд заасан бүх хөнгөлөлтийг эдэлж цахилгаан мэдээ илгээлтийн төлбөрөөс чөлөөлөгдөх бөгөөд аргагүйд хүрвэл ихээхэн хямдруулсан үнээр илгээнэ.

**IV АНГИ  
КОНВЕНЦИЙГ БИЕЛҮҮЛЭХ**

**I ХЭСЭГ  
НИЙТЛЭГ ЗААЛТ**

*142 дугаар зүйл*

Олзлогч гүрнүүд өөрийн аюулгүй байдал буюу аливаа бусад боломжит шаардлагыг хангахуйц арга хэмжээ авахын хамт эдгээр гүрэн шашны байгууллагын төлөөлөгчид, тусламжийн нийгэмлэгүүд буюу хамгаалагдсан хүмүүст тусламж үзүүлдэг бусад байгууллагад өөрсөд нь, эсхүл зохих ёсоор эрх олгогдсон төлөөлөгчдөд эдгээр хамгаалагдсан хүмүүсийг эргэх, боловсролын, амралт цэнгээний буюу шашны зориулалтын, эсхүл тэдэнд тусгаарлан хорих газрын хүрээнд чөлөөт цагаа зохион байгуулахад туслахад зориулагдсан тусламжийн бараа, материал тараах нөхцөл бололцоог олгоно. Ийм нийгэмлэг буюу байгууллагыг олзлогч гүрний нутаг дэвсгэрт буюу аливаа бусад оронд байгуулж болох бөгөөд тэд олон улсын шинж чанартай байж болно.

Олзлогч гүрэн нутаг дэвсгэрт нь, эсхүл хяналтынх нь дор үйл ажиллагаагаа явуулах төлөөлөгчид бүхий зөвшөөрөлтэй нийгэмлэг буюу байгууллагуудын тоог хязгаарлаж болох боловч ийм хязгаарлалт нь хамгаалагдсан бүх хүнд зориулсан үр дүнтэй болон тохиромжтой тусламжийг үзүүлэхэд саад учруулахгүй.

Энэ салбар дахь Олон улсын улаан загалмайн хорооны онцгой байр суурийг бүх үед хүлээн зөвшөөрч, хүндэтгэнэ.

*143 дугаар зүйл*

Хамгаалагч гүрний төлөөлөгчид элч төлөөлөгчид буюу хамгаалагдсан хүмүүсийн байгаа бүх газарт очих, ялангуяа тусгаарлан хорих, саатуулах газар болон ажлын байранд очихыг зөвшөөрнө.

Тэд хамгаалагдсан хүмүүсийн ашиглаж буй бүх байранд орж болох бөгөөд тэдэнтэй өөрөө шууд буюу орчуулагчаар дамжуулан гэрчгүйгээр ярилцаж болно.

Ийм эргэлтийг цэргийн зайлшгүй шаардлагын улмаас шаардлагатай болсон үед зөвхөн онцгой болон түр зуурын арга хэмжээ болгон хориглохоос бусад тохиолдолд хориглож болохгүй. Эргэлтийн хугацааг хязгаарлаж болохгүй.

Ийм төлөөлөгчид буюу элч төлөөлөгчид очих газраа чөлөөтэй сонгох эрхтэй байна. Тусгаарлан хоригдогсдыг нутаг нэгт хүмүүстэй уулзуулахыг зөвшөөрөх талаар олзлогч гүрэн, эзлэгч гүрэн буюу хамгаалагч гүрэн, шаардлагатай тохиолдолд уулзах хүмүүсийн гарлын гүрэн тохиролцож болно.

Олон улсын улаан загалмайн хорооны төлөөлөгч дээрх онцгой эрхийг мөн эдэлнэ. Эдгээр төлөөлөгчийг томилохдоо тэдний очиж ажиллах нутаг дэвсгэрийг удирдаж буй гүрний зөвшөөрлийг авна.



144 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд тайван цагт болон дайны үед энэхүү конвенцийн зарчмыг нийт хүн амд таниулах үүднээс энэхүү конвенцийн эх бичвэрийг өөрийн оронд аль болох өргөнөөр түгээн сурталчлах, тухайлбал түүний талаар цэргийн, боломжтой бол иргэний сургалтын хөтөлбөрт оруулах үүрэг хүлээнэ.

Дайны цагт хамгаалагдсан хүмүүсийг хариуцах үүрэг хүлээх аливаа энгийн, цэргийн, цагдаагийн буюу бусад эрх бүхий этгээдэд энэхүү конвенцийн эх бичвэр байх бөгөөд тэдгээрийн утга агуулгатай тэд тусгайлан танилцсан байх ёстой.

145 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд энэхүү конвенцийн албан ёсны орчуулга болон түүнийг хэрэглэх явдлыг хангах зорилгоор гаргасан хууль тогтоомжийг тайван цагт Швейцарийн холбооны зөвлөлөөр, дайтах ажиллагааны үед хамгаалагч гүрнээр дамжуулан харилцан өөр хоорондоо хүргүүлнэ.

146 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд дараагийн зүйлд тодорхойлсон энэхүү конвенцийн ноцтой зөрчлийг үйлдэж байгаа буюу үйлдэхийг тушаасан этгээдэд үр дүнтэй эрүүгийн ял хүлээлгэхэд шаардлагатай аливаа хууль тогтоомжийг батлан гаргах үүрэг хүлээнэ.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр ийм ноцтой зөрчлийг үйлдсэн буюу үйлдэхийг тушаасан гэж буруутгагдаж байгаа хүмүүсийг эрж олох, түүний харьяаллыг үл харгалзан өөрийн шүүхэд шилжүүлэх үүрэг хүлээнэ. Тухайн тал хүсвэл өөрийн хууль тогтоомжийн заалтад нийцүүлэн тийм хүмүүсийг хэлэлцэн тохирогч эрхэм дээд өөр холбогдох талын шүүхэд шилжүүлж болох бөгөөд чингэхдээ хэлэлцэн тохирогч эрхэм дээд тухайн тал нь *prima facie* хэрэг үүсгэсэн байвал зохино.

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр дараагийн зүйлд тодорхойлсон ноцтой зөрчлөөс бусад энэхүү конвенцийн заалтад харш бүх үйлдлийг таслан зогсооход шаардлагатай арга хэмжээг авна.

Яллагдаж байгаа этгээд ямар ч нөхцөл байдалд Дайнд олзлогдогчидтой харьцах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 105 дугаар зүйл болон түүний дараагийн зүйлүүдэд зааснаас дордуулахааргүй шүүх болон өмгөөллийн зохих ажиллагааны баталгаа эдэлнэ.

147 дугаар зүйл

Өмнөх зүйлд дурдсан ноцтой зөрчил нь энэхүү конвенцоор хамгаалагдаж байгаа хүмүүс буюу эд хөрөнгийн эсрэг үйлдсэн дараахь аливаа үйлдлийг оролцуулсан зөрчил байх бөгөөд тэдгээрт санаатайгаар амийг нь хөнөөх, эрүүдэн шүүх буюу хүнлэг бусаар харьцах, түүний дотор биологийн туршилт хийх, бие махбодь буюу эрүүл мэндэд үлэмж шаналал буюу хүнд гэмтэл санаатайгаар учруулах, хамгаалагдсан хүмүүсийг хууль бусаар хөөн гаргах буюу шилжүүлэх, эсхүл саатуулах, дайсагнагч

гүрний хүчинд алба хашихыг албадах буюу энэхүү конвенцид заасан шударга болон хэвийн шүүн таслуулах эрхийг нь санаатайгаар хасах, хүн барьцаанд авах бөгөөд дайны шаардлагаар зөвтгөх боломжгүйгээр бөгөөд хууль бусаар болон дур зоргоор эд хөрөнгө их хэмжээгээр эвдэж сүйтгэх буюу ашиглан завших хэрэг хамаарагдана.

*148 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талуудын аль нь ч өмнөх зүйлд дурдсан зөрчил үйлдсэний улмаас хүлээх хариуцлагаас өөрийгөө буюу хэлэлцэн тохирогч эрхэм дээд өөр аль нэг талыг чөлөөлөхийг зөвшөөрөхгүй.

*149 дүгээр зүйл*

Энэхүү конвенцийн аливаа зөрчилтэй холбогдуулан мөрдөн байцаалтыг мөргөлдөөнд оролцогч аль нэг талын хүсэлтээр сонирхогч талуудын хооронд тохиролцсон журмаар эхлүүлнэ.

Хэрэв мөрдөн байцаалтын журмын талаар тохиролцоонд хүрч чадаагүй бол талууд дагаж мөрдөх журмыг шийдвэрлэх зуучлагчийг тохиролцон сонгоно.

Нэгэнт зөрчил гарсныг тогтоосон тохиолдолд мөргөлдөөнд оролцогч талууд түүнийг дуусгавар болгож, аль болох богино хугацаанд түүнд ял оногдуулах арга хэмжээ авна.

## **II ХЭСЭГ**

### **ТӨГСГӨЛИЙН ЗААЛТ**

*150 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг англи, франц хэлээр үйлдэв. Хоёр эх бичвэр нь адил хүчинтэй байна.

Швейцарийн холбооны зөвлөл Конвенцийн орос, испани хэлний албан ёсны орчуулгыг зохион байгуулна.

*151 дүгээр зүйл*

Энэ өдрийн он, сар, өдрөөр тэмдэглэгдэх энэхүү конвенц 1949 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Женев хотноо нээгдсэн бага хуралд оролцсон гүрнүүдийн нэрийн өмнөөс 1950 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хүртэл гарын үсэг зурахад нээлттэй байна.

*152 дугаар зүйл*

Энэхүү конвенцийг аль болох түргэн соёрхон батлах бөгөөд батламж жуух бичгийг Берн хотноо хадгалуулна.

Швейцарийн холбооны зөвлөл хадгалуулахаар өгсөн батламж жуух бичиг бүрийн бүртгэл хөтөлж, энэ бүртгэлийн баталгаатай хуулбарыг нэрийн нь өмнөөс конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсноо мэдэгдсэн бүх гүрэнд дамжуулна.

*153 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь хоёроос доошгүй батламж жуух бичгийг хадгалуулснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Түүнээс хойш энэ нь хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүрийн хувьд соёрхон батласан батламж жуух бичгээ хадгалуулснаас хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

*154 дүгээр зүйл*

1899 оны 7 дугаар сарын 29-ний эсхүл 1907 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Хуурай газрын дайны тухай хууль, заншлын тухай Гаагийн конвенцуудыг дагаж мөрддөг гүрнүүд болон энэхүү конвенцид оролцогч тал гүрнүүд хоорондын харилцаанд дээр дурдсан Гаагийн конвенцуудад хавсаргасан журмын II болон III хэсэг энэ конвенцийг орлоно.

*155 дугаар зүйл*

Энэхүү конвенц нь хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш түүнд нэрийх нь өмнөөс гарын үсэг зураагүй аливаа гүрний хувьд нэгдэн ороход нээлттэй байна.

*156 дугаар зүйл*

Нэгдэж орсноо Швейцарийн холбооны зөвлөлд бичгээр мэдэгдэх бөгөөд ийнхүү нэгдэж орсон нь тухайн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

Швейцарийн холбооны зөвлөл нэгдэн орсон талаар нэрийх нь өмнөөс Конвенцид гарын үсэг зурсан буюу нэгдэн орсноо мэдэгдсэн бүх гүрэнд мэдэгдэнэ.

*157 дугаар зүйл*

Дайтах ажиллагаа буюу эзлэлт эхлэхээс өмнө буюу эхэлсний дараа мөргөлдөөнд оролцогч талуудын хадгалуулсан батламж жуух бичиг болон нэгдэн орсон тухай мэдэгдэл 2, 3 дугаар зүйлд заасан тохиолдолд нэн даруй хүчин төгөлдөр болно. Швейцарийн холбооны зөвлөл мөргөлдөөнд оролцогч талуудаас хүлээн авсан соёрхон батласан буюу нэгдэн орсон тухай аливаа мэдэгдлийг хамгийн түргэн аргаар хүргүүлнэ.

*158 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд тал бүр энэхүү конвенцийг цуцлах эрхтэй.

Цуцлах тухайгаа Швейцарийн холбооны зөвлөлд бичгээр мэдэгдэх бөгөөд түүнийг Швейцарийн холбооны зөвлөл хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талын засгийн газарт дамжуулна.

Цуцлалт нь цуцлах тухай Швейцарийн холбооны зөвлөлд мэдэгдсэнээс хойш нэг жилийн дараа хүчин төгөлдөр болно. Гэвч цуцалж буй гүрэн мөргөлдөөнд оролцож байх үедээ цуцлах тухай мэдэгдсэн тохиолдолд хоёр тал найрамдал зарлах болон энэхүү конвенцоор хамгаалагдсан хүмүүсийг суллаж эх оронд нь буцаах ажиллагаа дуусах хүртэл цуцлалт нь хүчин төгөлдөр болохгүй.

Цуцлалт нь зөвхөн цуцалж буй гүрний хувьд хүчинтэй байна. Энэ нь дэлхийн соёл иргэншилт ард түмнүүдийн хооронд тогтсон заншил, хүнлэг ёсны хууль болон олон нийтийн ухамсарт ёс суртахуунаас үндэстэй олон улсын эрх зүйн зарчмын дагуу мөргөлдөөнд оролцогч талуудын заавал биелүүлэх ёстой хэвээр байх үүрэгт хэрхэвч нөлөөлөхгүй.

#### *159 дүгээр зүйл*

Швейцарийн холбооны зөвлөл энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт бүртгүүлнэ. Мөн Швейцарийн холбооны зөвлөл нь энэхүү конвенцийг соёрхон батласан, түүнд нэгдэж орсон болон түүнийг цуцалсан тухай мэдэгдлийг хүлээн авсан талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газарт мэдээлнэ.

Дээр дурдсаныг нотлон дор гарын үсэг зурагчид бүрэн эрхээ хадгалуулж энэхүү конвенцид гарын үсэг зурцгаав.

Женев хотноо 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдөр англи, франц хэлээр үйлдэв. Жинхэнэ эх бичвэрийг Швейцарийн Холбооны Улсын архивт хадгална. Швейцарийн холбооны зөвлөл түүний баталгаат хуулбарыг гарын үсэг зурсан болон нэгдэж орсон улс бүрт хүргүүлнэ.

## I ХАВСРАЛТ

### ЭМНЭЛГИЙН БҮС БОЛОН ОРОН НУТГИЙН БҮСЭД ХАМААРАХ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСӨЛ

#### *1 дүгээр зүйл*

Эмнэлгийн бүсийг зөвхөн Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 23 дугаар зүйлд заасан этгээдүүд болон Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай 1949 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн Женевийн конвенцийн 14 дүгээр зүйлд заасан этгээдүүд, мөн эдгээр бүс газрыг зохион байгуулан удирдаж, тэнд цугларсан этгээдүүдийг асрах үүрэг бүхий ажилтнуудад зориулна.

Гэсэн хэдий ч ийм бүсийн дотор байнга оршин суугчид тэндээ үлдэх эрхтэй байна.

#### *2 дугаар зүйл*

Эмнэлгийн бүсэд аливаа эрхтэйгээр оршин суугаа ямар ч этгээд уг бүсийн дотор буюу гадна цэргийн үйл ажиллагаатай буюу дайны материал үйлдвэрлэхтэй шууд холбоотой ажил гүйцэтгэхгүй.

#### *3 дугаар зүйл*

Эмнэлгийн бүс байгуулж байгаа гүрэн тухайн бүсэд оршин суух буюу түүнд нэвтрэх эрхгүй бүх этгээдийг оруулахыг хориглох талаар шаардлагатай бүх арга хэмжээ авна.

#### *4 дүгээр зүйл*

Эмнэлгийн болон аюулгүйн бүс нь дараахь нөхцлийг хангасан байна:

- (a) Тухайн бүсийг байгуулсан гүрний захирч буй нутаг дэвсгэрийн зөвхөн бага хэсгийг бүрдүүлж байх;
- (b) Байрны боломжтой харьцуулахад сийрэг суурьшуулах;
- (c) Эдгээр бүс цэргийн бүх объект, эсхүл аж үйлдвэр буюу захиргааны томоохон байгууллагаас алслагдсан газар орших;
- (d) Аливаа магадлалаас хамааран дайны ажиллагаа явуулахад өртөж болох газарт байрлаагүй байх.

*5 дугаар зүйл*

Эмнэлгийн болон аюулгүйн бүс нь дараахь үүргийг хүлээнэ:

(а) Эдгээр бүсийн эзэмшиж буй зам харилцаа болон тээврийн хэрэгслийг цэрэг буюу цэргийн материал тээвэрлэх, дамжин өнгөрүүлэхэд ашиглаж болохгүй;

(б) Тэдгээрийг ямар ч тохиолдолд цэргийн хүч хэрэгслээр хамгаалахгүй.

*6 дугаар зүйл*

Эмнэлгийн болон аюулгүйн бүсийг бүсийн хязгаар болон барилга дээр байрлуулсан цагаан дэвсгэр дээрх ташуу улаан туузаар тэмдэглэнэ.

Гагцхүү шархтан, өвчтөнд зориулсан бүсийг цагаан дэвсгэр дээрх улаан загалмайн (улаан хавирган сар, улаан арслан болон нар) бэлгэ тэмдгээр тэмдэглэж болно.

Тэдгээрийг шөнийн цагт зохих гэрэлтүүлгийн аргаар мөн адил тэмдэглэж болно.

*7 дугаар зүйл*

Гүрнүүд тайван цагт буюу дайны ажиллагаа эхлэхэд захирч буй нутаг дэвсгэрт нь байгаа эмнэлгийн болон аюулгүйн бүсийн жагсаалтыг хэлэлцэн тохирогч эрхэм дээд бүх талд хүргүүлнэ. Түүнчлэн тэд дайтах ажиллагааны үед байгуулсан аливаа шинэ бүсийн тухай мэдэгдэнэ.

Дайсагнагч тал дээр дурдсан мэдэгдлийг хүлээн авмагц бүсийг хууль ёсоор оршин тогтнож байгаад тооцно.

Гэвч хэрэв дайсагнагч тал энэхүү хэлэлцээрийн нөхцөл хангагдаагүй гэж үзвэл тухайн бүсийг хариуцаж буй талд нэн даруй мэдэгдэх замаар бүсийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, эсхүл тухайн бүсийг хүлээн зөвшөөрөх асуудлыг 8 дугаар зүйлд заасан хяналт тогтоох тухай асуудалтай холбоотой санал тавьж болно.

*8 дугаар зүйл*

Дайсагнагч талын байгуулсан эмнэлгийн нэг буюу хэд хэдэн бүсийг хүлээн зөвшөөрсөн аливаа гүрэн эдгээр бүс нь энэхүү хэлэлцээрт заасан нөхцөл, үүргийг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор нэг буюу хэд хэдэн тусгай комиссараар хяналт тавихыг шаардах эрх эдэлнэ.

Эл зорилгоор тусгай комиссын гишүүд нь янз бүрийн бүсэд хэдийд ч чөлөөтэй нэвтрэх бөгөөд тэнд байнга оршин сууж ч болно. Тэдэнд шалгалт хийх үүргээ биелүүлэх бүх нөхцөл боломжийг олгоно.

*9 дүгээр зүйл*

Тусгай комиссын гишүүд энэхүү хэлэлцээрийн нөхцөлд харшилж байна гэж үзэж буй аливаа баримтыг тогтоовол тухайн бүсийг захирч буй гүрний анхаарлыг уг баримтад даруй хандуулах бөгөөд байдлыг засаж залруулахад тав хоногийн хугацаа олгоно. Тэд бүсийг хүлээн зөвшөөрсөн гүрэнд энэ тухай зохих ёсоор мэдэгдэнэ.

Хэрэв хугацаа дуусахад бүсийг захирч буй гүрэн шаардлагыг биелүүлээгүй бол дайсагнагч тал тухайн бүсийн хувьд энэхүү хэлэлцээртэй ямар ч холбоогүй болсноо мэдэгдэж болно.

*10 дугаар зүйл*

Эмнэлгийн болон аюулгүйн нэг буюу хэд хэдэн бүс байгуулсан аливаа гүрэн, түүнчлэн эдгээр бүс байгаа тухай мэдэгдсэн дайсагнагч талууд 8, 9 дүгээр зүйлд дурдсан тусгай комиссын гишүүн болох этгээдийн нэр дэвшүүлэх, эсхүл хамгаалагч гүрнүүд, эсхүл төвийг сахигч бусад гүрнээр нэр дэвшүүлүүлнэ.

*11 дүгээр зүйл*

Эмнэлгийн болон аюулгүйн бүс рүү ямар ч нөхцөл байдалд халдаж болохгүй. Мөргөлдөөнд оролцогч талууд эдгээр бүсийг ямагт хамгаалж, хүндэтгэнэ.

*12 дугаар зүйл*

Эмнэлгийн болон аюулгүйн бүсүүд байгаа нутаг дэвсгэрийг эзэлсэн тохиолдолд эдгээр бүсийг урьдын адил хамгаалж, зориулалтаар нь ашиглана.

Гэвч эзлэгч гүрэн тухайн бүсэд байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хангах бүх арга хэмжээг авсан нөхцөлд бүсийн зориулалтыг өөрчилж болно.

*13 дугаар зүйл*

Энэхүү хэлэлцээрийг гүрнүүдээс эмнэлгийн болон аюулгүйн бүсийн нэгэн адил зориулалтаар ашиглаж байгаа орон нутгийн бүсэд мөн хэрэглэж болно.

## II ХАВСРАЛТ

### ХАМТЫН ТУСЛАМЖИЙН ТУХАЙ ЖУРМЫН ТӨСӨЛ

#### *1 дүгээр зүйл*

Тусгаарлан хоригдогсдын хороо нь хүлээн авсан хамтын тусламжийн ачааг захиргааны хувьд түүнээс хамааралтай хоригдогсод болон өөрийн харьяалалд орших эмнэлэг, эсхүл шорон буюу бусад засан хүмүүжүүлэх газарт буй тусгаарлан хоригдогсдод хуваарилахыг зөвшөөрнө.

#### *2 дугаар зүйл*

Хамтын тусламжийн ачааг хандивлагчийн зааварчилгаа болон Тусгаарлан хоригдогсдын хорооноос боловсруулсан төлөвлөгөөний дагуу хуваарилна. Гэхдээ эмнэлгийн агуулахад байх зүйлийг эмнэлгийн ахлах ажилтантай тохиролцсоноор хуваарилж болох бөгөөд тэрбээр өвчтөний байдал тийнхүү шаардаж байвал эмнэлэг болон тусгай газрын дээр дурдсан зааварчилгааг мөрдөхөөс татгалзаж болно. Ийнхүү тогтоосон хязгаарлалтын хүрээнд тусламжийн барааг үргэлж эрх тэгш зарчмаар хуваарилна.

#### *3 дугаар зүйл*

Хүлээн авсан ачааны хэмжээ болон чанарыг шалгаж үзэх, энэ асуудлаар хандивлагч нарт зориулан дэлгэрэнгүй илтгэл бэлтгэх боломж олгох үүднээс Тусгаарлан хоригдогсдын хорооны гишүүдэд тусгаарлан хорих газрын ойр байгаа галт тэрэгний буудал буюу тусламж хүрэлцэн ирэх бусад цэгт илгээмж хүлээн авахыг зөвшөөрнө.

#### *4 дүгээр зүйл*

Хамтын тусламжийн ачааг тусгаарлан хорих газруудын бүх салбар, хэсгүүдэд зааварчилгааны дагуу хүргэгдсэн эсэхийг хянах нөхцөл бололцоог Тусгаарлан хоригдогсдын хороонд олгоно.

#### *5 дугаар зүйл*

Хандивлагчдад зориулсан хамтын тусламжийн (хуваарилалт, хэрэгцээ, тоо хэмжээ гэх мэт) ачаатай холбогдолтой хуудас буюу мэдүүлгийг бөглөх, түүнчлэн эдгээр хуудсыг Тусгаарлан хоригдогсдын хорооны гишүүдийн ажлын баг буюу тусгай газар, эмнэлгийн ахлах ажилтнаар бөглүүлэхийг Тусгаарлан хоригдогсдын хороонд зөвшөөрнө. Зохих ёсоор бөглөсөн эдгээр хуудас болон анкетыг хандивлагчдад цаг алдалгүй дамжуулна.



*6 дугаар зүйл*

Тусгаарлан хоригдож буй газарт хамтын тусламжийн ачааг тусгаарлан хоригдогсдод тогтмол хуваарилах явдлыг баталгаажуулах болон шинээр тусгаарлан хоригдогсод ирэхтэй холбогдон гарч болох аливаа хэрэгцээг хангах үүднээс хамтын тусламжийн хангалттай нөөц бий болгон хадгалахыг Тусгаарлан хоригдогсдын хороонд зөвшөөрнө. Эл зорилгоор тэд хэрэглэхэд тохиромжтой агуулахтай байна. Агуулах бүр хоёр цоожтой байх бөгөөд нэг цоожны түлхүүрийг Тусгаарлан хоригдогсдын хороонд, нөгөө цоожны түлхүүрийг тусгаарлан хорих газрын захирагчид тус тус хадгалуулна.

*7 дугаар зүйл*

Хэлэлцэн тохирогч эрхэм дээд талууд болон, ялангуяа олзлогч гүрнүүд, боломжийн хэрээр хүн амын хүнс тэжээлийн хүрэлцээг зохицуулах журмыг мөрдөхийн хамт тэдний нутаг дэвсгэрт байгаа тусгаарлан хоригдогсдод хамтын тусламжийг хуваарилах зорилгоор бараа худалдан авах зөвшөөрөл олгоно. Түүнчлэн мөнгө шилжүүлэх болон ийм бараа худалдан авах зорилгоор техникийн буюу захиргааны шинж чанартай бусад санхүүгийн арга хэмжээ авахад тэд дэмжлэг үзүүлнэ.

*8 дугаар зүйл*

Хамгаалагч гүрнүүд, Олон улсын улаан загалмайн хороо буюу тусгаарлан хоригдогсдод хамтын тусламжийн ачааг дамжуулан өгөх үүрэг бүхий аливаа бусад хүмүүнлэгийн байгууллагын төлөөлөгчдөөс ачааг аль болох тохиромжтой аргаар хуваарилах бололцоогүй үед тусгаарлан хоригдогсод байрлах газартаа хүрэлцэн ирэхийн өмнө буюу ирж явах замдаа хамтын тусламжийн ачааг хүлээн авахад өмнөх зүйлүүд саад учруулахгүй.

**III ХАВСРАЛТ**

**I. ТУСГААРЛАН ХОРИХ БАРИМТ**

**Нүүрэн тал**

<u>Энгийн тусгаарлан хориглогчийн захидал</u>		<b>Төлбөргүй</b>
Ил захидал		
<b>АНХААРУУЛАХ НЬ</b>	<b>ХАМГААЛАГДСАН ХҮМҮҮСИЙН МЭДЭЭЛЛИЙН ТӨВ АГЕНТЛАГ</b>	
<p>Энэхүү баримтыг тусгаарлан хоригдогч бүр тусгаарлан хоригдсон болон тусгаарлан хорих өөр газар буюу эмнэлэгт шилжүүлсэн шалтгаанаар түүний хаяг нь өөрчлөгдсөн даруй бөглөнө.</p> <p>Энэхүү баримт нь тусгаарлан хоригдогчоос төрөл садандаа илгээхийг зөвшөөрсөн тусгай баримтанд үл хамаарна.</p>	<p>Олон улсын улаан загалмайн хороо</p>	

**Ар тал**

Гаргацтайгаар дармал үсгээр бич - 1. Иргэний харьяалал		
2. Овог	3. Нэр /бүтнээр/	4. Эцгийн нэр
.....		
5. Төрсөн он, сар, өдөр.....	6. Төрсөн газар.....	
7. Мэргэжил.....		
8. Саатуулагдахаас өмнөх хаяг.....		
9. Ойрын төрөл садангийн хаяг.....		
*10. Тусгаарлан хоригдсон он, сар, өдөр:..... (эсхүл)		
(Эмнэлэг гэх мэтээс) ирсэн он, сар, өдөр:.....		
*11. Эрүүл мэндийн байдал		
12. Одоогийн хаяг.....		
.....		
13. Он, сар, өдөр.....		14. Гарын үсэг.....
* Хэрэглэж болохгүйг дар – Ямар нэгэн тэмдэг бүү тавь – Баримтын нөгөө тал дээр байгаа тайлбарыг хар		

(Тусгаарлан хорих баримтын хэмжээ: 10 x 15 см)

**III ХАВСРАЛТ**

**II. ЗАХИДАЛ**

**Захидал**

Энгийн тусгаарлан хоригдогчийн  
шуудан

Төлбөргүй

Хэнд.....  
Гудамж, байшингийн дугаар.....  
Очих газар (дармал, том үсгээр).....  
Муж буюу дүүрэг.....  
Улсын нэр (дармал, том үсгээр).....

Явуулагч:

Овог, нэр.....  
Төрсөн он, сар, өдөр ба газар.....  
Тусгаарлан хорих газрын хаяг.....

(Захидлын цаасны хэмжээ 29 x 15 см)

**III ХАВСРАЛТ**

**III. ХАРИЛЦАХ ЗАХИДАЛ**

**Нүүрэн тал**

Энгийн тусгаарлан хориглогчийн захидал		Төлбөргүй
Ил захидал		
Илгээгч:	Хэнд:	
Овог, нэр.....	.....	
Төрсөн он, сар, өдөр ба газар	Гудамж, байшингийн дугаар	
.....	.....	
Тусгаарлан хоригдох газрын хаяг	Очих газар (дармал, том үсгээр)	
.....	.....	
	Муж буюу дүүрэг	
	Улсын нэр (дармал, том үсгээр)	
	.....	

**Ар тал**

Он, сар өдөр:
.....
.....
.....
.....
.....
.....
Зөвхөн таталсан шугаманд гаргацтай бичнэ

(Захидлын цаасны хэмжээ 10 x 15 см)